

---

# Сайн мэдээний зарчмууд

*Тэд өөрсдийн Гэтэлгэгч мөн түүний сургаалын мөн чанарын мэдлэгт орох болно; тэд түүнд хэрхэн ирж бас аврагдахыг мэдэж болохын тулд буюу. 1 Нифай 15:14*



# Сайн мэдээний зарчмууд

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс  
ХЭВЛЭВ  
Юта, Солт Лейк хот

Бид та бүхнээс энэхүү номны талаарх санал хүсэлтийг хүлээн авахдаа баяртай байх болно. Сургалтын Алба, 50 East North Temple Street, Salt Lake City, Utah 84150-0024 гэсэн хаягаар санал хүсэлтээ ирүүлнэ үү. Э-мэйл хаяг: [cur-development@ldschurch.org](mailto:cur-development@ldschurch.org). Та өөрийн нэр, хаяг, тойрог ба гадасны нэрээ бичнэ үү. Мөн номынхоо нэрийг бичихээ бүү мартаарай. Мөн номын аль хэсгийг илүү сайжруулах шаардлагатай байгаа талаарх санал сэтгэгдлээ илгээнэ үү.

© 2009 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан.

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 5/07

# Гарчиг

---

<i>Оршил</i> .....	1
<i>Бүлэг 1</i> Бидний Тэнгэрлэг Эцэг .....	5
<i>Бүлэг 2</i> Бидний Тэнгэрлэг гэр бүл .....	9
<i>Бүлэг 3</i> Есүс Христ бидний сонгогдсон удирдагч буюу аврагч .....	13
<i>Бүлэг 4</i> Сонгох эрх чөлөө .....	19
<i>Бүлэг 5</i> Бүтээлт .....	23
<i>Бүлэг 6</i> Адам Ева нарын уналт .....	27
<i>Бүлэг 7</i> Ариун Сүнс .....	32
<i>Бүлэг 8</i> Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирах нь .....	37
<i>Бүлэг 9</i> Бурханы бошиглогчид .....	43
<i>Бүлэг 10</i> Судрууд .....	49
<i>Бүлэг 11</i> Христийн амьдрал .....	55
<i>Бүлэг 12</i> Цагаатгал .....	65
<i>Бүлэг 13</i> Санваар .....	75
<i>Бүлэг 14</i> Санваартны байгууллага .....	81
<i>Бүлэг 15</i> Их Эзэний гэрээт хүмүүс .....	89
<i>Бүлэг 16</i> Эртний үеийн Есүс Христийн Сүм .....	95
<i>Бүлэг 17</i> Есүс Христийн өнөөгийн сүм .....	103
<i>Бүлэг 18</i> Есүс Христэд итгэх итгэл .....	109
<i>Бүлэг 19</i> Наманчлал .....	117
<i>Бүлэг 20</i> Баптисм .....	125
<i>Бүлэг 21</i> Ариун Сүнсний бэлэг .....	131

---

---

Бүлэг 22	Сүнсний бэлгүүд .....	137
Бүлэг 23	Ариун ёслол .....	145
Бүлэг 24	Хүндэтгэлийн өдөр .....	151
Бүлэг 25	Мацаг барилт .....	157
Бүлэг 26	Золиослол .....	163
Бүлэг 27	Ажил ба хувийн үүрэг хариуцлага .....	171
Бүлэг 28	Үйлчлэл .....	177
Бүлэг 29	Их Эзэний өгсөн эрүүл мэндийн хууль .....	185
Бүлэг 30	Энэрэл .....	191
Бүлэг 31	Шударга ёс .....	197
Бүлэг 32	Аравны нэг ба мацгийн өргөл .....	203
Бүлэг 33	Номлолын ажил .....	209
Бүлэг 34	Авьяасаа хөгжүүлэх нь .....	217
Бүлэг 35	Дуулгавартай байдал .....	221
Бүлэг 36	Гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна .....	229
Бүлэг 37	Гэр бүлийн үүрэг хариуцлага .....	235
Бүлэг 38	Мөнхийн гэрлэлт .....	241
Бүлэг 39	Ариун явдлын хууль .....	249
Бүлэг 40	Гэр бүлийн түүх ба Ариун сүмийн ажил .....	259
Бүлэг 41	Зуурдын амьдралын дараах Сүнсний дэлхий ..	265
Бүлэг 42	Израилын овгийг цутлуулах нь .....	271
Бүлэг 43	Хоёр дахь ирэлтийн тэмдгүүд .....	277
Бүлэг 44	Есүс Христийн хоёр дахь ирэлт .....	283
Бүлэг 45	Мянган жил .....	289
Бүлэг 46	Эцсийн шүүлт .....	295
Бүлэг 47	Өргөмжлөл .....	303
<i>Үзүүлэх материалын жагсаалт .....</i>		<i>309</i>
<i>Жагсаалт .....</i>		<i>312</i>

---

# Оршил

---

## **Суралцах удирдамж ба багшийн гарын авлага**

*Сайн мэдээний зарчмууд* нь хувийн сургалтын удирдамж болон багшийн гарын авлагын зориулалтаар боловсруулагдсан. Та энэ номноос суралцахдаа Их Эзэний ариун сүнсийг эрэлхийлэх аваас Бурхан Эцэг, Есүс Христийн Цагаатгал, сайн мэдээний сэргээлтийн талаар гэрчлэлтэй болж, таны мэдлэг өсөн нэмэгдэнэ. Амьдралын талаарх асуултуудынхаа хариуг олж, өөрийн зорилгоо тодорхой болгож, өөртөө итгэх итгэлтэй, өөрт болон гэр бүлдээ тохиолдох саад бэрхшээлийг даван туулах чадвартай болно.

## **Сүм дээр болон гэрт заах удирдамж**

Багш байх нь бусдыг хүчирхэгжүүлэх, тэднийг “Бурханы сайн үгээр тэжээгдэхийг” (Моронай 6:4) харах олон боломжуудыг агуулсан агуу хариуцлага юм. Та дараах зарчмуудыг даган хэрэгжүүлснээр үр дүнтэй зааж чадна:

- Зааж байгаа хүмүүсээ хайрла.
- Ариун сүнстэйгээр заа.
- Сургаалыг заа.
- Хичээнгүй суралцахыг хүс.

### *Зааж байгаа хүмүүсээ хайрла*

Зааж байгаа хүмүүстээ хайраа үзүүлснээр тэднийг Их Эзэний Ариун сүнсийг хүлээн авахад нь туслах болно. Тэд илүү суралцах хүсэлтэй болж, танд болон бусдад илүү нээлттэй болно. Зааж байгаа хүмүүстэйгээ илүү ойр дотно байж, бүгдэд нь анхаарал халамж тавьж байгаагаа харуул. Онцгой тусламж хэрэгтэй хүмүүсийн зовлон бэрхшээлд мэдрэмжтэй бай. Сайн мэдээний

---

---

зарчмуудыг хэрэгжүүлэх талаар хүн бүхэн дуртай асуултаа тавьж чөлөөтэй харьцах тав тухтай орчныг бүрдүүл.

Хайр, нэгдмэл байдалтай байх аваас Их Эзэний Ариун сүнс бидэнтэй байх болно. Их Эзэн, “Би та нарт бие биенээ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна” (Иохан 13:34) хэмээн хэлсэн байдаг.

*Teaching, No Greater Call* номны 31–39-р хуудсаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

### *Ариун Сүнсээр заа*

Таны заах хамгийн чухал зүйл бол Ариун Сүнсээр баталгаажсан, судрууд болон хожмын үеийн бошиглогчдоор дамжуулан илчлэгдсэн Христийн сургаал юм. Үүнийг үр дүнтэй болгохын тулд та Их Эзэний Ариун сүнсийг байлгах хэрэгтэй. “Уг Сүнс итгэлийн залбиралаар та нарт өгөгдөх болно,” “Сүнсийг эс хүлээн авбаас та нар заах нь үгүй” хэмээн Их Эзэн хэлсэн (С ба Г 42:14 мөн С ба Г 50:13–22 үз). Ариун сүнс жинхэнэ багш нь бөгөөд Их Эзэний Ариун Сүнс оршихуйц орчныг бүрдүүлэх нь чухал юм.

*Teaching, No Greater Call* номны 41–48-р хуудсаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

### *Сургаалыг заа*

Заахаасаа өмнө тухайн бүлгийг сайн судалж сургаалыг судалж ойлго. Мөн бүлгийн төгсгөлд өгөгдсөн нэмэлт судруудаас суралц. Бүлэгт зааж буй сургаал таны амьдралд нөлөөлж байсан тохиолдолд та агуу хүчтэйгээр, чин сэтгэлээсээ заах болно. Сүмийн сургаалыг хэзээ ч бүү гуйвуул. Зөвхөн Ариун сүнсээр чиглүүлэгдэн хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийн үгс, судруудад тулгуурлан заа (С ба Г 42:12–14; 52:9).

---

Та энэ номыг ашиглан чуулга болон ангид багшлахаар дуудагдсан бол өөр ямар ч сонирхолтой материал бүү ашигла. Зөвхөн номын үгс болон судруудыг ашигла. Тохиромжтой гэж үзвэл хичээлээ баяжуулах үүднээс хувийн туршлагауд болон Сүмийн сэтгүүлээс ашигла.

*Teaching, No Greater Call* номны 50–59-р хуудсаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

### *Хичээнгүй суралцахыг урь*

Сайн мэдээний зарчмуудыг өдөр тутмын амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болохыг харж жишээ авахуйцаар заа. Бурхан, гэр бүл, хөршүүд болон өөрсдийнхөө талаарх бидний сэтгэгдэлд эдгээр зарчмууд хэрхэн нөлөөлж болох тухай ярилцахыг урамшуулан дэмж. Оролцогсдыг зарчмуудын дагуу амьдрахад нь дэмжин урамшуул.

Хичээлд аль болох олон хүнийг хамруул. Та тэднийг чангаар унших, асуултанд хариулах, туршлагаасаа хуваалцахыг урьснаар хичээлд идэвхтэй оролцуулж болох боловч тэднийг ичээн сандаргах гэх мэт эвгүй байдалд оруулахгүй гэдэгтэй итгэлтэй байгаа тохиодолд л хий. Та хичээлд бэлтгэх явцдаа оролцогсдод урьдчилан даалгавар өгч болно. Бусдын хэрэгцээ, шаардлагад мэдрэмтгий бай. Хичээлийн өмнө хүмүүстэй биечлэн уулзаж, тэдэнд даалгавар өгч болох эсэхийг асуу.

*Teaching, No Greater Call* номны 61–74-р хуудсаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

### **Багш нарт туслах нэмэлт мэдээлэл**

Энэ номын бүрд бүрт багш нарт зориулсан нэмэлт тайлбарууд байгаа. Эдгээр тайлбар нь зааж буй хүмүүсээ хайрлах, Ариун Сүнстэйгээр заах, сургаалыг заах мөн суралцагсдыг хичээнгүйгээр суралцахыг урих зэрэг санаануудыг агуулдаг.





# Бидний Тэнгэрлэг Эцэг

## Бүлэг 1

---

### Бурхан оршдог

- Бурхан байдгийг гэрчлэх ямар зүйлс байдаг вэ?

Мормоны Номын бошиглогч Алма, “Бүх зүйл Бурхан байдгийг үзүүлдэг; тийм ээ, бүр газар дэлхий, мөн үүний гадаргуу дээрх бүр зүйл, тийм ээ, мөн үүний хөдөлгөөн, тийм ээ, мөн түүнчлэн өөрсдийн байнгын замаар хөдлөх тэр бүх гарагууд Эрхэм дээд Бүтээгч байдгийг гэрчилдэг юм”(Алма 30:44) хэмээн бичжээ. Бид шөнийн тэнгэрийг харж Алма юун тухай хэлснийг мэдэж болно. Төгс дэг журам, дараалалд цэгцлэгдсэн сая сая одод, гарагууд байдаг. Тэд зүгээр л тохиолдлоор тэнд байгаа юм биш. Бид тэнгэрт, мөн газар дээр Бурханы ажлыг харж чадна. Олон янзын ургамал, олон төрлийн амьтад, уул нурууд, гол мөрөн, бидэнд цас бороог авчрах үүлс—энэ бүхэн нь бидэнд Бурхан байдгийг гэрчилдэг.

Бошиглогчид Бурхан бол ертөнцийн Бүхнийг Удирдагч гэдгийг заасан. Бурхан тэнгэрт оршдог (С ба Г 20:17). Түүний Хүү, Есүс Христээр дамжуулан Тэр тэнгэр ба газрыг мөн тэдгээрийн дээрх бүх зүйлийг бүтээсэн билээ (3 Нифай 9:15; Мосе 2:1). Тэр сар, одод мөн нарыг бүтээсэн. Тэр энэ дэлхийг зохион байгуулж, түүнд хэлбэр дүрс, хөдөлгөөн мөн амьдралыг өгсөн. Тэр агаар, усыг амьд зүйлсээр дүүргэсэн. Тэр уул нурууд, хээр талыг төрөл бүрийн амьтдаар дүүргэв. Тэр өдөр ба шөнийг, өвөл ба зуныг, тариалах ба хураах цагийг бидэнд өгсөн. Тэрээр өөрийн бусад бүх бүтээлүүдийн удирдагч байлгахаар Өөрийн дүр төрхөөр хүнийг бүтээсэн (Эхлэл 1:26–27).

---

**Багшид зориулж:**Ярилцлагыг эхлэхдээ тухайн хэсгийн эхэнд байгаа асуултуудыг ашигла. Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг судар дээрээс дэлгэрэнгүй мэдэж ав. Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдээ уншсан зүйлийнхээ талаар, амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар тунгаан бодож, харилцан ярилцахад нь туслахын тулд тухайн хэсгийн төгсгөл дэх асуултуудыг ашигла.

Бурхан бол бидний итгэдэг, бидний шүтэн биширдэг Төгс, Агуу Нэгэн билээ. Тэр бол “ертөнцийн Агуу Эцэг” мөн Тэр “бүх хүн төрөлхтний дээрээс эцгийн хайр халамжаар, эцэг ёсоор харж ханддаг” (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 39).

### **Бурханы мөн чанар**

- Бурханы зарим мөн чанар юу вэ?

Бид Түүний дүрх төрхөөр бүтээгдсэн болохоор (Мосе 2:26; 6:9) бидний бие махбодь Түүний биетэй адилхан гэдгийг мэддэг. Түүний мөнхийн сүнс нь хүмүүнийхтэй адил мэдрэгдэх мах хийгээд ясан биетэй болой (С ба Г 130:22). Гэхдээ Бурханы бие юутай ч зүйрлэшгүй алдар сууд төгөлдөржин өргөмжлөгдсөн билээ.

Бурхан бол төгс. Тэр бол хайр, энэрэнгүй нинжин, үнэн, хүч чадал, итгэл, мэдлэг болон шүүлт зэрэг мөн чанаруудыг агуулсан зөв шударгын Бурхан. Түүнд бүх хүч бий. Тэр бүгдийг мэддэг. Тэр бол нинжин сэтгэлээр дүүрэн.

Хамаг сайн сайхан бүхэн Бурханаас ирдэг. Түүний хийж буй бүхэн нь хүүхдүүдээ Өөрийн адил төгс төгөлдөр болоход л оршдог. Тэр “Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө” гэж хэлсэн (Мосе 1:39).

- Бидэнд яагаад Бурханы мөн чанарыг ойлгох нь чухал вэ?

### **Бурханаа мэдэх нь**

- Бид Бурханыг хэрхэн мэдэх вэ?

Бурханыг мэдэх нь чухал гэдгийг Аврагч: “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” (Иохан 17:3) хэмээн хэлжээ.

“Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла” (Матай 22:37) хэмээн хэлсэн нь анхны бөгөөд агуу зарлиг билээ.

Бурханаа сайн мэдэх тусам бид Түүний зарлигуудыг сахиж, Түүнийг илүү хайрладаг (1 Иохан 2:3). Түүний зарлигуудыг сахиснаар бид Түүнтэй адил болж чадна.

Хэрэв бид хүсвэл Бурханыг мэдэж чадна. Үүний тул:

1. Тэр оршдог гэдэгт, Тэр бидэнд хайртай гэдэгт итгэ (Мозая 4:9).
2. судруудаас суралц (2 Тимот 3:14 17).
3. Түүнд хандан залбир (Иаков 1:5).
4. Бүхий л чадлаараа Түүний зарлигуудад дуулгавартай дага (Иохан 14:21 23).

Бид эдгээрийг хийх аваас Бурханаа мэддэг болж, эцэстээ бид мөнхийн амьдралыг авах болно.

- Бурхантай ойр байхын тул юу хийх ёстойг тунгаан бод.

### **Нэмэлт судрууд**

- Үйлс 7:55 56 (Хүү Эцэгийн баруун гар талд)
- С ба Г 88:41 44 (Бурханы мөн чанарууд)
- Дуулал 24:1 (дэлхий бол Их Эзэнийх)
- Мосе 1:30 39 (Бүтээлт)
- Алма 7:20 (Бурхан бурууг хийж чадахгүй)
- Иосеф Смит Түүх 1:17 (Эцэг ба Хүү салангид бодиуд)
- Алма 5:40 (сайн сайхан Бурханаас ирдэг)
- Иохан 14:6 9 (Хүү ба Эцэг адилхан)
- Мормон 9:15 20 (гайхамшгийн Бурхан)
- Амос 3:7 (илчлэлтийн Бурхан)
- Иохан 3:16 (хайрын Бурхан)



# Бидний Тэнгэрлэг гэр бүл

Бүлэг 2

---

## **Бид Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд**

- Бидний Бурхантай харилцах харилцааны талаар судрууд ба хожмын үеийн бошиглогчид юу гэж заадаг вэ?

Бурхан зөвхөн бидний Удирдагч, Бүтээгч биш; Тэр мөн бидний Тэнгэрлэг Эцэг билээ. Дэлхийн бүх хүмүүс угтаа Бурханы охид хөвгүүд юм. “Хүн зуурдын махан биебодийг олж, дэлхийд ирэхээс өмнө сүнсэн биеэр тэнгэрлэг эцэг эхээс төрсөн, Эцэгийн мөнхийн гэрт нас бие гүйцэн бойжсон” (*Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* [1998], 335)

Энэ дэлхийд төрсөн хүн бүр бидний сүнсэн ах, дүүс билээ. Бид Бурханы сүнсэн хүүхдүүд учир Түүний бурханлиг чанаруудыг өвлөн авах чадвартай байдаг. Бид Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болж, баяр баясгалангийн бүрэн байдлыг хүлээн авч чадна.

- Та өөрийгөө Бурханы хүүхэд гэдгээ мэдэх нь санаа бодол, үг хэллэг, үйлдэлд тань хэрхэн нөлөөлдөг бэ?

## **Бид Тэнгэрт амьдарч байхдаа хувийн зан чанар, авьяас билгээ хөгжүүлсэн.**

- Та өөрийн адислагдсан авьяас бэлгүүдийн талаар бод доо.

Бошиглогчид тэнгэрт сүнсэн биеэр байхдаа дэлхий дээр удирдагч болохоор бэлтгэгдсэн гэдгийг судрууд бидэнд заадаг (Алма 13:1–3). Тэд зуурдын махан биед төрөхөөс өмнө Бурхан

---

**Багш нарт зориулж:** Та бүлэгт байгаа бүхнийг заах шаардлагагүй. Та хичээлээ бэлтгэхдээ бүлгийн аль хэсгийн талаар ярихыг, ямар асуултууд асуухыг мэдэхийн тулд залбирч, Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийл.

тэднийг дэлхий дээр удирдагч байхаар урдчилан томилсон (сонгосон). Есүс, Адам, Абрахам нар тэдгээр удирдагчдын нэг билээ (Абрахам 3:22–23). Иосеф Смит “дэлхийн хүмүүсийг тохинуулах дуудлагатай хүн бүр онцгой зорилгын учир урьдчилан томилогдсон” тухай заадаг (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 511). Гэвч дэлхийн хүн бүр аливаа нэгэн үйлчлэл хийх боломжийг хүлээн авах эсвэл татгалзах чөлөөт эрхтэй.

Бүгд тэнгэрт байсантайгаа адил биш. Жишээ нь, бид бүгд тэнгэрлэг эцэг эхийн охид хөвгүүд гэдгээ мэддэг (“Тэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” ба *Ensign*, 11 сар. 1995, 102). Бид өөр өөр авьяас билэг, ур чадвартай бөгөөд дэлхий дээр өөр өөр зүйлс хийхээр дуудагдсан. Бид өөрсдийн патриархын адислалыг хүлээн авснаар өөрт байгаа “мөнхийн боломжуудын” талаар илүү сайн суралцаж чадна (Томас С.Монсон, in Conference Report, 10 сар. 1986, 82; *Ensign*, 11 сар. 1986, 66).

Бидний өмнөх амьдралын дурсамжууд хөшгөөр хаагдсан байдаг. Гэвч Тэнгэр дэх Эцэг энд ирэхийн өмнө бид юу хийж байсныг мөн бидний хэн болохыг минь мэддэг. Тэр хүн бүрийн төрөх цаг, газрыг нь сонгосон байдаг. Тиймээс хүн өөрсдийн сурах ёстой сургамжуудыг суралцаж, авьяас, хувийн шинж чанарыг ашиглан хамгийн сайныг хийх ёстой.

- Бусдын авьяас билэг таныг хэрхэн адисалсан бэ? Таны авьяас билгүүд бусдыг хэрхэн адисалж чадах вэ?

### **Тэнгэрлэг Эцэг бидэнд Өөртэйгөө адил болох төлөвлөгөөг өгсөн.**

- Биднийг Тэнгэрлэг Эцэгтэй адил болоход дэлхийн амьдрал хэрхэн тусалдаг вэ?

Бид Тэнгэрлэг Эцэгийн дэргэдээс хэсэг хугацаанд хол байхаас нааш бид хөгжиж дэвшихгүй гэдгийг Тэр мэдэж байлаа. Тэрээр биднийг бурханлиг шинжүүдийг хөгжүүлээсэй хэмээн хүсдэг. Ингэхийн тулд бид сорилтонд орж туршлагыг олж авахаар

---

**Багш нарт зориулж:** Хэрэв ангийн эсвэл гэр бүлийн гишүүдэд хариултынх нь талаар тунгаан бодох хугацааг өгвөл тэд илүү ухаалаг хариултыг өгөх болно. Жишээ нь: асуулт асуусныхаа дараа “ та хэсэг хугацаанд тунгаан бод. Тэгээд хариулна уу” гэж хэлээд бодох хугацаа өг.

дэлхийн өмнөх амьдралаа орхих хэрэгтэй байлаа. Бидний сүнс яс махан биебодьтой болох хэрэгтэй байсан. Бид нас барахад бие махбодоо орхих хэрэгтэй болдог ба дахин амилалтаар тэд дахин нийлэх болно. Тэгээд бид Тэнгэрлэг Эцэгийн адил мөхөшгүй биебодийг олох болно. Бид өөрт тулгарсан сорилтуудыг давах аваас Тэнгэрлэг Эцэгт байдаг баяр баясгалангийн бүрэн байдлыг хүлээн авах болно (С ба Г 93:30–34).

Тэнгэрлэг Эцэг бидний хөгжил дэвшлийн төлөөх төлөвлөгөөгөө танилцуулахаар Их зөвлөгөөнийг зарлан хуралдуулсан (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith*, 209, 511). Хэрэв бид Түүний төлөвлөгөөг дагавал Түүнтэй адил болно гэдгийг тэндээс суралцсан. Бид амилуулагдах болно. Бид тэнгэр ба газар дахь бүх хүчийг авах болно. Бид Түүнтэй адил сүнсэн хүүхдүүдтэй тэнгэрлэг эцэг эх болж болно (С ба Г 132:19–20).

Бид өөрсдийгөө нотлох дэлхийг Тэрээр бидэнд бий болгоно гэдгийг суралцсан (Абрахам 3:24–26). Хөшиг бидний өнгөрсөн дурсамжийг хааж, бид тэнгэрлэг гэрээ мартах болно. Энэ нь бид муу, сайныг сонгох өөрсдийн чөлөөт сонголтыг хийхийн тулд ингэх шаардлагатай байв. Ийм маягаар Их Эзэнээ мэдэх мэдлэгийн учир юм уу Түүнийг мэдэх дурсамжийн учир бус харин Түүнд итгэх өөрсдийн итгэлийн учир бид Түүнд дуулгавартай байж чадна. Дэлхий дээр бид үнэнийг дахин сонсох үед түүнийг танихад Тэр туслах болно (Иохан 18:37).

Их зөвлөгөөн дээр бид баяр баясгалангийн бүрэн байдлыг авах өөрсдийн дэвшил хөгжлийн зорилгын талаар суралцсан. Мөн зарим нь мэхлэгдэж, өөр замыг сонгон өөрсдийн үнэн замыг алдана гэдгийг ч суралцсан. Бид бүгдийн амьдралд өвчин эмгэг, гуниг гансрал, өвдөлт, харамсал, үхэл зэрэг саад тотгорууд байх болно гэдгийг мэдэж авсан. Гэхдээ эдгээр нь бидний сайн сайхан, өсөж хөгжихийн төлөө өгөгдсөн гэдгийг бид ойлгосон (С ба Г 122:7). Хэрэв бид хүсэх аваас, эдгээр саад тотгорууд нь биднийг бүтэлгүйтүүлэх бус харин цэвэр ариун болгоно. Тэдгээр нь тэсвэр хатуужил, тэвчээртэй энэрэнгүй байхыг бидэнд заах болно (*Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* [2006], 15–16).



Энэ зөвлөгөөний үеэр бид өөрсдийн сул талын улмаас бяцхан хүүхдээс бусад нь нүгэл үйлдэх болно гэдгийг суралцсан (С ба Г 29:46–47). Бидэнд Аврагчийг өгсөн тул бид нүглийг, мөн үхлийг давж дахин амилна гэдгийг суралцсан. Хэрэв бид Түүнд итгэн найдаж, Түүний үгэнд дуулгавартайгаар Түүний үлгэр жишээг дагах аваас бид өргөмжлөлийг олж, Тэнгэрлэг Эцэгтэй адил болно гэдгийг суралцсан. Бид баяр баясгалангийн бүрэн байдлыг хүлээн авах болно.

- Тэнгэрлэг Эцэгийн зарим мөн чанараас бич. Авралын төлөвлөгөө нь эдгээр мөн чанаруудыг өөртөө хөгжүүлэхэд хэрхэн туслах вэ?

### **Нэмэлт судрууд**

- Еврей 12:9 (Бурхан бол бидний сүнсэн Эцэг)
- Иов 38:4–7 (өмнөх амьдрал хөшгөөр хаагдсан)
- Абрахам 3:22–28 (өмнөх амьдралын тухай үзэгдэл)
- Иеремиа 1:5 (өмнөх амьдралын тухай үзэгдэл)
- С ба Г 29:31–38 (өмнөх амьдралын тухай үзэгдэл)
- Мосе 3:4–7 (сүнслэг ба зуурдын бүтээлүүд)
- 1 Коринт 15:44 (сүнслэг ба зуурдын бүтээлүүд)
- С ба Г 76:23–24 (хайртай охид хөвгүүд)
- С ба Г 132:11–26 (хөгжин дэвших төлөвлөгөө)

# Есүс Христ бидний сонгогдсон удирдагч буюу Аврагч

Бүлэг 3

---

## **Аврагч буюу удирдагч зайлшгүй хэрэгтэй байсан**

- Яагаад бид Тэнгэрлэг Эцэгийн дэргэдээс холдох хэрэгтэй болсон бэ? Яагаад бидэнд Аврагч хэрэгтэй вэ?

Бидний төлөөх авралын төлөвлөгөөг мөнх бус байдлын өмнөх сүнсний дэлхий дээр танилцуулах үед бид баярлалдан дуулж, уухайлан маш их баяртай байсан (Иов 38:7).

Бид тэнгэрлэг гэрээ хэсэг хугацаанд орхих хэрэгтэй гэдгээ ойлгож байв. Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд бид хамт амьдрахгүй болно. Түүнээс хол байх хугацаанд хүн бүр нүгэл үйлдэж, зарим нь бүр замаа алдах болно. Тэнгэрлэг Эцэг маань үүнийг мэдэж байсан ба хүн нэг бүрийг хайрладаг. Бидэнд тусламж хэрэгтэй гэдгийг Тэр мэдэж байлаа. Тиймээс Тэр бидэнд туслах замыг төлөвлөсөн.

Бидний нүглийн төлөөсийг төлж, Тэнгэрлэг Эцэг уруугаа хэрхэн буцаж очихыг заах Аврагч бидэнд хэрэгтэй байлаа. Бидний Эцэг “Би, хэнийг илгээх вэ?” гэв (Абрахам 3:27). Иехова хэмээн нэрлэгдэх Есүс Христ “Би энд байна, намайг илгээгтүн” гэж хэлэв (Абрахам 3:27; мөн Мосе 4:1–4).

Есүс дэлхийд ирж бидний нүглийг өөр дээрээ авч бидний төлөө амиа өгөхийг хүсч байлаа. Тэр яг Өөрийн Эцэгийн адил биднийг Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудад дуулгавартай байхыг сонгоосой хэмээн хүссэн. Өргөмжлөлийг олохоор зохистой байгаагаа батлахын тул бид чөлөөт сонголттой байх ёстой гэдгийг Тэр мэдэж

---



байсан. Есүс “Аав аа, таны таалал хэрэгжих болно, мөн алдар суу үүрд таных байх болно” гэж хэлсэн (Мосе 4:2).

Люсифер хэмээн нэрлэгдэх Сатан мөн ирж “Болгоогтун, би энд байна, намайг илгээгтүн, би таны хүү байх болно, мөн нэг ч бодгаль хаягдахгүйгээр бибээр хүн төрөлхтнийг гэтэлгэх болно, иймийн тул өөрийн алдар хүндэтгэлийг надад өгөгтүн” гэж хэлэв (Мосе 4:1). Сатан биднийг хүчлэн, бүгдийг өөрийнхөө хүслийн дагуу байлгахыг хүссэн. Түүний төлөвлөгөөгөөр бол бидэнд сонгох эрх байхгүй болох байлаа. Эцэгийн бидэнд өгсөн сонголт хийх эрх чөлөөг тэр үгүйсгэсэн. Сатан бидний авралаар ирэх бүх хүндэтгэл, алдар хүндийг авахыг хүссэн. Түүний санал болгосон төлөвлөгөөгөөр бол бидний дэлхийд ирэх зорилго маань сэтгэл гонсойлгосон зүйл болох байлаа (*Teachings of Presidents of the Church: David O. McKay* [2003], 207).

### **Есүс Христ бидний сонгогдсон удирдагч буюу Аврагч болсон**

- Энэ хэсгийг уншиж байхдаа Аврагчийн талаар юу мэдэрч байгаагаа бод.

Тэнгэрлэг Эцэг хоёр хүүгийнхээ юу хэлэхийг сонссоны дараа “Эхнийхийг би илгээх болно” хэмээн хэлэв (Абрахам 3:27).

Есүс Христ бидний Аврагч байхаар урьдчилан томилогдож, сонгогдсон. Олон судруудад энэ талаар бичсэн байдаг (жишээ болгон 1 Петр 1:19–20; Мосе 4:1–2 үз). Есүсийг төрөхөөс нэлээд өмнө Мормоны Номны бошиглогч Жаредын ахад үзэгддэг бөгөөд “Болгоогтун, өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр дэлхийн үүслээс бэлтгэгдсэн нь би болой. Болгоогтун, бибээр Есүс Христ. . . Надаар бүх хүмүүн төрөлхтөн амьдралыг, бүр миний нэрэнд итгэх тэд мөнхийн түүнийг хүртэх болно” гэж хэлснийг судар бидэнд хэлдэг (Ифер 3:14).

Есүс дэлхий дээр амьдарч байхдаа Тэр бидэнд “Би Өөрийнхөө хүслийг хийхийн тулд бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хийхийн тулд тэнгэрээс бууж ирсэн юм. . . Учир нь Хүүг харж, Түүнд итгэгч бүр мөнх амьтай байх нь Миний Эцэгийн хүсэл юм. Эцсийн өдөрт Би Өөрөө Түүнийг амилуулна” гэж айлдлаа (Иохан 6:38, 40).

## **Тэнгэр дэх дайн**

Тэнгэрлэг Эцэг маань бидний Аврагч байхаар Есүс Христийг сонгосон тул Сатан уурлаж, бослого дэгдээсэн. Тэнгэрт дайн гарлаа. Сатан болон түүнийг дагагчид мөн Есүс Христ болон Түүний дагагчид нарын хооронд дайн болов. Аврагчийг дагагчид “түүнийг [сатаныг] Хурганы цус болон өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ” (Илчлэлт 12:11).

Энэ агуу бослогын үед Сатан болон түүнийг дагасан олон сүнснүүд Бурханы оршихуйгаас хөөгдөж, тэнгэрээс зайлуулагдав. Тэнгэрийн оршин суучдын гуравны нэг нь Сатаныг даган цээрлүүлэгдэв (С ба Г 29:36). Тэд махан биебодийг хүлээн авахаас татгалзав.

Бид Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг дагана хэмээн сонгосон тул энэ дэлхий дээр төрж, махан биебодтой болсон. Сатан болон түүнийг дагагчид энэ дэлхий дээр сүнсэн биеэр байгаа. Тэд бидний хэн гэдгийг мартаагүй. Тэд өдөр бүр биднийг Тэнгэрлэг Эцэгт маань тааламжтай бус байх зүйлийг хийлгэж, уруу татахаар эргэн тойронд маань байдаг. Дэлхийн өмнөх амьдралд бид Бурханы төлөвлөгөөг авч, Есүс Христийг дагана хэмээн сонгосон. Бид энэ дэлхий дээр Есүс Христийг дагахаа үргэлжлүүлэх ёстой. Зөвхөн Түүнийг дагаснаар бид тэнгэрлэг гэртээ буцаж чадна.

- Тэнгэрийн дайн өнөө үед хэрхэн үргэлжилж байна вэ?

## **Дагах ёстой Аврагчийн сургаалууд бидэнд бий.**

- Аврагчийн сургаал та нарт хэрхэн нөлөөлсөн талаар бод.

Тэнгэрлэг Эцэг уруугаа буцаж очихын тулд юу хийх хэрэгтэйг заадаг сургаалыг Есүс Христ эхлэлээс эхлэн бидэнд илчилсэн. Товлосон цагт Тэр Өөрийн биеэр дэлхий дээр ирсэн. Өөрийн үгээрээ, амьдралын хэв маягаараа Тэрээр авралд мөн өргөмжлөлд хүрэх төлөвлөгөөг заасан. Тэр дэлхий дээр Өөрийн сүм, Өөрийн санваарын хүчийг бий болгосон. Тэр бидний нүглийг Өөр дээрээ авсан.

Түүний сургаалыг дагаснаар бид селестиал хаант улсыг өвлөн авч чадна. Биднийг Тэнгэрлэг Эцэгтээ буцан очиход туслах үүргээ Тэрээр биелүүлсэн. Одоо бид өргөмжлөлийг хүртэхээр зохистой байх ажлаа хийх л үлдээд байна.

### **Нэмэлт судрууд**

- Мосе 4:1–4; Абрахам 3:22–28 (Аврагч өмнөх дэлхийд сонгогдсон)
- С ба Г 76:25–29 (Тэнгэр дэх дайн)
- Илчлэлт 12:7–9, 11 (Тэнгэрт болсон дайнд Аврагчийг дагагчид сатаныг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлээр ялсан)
- Исаиа 14:12–15 (Люсифер яагаад хөөгдсөн бэ)

---

**Багш нарт зориулж:** Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг хувиараа, хоёр хоёроороо эсвэл баг болгон “Нэмэлт судрууд”-ыг судал.



# СОНГОХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүлэг 4

---

## Сонгох эрх нь мөнхийн зарчим юм

- Хэрэв хэн нэгэн танаас яагаад сонгох эрх чухал вэ гэж асуувал та юу гэж хариулах вэ?

“Өөрийнхөө төлөө сонгож болно, учир нь энэ нь чамд өгөгдсөн билээ” (Моисе 3:17).

Бурхан, бошиглогчдоороо дамжуулан сайн муугийн аль алиныг нь сонгох эрхийг бидэнд өгсөн гэдгээ хэлсэн. Есүс Христийг дагаснаар бид мөнхийн амьдрал болон эрх чөлөөг сонгож чадна. Мөн Сатаныг дагаж үхэл ба боолчлолыг сонгох эрхтэй (2 Нифай 2:27). Сайн ба муугийн аль нэгнийг сонгох ба өөрсдийн төлөө хийх үйлдлийг сонгох эрх гэдэг.

Дэлхийн өмнөх амьдралд бидэнд ёс суртахууны сонгох эрх байсан. Дэлхийн амьдралын нэг зорилго бол бид ямар сонголт хийхээ харуулах явдал (2 Нифай 2:27). Хэрэв бид сонгох эрхгүй байсан бол өөрсдийн төлөө ямар сонголт хийснээ харуулж чадахгүй байсан. Мөн бид өөрсдийн хүслээр сонголт хийснээр аз жаргалтай байдаг.

Дэлхийн өмнөх амьдрал дахь Тэнгэрийн зөвлөгөөнд хэлэлцсэн гол зарчмуудын нэг нь сонгох эрх байв. Энэ нь Христийг болон Сатаныг дагагчдын хооронд болсон маргааны гол шалтгаан нь байв. Сатан “Болгоогтун, би энд байна, намайг илгээгтүн, би таны хүү байх болно, мөн нэг ч бодгаль хаягдахгүйгээр бибээр хүн төрөлхтөнийг гэтэлгэх болно, мөн би үүнийг гарцаагүй хийх болно, иймийн тулд өөрийн алдар хүндэтгэлийг надад өгөгтүн” гэж хэлсэн (Моисе 4:1). Үүнийг хэлснээр тэр “[Бурханы] эсрэг бослого гаргасан хийгээд хүмүүний сонгох эрхийг устгахыг эрэлхийлсэн” (Моисе 4:3). Түүний саналыг татгалзаж, тэр дагалдагчдынхаа хамтаар тэнгэрээс хөөгдсөн (С ба Г 29:36–37).

---



## **Сонгох эрх нь Авралын төлөвлөгөөний чухал хэсэг**

Сонгох эрх нь бидний дэлхий дээрх амьдралыг сорилтын үе болгодог. Өөрийн хүүхдүүдийн мөнх бус бүтээлтийг төлөвлөж байхдаа Бурхан: “Бид Мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно” хэмээн хэлсэн (Абрахам 3:25). Сонгох эрх байхгүй бол бид Түүний зарлигласан бүгдийг хийж байна уу үгүй юу гэдгээ Тэнгэрлэг Эцэгтээ харуулж чадахгүй байлаа. Бидэнд сонгох эрх байгаа учраас бид өөрсдийн үйлдэлдээ хариуцлагыг хүлээдэг (Хиламан 14:30–31).

Бид Бурханы төлөвлөгөөний дагуу амьдрахад бидний сонгох эрх улам хүчирхэг болдог. Зөв сонголтууд нь илүү их зөв зүйл хийх хүчийг нэмэгдүүлдэг.

Эцэгийн зарлиг бүрт дуулгавартай байснаар зан төлөв минь хүчирхэгжиж, мэргэн ухаан минь тэлдэг. Бидний итгэл өсдөг. Бид зөв сонголтууд хийх нь амархан гэдгийг сурна.

Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд сүнсэн хүүхдүүд байхаас эхлэн бид сонголт хийсэн. Тэдгээр сонголтууд нь биднийг дэлхийд ирэхүйц зохистой болгосон. Тэнгэрлэг Эцэг маань бидний итгэл, хүч чадал, мэдлэг, мэргэн ухаан болон бусад сайн сайхан зүйлсийг өсч хөгжихийг хүсдэг. Хэрэв бид Түүний зарлигуудыг сахиж, зөв сонголтуудыг хийх аваас бид ихийг суралцаж ойлгох болно. Бид Түүнтэй адил болох болно (С ба Г 93:28).

- Зөв сонголтууд хийх нь цаашдаа зөв сонголт хийхэд хэрхэн тусалдаг вэ?

## **Сонгох эрх нь сонголттой байхыг шаарддаг**

- Яагаад сөрөг зүйл байх шаардлагатай вэ?

Хэрэв бидний өмнө сайн муу зүйлс байгаагүй бол бид зөв сонголт хийж чадахгүй байсан. Мормоны Номын агуу бошиглогч Лихай хүү Иаковт Бурханы мөнхийн зорилгуудыг авчрахын тулд “бүх зүйлд сөрөг тал байдаг. Хэрэв тийм бус аваас, аглаг буйдад төрсөн ууган хүү минь, зөв шударга нь бас ёсон бус ч, ариун нандин хийгээд зовлон шаналал ч, сайн муу ч тохиохгүй болой” гэж хэлсэн (2 Нифай 2:11).

---

Бурхан Сатанд сайныг сөрөхийг зөвшөөрсөн. Бурхан Сатаны талаар хэлэхдээ:

“Түүнийг Би доош хаягдахаар болгосон;

Мөн тэрээр Сатан, тийм ээ, бүр чөтгөр, хүмүүнийг мэхлэн мөн харалган болгох, мөн тэднийг, бүр миний дуу хоолойг үл сонсох болгоныг таалалдаа боолчлон хөтлөх бүх худал хуурмагийн эцэг болсон билээ” (Моисе 4:3–4) гэжээ.

Сатан Бурханы ажлын эсрэг чадах бүхнээ хийдэг. Тэр “бүх хүн төрөлхтний зовлонг эрэлхийлсэн. . . . Учир нь тэрээр бүх хүмүүн өөрийн адил зовлонг байж болохыг эрэлхийлдэг бөлгөө” (2 Нифай 2:18, 27). Тэр бидэнд хайргүй. Тэр бидэнд ямар ч сайн сайхан зүйлсийг хүсдэггүй (Моронай 7:17). Тэр биднийг аз жаргалтай байлгахыг хүсдэггүй. Тэр биднийг өөрийнхөө боол байлгахыг хүсдэг. Тэр биднийг боолчлох олон янзын башир аргыг хэрэглэдэг.

Бид Сатаны уруу таталтанд автагдсанаар сонголтоо хязгаарладаг. Тэр хэрхэн энэ бүгдийг хийдэг талаар доорх жишээнээс харж болно. Далайн эрэг дээр “Аюултай усны эргүүлэг. Энд сэлэхийг хориглоно” гэсэн тэмдэг байна гэж төсөөл. Энэ зүгээр л хориглох гэсэн хэрэг гэж бид бодож магад. Гэвч энэ тийм үү? Бидэнд олон сонголт бий. Бид өөр газар сэлж болно. Далайн эргээр алхаж, дунгийн хясаа цуглуулж болно. Бид нар жаргахыг харж болно. Бид гэртээ харьж болно. Мөн бид анхааруулгыг тоомсорлохгүйгээр аюултай газарт сэлж болно. Усны эргүүлэгт орж аюул тулгарах үед л бид сонголт бага үлдсэнийг ойлгох болно. Бид аюулаас зугтахыг хичээх юм уу эсвэл тусламж эрж ориловч, живж болзошгүй байдалд орсон байна.

Өөрсдийн хийх үйлдэлдээ бид сонгох чөлөөт эрхтэй байдаг ч үйлдлийнхээ үр дагаварыг сонгож чадахгүй. Үр дагавар нь сайн муу аль нь ч байсан бидний хийсэн сонголтын үр дүн болж дагадаг юм (Галат 6:7; Илчлэлт 22:12).

---

**Багш нарт зориулж:** Энгийн нэгэн зураг суралцагсдын анхаарлыг төвлөрүүлэхэд тусалж чадна. Хэрэв та энэ бүлэгт татсан анхааруулах тэмдгээр жишээ аван ярьж байгаа бол самбар дээр ямар нэгэн анхааруулах тэмдэг эсвэл анхааруулах үгсийг том цаасан дээр бичиж тавь.

Тэнгэрлэг Эцэг бидэнд Сатаны боолчлолоос хэрхэн зугтахыг хэлж өгсөн. Бид үргэлж Бурханаас сатаны уруу таталтыг даван тэсвэрлэх тусламжийг гуйн залбирч, сэрэмжлэх хэрэгтэй (3 Нифай 18:15). Тэнгэрлэг Эцэг маань биднийг хэрээс минь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй (1 Коринт 10:13; Алма 13:28).

Бурханы зарлигууд биднийг аюулаас холдуулж, мөнхийн амьдрал уруу чиглүүлдэг. Мэргэн ухаанаар сонголт хийснээр бид мөнхийн дэвшил хөгжлийг олж, төгс аз жаргалд баясан, өргөмжлөлийг авах болно (2 Нифай 2:27–28).

- Бидний сонголтыг хязгаарлах ямар үйлдлүүд байдаг вэ? Бидэнд эрх чөлөөг олгох ямар үйлдлүүд байдаг вэ?

### **Нэмэлт судрууд**

- Мосе 7:32 (сонгох эрх чөлөө)
- Абрахам 3:24–25 (дэлхийн амьдралын сорилт)
- Алма 41:3; Моронай 7:5–6 (шүүгдэх ажлууд)
- 2 Нифай 2:11–16 (сөрөг тал зайлшгүй шаардлагатай)
- Моронай 7:12–17 (сайн мууг сонгох нь)
- 2 Петр 2:19; Иохан 8:34 (нүгэл бол боолчлол)
- 2 Нифай 2:28–29; Алма 40:12–13 (хийснээр олох шагнал)

# БҮТЭЭЛТ

## Бүлэг 5

---

### **Бидэнд зориулсан Бурханы төлөвлөгөө**

- Яагаад бид дэлхийд ирэх хэрэгтэй болсон бэ?

Тэнгэрлэг эцэг биднийг сүнсэн хүүхдүүд байхад минь Өөртэйгөө адил болох төлөвлөгөөг хэлсэн. Бид Түүний төлөвлөгөөг сонсоод баярлан уухайлдсан (Иов 38:7 хар). Бид шинэ туршлага олж авахыг үнэхээр хүсч тэмүүлж байсан. Эдгээр зүйл тохиохын учир бид Эцэгийн оршихуйг орхиж, махан биебодийг хүлээн авах хэрэгтэй байлаа. Түүнтэй адил болоход бэлтгэх чадах өөр нэгэн амьдрах газар бидэнд хэрэгтэй байв. Бидний амьдрах шинэ газрыг дэлхий хэмээн нэрлэдэг.

- Авралын төлөвлөгөөний талаар сонсмогцоо бид яагаад баярлалдан уухайлдсан бэ?

### **Есүс дэлхийг бүтээсэн**

Есүс Христ дэлхий болон түүн дээрх бүгдийг бүтээсэн. Тэр мөн бусад олон дэлхийг бүтээсэн. Тэрээр үүнийг Тэнгэрлэг Эцэгийн удирдлаган дор санваарын хүчээр хийсэн. Бурхан Эцэг “Мөн тоо томшгүй олон дэлхийг бүтээсэн, . . . мөн миний Төрсөн Ганц болох Хүүгээр би тэдгээрийг бүтээлгэсэн юм” (Мосе 1:33). Бид энэ үнэний тухай олон гэрчлэлтэй. Иосеф Смит, Сидней Ригдон нар Есүс Христийг үзэгдэлд харсан. Тэд “ийнхүү түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс, дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугшид нь Бурханы төрсөн хөвгүүд хийгээд охид нь бөлгөө” хэмээн гэрчилсэн (С ба Г 76:24).

---

**Багш нарт зориулж:** Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийн заримд нь чангаар унших нь таатай бус байж болно. Тэднээс чангаар уншихыг хүсэхийн өмнө “Хэн унших вэ?” гэж асуух нь зохистой болов уу. Дараа нь сайн дураар уншихыг хүссэн хэн нэгнээр уншуул.



## **Бүтээлийг хийсэн нь**

- Бүтээлтийн зорилго нь юу вэ?

Дэлхий болон түүн дээрх бүх зүйл биетээр бүтээгдэхээсээ өмнө сүнслэг хэлбэрээр бүтээгдсэн байсан (Мосе 3:5). Одоо энэ байгаа дэлхийг бүтээхээс өмнө Түүнтэй байсан тэдэнд Христ ийн хэлжээ: “Бид доош явцгаах болно, учир нь тэнд орон зай буй, мөн бид эдгээр материалуудаас авч, мөн дээр нь тэд [Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд] оршин сууж болох дэлхийг бид хийх болно” (Абрахам 3:24).

Эцэгийн удирдлага дор Христ дэлхийг хэлбэрт оруулж, зохион байгуулсан. Тэр өдөр ба шөнө байж болохын тул гэрэл ба харанхуйг салгасан. Тэр нар, сар, оддыг бүтээсэн. Тэр далай, гол нуурыг хийхийн тулд хуурай газар ба усыг салгасан. Тэр үзэсгэлэнтэй бөгөөд өгөөжтэй дэлхийг хийсэн. Тэр өвс ногоо, модод болон бусад бүх төрлийн өвс ургамлыг бүтээсэн. Эдгээр өвс ургамал нь шинэ ургамлыг тариалах үртэйгээр хийгдсэн. Дараа нь Тэр загас, араатан амьтад, шавьж хорхой болон шувууд зэрэг олон төрлийн амьтдыг бүтээсэн. Эдгээр амьтад нь өөрийн үр удамдаа үлдээж өсөн хөгжих чадвартай.

Ийнхүү дэлхий бүх хүн төрөлхтний хамгийн агуу бүтээлд бэлэн болсон. Бидний сүнсэн биеүдэд яс махан биебодийг өгч дэлхий дээр амьдрах боломжтой болгосон. “Бурхан эхлэлээс надтай хамт байгаа, өөрийн Төрсөн Ганцад хэлэв: Өөрсдийн дүр төрхөөр, өөрсдийн адил төсөөр хүмүүнийг хийцгээе; мөн энэ нь үүнчлэн болов” (Мосе 2:26). Ингээд анхны эрэгтэй хүн Адам, анхны эмэгтэй хүн Ева нарыг тэнгэрлэг эцэг эхийн дүр төрхөөр хийж, яс махан биебодийг өгөв. “Бурхан өөрийн дүр төрхөөр эрэгтэй эмэгтэй хүмүүнийг бүтээв” (Эхлэл 1:27). Их Эзэн Өөрийн ажлыг сайн болсныг мэдэж байсан тул сэтгэл хангалуун байлаа. Тэгээд Тэрээр бүтээлтийг дуусгаад, хэсэг хугацаанд амрав.

## **Бурханы бүтээлүүд Түүний хайрыг илтгэдэг**

- Бурханы бүтээл хэрхэн Түүний бидэнд хайртайг харуулдаг вэ?

Бид одоо энэ үзэсгэлэнтэй дэлхийд амьдарч байна. Бидэнд гэрэл, дулааныг өгдөг нарны тухай бод. Дэлхийг цэвэр, цэмцгэр

болгодог элдэв цэцэгс ургамлыг тэжээгч борооны талаар бод. Шувууд жиргэхийг эсвэл найз нөхөд инээлдэн баясалдахыг сонсох нь ямар сайхан байдаг талаар бод. Ажиллаж, амарч, тоглож чадах бидний гайхалтай бие махбодийнхоо талаар бод. Бид эдгээр бүх бүтээлийн талаар эргэцүүлэн бодоход бидний Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ ямар энэрэнгүй нинжин сэтгэлтэй, хүчирхэг, мэргэн ухаантай болохыг ойлгох болно. Тэд бидний бүх хэрэгцээг хангах зүйлсийг бий болгож, бидэнд агуу хайраа үзүүлсэн.

Ургамал, амьтад мөн бидэнд баяр баяслыг авчрахаар бүтээгдсэн. Их Эзэн “Тийм ээ, дэлхийгээс, өөр өөрсдийн цагт ирдэг бүх зүйл, хүмүүний тусын тулд мөн ашиглалтын тулд, нүд баясгах хийгээд сэтгэл баярлуулах аль алиных нь тулд хийгдсэн болой” гэжээ (С ба Г 59:18–19). Бурханы бүтээлүүд хэдийгээр маш олон ч Тэрээр бүтдийг нь мэддэг мөн хайрладаг билээ. Тэр “Бүх зүйл надад тоологддог буюу, учир нь тэдгээр нь минийх бөгөөд мөн би тэдгээрийг мэддэг” гэж хэлсэн (Моше 1:35).

- Талархалтай байдаг ямар ямар Бурханы бүтээл байдаг вэ?

### **Нэмэлт судрууд**

- Эхлэл 1; 2:1–7; Абрахам 3:22–23; 4–5; Моше 1:27–42; 2–3 (Бүтээлтийн талаарх шүлгүүд)
- Еврей 1:1–3; Колоссай 1:12–17; С ба Г 38:1–3 (Есүс бол Бүтээгч)
- С ба Г 59:18–20; Моше 2:26–31; С ба Г 104:13–17; Матай 6:25–26 (Бүтээлт Бурханы хайрыг үзүүлдэг)

# Адам Ева нарын уналт

## Бүлэг 6

---

### Дэлхийд анх Адам Ева нар ирсэн

- Адам Ева нар баатарлаг сүнснүүд байсныг бидэнд юу нотолдог вэ?

Хүүхдүүдийнхээ амьдрах гэр болгохоор Бурхан энэ дэлхийг бэлтгэсэн. Адам Ева нар дэлхий дээр амьдрах анхны хүмүүс байхаар сонгогдсон (Мосе 1:34; 4:26). Эцэгийн төлөвлөгөөн дэх тэдний гол үүрэг нь дэлхийд хүмүүнийг авчрах байлаа. Тэд анхны эцэг эх байхаар сонгогдсон (С ба Г 107:54–56).

Адам Ева нар Эцэгийн сурвалжит хүүхдүүдийн нэгэн. Сүнсний дэлхийд Адамыг Михаил хэмээн дууддаг байв (С ба Г 27:11; Иуда 1:9). Тэр Сатаны эсрэг тулаанд зөв шударгыг удирдахаар Тэнгэрлэг Эцэгээр сонгогдсон (Илчлэлт 12:7–9). Адам Ева нар бидний анхны эцэг эх байхаар урьдчилан томилогдсон. Их Эзэн Адамд агуу амлалтыг өгсөн: “Бибээр чамайг тэргүүнд байхаар болголоо; олон үндэстэн чамаас ирэх болно, мөн чи тэдний дээр үүрд хунтайж бөлгөө” (С ба Г 107:55).

Ева “амьд бүхний эх байв” (Мосе 4:26). Бурхан Адам Ева нарыг хамтдаа байж, эхнэр нөхөр болгосон. Учир нь “хүн ганцаар байх нь сайн биш” (Мосе 3:18; мөн 1 Коринт 11:11). Ева нь Адамын үүрэг хариуцлага болон түүний мөнхийн адислалыг хуваалцах болно.

- Адам Ева нарын туршлагаас бид юу суралцаж болох вэ?

---

**Багш нарт зориулж:** Хэсгийн эхэнд байгаа асуултаар ярилцлагыг эхлүүл. Хичээлээс илүү мэдээлэл олж болохыг хэл. Бүлгийн төгсгөлд байгаа асуултуудыг ашиглан, уншсан зүйлээсээ өөрсдийн амьдралд хэрэгжүүлж болох зүйлсийн талаар тунгаан бодож, ярилцахыг урь.





## Едений цэцэрлэг

- Адам Ева нар Едений цэцэрлэгт ямар нөхцөл байдалд байсан бэ?

Адам Ева нар Едений цэцэрлэгт аваачигдах үед мөнх бус амьдралыг хараахан аваагүй байсан. Тиймээс “тэд хүүхдүүдгүй байлаа” (2 Нифай 2:23). Үхэл гэж байсангүй. Тэдний сүнс дэлхийн тоосноос хийгдсэн амьд бодгаль өмссөн учир тэд *жам ёсны* амьдралтай байв (Мосе 6:59; Абрахам 5:7). Тэд Бурханы оршихуйд байсан учир тэд *сүнслэг* амьдралтай байв. Тэд хараахан сайн муугийн хооронд сонголт хийгээгүй байв.

Бурхан тэдэнд хүүхэдтэй болохыг тушаасан. Тэр “Үр жимстэй байгтун, мөн өсөн үржиж, мөн үүнийг захирч, . . . мөн газар дэлхий дээр хөдлөн явдаг амьдрагч зүйл бүхний дээр эзэгнэлтэй байгтун” (Мосе 2:28) хэмээсэн. Бурхан тэдэнд тэд ганцхан сайн ба муугийн мэдлэгийн мод /амьдралын мод/-ноос бусад цэцэрлэгийн юм бүхнээс чөлөөтэй идэж болно хэмээн тушаасан. Бурхан энэ модноос “түүнээс идсэн тэр өдөртөө чи гарцаагүй үхэх болно” (Мосе 3:17).

Сатан Бурханы бодлыг мэдээгүй ч Бурханы төлөвлөгөөг нураахын тулд Едений цэцэрлэгт Ева дээр ирсэн. Тэр сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс идүүлэхээр Еваг уруу татсан. Та нар үхэхгүй ээ, харин “сайн ба мууг мэдсэнээр та нар бурхад шиг болох болно” гэж ятгасан (Мосе 4:11). Ева уруу таталтанд автаж, жимснээс идсэн. Юу болсныг Адам мэдээд мөн жимснээс амсахаар сонгосон. Жимснээс хүртсэний улмаас Адам Ева нарт ирсэн өөрчлөлтийг Уналт гэдэг.

## Адам Ева нар Бурханаас холдуулагдсан нь

- Тэдний зөрчлийн улмаас Адам Ева нарт биеийн болон сүнслэг ямар өөрчлөлт ирсэн бэ?

Сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс Адам Ева нар идсэн учир Их Эзэн тэднийг Едений цэцэрлэгээс гаргаж, дэлхий уруу илгээсэн. Тэд хориглогдсон жимснээс идсэний учир биеийн нөхцөл байдал нь өөрчлөгдсөн. Бурханы амласнаар тэд мөнх

бус болсон. Тэд болон тэдний хүүхдүүд өвчин зовлон, өвдөлт ба биеийн үхэл үзэх болсон.

Тэдний зөрчлийн улмаас Адам Ева нар мөн сүнсний үхэлд зовсон. Энэ нь тэд болон тэдний хүүхдүүд Бурхантай нүүр тулан зэрэгцэн алхаж, ярьж чадахгүй болсон үг байв. Адам Ева болон тэдний хүүхдүүд биеэр болон сүнслэгээр Бурханаас холдуулагдсан.

### **Зөрчлөөс агуу адислалуудад**

- Уналт хэрхэн бидэнд Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болох боломжийг өгсөн бэ?

Зарим хүмүүс Адам ба Ева нар сайн ба муугийн мэдлэгийн модноос хүртсэнээр агуу нүглийг үйлдсэн гэж итгэдэг. Гэвч хожмын үеийн судрууд тэдний Уналт нь бидний амьдралын төлөвлөгөөний чухал алхам бөгөөд бид бүгдэд агуу адислал болсон гэдгийг ойлгоход тусалдаг. Уналт байсан учир бид сайн мууг сонгох эрх, мөнхийн амьдралыг олох боломжтой махан биебодиор адислагдсан. Адам Ева нарын цэцэрлэгт олж авсан зүйл байгаагүй бол эдгээр боломжийн аль нь ч биднийх болохгүй байсан.

Уналтын дараа Ева “Хэрэв бидний зөрчил байгаагүй сэн бол бид хэзээ ч үр удамгүй байх байсан, мөн сайн ба мууг, мөн бидний гэтэлгэлийн баяр баясгаланг, мөн дуулгавартай бүгдэд Бурханы өгсөн мөнх амьдралыг бид хэзээ ч мэдэхгүй байх байсан” гэж хэлсэн (Мосе 5:11).

Бошиглогч Лихай үүнийг тайлбарлахдаа:

Мөн эдүгээ, болгоогтун, хэрэв Адам зөрчил үйлдээгүй аваас тэрээр унахгүй [Бурханы оршихуйгаас хөөгдөхгүй], харин тэр Едений цэцэрлэгт үлдэх байсан билээ. Мөн бүтээгдсэн бүх зүйл тэд бүтээгдсэнийхээ дараа байсан тэр байдлаараа нэгэн адил үлдэх ёстой байсан бөлгөө. . . .

“Мөн тэд хүүхдүүдгүй байх байсан; иймийн тул тэд зовлонг мэдээгүйн учир, баясал үгүй, гэм зэмгүй гэнэн байдалдаа үлдэх байсан; тэд нүглийг мэдэхгүй учир сайныг эс үйлдэх байсан билээ.

“Гэвч болгоогтун, бүх зүйл, бүхнийг мэдэгч түүний мэргэн ухаанд хийгдсэн билээ.

“Адам хүмүүн байж болохын тулд унасан; мөн тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө” (2 Нифай 2:22–25).

- Яагаад бид Уналтын талаар мэдэх нь чухал вэ? Уналт хэрхэн бидэнд нөлөөлдөг бэ?

### **Нэмэлт судрууд**

- 1 Нифай 5:11; 2 Нифай 2:20 (Адам Ева нар анхны эцэг эх, гэр бүл)
- 2 Нифай 2:14–21 (Уналт ба сөрөг тал; амьдрал бол сорилт)
- 2 Нифай 2:22–26 (Уналт авралын төлөвлөгөөний нэг хэсэг)

# Ариун Сүнс

Бүлэг 7

---

## Ариун Сүнс Адам Ева нар дээр ирсэн

- Яагаад Адам Ева нарт Ариун Сүнсний удирдамж хэрэгтэй байсан бэ?

Адам Ева нар Едений цэцэрлэгийг орхисны дараа тэд амьдрахын төлөө бусад ажил үүргийн тул ажиллаж, духныхаа хөлсийг дуслуулан байж талхаа олж идэхийн тулд газар боловсруулж эхлэв. Тэд олон хөвгүүд охидыг төрүүлж, мөн тэд өсөн үржиж гэрлэн мөн өөрсдийн хүүхдүүдтэй болов (Мосе 5:1–3). Ийнхүү тэдэнд амлагдсаны дагуу Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд дэлхийд ирэхээр Түүний оршихуйг орхиж эхлэв (Абрахам 3:24–25). Тэднийг дэлхийд ирэх үед тэнгэрлэг гэрийн тухай дурсамж нь авагддаг. Гэхдээ бидний Эцэг Түүний нөлөөнөөс бүр гаргадаггүй. Түүний бүх сүнсэн хүүхдүүдийг газарчлан туслах мөн тайвшруулах Ариун Сүнсийг Тэр илгээсэн.

Адам Ева нар Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирсан. Тэр тэдэнтэй ярьж, тэд дуулгавартай сахих ёстой зарлигуудыг өгсөн. Их Эзэний тэнгэр элч Адам Ева нар дээр ирж авралын төлөвлөгөөг заасан. Их Эзэн Адам Ева нарт сургаалыг зааж, Эцэг ба Хүүт гэрчлэх Ариун Сүнсийг илгээсэн (Мосе 5:4–9).

Ариун Сүнсний хүчээр Адам “дэлхийн бүх гэр бүлийн талаар бошиглож эхлэв: Бурханы нэр адислагдаг, учир нь миний зөрчлийн улмаас нүд минь нээгдсэн буюу, мөн энэ амьдралд баяр хөөртэй байх болно, мөн махан бодид бибээр Бурханыг дахин харах болно” (Мосе 5:10). Ева Ариун Сүнсээр гэрчлэлийг олж

---

**Багш нарт зориулж:** Таныг ангийнхаа эсвэл гэр бүлийнхээ гишүүдийг нэрээр нь дуудах үед тэднийг халамжлан, тэд таны хувьд чухал хүмүүс гэдгийг мэддэг. Тэдний нэрийг тогтоо. Хичээлийн явцад нэрээр нь хандан ярь. Бие биенийхээ нэрийг тогтооход нь тусал. .

“Хэрэв бидний зөрчил байгаагүй сэн бол бид хэзээ ч үр удамгүй байх байса, мөн сайн ба мууг, мөн бидний гэтэлгэлийн баяр баясгаланг, мөн дуулгавартай бүгдэд Бурханы өгсөн мөнх амьдралыг бид хэзээ ч мэдэхгүй байх байсан” (Мосе 5:11).

- Адам Ева нарт байсан Ариун Сүнсний удирдамж бидэнд яагаад хэрэгтэй вэ?

### **Ариун Сүнсний мөн чанарууд**

- Ариун Сүнс Эцэг ба Хүүгээс юугаараа өөр вэ? Яагаад энэ ялгаа бидэнд чухал вэ?

Ариун Сүнс Бурханлаг бүрэн байдлын нэг гишүүн (1 Иохан 5:7; С ба Г 20:28). Тэр бол “Сүнсэн хүн” (С ба Г 130:22). Тэр нэгэн мөчид зөвхөн нэг газар байж чадах ч Түүний нөлөө нь нэгэн мөчид газар бүрт байж чадна.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ ба Ариун Сүнс гурвыг Бурханлаг бүрэн байдал гэж нэрлэдэг. Тэд нэгэн зорилгын учир нэгддэг. Авралын төлөвлөгөөнд тус бүрдээ чухал үүргийг гүйцэтгэдэг. Тэнгэрлэг Эцэг маань бидний Эцэг бөгөөд удирдагч. Есүс Христ бол бидний Аврагч. Ариун Сүнс бүх үнэнийг илчлэгч бөгөөд гэрчлэгч.

Ариун Сүнс бидний Тэнгэрлэг Эцэгийн зарлага бөгөөд бидэнд өгсөн онцгой бэлэг (энэ номны 21-р бүлгийг үз).

### **Ариун Сүнсний ажил**

- Бидэнд Ариун Сүнсний илчилдэг үнэнээс хэлнэ үү?

Ариун Сүнсний ажил бол Эцэг ба Хүүт мөн бүх зүйлийн үнэнийг гэрчлэх юм.

Ариун Сүнс бидэнд Есүс бол бидний Аврагч ба Гэтэлгэгч гэдгийг гэрчлэх болно (3 Нифай 28:11; С ба Г 20:27). Тэнгэрлэг Эцэг бол бидний сүнсний Эцэг гэдгийг Тэр гэрчлэх болно. Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил өргөмжлөгдөж болно гэдгийг Тэр бидэнд гэрчлэх болно (Роман 8:16–17). Их Эзэний бошиглогчид “Ариун сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно” хэмээн амласан (Моронай 10:5).

Ариун Сүнсгүйгээр бид Есүс бол Христ гэдгийг мэдэж чадахгүй. Төлөөлөгч Паул бичихдээ, “Тиймээс хэн ч Бурханы Сүнсээр бус бол өөр хэн ч ‘Есүс бол Эзэн’ гэж хэлж чадахгүй гэдгийг би та нарт мэдэгдье” (1 Коринт 12:3) гэжээ. Аврагч Өөрөө, “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” (Иохан 17:3) гэжээ. Ариун сүнсний хүчээр бид Есүс Христийн сайн мэдээг ойлгож, түүгээр амьдардаг.

Ариун сүнсний хөрвүүлэх хүч нь үнэхээр агуу бөгөөд бидэнд Тэр үнэнийг илчилдэг гэдэгт эргэлзэх зүйлгүй. Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит:

“Хүн Ариун сүнсний тунхаглалыг авахад түүний бодгаль дахь үл мартагдах сэтгэлийн элдэв зовнил, үнэхээр мартагддаггүй тэр мэдрэмж амархнаар арилан, мартагддаг. Энэ нь Ариун сүнс бидний сүнсэтэй ярьж байгаа нь тэр бөгөөд энэ нь хөрвүүлэх хүчтэйгээр ирдэг. Тэнгэр элч эсвэл бүр Бурханы Хүүгийн Өөрөө хийх тэр тунхаглал оюун санаа болон нүдэнд минь нэлээд сэтгэгдлийг үлдээж болох ч эцэстээ унтарч болох юм. Харин Ариун Сүнсний мэдрэмж бодгальд гүнзгийгээр шингэдэг ба үүнийг арилгахад хэцүү” (*Answers to Gospel Questions*, comp. Бага Жозеф Филдинг Смит, 5 vols. [1957–66], 2:151).

Ерөнхийлөгч Смит мөн, “Үнэн нь Ариун Сүнсээр дамжуулан биеийн хамаг судас, шөрмөс булчинд нэвчин орж хэзээ ч мартагдахгүй болдог” гэжээ (*Doctrines of Salvation*, comp. Bruce R. McConkie, 3 vols. [1954–56], 1:48).

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бид өөрсдийгөө энэ онцгой зарлагыг хүлээн авах зохистой байж, Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христийн гэрчлэгч байх ёстой.

- Ариун сүнс таны гэрчлэлийг өсөхөд тусалсан тэр үеүдийн талаар бод. Боломжтой бол, эдгээр туршлагаасаа ангийн эсвэл гэр бүлийн гишүүдтэй хуваалц.

### **Нэмэлт судрууд**

- Мосе 5 (Адамын гэр бүлийн тухай түүх)
- С ба Г 130:22 (Ариун Сүнсний тодорхойлолт)
- Иохан 14:26; 15:26; 16:13; Лук 12:12; 2 Нифай 31:18; 32:5, 8; 33:1; Алма 14:11; 3 Нифай 27:20; 4 Нифай 1:48; Моронай 10:6–7; С ба Г 8:2–3; 11:12–13; 20:26 (Ариун Сүнсний үүрэг роль)





# ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГТЭЭ ХАНДАН ЗАЛБИРАХ НЬ

Бүлэг 8

---

## **Залбирал гэж юу вэ?**

Есүс “Тиймийн тул та нар миний нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой” хэмээн заасан (3 Нифай 18:19).

Залбирал нь дэлхий дээрх хамгийн агуу адислалуудын нэг юм. Бид залбирлаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэй хамт байж, өдөр бүр Түүний удирдамжийг эрэлхийлж чадна.

Залбирал нь зүрхний гүнээс Тэнгэрлэг Эцэгтэй ярих чин сэтгэлийн зүйл юм. Бид өөр хэнд ч бус зөвхөн Бурхандаа залбирах ёстой. Өөр ямар ч зүйлд бүү залбир эсвэл хүний хийсэн ямар ч зүйлд бүү залбир (Египетээс гарсан нь 20:3–5).

## **Бид яагаад залбирдаг вэ?**

Дэлхийн эхлэлээс залбирал сайн мэдээний чухал хэсэг байсан. Их Эзэний тэнгэр элч Адам ба Евад наманчлалыг хийж, Хүүгийн нэрээр Бурханд хандан залбир хэмээн тушаасан (Мосе 5:8). Энэ зарлигийг хэзээ ч буцааж аваагүй. Залбирал биднийг Бурхантай ойр болгодог. Бидний бүх бодол санаа, үг, үйлдэл бидний залбирлаар нөлөөлөгддөг.

Сатан болон түүний дагалдагчдын уруу таталтыг сөрөн зогсох хүчийг гуйн залбирах ёстой (3 Нифай 18:15; С ба Г 10:5).

---

**Багш гарт зориулж:** Энэ бүлэг таван сэдэвт хуваагдсан болно. Сэдэв бүрт залбирлын тухай асуулт байгаа. Эдгээр асуултуудыг хичээлийн удирдамж болгон ашиглаж болно. Хэрэв ангийн гишүүдийг жижиг бүлэгт хуваан суулгах боломжтой бол хоёр юм уу дөрвөн баг болго. Баг бүрт бүлгийн нэг хэсгийг хэлэцүүлэхээр өг. Тэд өөрсдийн авсан хэсгийг уншиж хэлэлцэн, түүнтэй хамаатай өөрийн туршлагаас хуваалц. Дараа нь баг бүр нэгдэн ангийн гишүүдийн анхаарлыг илүү татах асуултуудын дагуу таван сэдвээр ярилц.

Бурханд нүглээ наманчлан, биднийг уучлахыг хүсэн залбирах ёстой (Алма 38:14).

Өдөр тутмын амьдралд туслах Их Эзэний удирдамж хүсэн залбирах ёстой. Бид өөрсдийн гэр бүл, найз нөхөд, хөрш болон ургац, амьтад, өдөр тутмын ажил ба бусад үйл ажиллагаануудын төлөө залбирах ёстой. Биднийг дайснаудаас минь хамгаалахыг хүсэн залбирах ёстой (Алма 34:17–27).

Тэнгэрлэг Эцэгтээ өөрсдийн хайраа илэрхийлэн, Түүнд ойр байж илүүтэйгээр Түүнийг мэдрэхийн төлөө залбирах ёстой. Бидэнд өгдөг халамж, амар амгалан болон өдөр бүр өгдөг олон зүйлийнх нь төлөө Түүнд талархлаа илэрхийлэн залбирах ёстой (1 Тесалоник 5:18). Сайн мэдээний дагуу амьдрах хүчийг хүсэн Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирах ёстой.

Мөнхийн амьдрал уруу хөтлөх нарийн бөгөөд шулуун зам дээр байлгахын төлөө бид залбирах ёстой. Өөрсдийн бодол санаа, үг, үйлдэлдээ зөв шударга байхын төлөө зөв шударгыг зохиогч Бурхандаа хандан бид залбирах ёстой.

- Залбирал хэрхэн та нарыг Их Эзэнд ойр байлгадаг вэ?

### **Хэзээ бид залбирах ёстой вэ?**

Тэнгэрлэг Эцэгтэй харьцах хэрэгтэй гэж үзсэн үедээ хэзээ ч хамаагүй чимээгүй эсвэл чангаар залбирч болно. Заримдаа бид цор ганцаар байж, өөрсдийн бодгалийг Түүнд хандан юүлэх хэрэгтэй байдаг (Матай 6:6). Мөн бид өдөр тутмын үйл ажиллагаанууддаа залбирч чадна. Бид Сүмийн цуглаан дээр, гэртээ, гудамжаар алхаж явахдаа, ажиллаж байхдаа, хоол хийж байхдаа, эсвэл байж болох газар бүртээ, хийж байгаа зүйлдээ залбирч чадна. Бид өдөр шөнийн алинд нь ч залбирч чадна. Ганцаар байхдаа эсвэл бусад хүмүүстэй байхдаа ч бид залбирч чадна. Тэнгэрлэг Эцэгийг бид дандаа өөрсдийн бодол санаандаа байлгаж чадна (Алма 34:27). Бид “ямагт залбирч” чадна (С ба Г 10:5).

Зарим үед бид залбирах хүсэлгүй байж магадгүй. Бид ууртай эсвэл зориг мохсон эсвэл сэтгэлээр унасан байж магадгүй. Ийм үед бид залбирах онцгой хичээл зүтгэл гаргах хэрэгтэй (2 Нифай 32:8–9).

---

Хүн бүхэн өглөө бүр, орой бүр хувийн залбирлыг хийх хэрэгтэй. Судрууд өглөө, өдөр, оройд залбирах талаар хэлдэг (Алма 34:21).

Бидний гэр бүл адислагдаж болохын тул гэр бүлийн залбирлыг хий хэмээн тушаасан (3 Нифай 18:21). Манай Сүмийн удирдагчид гэр бүлээрээ өглөө, оройн залбирлыг хийж байхыг бидэнд зөвлөсөн.

Бид мөн хоолоо идэхийн өмнө идэх хоол хүнс өгсөнд талархан залбирах боломжтой.

Бид Сүмийн цуглаануудыг залбирлаар эхэлж, залбирлаар дуусгадаг. Түүний тааллыг авч, бишрэн шүтэх арга барилд, Түүний тусламжийг хүсч Түүний адислалуудынх нь төлөө Их Эзэнд талархаж болно.

### **Бид яаж залбирах ёстой вэ?**

Бид сууж эсвэл өвдөглөсөн байна уу, чангаар эсвэл чимээгүй залбирч байна уу, хувийн эсвэл бүлгээрээ залбирч байна уу, хаана байгаа нь хамаагүй бид үргэлж итгэлтэй байж “чин сэтгэлээсээ, үнэн хүсэлтэйгээр” залбирах ёстой (Моронай 10:4).

Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирахдаа бид зүрх сэтгэлд байгаа бүхнээ Түүнд даатган, Түүнээс уучлалтыг хүсч, Түүнтэй хамт залбиралд умбаж, Түүнд талархаж өөрсдийн хайрыг Түүнд үзүүлэх хэрэгтэй. Бид ач холбогдол багатай үг, хэллэгийг давтах ёсгүй (Матай 6:7–8). Бидний хувьд өөрсдийн минь хүсэлтийм ч сайн зүйл биш байж магадгүй тул бид үргэлж Таны хүсэл биелэх болтугай хэмээн залбирах ёстой (3 Нифай 18:20). Залбирлынхаа төгсгөлд бид Есүсийн Христийн нэрээр гэж дуусгах ёстой (3 Нифай 18:19).

### **Хэрхэн залбирлууд маань хариулагддаг вэ?**

- Залбирлын хариу яагаад тэр дороо тодорхойгоор хариулагддаггүй гэж бодож байна? Яагаад залбирлын хариу бидний хүссэн үед эсвэл бидний хүссэнээр хариулагддаггүй вэ?

Бидний чин сэтгэлийн залбирал үргэлж хариулагддаг. Учир нь бидний асуусан зүйл бидэнд сайн зүйл биш байсан тул

заримдаа хариулт үгүй гэж болно. Заримдаа хариулт нь тийм гэж ирэх бөгөөд бид хийх ёстой зүйлийн талаар дулаан, амар амгалан мэдрэмжийг авдаг (С ба Г 9:8–9). Заримдаа хариу нь “бага зэрэг хүлээ” гэж болно. Бидний залбирал бидэнд илүүтэйгээр тусалж болох Их Эзэний мэддэг тэр замаар Түүний цагт үргэлж хариулагддаг.

Заримдаа Их Эзэн бидний залбирлыг бусад хүмүүсээр дамжуулан хариулдаг. Дотнын найз, нөхөр юм уу эхнэр, эцэг эх эсвэл гэр бүлийн бусад гишүүд, Сүмийн удирдагч, бүрэн цагийн номлогч—эдгээр хүмүүсийн хэн нь ч гэсэн бидний залбиралд хариулах үйлдлийг үзүүлэхээр өдөөгдөж болно. Үүний нэг жишээ бол гэр-тээ осолд орсон бяцхан хүүхдийн залуу эхийн туршлага байна. Залуу эх хүүхдээ эмч уруу авч явах ямар ч аргагүй болсон байв. Тэр хөршүүдээ танихгүй шинэхэн ирсэн байв. Залуу эх тусламж хүсэн залбирчээ. хэсэг хугацааны дараа хөрш нь ирж хаалга тогшин, “Танд ямар нэгэн тусламж хэрэгтэй юм шиг санагдаад асуухаар ирлээ” гэв. Хөрш залуу эхэд хүүхдээ эмч уруу аваачин үзүүлэхэд нь туслав.

Ихэвчлэн Бурхан бидний хувийн залбирлуудын хариулалтанд туслах хүчийг өгдөг. Бид тусламж хүсэн залбирахдаа өөрсдийн гүйцэтгэхийг хүсч байгаа зүйлийнхээ төлөө өөрсдөөсөө шалт-гаалах бүхнийг хийх ёстой.

Бид тогтмол залбиралтайгаар Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрах аваас бид аз жаргал, баяр баясгалантай байх болно. “Чи даруу бай; тэгвэл чиний Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь чамд хариу өгөх болно” (С ба Г 112:10).

- Ямар замаар Их Эзэн залбиралд чинь хариулдаг вэ?

**Нэмэлт судрууд ба бусад нөөцүүд**

- Иаков 1:5 (юуны төлөө залбирах вэ)
- 1 Тесалоник 5:17; Дуулал 55:17; 2 Нифай 32:9 (хэзээ залбирах вэ)
- Алма 34:26 (хаана залбирах вэ)
- 3 Нифай 19:6, 24 (яаж залбирах вэ)
- С ба Г 88:63–65 (залбирлууд хэрхэн хариулагддаг вэ)
- Моронай 10:3–5; Алма 37:37 (залбирлын амлалтууд)
- Иаков 5:16 (зөв хүний залбирлын хүч)
- Судруудын Удирдамж, “Залбирал” хуудас 83



Иосеф Смит



Брингам Янг



Жон Тэйлор



Вилфорд Вүүдраф



Лорензо Снеу



Жозеф Ф.Смит



Хебер Ж.Грант



Жорж Алберт Смит



Дэвид О.МкКэй



Жозеф Филдинг Смит



Харолд Б.Лий



Спенсер В.Кимбал



Эзра Тафт Бэнсон



Ховард В.Хантер



Гордон Б.Хинкли



Томас С.Монсон

# Бурханы бошиглогчид

Бүлэг 9

---

## **Бурханы бошиглогчид бол дэлхий дээрх Түүний төлөөлөгчид мөн**

- Бошиглогчдод ямар хүч, бэлгүүд байдаг вэ?

“Үнэхээр Эзэн БУРХАН зарц нар, эш үзүүлэгчиддээ Өөрийн нууцыг илчлэхээс нааш Тэр юуг ч хийхгүй” (Амос 3:7).

Олон хүн Бурханы хүслээс гадуур харанхуйд амьдардаг. Тэд тэнгэр тэдний хувьд хаалттай, дэлхийн аюулыг ганцаар туулах хэрэгтэй гэж итгэдэг. Хожмын үеийн Гэгээнтнүүд ямар азтай хүмүүс вэ! Түүний бошиглогчоор дамжуулан Сүмтэй маань Бурхан харьцдаг гэдгийг бид мэддэг. Чин сэтгэлийн талархалтайгаар бүх Гэгээнтнүүд “Энэ үед биднийг удирдан залах Бошиглогч илгээсэнд баярлалаа” (*Сүмийн дуулал*, 36-р дуу) хэмээн дуулдаг.

Бошиглогч гэдэг нь дэлхий дээр Түүний төлөөлөгч байхаар Бурханаар дуудагдсан хүн юм. Бурханыг төлөөлөн бошиглогч ярихад энэ нь яг л Бурхан ярьж байгаа мэт л байдаг (С ба Г 1:38). Бошиглогч мөн Христийн онцгой гэрчлэгч Түүний бурханлаг Бошиглогч үнэнийг зааж, Бурханы үгийг дамжуулдаг. Тэр зөв шударга бус нэгнийг наманчлалд ирэхийг дууддаг. Тэр бидний тусын тулд өгөгдөх Их Эзэний илчлэлт, зөвлөмжийг хүлээн авдаг. Дэлхийд сэрэмжлүүлэхийн тулд Тэр ирээдүйг харж, ирэх зүйлсийг урьдчилан хэлдэг.

Тэр амьдралын ямар ч төвшнөөс ирж болно. Тэр залуу эсвэл өндөр настай, өндөр боловсролтой эсвэл боловсролгүй байж болно. Тэр малчин, хуульч эсвэл багш байж болно. Эртний бошиглогчид дан урт нөмрөг нөмрөөд, өөрсдийн юмаа бариад алхаж байсан. Орчин үеийн бошиглогчид костюм өмсөөд, цүнх бариад алхаж байна. Тэгээд энэ бүгд нь үнэн бошиглогчийг

---



тодорхойлох зүйлс үү? Үнэн бошиглогч нь үргэлж Бурханаас сонгогдсон байх бөгөөд санваарын зохистой эрх мэдлээр дуудагддаг (Итгэлийн Тунхаг 1:5).

Хожмын үеийн Гэгээнтнүүд Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчдийг бошиглогчид хэмээн баталдаг. Гэхдээ бид “Сүмийн бошиглогч” гэж ярьдаг. Тэр бол дээд санваартны Ерөнхийлөгч ба бид түүнийг Сүмийн Ерөнхийлөгч гэдэг.

### **Хүн төрөлхтөнийг удирдуулахаар өнгөрсөн он жилүүдийн турш Бурхан Өөрийн бошиглогчдыг дуудаж байв.**

- Өнгөрсөн үед Бурханы хүүхдүүдийг ямар замаар бошиглогчид удирдаж байсан бэ?

Адамын өдрөөс эхлэн дэлхий дээр бошиглогчид байсан. Эдгээр агуу хүмүүсийн үлгэр жишээ бидний сэтгэлийг догдлуулж, өдөөн урамшуулдаг. Хуучин Гэрээний бошиглогч Мосе мянга мянган хүмүүсийг удирдан Египетийн боолчлолоос гаргаж, амлагдсан нутагт авчирсан. Тэр Хуучин Гэрээний эхний таван бүлгийг бичсэн бөгөөд Арван хуулийг мөнхжүүлсэн. Мормоны Номын бошиглогч Нифай Христийн төрөлтөөс 600 жилийн өмнө Иерусалимаас Америк тив хүртэлх аяныг хийсэн. Энэ агуу удирдагч, газар нутгийг эзэмшигч Мормоны Номон дээр олон чухал бичээсийг бидэнд өгсөн. Усаар батлагч Иохан дэлхийг Их Эзэн Есүс Христийн ирэлтэнд бэлтгэхээр сонгогдсон байсан. Хожмын үеийн бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн Сүмийг дахин сэргээсэн. Залуу насандаа Иосеф Смит мөн Мормоны Номыг орчуулсан.

- Бошиглогчдын амьдрал, сургаалаас юу суралцсан бэ?

### **Өнөөдөр дэлхий дээр бид амьд бошиглогчтой.**

- Өнөөдөр бидэнд яагаад амьд бошиглогч хэрэгтэй вэ?

Бидэнд өнөөдөр дэлхий дээр амьд бошиглогч байгаа. Энэ бошиглогч бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч юм. Тэр бүхэл Сүмийн төлөө илчлэлтийг авах эрхтэй. Тэр “хаант улсын түлхүүрүүдийг” атгадаг. Энэ нь

санваарын ёслолуудыг захиран удирдахыг оролцуулан Сүмийг ба дэлхий дээрх Бурханы хаант улсыг удирдах эрхтэй гэсэн үг (Матай 16:19). Сонгогдсон бошиглогч ба Ерөнхийлөгчөөр бусад ямар ч хүн Сүмийн бүх гишүүдийн өмнөөс Бурханы тааллыг хүлээн авч чадахгүй. Их Эзэн “Тэнд хэзээ ч өөрөөр бус, харин дэлхий дээр тэр нэгэн, энэ хүч хийгээд энэ санваарын түлхүүрүүд олгосон хүн тухайн цаг үед зөвхөн ганцхан л байдаг” (С ба Г 132:7). Сүмийн Ерөнхийлөгч нь Тэргүүн Зөвлөлд түүнд туслах хоёр зөвлөх, мөн бошиглогчид, үзмэрчид, илчлэгчид болох Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд байдаг.

Бид бошиглогчид хий хэмээн хэлсэн зүйлсийг хийх ёстой. Ерөнхийлөгч Вилфорд Вүүдраф бошиглогч Сүмийг төөрөлдүүлэн гуйвуулж удирдахыг хэзээ ч зөвшөөрөхгүй:

“Их Эзэн надад эсвэл Сүмийн Ерөнхийлөгч байхаар дуудагдсан бусад хэнд ч та нарыг төөрөлдүүлэн гуйвуулахаар удирдахыг хэзээ ч зөвшөөрөхгүй. Ийм зүйл хэзээ ч тохиолдохгүй. Энэ нь Бурханы бодолд ч байхгүй. Хэрэв би тэгэхийг завдах аваас Их Эзэн намайг энэ байрнаас зайлуулах болно” (*Teachings of Presidents of the Church: Wilford Woodruff* [2004], 199).

- Ямар замаар амьд бошиглогч сүмд нөлөөлдөг вэ?

### **Бид Их Эзэний бошиглогчийг дэмжин батлах ёстой.**

- Бид бошиглогчийг дагаж, дэмжихийн тул юу хийж чадах вэ?

Олон хүн өнгөрсөн үеийн бошиглогчдод итгэхэд амар гэж үздэг. Гэхдээ амьд бошиглогчид итгэж дагах нь илүү гайхамшигтай. Бид Сүмийн Ерөнхийлөгчийг бошиглогч, үзмэрч, илчлэгч хэмээн гараа өргөн баталдаг.

Бид бошиглогчийг хэрхэн дэмжин баталж чадах вэ? Бид түүний төлөө залбирах ёстой. Түүний ачаа нь хүнд бөгөөд түүнд Гэгээнтнүүдийн залбирлын хүч хэрэгтэй.

Бид түүний үгсийг суралцах ёстой. Бид түүний ерөнхий чуулганууд хэлэх сургаалыг сонсож чадна. Бид мөн *Ensign* эсвэл *Лиакхона* дээрээс түүний эдгээр ерөнхий чуулганы яриаг болон түүний өгсөн бусад захиасуудыг уншиж чадна.

Бид түүний өдөөн урамшуулах сургаалуудыг бүрнээр нь дагах ёстой. Бид дагахад хүндрэлтэй юм уу өөрт таалагдахгүй байгааг нь орхих, зарим сургаалыг дагах зэргээр түүний сургаалд сонголт хийх ёсгүй. Их Эзэн Түүний бошиглогчдын өдөөн урамшуулах сураалуудыг дага хэмээн бидэнд тушаасан.

“Та нарт түүний [бошиглогчийн] өгөх түүний үгсэд хийгээд зарлигуудад анхаарал тавигтун, учир нь түүний үгийг та нар миний амнаас гарсан мэтээр

бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой” (С ба Г 21:4–5).

Их Эзэн Сүмийн Ерөнхийлөгч төөрөлдүүлэн гуйвуулахаар удирдахыг хэзээ ч зөвшөөрөхгүй.

- Саяхан Сүмийн Ерөнхийлөгч юу зааж эсвэл юуг илүү тодотгосон бэ?

### **Бошиглогчийг дуулгавартайгаар дагаснаар агуу адислалууд ирдэг**

Хэрэв бид дуулгавартай байх аваас Их Эзэн бидэнд “Тамын үүд та нарыг дийлэх нь үгүй; тийм ээ, мөн Их Эзэн Бурхан харанхуйн хүчийг та нарын өмнөөс сарниулж, мөн та нарын сайн сайхан хийгээд түүний нэрийн алдар суугийн төлөө тэнгэрийг сэгсрэхэд хүргэх болно” хэмээн амласан (С ба Г 21:6). Бошиглогчийн заавраар бид бүгдийг хийснээр адислалууд тэнгэрээс цутгах болно.

Үнэн Сүм болон зогсохын тулд “та нар элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн чулуу нь” (Ефес 2:20) байх ёстой. Энэ ороо бусга дэлхийд Их Эзэн Өөрийн тааллыг илчлэх бошиглогчтой бид адислагдсан хүмүүс.

- Бошиглогчийн зөвлөсөнд дуулгавартай байхад танд ямар байсан бэ?

---

**Багш нарт зориулж:** Туршлагаасаа хуваалцаж, гэрчлэлээ хэлж Ариун Сүнснийг урь. Сүмийн ерөнхийлөгчийн зөвлөгөөг дагаснаар өөрт тань тохиолдсон туршлагаас хуваалцан энэ хичээлийг дуусга. Амьд бошиглогчийн тухай гэрчлэлээ хуваалц.

### **Нэмэлт судрууд**

- Тоолол 12:6 (Бурхан бошиглогчоор дамжуулан ярьдаг)
- 1 Самуел 9:9 (бошиглогч бол үзмэрч)
- Амос 3:7 (Бурхан Өөрийн нууцуудыг бошиглогчид илчилдэг)
- Мозая 8:16–18 (үзмэрч өнгөрсөн ба ирээдүйн зүйлсийг мэддэг)
- Лук 1:70 (Бурхан бошиглогчоор дамжуулан ярьдаг)
- С ба Г 45:10, 15 (Бурхан өнөөдөр яг эрт үед ярьсан шиг ярьж байна)
- 1 Нифай 22:2 (Сүнслэг зүйлсээр дамжуулан бошиглогчийг таньж болно)
- С ба Г 68:3–5 (Их Эзэний үйлчлэгчид Ариун Сүнсээр хөтлөгдөн ярих үед энэ нь Их Эзэний бодол санаа, хүсэл, дуу мэт байдаг)
- С ба Г 107:65–67, 91–92 (Сүмийн Ерөнхийлөгчийн үүргүүд)
- С ба Г 43:1–7 (зөвхөн бошиглогч Сүмийн төлөө илчлэлтийг хүлээн авах эрх мэдэлтэй)



# Сударууд

Бүлэг 10

---

## Өнөөдөр бидэнд судрууд бий

- Судрууд хэрэглэхэд дөхөм байгаа учраас өнөөдөр бид ямар адислалуудыг аван баясдаг вэ?

Их Эзэний үйлчлэгчид ярих юм уу Ариун Сүнсний нөлөөгөөр бичих үед тэдний үгс судар болдог (С ба Г 68:4). Эхлэлээс Их Эзэн Өөрийн бошиглогч нартаа Түүний илчлэлтийн талаар, Түүний Өөрийн хүүхдүүдтэйгээ шударгаар ажилладаг талаар бичээс хөтлөхийг зарлигласан. Тэрээр “Би бүх хүмүүнд, өрнөдөд мөн дорнодод аль алинд нь, мөн өмнөдөд бас умардад мөн далайн арлуудад, тэд миний тэдэнд ярих тэдгээр үгсийг бичихийг зарлиг болгодог; өөрөөр хэлбэл тэр номнуудаас би дэлхийг, шүүнэ, хүн бүрийг тэдний үйлүүдийнх нь дагуу, бичигдсэн түүний дагуу болой” (2 Нифай 29:11) гэжээ.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм судар хэмээн: Ариун Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Ариун Үнэт Сувд дөрвөн номыг хүлээн зөвшөөрдөг. Эдгээр номнууд Сүмийн албан ёсны номнууд хэмээн нэрлэгддэг. Бидний амьд бошиглогчдын өдөөх урмыг өгсөн үгс мөн судар болон хүлээн зөвшөөрөгдсөн.

### *Ариун Библи*

Ариун Библи нь Бурханы хүмүүст өгсөн илчлэлтүүдийг агуулсан нандин бичээсүүдийн цуглуулга юм. Эдгээр бичээсүүд Адамын үеэс Есүс Христийн амьдарч байсан үеийн Төлөөлөгчдийг хүртэл

---

**Багш нарт зориулж:** Дөрвөн албан ёсны номнуудын талаар хэлэлцэхийн тул ангийн эсвэл гэр бүлийн гишүүд бүрт 1-ээс 4-ийн хоорондох тоог даалгавар болгон өгч болно. 1 гэсэн тоог авсан хүн Ариун Библийн энэ бүлэгт юу заадаг, 2 гэсэн тоог авсан хүн Мормоны Номын энэ бүлэгт юуг заадаг, 3 гэсэн тоотой хүн Сургаал ба Гэрээний энэ бүлэгт юу заадаг, 4 гэсэн тоог авсан хүн Агуу Үнэт Сувдын энэ бүлэгт юу заадгийг уншихыг хүс. Дараа нь тэднээс юу сурснаа хуваалцахыг хүс.

олон зууныг хамардаг. Тэдгээр нь дэлхийн түүхийн янз бүрийн цагуудад амьдарч байсан бошиглогчид бичсэн.

Ариун Библи нь: Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Хуучин Гэрээний олон бошиглол Аврагч ба Гэтэлгэгчийн ирэлтийг урьдчилан хэлдэг. Шинэ Гэрээ Аврагч ба Гэтэлгэгч болох Есүс Христийн амьдралын талаар хэлдэг. Мөн тэр өдөр Өөрийн Сүмийг байгуулсан тухай хэлдэг. “Библи зөв орчуулагдсан байхын хэрээр Бурханы үг гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:8).

Их Эзэн Ариун Библи дээрх зарим хэсгийн тухай бидний ойлголтыг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан хэлсэн. Их Эзэн Бошиглогч Иосеф Смитийг сүнслэг өдөөлтөөр урамшуулж, Ариун Библи дээрх анхны эх үгсийн алдагдсан эсвэл өөрчлөгдсөн бичээсийн үнэнийг сэргээсэн. Тэдгээр сүнслэг засалтыг Ариун Библийн Иосеф Смитийн орчуулга гэдэг. Хожмын үеийн Гэгээнтнүүдийн хэвлэл дэх Ариун Библийн Иаков Хааны хувилбарт тэдгээр хэсгүүд олон зүүвэр тайлбар ба Библийн Иосеф Смитийн орчуулгаас авсан Түүврүүд гэсэн 246–272-р хуудсаас харж болно.

### *Мормоны Ном*

Мормоны Ном нь Америк тив дээр мээ 2000 ба мээ 400 хооронд амьдарч байсан зарим хүмүүсийн нандин бичээс юм. Энд Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг (С ба Г 20:9; 42:12; 135:3). Мормоны Ном Есүс Христ Өөрийн Амилалтын дараа удалгүй Америкт байсан хүмүүст зочилсон тухай хэлдэг.

Иосеф Смит Бурханы өгсөн бэлгийн хүчээр Мормоны Номыг англи хэл уруу орчуулсан. Тэр хэлэхдээ энэ бол “энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуурын чулуу, түүнчлэн бусад ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой” гэжээ (Мормоны Номын Удиртгал).

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэрхэн Мормоны Ном манай шашны тулгуурын чулуу болохыг бидэнд ойлгоход тусалсан. Тэр хэлэхдээ:

“Мормоны Ном нь манай шашны тулгуурын чулуу болохыг батлах гурван зүйл байдаг. Энэ бол Христийн тухай гэрчлэх бидний гэрчлэл дэх тулгуурын чулуу Энэ бол бидний сургаалын тулгуурын чулуу Энэ бол гэрчлэлийн тулгуур чулуу.

“Мормоны Ном нь бидний хийж байгаа бүх зүйлийн булангийн чулуу болох Тэр, Есүс Христийн тухай бидний гэрчлэл дэх тулгуурын чулуу мөн. Энэ Ном Түүний тухай бодитоор хүчтэй, тодорхой гэрчилдэг. . . .

“[Тэр] авралын сургаалын тухай бидний ойлголтыг өргөжүүлэн тэлдэг. . . . Мормоны Ном бидний өдрүүдэд зориулан бичигдсэн. . . . Түүнээс бид Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх замыг олдог. . . .

“. . . Мормоны Ном Христийн гэрчлэл, үнэний тухай бидэнд заадаг. . . . Бас үүнээс ч илүү зүйл бий. Энэ номонд мөн, номыг хичээнгүйгээр судалж эхлэх тэр мөчөөс номын хүч та нарын амьдрал уруу урсан орох хүч юм. Та нар уруу таталтыг эсэргүүцэн зогсох агуу хүчийг олох болно. Та нар хууран мэхлэлтээс зайлсхийх хүчийг олох болно. Та нар нарийн бөгөөд шулуун зам дээр үлдэх хүчийг олох болно. Судруудыг “амьдралын үгс” гэж нэрлэдэг. Мормоны Номын үнэнээс илүү үнэн гэж үгүй. . . . ‘Хожмын үеийн Гэгээнтэн бүр энэ номыг амьдралынхаа турш судлах зорилгоо болгох ёстой’ (1986 оны 10-р сарын Ерөнхий Чуулган 4–7; эсвэл 1986 оны 11-р сарын *Ensign*, 5–7; 1980 оны 4-р сарын Ерөнхий Чуулган дээр Марион Г. Ромнейгийн хэлсэн үгнээс, 90; эсвэл 1980 оны 5-р сарын *Ensign*, 67).

### *Сургаал ба Гэрээ*

Сургаал ба Гэрээ орчин цагийн илчлэлтүүдийн цуглуулга юм. Сургаал ба Гэрээний 1-р хэсэгт Их Эзэн энэ ном дэлхийн оршин суугчдыг Түүний ирэлтэд бэлтгэхийн тул хэвлэгдсэн болохыг илчилдэг.

“Иймийн тул Их Эзэний дуу хоолой дэлхийэ өнцөг булангуудад, сонсох бүгд нь сонсож болохын тулд хандсан авай:

“Бэлтгэгтүн та нар, ирэх тэр зүйлийн төлөө бэлтгэгтүн та нар, учир нь Их Эзэн ойрхон байна” (С ба Г 1:11–12).



Энэ ном Есүс Христийн Сүм энэ хожмын өдрүүдэд сэргээгдсэнтэй холбоотойгоор өгөгдсөн илчлэлтүүдийг агуулдаг. Номын нилээд хэдэн хэсгүүд санваартны байгууллагууд болон тэдгээрийн үйл ажиллагааг нарийн тогтоосон Сүмийн зохион байгуулалтын талаар тайлбарладаг. 76 ба 88-р хэсгүүд зуун зуун жилийн өмнө дэлхийд алдагдсан гайхамшигт үнэнүүдийг агуулдаг. Мөн 29 ба 93-р хэсэг Ариун Библийн сургаал дээр гол анхаарлаа хандуулсан байдаг. section 133 зэрэг зарим хэсгүүд нь ирээдүйд болох зүйлсийн тухай бошиглолыг агуулсан байдаг. Түүний илчлэлтүүдийг суралцан судлахыг бидэнд Бурхан тушаасан байдаг. “Эдгээр зарлигуудыг судлагтун, учир нь тэдгээр нь үнэн бөгөөд итгэмжлэгдсэн юм, мөн тэдгээрт буй бошиглолууд хийгээд амалтууд бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:37).

### *Агуу Үнэт Сувд*

Агуу Үнэт Сувд нь Мосегийн ном, Абрахамын ном болон Иосеф Смитийн зарим сүнслэг бичээсийг агуулсан байдаг. Мосегийн ном Бошиглогч Иосеф Смитэд илчлэгдсэн Мосегийн зарим үзэгдэл ба бичээсүүдийг агуулсан байдаг. Энэ нь дэлхийн Бүтээлтийн тухай Нэмэлт мэдээллийг өгдөг ба мөн Ариун Библиэс алдагдсан сургаал ба номлолуудыг тодотгож өгдөг.

Абрахамын номыг Египетийн булшнаас авагдсан үйсэн дээр бичигдсэн номноос Бошиглогч Иосеф Смит орчуулсан. Энэ ном Бүтээлт, сайн мэдээ, Бурханы мөн чанар ба санваарын тухай үнэлж баршгүй мэдээллүүдийг агуулсан байдаг.

Иосеф Смитийн бичээсүүд нь Иосеф Смитийн сүнслэг өдөөлтөөр Ариун Библийн орчуулгын хэсэг, түүний *Сүмийн Түүх* –ээс сонгон авсан хэсгүүд болон Итгэлийн Тунхаг агуулсан байдаг.

- Таныг өдөөн урамшуулсан судрын ямар түүхүүд байдаг вэ? Судрын эдгээр номнуудын ямар сургаал танд тусалсан бэ?

## Амьд бошиглогчдын үгс

Судрын эдгээр дөрвөн номноос гадна амьд бошиглогчдын сүнслэгээр нөлөөлөх үгс бидэнд судар болдог. Тэдний үгс ерөнхий чуулган, *Лиакона* эсвэл *Ensign* сүмийн сэтгүүлүүд, мөн орон нутгийн санваартны удирдагчдаар дамжуулан бидэнд ирдэг. “Бурханы илчилсэн бүтдэд, эдүгээ түүний илчилж буй бүтдэд бид итгэдэг, мөн Бурханы хаант улсад хамаарах олон агуу хийгээд чухал зүйлийг Тэрээр цаашид илчлэх болно гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:9).

- Амьд бошиглогчдын үгсийг бид хаанаас олж болох вэ?

## Судраас судлах нь

- Бид судруудыг судалснаар ямар адислалуудыг хүлээн авч чадах вэ?

Хүн бүр өдөр бүр судраас суралцах ёстой. Эдгээр үнэнүүдийг бид хүүхдүүдтэйгээ хуваалцах ёстой. Хүүхдүүд маань судруудыг хайрлаж, судруудаас олсон үнэнийг өөрсдийн амьдралдаа ашиглаж болохын тул тэдэнтэй албан ёсны номнуудаас хамтдаа унших ёстой.

Хэрэв бид энэ дэлхийн хилэнцтээс зайлсхийхийг хүсч байгаа бол өөрсдийн оюун ухааныг судрууд дахь үнэн ба зөв шударгаар тэжээх ёстой. Судруудыг хамтдаа уншиж, тунгаан бодсоноор бид Бурхандаа болон бие биестэйгээ ойр байх болно.

Судраас уншиж, тунгаан бодож, залбирах үедээ тэдгээрийг ойлгоход туслахыг Бурханаас хүс. Ариун Сүнс эдгээр зүйлсийн үнэнийг бидэнд гэрчлэх болно. Хүн болгон эдгээр зүйлийн үнэнийг зайлшгүй мэдэх болно. Бид мэхлэгдэхгүй байх болно (Итгэлийн тунхаг 1:9). Нифайн мэдэрсэн зүйлийг мөн бид хүлээн авч чадна. “Сэтгэл минь Их Эзэний зүйлүүдэд баясч, мөн зүрх минь өөрийн үзсэн мөн сонссон зүйлийг үргэлж тунгаадаг” (2 Нифай 4:16).

- Бид хэрхэн өдөр бүр судруудаас судлах амлалтыг сахиж чадах вэ? Өдөр бүр судраас судлах цаг, газраа төлөвлөн зохицуул.

### **Нэмэлт судрууд**

- 1 Нифай 14:20–26 (бошиглогчид бичихийг зарлиглагдсан)
- 1 Нифай 19:1–3, 6–7; Алма 37:1–8 (судруудын агуу үнэ цэнэ)
- 2 Нифай 33:10 (судрууд христийг гэрчилдэг)
- Алма 29:8 (Их Эзэн судруудаар дамжуулан хамаг үндэстэнтэй ярьдаг)
- Алма 31:5; Хиламан 3:29–30 (Бурханы үг бол хүчирхэг)
- Хиламан 15:7–8 (судрууд биднийг итгэлд бат бөх гуйвшгүй байхад хөтөлдөг)
- 2 Тимот 3:16–17; 1 Нифай 19:21–24 (яагаад мөн яаж судрууд өгөгдсөн бэ)
- 2 Петр 1:20; Алма 13:20; С ба Г 10:62 (судрууд сургаалын гол үнэнийг тодотгож өгдөг)
- С ба Г 128:18; Итгэлийн тунхаг 1:9; 1 Нифай 14:25–26 (судрууд ирсээр байна)
- 2 Нифай 29:3–10 (Иудей ба харийнханд өгсөн судрууд)

# Христийн амьдрал

Бүлэг 11

---

## **Христийн амьдрал Түүнийг төрөхөөс хамаагүй өмнө тааварлагдсан байсан**

Дэлхийд ирдэг хүн бүр Есүс Христэд хамааралтай, Түүний тэнгэрт бидний Аврагч байхаар хийсэн амлалтыг гүйцэлдүүлэхээс хамааралтай. Түүнгүйгээр авралын төлөвлөгөө нурах байсан. Түүний ажил гарцаагүй шаардлагатай байсан учраас Адамаас Христийг хүртэлх бүх бошиглогчид Түүний ирэхийг гэрчилж байсан (Үйлс 10:43). Христээс эхлэн бүх бошиглогчид Түүний ирснийг гэрчилдэг. Бид бүгд амьдралынхаа турш Түүнийг итгэлтэйгээр дагаж, Аврагчийн амьдралыг судлах хэрэгтэй.

Аврагчийн нэр Есүс Христ гэдгийг Адам мэдэж байсан (Мосе 6:51–52). Енох загалмай дээр цовдлогдон нас бараад дахин амилах Есүсийг харсан (Мосе 7:55–56). Ноа ба Мосе нар мөн Түүнийг гэрчилсэн (Мосе 1:11; 8:23–24). Дэлхийд Аврагчийг төрөхөөс 800-гаад жилийн өмнө Исаиа Түүний амьдралыг урьдчилан харсан. Бидний нүглүүдийн төлбөрийг төлөхийн төлөө зовох Аврагчийн уй гашуу, зовлонг Исаиа хараад уулга алдан: “Тэр үзэн ядагдаж, хүмүүсээр орхигдов, Тэр уй гашууны хүн бөгөөд зовлонг мэдсэн. . . .

“ . . . Үнэхээр Тэр бидний өвчнийг Өөртөө тээж, бидний уй гашууг даав. . . .

“Тэр бидний нүглийн төлөө хатгагдан бидний гэмийн төлөө бяцарчээ. . . .

---

**Багш нарт зориулж:** Энэ бүлэг ангид бүгдийг заах боломжгүй маш их материалтай. Хичээлд бэлтгэхдээ заах тэдэнд аль хэсэг нь илүү тустай байхыг тодотгох Ариун Сүнсийг удирдамжийг эрэлхийл.



“Тэр тамлагдсан, зовсон боловч амаа нээсэнгүй, алагдахаар хөтлөгдөх хурга шиг, хяргагчийн өмнө дуугарахгүй хонь шиг Тэр амаа нээсэнгүй” (Исаиа 53:3–5, 7).

Нифай мөн Аврагчийн ирээдүйд төрөхийг болон номлолыг үзэгдлээр харсан. Тэр үзэсгэлэнтэй онгон бүсгүйг харсан ба тэнгэрийн элч түүнд “Болгоогтун, таны харж буй тэр онгон бүсгүй бол Бурханы Хүүгийн махан бодийн биеийг төрүүлэгч эх нь бөлгөө” хэмээн тайлбарласан (1 Нифай 11:18). Тэгээд Нифай онгон бүсгүй гартаа бяцхан хүүхэд тэвэрсэн байхыг харсан. Тэнгэрийн элч “Бурханы Хургыг, тийм ээ, бүр Мөнхийн Эцэгийн Хүүт болгоогтун!” хэмээн тунхаглав (1 Нифай 11:21).

Есүсийг төрөхөөс ойролцоогоор<sup>124</sup> жилийн өмнө Нифайчуудын бошиглогч Хаан Бенжамин мөн Аврагчийн амьдралыг урьдчилан харсан:

“Учир нь болгоогтун, тэр цаг ирнэ, мөн энэ нь хол зайтай бус, засаглах тэр, байсан, мөн үүрд мөнхөөс үүрд мөнхөд байдаг тэр, Төгс Хүчит Их Эзэн хүмүүний үрсийн дунд тэнгэрээс хүчтэйгээр бууж ирэх болно, мөн махбодийн асарт орших болно, мөн өвчтөнийг эдгээж, үхсэнийг босго, хазгарыг алхуулж, сохрыг хараатай болгож, мөн дүлийг сонсгож, мөн зүйл бүрийн эмгэгийг анагаах зэрэг хүчит гайхамшгуудыг үйлдэн, хүмүүний дунд урагшлан явах болно.

“Мөн тэрээр хүмүүний үрсийн зүрх сэтгэлд орших ёс бусын сүнснүүд, өөрөөр хэлбэл чөтгөрүүд зайлуулах болно.

“Мөн үз, тэрээр уруу таталтыг, мөн биеийн өвчин, өлсгөлөн, цангаа, мөн зүдрэлийг, энэ нь үхэлд хүргэхээс бусдаар бол, бүр хүмүүний тэвчиж чадахаас илүүт тэвчих болно; учир нь болгоогтун, арьсных нь сүв бүрээс цус шүүрэх болно, өөрийнхөө хүмүүсийн ёс бус мөн жигшүүрт хэргүүдийн төлөөх түүний тарчлал ийм агуу байх болно.

“Мөн тэрээр Есүс Христ, Бурханы Хүү, тэнгэр ба газрын Эцэг, эхлэлээс бүх зүйлийг Бүтээгч хэмээн нэрлэгдэх болно; мөн түүний эх Мариа гэгдэх болно” (Мозая 3:5–8).

- Эртний бошиглогчид Есүс Христийн тухай юу бошиглосон бэ?

### **Тэр Эцэгийн Цорын ганц Хүү байсан.**

- Есүс Христ Өөрийн Эцэгээс юу өвөлж авсан бэ? Тэр Өөрийн эхээс юу өвөлж авсан бэ?

Аврагчийн төрөлт ба амьдралын тухай түүхийг Шинэ Гэрээний Матай, Марк, Лук ба Иоханы номноос олж болно. Тэдний бичээсээс бид Есүс онгон бүсгүй Мариагаас төрснийг мэдэж болно. Их Эзэний тэнгэр элч Мариад үзэгдэх үед тэр Иосефтэй гэрлэхээр сүй тавьсан байсан. Тэнгэр элч түүнд Бурханы Хүүгийн эх байхыг хэлсэн. Тэр тэнгэр элчээс энэ нь яаж бүтэхийг асуусан (Лук 1:34). Тэнгэр элч түүнд “Ариун Сүнс чам дээр ирж, Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ. Тиймээс төрөх ариун нэгэн нь Бурханы Хүү гэж дуудагдах болно” (Лук 1:35). Тиймээс Бурхан Эцэг Есүс Христийн жинхэнэ Эцэг болсон.

Есүс бол дэлхий дээр мөнх бус эх ба мөнхийн Эцэг хоёроос төрсөн цорын ганц хүн. Ийм учраас Түүнийг Цорын ганц Хүү гэдэг. Тэр Өөрийн Эцэгээс бурханлаг хүчийг өвлөн авсан. Өөрийн эхээс Тэр өлсөх, цангах, ядрах, өвдөх ба үхэх мөнх бусын шинжүүдийг өвлөн авсан. Аврагчийн амийг Түүнээс Тэр Өөрөө биш аваас хэн ч авч чадахгүй. Түүнд үүнийг доош хэвтүүлэх хүч мөн нас барсны дараа Өөрийн биеийг дахин дээш авах хүч байсан (Иохан 10:17–18).

### **Тэр төгс амьдралаар амьдарсан**

- Аврагчийн амьдрал бидэнд ямар утгатай вэ?

Бага наснаасаа Есүс Тэнгэрлэг Эцэгийн Түүнээс шаардсан бүхэнд дуулгавартай байсан. Есүс Мариа ба Иосефын заавраар бусад хүүхдүүдийн адил өссөн. Тэр үнэнийг хайрлаж, дуулгавартай байсан. Лук “Хүүхэд өсөж, хүчирхэг болон мэргэн ухаанд боловсорсоор байлаа; Бурханы нигүүсэл Түүн дээр байсан юм” хэмээн бидэнд хэлсэн (Лук 2:40; С ба Г 93:12–14).

Есүс өсөж, Тэр 12 настай байхдаа Эцэгийнхээ хүслийг гүйцэлдүүлэхээр ирснээ Тэр бүрэн ойлгосон. Өөрийн эцэг, эхтэйгээ Тэр Иерусалим орохоор явсан. Түүний эцэг эх гэр лүүгээ буцах үед Түүнийг өөрсөдтэй нь хамт байхгүй байгааг тэд олж мэдэв.

Тэд Иерусалим руу буцаж, Түүнийг хайв. “Гурван өдрийн дараа тэд түүнийг ариун сүмд багш нарын дунд сууж байхыг нь олж харав; мөн тэд түүнийг сонсож, мөн түүнээс асуултууд асууж байв” (Иосеф Смитийн орчуулга, Лук 2:46). “Түүний ухаан болон хариултууд нь Түүнийг сонссон бүхний гайхлыг төрүүлж байв” (Лук 2:47).

Иосеф ба Мариа нар Түүнийг олсондоо тайвширсан ч “тэд Түүнийг хараад гайхаж, эх нь Түүнд: Хүү минь Чи юунд бидэнд хандав? эцэг бид хоёр чинь санаа зовон Чамайг эрж хайлаа.” Есүс хариуд нь түүнд, “та нар юунд намайг хайсан юм бэ? Эцэгийнхээ гэрт байх ёстойг минь та нар мэдсэнгүй гэж үү?” (Лук 2:48–49).

Өөрийн ажлыг гүйцэлдүүлэхийн тул Есүс Өөрийн Тэнгэр дэх Эцэгийн хүслээр хийх ёстой байв. “Би Өөрийн санаагаар юут ч хийдэггүй,” хэмээн Тэр тунхаглаад, “харин Эцэгийн Надад зааснаар Би эдгээрийг ярьдаг. . . . Би үргэлж Түүнд тааламжтай зүйлсийг үйлддэг” (Иохан 8:28–29).

Есүс 30 настай байхдаа Тэр Иордан гол дээр Иохан Баптисм дээр ирж, усаар батлуулсан. Есүс түүнээс илүү агуу гэдгийг Иохан мэдэж байсан учраас Түүнийг усаар батлахаас эмээж байлаа. “Хамаг зөв шударгыг гүйцэлдүүлэхийн” тул Түүнийг усаар батлахыг Есүс Иоханаас хүсэв. Иохан Түүнийг усанд бүрэн булхаж, Аврагчийг усаар батлав. Есүсийг баптисм хийлгэсний дараа Түүний Эцэг тэнгэрээс “Энэ бол Миний хайрт Хүү. Түүнд Миний таалал оршдог” гэх дуу гарлаа. Ариун Сүнс цагаан тагтаа болон нисч ирэв (Матай 3:13–17).

Есүс баптисм хүрсэнийхээ дараа удалгүй, Бурхантай байхын тул Тэр 40 өдөр 40 шөнө мацаг барив. Үүний дараа Сатан Түүнийг уруу татахаар ирсэн. Есүс тууштайгаар Сатаны уруу таталтыг эсэргүүцсэн, дараа нь Сатаныг зайлахыг тушаасан (Матай 4:1–11; Иосеф Смитийн орчуулга, Матай 4:1, 5–6, 8–9, 11). Есүс Христ дэлхий дээр нүгэлгүйгээр үлдсэн цорын ганц төгс хүн (Еврей 4:15; 1 Петр 2:21–22).

- Аврагчийн амьдралын аль нь та нарт илүү онцгой чухал ач холбогдолтой вэ?



## **Тэр хэрхэн бие биеэ хайрлах, үйлчлэхийг бидэнд заасан.**

- Хэрхэн Аврагч бидэнд бие биеэ хайрлах, үйлчлэхийг заасан бэ?

Тэр мацаг барьж, Сатаныг даван ялсныхаа дараа, Есүс Өөрийн олон түмэнд номлох ажлаа эхэлсэн. Тэр дэлхийд зөвхөн бидний төлөө амиа өгөхөөр ирээгүй мөн хэрхэн амьдрахыг бидэнд заахаар ирсэн. Тэр хоёр агуу зарлиг гэдгийг заасан: нэгдүгээрт, Бурханаа өөрийн бүх зүрх сэтгэл, оюун ухаан, хүч чадлаар хайрлах; хоёрдугаарт, өөрсдийгөө хайрладаг шиг бусдаг хайрла (Матай 22:36–39). Түүний амьдрал бол энэ хоёр зарлигийг хэрхэн сахих үлгэр жишээ юм. Хэрэв бид Бурханд хайртай бол бид Есүсийн адил Түүнд итгэлтэй, дуулгавартай байх болно. Хэрэв бид бусдыг хайрладаг бол бид тэдэнд биеийн болон сүнсний хэрэгцээг олоход нь туслах болно.

Есүс Өөрийн амьдралыг бусдад үйлчлэхэд зориулсан. Тэр тэднийг өвчнөөс анагаасан. Тэр сохрыг хараатай болгож, дүлийг сонсдог болгож, доголонт явуулсан. Тэр өвчтөнийг анагааж байх үед орой болж, хүмүүс өлсөж цангасан. Тэднийг явуулахын оронд Тэр таван хэрчим талх, хоёр загасыг адислаж, 5000 хүнийг хооллох чадвартай байсан (Матай 14:14–21). Хаа ч байсан хэн нэгнийг өлсөж, даарч, нүцгэн, эсвэл ганцаардсан байхыг мэдвэл бид өөрсдийн чадах бүхнээрээ тэдэнд туслах ёстойг Тэр заасан. Бид бусдад тусалснаар Их Эзэндээ үйлчилдэг (Матай 25:35–46).

Есүс бүх зүрх сэтгэлээрээ бусдыг хайрладаг. Түүний зүрх сэтгэл энэрэл нигүүлслээр дүүрч, Тэр уйлж байсан. Тэр бяцхан хүүхдүүд, өндөр настан, номхон дөлгөөн Түүнд итгэдэг жирийн хүмүүсийг хайрладаг. Нүгэл үйлдсэн тэдгээрийг Тэр хайрладаг бөгөөд агуу энэрэнгүй нигүүлслээр Тэр тэдэнд наманчлалд ирж, баптисм хүртэхийг заадаг. Тэр “Би бол зам, үнэн, амь мөн” (Иохан 14:6) гэж заасан.

Есүс бүр Түүнийг эсэргүүцэх нүглийг хийгч, наманчилдаггүй тэднийг хайрладаг. Загалмай дээр цовдлогдсон байсан амьдралынхаа төгсгөлд Тэр Түүнийг цовдолж буй цэргүүдийн төлөө Эцэгт хандан “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна” хэмээн залбирсан (Лук 23:34). Тэр “Би та нарыг

яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагтун. Энэ бол Миний тушаал” хэмээн заасан (Иохан 15:12).

- Их Эзэнд ямар замаар бид Түүнд хайртайгаа харуулж чадах вэ?

### **Тэр цорын ганц үнэн сүмийг байгуулсан**

- Яагаад Аврагч Өөрийн Сүмийг байгуулж, төлөөлөгчдийг томилсон бэ?

Өөрийн сайн мэдээг дэлхий даяар бүх хүнд заахыг Есүс хүссэн тул Тэр Түүнийг гэрчлэх арванхоёр төлөөлөгчийг сонгосон. Тэд Түүний Сүмийн анхны удирдагчид байв. Тэд Түүний нэрээр үйлдэх эрх мэдлийг хүлээн авч, өөрсдийн харсан Түүний хийж байсан ажлыг хийсэн. Тэднээс эрх мэдлийг хүлээн авсан тэдгээр нь мөн заах, баптисм хүртээх болон бусад ёслолуудыг Түүний нэрээр үйлдэх чадвартай байсан. Түүнийг нас барсны дараа хүмүүс Түүний төлөөлөгчдийг хүртэл алах агуу нүгэлд унах хүртэл тэд Түүний ажлыг үргэлжлүүлэн хийсээр байсан.

### **Тэр биднийг нүглүүдээс гэтэлгэсэн мөн биднийг үхлээс аварсан**

- Энэ хэсгийг судлах үедээ Цагаатгалын үйл явдлын талаар тунгаан бод.

Өөрийн мөнх бус амьдралын үйлчлэлийн төгсгөл ойртох тэр үед Есүс хүн төрөлхтөний хамаг нүглүүдийн төлөө хамгийн эцсийн золиослолыг хийхээр бэлтгэсэн. Тэр Бурханы Хүү гэдгээ хүмүүст гэрчилсэн учраас Тэр гарцаагүй үхэх ёстой байлаа.

Өөрийн цовдлолын өмнөх орой Есүс Гетсеманийн цэцэрлэгт очсон. Удагүй Тэр гүн уй гашууд дарагдсан байв. Тэр залбирав. Хожмын үеийн төлөөлөгч Орсон Ф.Витней Аврагчийн зовлон зүдүүрийг үзэгдэлд харах боломжтой байв. Аврагчийн уйлахыг хараад тэр: “Би харсан зүйлдээ сэтгэл минь догдолж, цэвэр хайр энэрлээр би мөн уйллаа. Миний хамаг зүрх сэтгэл Түүнийг хайрлан энэрч; Би чин сэтгэлээсээ Түүнийг хайрласан, юу юунаас

---

**Багш гарт зориулж:** Тунгаан бодох нь Ариун Сүнснийг урьдаг. Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдээс бүлгийг сүүлийн хоёр хэсгийг Аврагчийн тухай өөрсдийн мэдэрч байгаа зүйлийг бодон дор бүрээ уншихыг хүс. Дараа нь хүсч байгаа хэн нэгнийг өөрийн сэтгэгдлээ хуваалцахыг хүс.

илүүтэйгээр Түүнтэй хамт байхыг би хүссэн” (“The Divinity of Jesus Christ,” *Improvement Era*, Jan. 1926, 224–25; see also *Ensign*, Dec. 2003, 10). Есүс “гэднээс жаахан цаашаа яваад, нүүрээрээ унаж, Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог” (Матай 26:39).

Орчин үеийн илчлэлтэд Аврагч Өөрийн зовлон зүдгүүр ямар агуу байсныг “сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн” хэмээн дүрсэлсэн байдаг (С ба Г 19:18). Тэр “бие махбодийн дагуу” бидний өвдөлт, өвчин, хөгшрөлт, нүглүүд бүгдийн өөр дээрээ авч зовсон (Алма 7:10–13). Мөнх бус хүн үүнийг ямар агуу ачаа байсныг ойлгож чадах нь үгүй. Мөнх бус хүн биеийн болон сүнсний шаналгааг даван гарч чадахгүй байсан. “Тэр бүхэнд мөн бүх зүйлээр, үнэний гэрэл байж болохын тулд . . . доор бууж ирсэн” (С ба Г 88:6).

Гэвч Түүний зовлон зүдгүүр хараахан дуусаагүй байлаа. Дараагийн өдөр нь Есүс зодуулсан, доромжлогдсон, нулимуулсан. Тэр Өөрийн загалмайг үүрэн явсан; дараа нь Тэр загалмай дээр хадагдсан, түүн дээрээ өргөгдсөн. Тэр хүн төрөлхтөний бодож олсон хамгийн харгис тамлалын нэг аргаар тамлагдан зовсон. Загалмай дээр зовон, шаналалд байхдаа Тэр чангаар “Миний Бурхан, Миний Бурхан юунд Та Намайг орхив?” хэмээн хашгирав (Марк 15:34). Есүсийн хамгийн гашуун зовлонгийн цагт, зөвхөн Есүс бүрэн гүйцэтгэж чадах, хүн төрөлхтөний нүглийн төлөөсийг бүрэн төлж дуусгаад нүгэл, үхлийн дээр ялалтыг мандуулж болохын тул Эцэг Түүнээс дөлөн холдсон байв (James E. Talmage, *Jesus the Christ*, 3 дахь хэвлэл. [1916], 660–61).

Аврагч Түүний золиослол Эцэгээр хүлээн зөвшөөрөгдсөнийг мэдэх үед Тэр “Энэ нь төгслөө” (Иохан 19:30). “Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая” (Лук 23:46) хэмээн чанга дуугаар хашгирав. Тэр Өөрийн толгойг бөхийлгөж, сайн дураар Өөрийн сүнсийг өгөв. Аврагч нас барав. Дэлхийд хүчтэй газар хөдлөлт боллоо.

Нөхөд нь Аврагчийн биеийг, гурав дахь өдрийг хүртэл тэнд байх, булшанд аваачив. Энэ үед Түүний сайн мэдээг хүлээн авах хэрэгтэй бусад сүнснүүдэд номлолын ажлыг хийхээр

---

Түүний сүнс явсан байв (1 Петр 3:18–20; С ба Г 138). Гурав дахь өдөр нь, Ням гарагт, Тэр Өөрийн биед эргэн ирж, дахин дээш авагдсан. Тэр үхлийг даван ялсан анхны хүн байсан. “Учир нь Тэр үхэгсдээс амилах ёстой” гэсэн бошиглол бүрэн биеллээ олсон (Иохан 20:9).

Удалгүй Өөрийн Амилалтын дараа, Аврагч Нифайчууд дээр хүрэлцэн ирж, Америк тивд Өөрийн Сүмийг байгуулсан. Тэр хүмүүст зааж, тэднийг адисалсан. Энэ сэтгэл догдлом хүчтэй түүхийг 3 Нифай 11 -ээс 28 дээрээс уншиж болно.

### **Түүний золиослол нь Өөрийн Эцэг мөн биднийг гэсэн Түүний хайрыг үзүүлдэг.**

Есүс “Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас өөр агуу хайр байхгүй. Хэрэв та нар Миний тушаасныг хийвэл, та нар Миний нөхөд мөн” (Иохан 15:13–14). Бид авралын төлөвлөөний бүх адислалуудыг хүлээн авч болохын тул Тэр Гетсаманид сайн дураараа, номхон даруухнаар уй гашууг туулж, загалмай дээр зовсон. Эдгээр адислалуудыг хүлээн авахын тулд бид Түүн уруу ирж, өөрсдийн нүглийг наманчлан, Түүнийг хамаг зүрх сэтгэлээрээ хайрлах ёстой. Тэр хэлэхдээ:

“Мөн энэ бол та нарт Миний өгсөн тэр сайн мэдээ – Эцэг миний намайг илгээсний учир би Эцэгийнхээ тааллыг гүйцэлдүүлэхээр дэлхийд ирсэн билээ.

“Мөн би загалмай дээр өргөгдөж болохын тулд, би загалмай дээр өргөгдсөний дараа, би хүмүүнийг өөртөө татаж болохын тулд, би хүмүүнээр өргөгдсөний адилаар хүмүүн миний өмнө зогсож, өөрсдийн үйлүүдээр тэд сайн эсвэл хилэнцэт байх эсэхээрээ шүүгдэхээр . . .

“Учир нь миний хийснийг та нар харсан, бүр түүнийг та нар хий болно. . . .

“Тиймийн тул, та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ? Үнэнээр би та нарт хэлье, *бүр миний адил буюу*” (3 Нифай 27:13–15, 21, 27).

- Таны төлөө хийсэн Аврагчийн золиослолын талаар тунгаан бодоход ямар мэдрэмж төрж байна вэ?

### **Нэмэлт судрууд ба бусад эх сурвалжууд**

- 2 Нифай 25:12 (Эцэгийн махан бодьтой Цорын Ганц Хүү)
- Мосе 6:57 (Есүс Христийг Цорын Ганц Хүү гэдэг)
- Матай, Марк, Лук, Иохан (Есүс Христийн амьдрал, сургаалууд)
- Матай 10:1–8; Лук 9:1–2 (Төлөөлөгчид хүч, эрх мэдлийг авдаг)
- Матай 26–28; Марк 14–16; Лук 22–24; Иохан 18–20 (Есүс цэцэрлэгт; Түүнээс урвасан, цовдолсон, дахин амилсан)
- “Амьд Христ: Төлөөлөгчдийн Гэрчлэл *Ensign*, 2000 оны 4-р сар, 2–3

# Цагаатгал

Бүлэг 12

---

## Бидний авралд цагаатгал зайлшгүй шаардлагатай

• Яагаад бидний авралд цагаатгал шаардлагатай вэ?

Есүс Христ “дэлхийн төлөө цовдлогдохоор, мөн дэлхийн нүг-лүүдийг үүрэхээр, мөн дэлхийг ариусгахаар, мөн үүнийг бүхий л шударга бус явдлаас нь цэвэрлэхээр . . . түүгээр дамжин бүтдээрээ аврагдаж болохын төлөө дэлхийд ирсэн” (С ба Г 76:41–42). Бидний нүгдүүдийн төлөө төлбөрийг төлж, үхлийг даван ялахын тул хийсэн Түүний агуу золиослолыг цагаатгал гэж нэрлэдэг. Энэ нь хүн төрөлхтөний түүхэнд тохиосон хамгийн чухал үйл явдал байв: Учир нь цагаатгал хийгдэх нь зайлшгүй юм; учир нь Мөнхийн Бурханы агуу их төлөвлөгөөний дагуу цагаатгал хийгдэх ёстой; эс бөгөөс бүх хүн төрөлхтөн гарцаагүй мөхөх ёстой; тийм ээ, бүгд унасан мөн төөрөлдсөн, мөн зайлшгүй хийгдэх ёстой уг цагаатгалаар бус аваас мөхөх ёстой” (Алма 34:9).

Адамын уналт нь дэлхийд биеийн үхэл, сүнслэг үхэл гэсэн хоёр төрлийн үхлийг авчирсан. Махан биебодь ба сүнс салан тусгаарлагдахыг биеийн үхэл гэдэг. Бурханаас салан тусгаарлагдахыг Сүнсний үхэл гэнэ. Хэрэв эдгээр хоёр үхлийг Есүс Христийн цагаатгалаар даван дийлээгүй бол хоёр янзын үр дагавар гарах байлаа: бидний бие ба сүнс хоёр мөнхөд салангид байх байсан, бид дахин хэзээ ч Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдарч чадахгүй байсан (2 Нифай 9:7–9).

Гэвч мэргэн ухаант Тэнгэрлэг Эцэг биднийг бие болон сүнсний үхлээс аврахын тулд гайхамшигтай, энэрэнгүй төлөвлөгөөг бэлтгэсэн. Тэр биднийг нүглүүд болон үхлээс гэтэлгэх Аврагч дэлхийд ирэхээр төлөвлөсөн. Бидний мөнх бус биеийн сул

---

**Багш нарт зориулж:** Энгийн хүснэгт, зурагнууд нь ангийн эсвэл гэр бүлийн гишүүдэд зарчмууд болон сургаалыг ойлгоход тусалж чадна. Хоёр баганатай хүснэгт хий. Нэг баганад *Уналтын үр дүн* нөгөөдөхөд нь *Цагаатгалын адислалууд гэж бич*. Энэ бүлгийн мэдээллийг ашиглан хүснэгтийг бөглө.



тал ба нүглүүдийн учир бид өөрсдийгөө гэтэлгэж чадахгүй (Алма 34:10–12). Бидний Аврагч байх тэр нэгэн нүгэлгүй бөгөөд үхлийг дийлэх хүчтэй байх хэрэгтэй байв.

### **Есүс Христ бидний нүглүүдийн төлөөх цагаатгалыг хийж чадах Цорын Ганц Хүн байлаа.**

- Яагаад зөвхөн Есүс Христ бидний нүглүүдийн төлөө цагаатгалыг хийж чадах хүн байсан бэ?

Зөвхөн Есүс Христ бидний Аврагч байх байсан. Үүнд хэдэн шалтгаан бий. Нэг дэх шалтгаан нь Тэнгэрлэг Эцэг Түүнийг бидний Аврагч байхаар сонгосон. Тэр Бурханы Цорын Ганц Хүү байсан учир үхлийг дийлэх хүчтэй байсан. Есүс “Би Өөрийн амийг буцааж авахын тулд амиа өгнө. Хэн ч Миний амийг Надаас авахгүй. Харин Би Өөрийн санаагаар түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий. Буцааж авах эрх мэдэл ч Надад бий” (Иохан 10:17–18).

Тэр дэлхий дээр амьдарч байсан цорын ганц нүгэлгүй хүн байсан тул Есүс мөн бидний Аврагч байхаар бэлэн байв. Энэ нь Түүнийг бусдын нүглүүдийн төлөө зохистой золиослолыг хийлгэсэн.

### **Христ бидний нүглүүдийн төлөөх цагаатгалыг хийхээр зовон шаналсан мөн нас барсан**

- Энэ хэсгийг уншиж байхдаа Есүс Христийн зовлон зүдгүүрийн гэрч болон Гетсеманийн цэцэрлэгт, эсвэл загалмай дээр байгаагаар өөрийгөө төсөөлөн бод.

Аврагч бидний нүглүүдийн төлөө Гетсеманийн цэцэрлэгт зовон шаналж, Өөрийн амийг загалмай дээр өгч цовдлогдсон. Бидний хамаг нүглүүдийн төлөө Тэр хэрхэн зовж шаналсныг бид бүрэн ойлгох ямар ч боломжгүй. Гетсеманийн цэцэрлэгт, бидний нүглүүд нь Түүний сүв бүрээс нь цус шүүрэн Түүнийг зовлон шаналах болгосон билээ (С ба Г 19:18–19). Дараахан нь Есүс хүн төрөлхтний мэдэх хамгийн харгис тамлал, зовиурт үхэл болох загалмай дээр зовж, Тэр цовдлогдсон.

Бидний төлөө биеийн болон сүнсний зовлон шаналалыг туулан зовсон Есүс бидэнд ямар их хайртай вэ! Бусад үлдсэн



хүүхдүүдийнхээ төлөө Өөрийн Цорын Ганц Хүүгээ зовон шаналж, үхэхээр илгээсэн Тэнгэрлэг Эцэгийн хайр ямар агуу вэ. “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16).

### **Цагаатгал ба амилалт бүгдэд дахин амилалтыг авчирсан**

Түүний цовдолтын гурав өдрийн дараа Христ Өөрийн биеийг дахин дээш авч, анхны дахин амилсан хүн болсон. Түүний нөхөд Түүнийг харахаар ирэхэд Түүний булшны дэргэд байсан тэнгэр элч “Тэр энд байхгүй. Учир нь хэлж байснаараа Тэр амилсан” гэж хэлэв (Матай 28:6). Түүний сүнс Түүний биетэй эргэн нийлсэн бөгөөд дахин хэзээ ч салахгүй.

Христ ингэснээр биеийн үхлийг ялан дийлсэн. Түүний Цагаатгал байсан учир энэ дэлхий дээрх хүн бүр дахин амилах болно (1 Коринт 15:21–22). Яг Есүс амилсаны адил бидний сүнс биетэйгээ эргэн нэгдэх болно “тэд дахин нэгээхэн ч үхэж чадахгүй болно . . . тэдний сүнснүүд биестэйгээ хэзээ ч салгагдахгүйгээр нэгдэнэ” (Алма 11:45). Ийм байдлыг үхэшгүй мөнх байх гэдэг. Амьдарч байсан бүх хүмүүс дахин амилах болно, “настай мөн залуу аль алинд нь, боол мөн чөлөөт аль алинд нь, эрэгтэй эмэгтэй аль алинд нь, ёс бусыг үйлдэгчид хийгээд зөв шударгыг үйлдэгчдэд аль алинд нь” (Алма 11:44).

- Дахин амилалтын тухай мэдлэг та нарт хэрхэн тусалсан бэ?

### **Цагаатгал Христэд итгэгч тэднийг өөрсдийн нүглүүдээс аврагдах боломжтой болгодог.**

- Энэ хэсгийн зүйрлэл цагаатгалыг ойлгоход хэрхэн тусалдаг талаар бод. Зүйрлэл дэх хүмүүс бидний амьдралд хэнийг төлөөлдөг вэ?

---

**Багш нарт зориулж:** Үзүүлэнт хичээлүүд нь зарчмууд ба сургаалыг ойлгоход ангийн эсвэл гэр бүлийн гишүүдэд тусална. Үхэл ба амилалтыг тайлбарлахын тулд энэ үзүүлэнт хичээлийг ашигла: Гартаа бээлий өмс. Бээлийтэй гар нь: гар – хүний сүнс, бээлий – хүний бие гэж зүйрлэн үз. Бээлийгээ тайл. Энэ нь биеийн үхэлтэй адил сүнс (гар) ба бие (бээлий) салж байна гэдгийг тайлбарла. Дараа нь бээлийгээ эргүүлэн өмс. Энэ нь дахин амилалттай адил сүнс бие хоёр эргэн нэгдэж байна гэдгийг тайлбарла.

Аврагчийн цагаатгал сүнсний үхлийг ялан дийлэх боломжтой болгосон. Зөвхөн Христийн цагаатгалыг хүлээн зөвшөөрсөн тэдгээр нь сүнсний үхлээс аврагдах болно (Итгэлийн тунхаг 1:3).

Түүнд итгэснээр бид Христийн цагаатгалыг хүлээн зөвшөөрдөг. Энэ итгэлээр дамжуулан бид нүглүүдээ наманчилж, баптисм хүртэж, Ариун Сүнснийг хүлээн авч, Түүний зарлигуудад дуулгавартай байдаг. Бид Есүс Христийн итгэлтэй шавь нар болдог. Бид нүглүүдээсээ уучлагдан, цэвэршдэг. Тэнгэрлэг Эцэгтэй буцан очиж үүрд мөнхөд амьдрахад бэлтгэгддэг.

Аврагч бидэнд “Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, . . . бүр Миний адилаар” (С ба Г 19:16–17) хэмээн хэлсэн. Христ бидний нүглүүдийн төлөө цовлогдох Өөрийн ажлаа хийсэн. Түүний Цагаатгалыг өөрсдийн амьдралд бүрэн үр дүнтэй болгохын тулд өөрсдийн нүглүүдийг наманчилж, Түүнд дуулгавартай байхыг бид хичээх хэрэгтэй.

Арванхоёрын зөвлөлийн Ерөнхийлөгч Боид К.Пакер *хэрэв* бид өөрсдөөс хамаарах бүхнээ хийх юм бол Христийн Цагаатгал хэрхэн биднийг нүглээс аврагдах боломжтой болгодгийг дараах зүйлээр дүрслэн үзүүлсэн.

“Би та нарт нэгэн сургаалт үлгэр ярьж өгье.

“Ямар нэгэн зүйлийг маш ихээр хүссэн нэгэн эр байжээ. Энэ нь түүний амьдралын хамгийн чухал зүйл мэт санагдаж байв. Өөрийн хүслийг биелүүлэхийн тулд тэр асар их өрөнд оржээ.

“Ийм их өрөнд унана гэдгийг түүнд сануулж байжээ. Ялангуяа түүний зээлдэгч нь. Гэвч түүнд хүсч байгаа зүйлээ гүйцэлдүүлэх нь чухал бөгөөд одоо л яг түүнийгээ авахыг хүсч байв. Тэр өрүүдийг дараа нь төлж болно гэж найдаж байв.

“Тэр дараа нь яаж ийгээд төлөх болно хэмээх гэрээнд тэр гарын үсгээ зурлаа. Үүний талаар ч их санаа зовсонгүй. Хэзээ нэгэн цагт гэдэг нь түүнд нилээд урт хугацаа мэт санагдаж байлаа. Тэр хүссэн зүйлээ авлаа. Энэ нь л түүнд чухал санагдаж байв.

“Зээлдүүлэгч үргэлж түүний бодол санааны цаад мухарт нь байв. Тэр яагаад ч юм тооцоо бодох өдөр үнэнээр хэзээ

ч ирэхгүй гэж бодон дөнгөж сая мөн дахин бэлэгдлийн төлбөрүүдийг хийлээ.

“Тэвч мэдээж хэрэг дандаа л тийм байдаг, гэрээгээ зохих ёсоор тооцох тэр өдөр ирлээ. Өр бүрэн төлөгдөөгүй байв. Түүний зээлдүүлэгч хүрч ирээд төлбөрийг бүрэн төлөхийг шаардав.

“Зөвхөн тэгэхэд л тэр түүний зээлдүүлэгч зөвхөн түүний эзэмшиж байсан бүхнийг эргүүлэн авах хүчтэй байсан бус мөн түүнийг шоронд хорих хүчтэй байсныг ойлгов.

“Надад төлөх ямар ч боломж алга, би чамд төлж чадахгүй” хэмээн тэр буруугаа хүлээв.

“Тэгэхэд зээлдүүлэгч түүнд, ‘бид гэрээний дагуу чиний эзэмшил эд хөрөнгийг авч, чи шоронд явах болно. Чи ингэхийг зөвшөөрсөн шүү дээ. Энэ чиний сонголт байсан. Чи гэрээнд гарын үсгээ зурсан. Одоо хуулиа мөрдөх ёстой.’

“Та хугацааг сунгах юм уу эсвэл өрийг минь өршөөж болох уу?” гэж өрөнд унасан хүн гуйв. ‘Намайг шоронд оруулахгүй өөр ямар нэгэн арга замыг олооч. Мэдээж та нигүүсэлд итгэдэг биз дээ? Та нигүүлсэл үзүүлэхгүй гэж үү?

“Зээлдүүлэгч түүнд ‘Нигүүсэл үргэлж ганц талтай байдаг. Энэ зөвхөн та нарт үйлчлэх болно. Хэрэв би чамд нигүүлслийг үзүүлбэл энэ нь төлөхгүйгээр үлдэнэ гэсэн үг. Энэ бол миний шаардах шүүлт. Та нар шүүлтэнд итгэдэг үү?

“Би гэрээнд гарын үсэг зурах үедээ шүүлтэнд итгэж байсан” хэмээн өртэй хүн хэлэв. ‘Энэ нь миний төлөө байсан юм байна, намайг энэ хамгаалах болно гэж би бодох байжээ. Тэгсэн бол надад нигүүсэл хэрэггүй байсан байна. Надад хэрэгтэй гэдгийг ч би бодсонгүй. Би бодохдоо шүүлт нь бид хоёрт хоёуланд нь тэнцүү үйлчлэх болно гэж бодож байлаа.’

“Энэ бол чи гэрээнийхээ дагуу төлбөрөө төлөх эсвэл шийтгэлийнхээ төлөө зовох тэр шүүлт” хэмээн зээлдүүлэгч хариулав. Энэ бол хууль. Та нар үүнийг зөвшөөрсөн бөгөөд яг ийм л байх ёстой. Нигүүлсэл шүүлтийг дээрэмдэж чадахгүй.’

“Тэдгээр нь: Нэг нь шүүлтийг гаргаж, бусад нь нигүүслийн төлөө гуйдаг. Нэг нь зовж, нөгөөдөх нь жаргаж байдаг юм хаа ч үгүй.

---

“Хэрэв та өрийг мартахгүй юм бол нигүүсэл гэж үгүй болно’ хэмээн өрөнд унасан хүн царайчлав.

“Хэрэв би үүнийг хийвэл шүүлт гэж байхгүй байх болно’ хэмээн зээлдүүлэгч хариулав.

“Хоёр хууль хоёул хамтдаа зэрэг биелэгдэж чадахгүй нь харагдаж байна. Тэд бие биетэйгээ зөрчилдөх мэтээр харагдах мөнхийн өв тэгш хоёр хууль. Шүүлт ба нигүүсэл хоёр хоёул бүрэн сэтгэл хангалуун байх зам байхгүй гэж үү?

“Тийм зам бий! Шүүлтийн хууль нь бүрэн сэтгэл хангалуун байж *чадах* мөн нигүүлсэл бүрэн өгөгдөж *чадах* зам бий. Үүний тулд хэн нэгний оролцоо шаардлагатай. Иймээс энэ бүхэн энэ цагт тохиолдсон юм.

“Өрөнд унасан хүнд нэг найз байжээ. Тэр туслахаар ирсэн. Тэр өрөнд унасан хүнийг сайн таньдаг байв. Тэр түүнийг богино ухаантай гэдгийг мэдэж байв. Түүнийг тэр өөрийгөө ийм гарцаагүй мухардалтанд оруулж байдаг тэнэг юм даа гэж бодож байв. Тэгсэн ч тэр түүнд хайртай байсан тул түүнд туслахыг хүссэн. Тэдний дундуур тэр алхан орж, зээлдүүлэгчтэй нүүр тулан түүний хүссэнийг хийсэн.

“Хэрэв чи түүнийг хийсэн гэрээнээс нь чөлөөлж, түүний эд хөрөнгийг үлдээн, шоронд орохгүй болгох юм бол би өрийг нь төлөх болно.

“Зээлдүүлэгчийг энэ талаар бодож байхад нь, зууч мөн нэмж ‘Та шүүлтийг шаардсан. Тэр үүнийг төлж чадахгүй, би түүнийг нь хийх болно. Та дахин шаардахааргүй тийм шүүлтийг хүлээн авах болно. Дахин үүнийг нэхэхгүй болно.’

Тэгээд зээлдүүлэгч зөвшөөрөв.

“Зууч өрөнд унасан хүн уруу эргэж харав. “Хэрэв чиний өрийг төлөх юм бол чи намайг өөрийн зээлдүүлэгч хэмээн хүлээн зөвшөөрөх үү?

“Тэгэлгүй яахав’ хэмээн өрөнд унасан хүн уухай алдав.

“Та намайг шоронгоос аварч нигүүслийг үзүүлээч.’

“Тэгээд өглөгийн эзэн ‘чи надад өрийг төлөх болно, би нөхцлийг нь тогтоох болно. Энэ амар байхгүй, гэхдээ энэ боломжтой байх болно. Би замыг нь бэлдэх болно. Та шоронд явах шаардлагагүй.’

“Ингээд өр зээл бүрэн төлөгдсөн байв. Тэр төлбөрийг бүрэн төлсөн байв. Гэрээ хүчингүй болсон.

“Өрөнд унасан хүн хариуд нь нигүүслийг үргэлжлүүлэн авсан. Хоёр хууль хоёул бүрэн гүйцэлдсэн. Учир нь нэхэгдэж байсан шүүлт бүрэн хийгдэж, нигүүсэл бүрэн сэтгэл хангалуун болсон зууч тэнд байлаа” (1977 оны 4-р сарын Ерөнхий Чуулган, 79–80; эсвэл 1977 оны 5-р сарын *Ensign*, 54–55).

Бидний нүглүүд бол бидний сүнсний өрнүүд юм. Бидний Аврагч, Зууч Есүс Христгүйгээр бид сүнслэг үхлийн зовлонгоор өөрсдийн нүглүүдийг төлөх болно. Гэхдээ Тэр байгаа учраас хэрэв бид Түүний нөхцлүүд болох Түүний зарлигуудыг сахих аваас бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдрахаар Түүнд эргэн очиж чадна.

Христ бидэнд нүглүүдээсээ ангижрах замыг хангаж өгсөн нь ямар гайхамшигтай вэ. Тэр хэлэхдээ:

“Болгоогтун, дэлхийнхэнд гэтэлгэл авчрахаар, дэлхийнхнийг нүглээс нь аврахаар би дэлхийнхэнд ирсэн бөлгөө.

“Тиймийн тул, наманчилж мөн бяцхан хүүхдийн адил надад ирэх хэнийг боловч, би түүнийг хүлээн авах болно, учир нь Бурханы хаант улс бол ийм хүмүүсийнх юм. Болгоогтун, ийм хүмүүсийн төлөө би амиа өгч, мөн үүнийгээ буцаан авсан юм; тиймийн тул намачил, мөн дэлхийн хязгаарууд та нар надад ир, мөн аврагдагтун” (3 Нифай 9:21–22).

- Цагаатгалын бэлгийн төлөө хэрхэн өөрсдийн талархлаа үзүүлж болох талаар тунгаан бод.

### **Нэмэлт судрууд**

- Алма 34:9–16 (Бурханы золиослол, Цагаатгал гарцаагүй байсан, )
- 2 Нифай 9:7–12 (Цагаатгал биднийг биеийн болон сүнсний үхлээс авардаг)
- Роман 5:12–17 (нэгнээр үхэл ирж, нэгнээр амь ирдэг)
- Хиламан 14:15–18 (Есүсийн үхлийн шалтгаан)
- Итгэлийн тунхаг 1:3 (бүгд аврагдаж болохын тулд)
- 1 Петр 1:18–20 (Есүс урьдчилан томилогдсон)
- Матай 16:21 (Есүсийн золиослол гарцаагүй шаардлагатай байсан)
- Лук 22:39–46 (цэцэрлэг дэх Есүсийн шаналал )
- 1 Иохан 1:7 (Есүс нүглээс цэвэрлэдэг)
- 2 Нифай 9:21–22 (Адрагч бүх хүн төрөлхтөний төлөө зовсон)
- Мозая 16:6–8 (амилалт зөвхөн Есүсээр дамжин боломжтой болсон)
- Алма 11:40–45; Мормон 9:12–14 (бүгд дахин амилах болно)
- Исаиа 1:18 (нүглүүд цагаан болох болно)
- 1 Коринт 15:40–44; Алма 40:23 (Амилалтын тухай дүрслэл)



# Санваар

Бүлэг 13

---

## Санваар гэж юу вэ?

Санваар гэдэг нь Бурханы эрх мэдэл ба мөнхийн хүч. Санваараар дамжуулан Тэр тэнгэр болон дэлхийг бүтээсэн бөгөөд захирдаг юм. Энэхүү хүчээр орчлон төгс журамд оршин байдаг. Энэ хүчээр дамжуулан Тэр “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Моисе 1:39) Өөрийн ажил болон алдар сууг гүйцэлдүүлдэг.

Тэнгэрлэг Эцэг Сүмийн зохистой эрэгтэй гишүүдэд Өөрийн санваарын хүчийн бүрэн эрхийг олгодог. Санваар тэднийг хүмүүний гэр бүлийн авралын төлөө Бурханы нэрээр үйлдэх эрхийг өгдөг. Үүгээр дамжуулан тэд сайн мэдээг номлож, авралын ёслолуудыг гүйцэтгэж, дэлхий дээр Бурханы хаант улсыг удирдан захирдаг.

- Зохистой эрчүүд болон хөвгүүд Бурханы санваарыг атгах боломжийн ач холбогдлын талаар бод.

## Дэлхий дээр бидэнд яагаад санваар хэрэгтэй вэ?

Бидэнд баптисм хүртээх, гишүүнээр батлах, ариун ёслолыг гүйцэтгэх, ариун сүмийн гэрлэлт зэрэг сайн мэдээний нандин ёслолуудыг Бурханы нэрээр үйлдэхэд санваарын эрх мэдэл байх ёстой. Хэдийгээр тэр чин сэтгэлээсээ байсан ч хэрэв тухайн эрэгтэй санваар хүртээгүй бол Их Эзэн түүний гүйцэтгэсэн

---

**Багш нарт зориулж:** Энэ бүлэг таван гарчгийн дор яригдах болно. Гарчиг бүр нь санваарын талаарх асуулт байх болно. Эдгээр асуултуудыг хичээлийн удирдамж болгон ашиглаж болно. Хэрэв тохиромжтой бол ангийн гишүүдийг хоёроос дөрвөн хүнтэй баг болгон хуваа. Баг бүрт бүлгийн нэг хэсгийг даалгаж өг (том анги бол нэг хэсгийг хэд хэдэн баг давхардуулан өгч болно). Баг бүрээр доорх зүйлсийг хийлгэ: (1) Өөрсдийн авсан хэсгийг уншаад ярилц. (2) Хэсэгт байгаа асуултуудад хариулах судруудыг ол. (3) Хэсэгт хамааралтай өөрийн туршлагаасаа хуваалц. Дараа нь ангийн гишүүдийг туршлагаасаа хуваалцахыг хүс.



ёслолуудыг танихгүй (Матай 7:21–23; Итгэлийн тунхаг 1:5). Дэлхий дээрх эдгээр чухал ёслолууд санваарыг атгагч эрэгтэйчүүдээр гүйцэтгэгдэх ёстой.

Дэлхий даяарх Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг мөн Сүмийн ажлыг удирдан явуулахын тулд эрэгтэйчүүдэд санваар хэрэгтэй. Христ дэлхий дээр амьдарч байхдаа Түүний Сүмийг удирдах Төлөөлөгчдөө сонгон томилсон. Тэр тэдэнд Түүний нэрээр үйлдэх санваарын эрх мэдэл, хүч чадлыг өгсөн (Марк 3:13–15; Иохан 15:16).

Дэлхий дээр санваар хэрэгтэй байсан бас нэг шалтгаан нь Их Эзэний тааллыг ойлгож, Түүний зорилгыг авч явж болохын тул билээ. Бурхан Өөрийнхөө эрх мэдэлтэй санваартан төлөөлөгч болох бошиглогчоор дамжуулан илчилдэг. Сүмийн Ерөнхийлөгч буюу бошиглогч нь дэлхийн бүх хүнд болон сүмийн бүх гишүүдэд Бурханы төлөөлөгчөөр үйлчилдэг.

- Ёслолуудыг гүйцэтгэхийн тул зүй ёсны эрх мэдэлтэй байх нь хүмүүнд яагаад чухал вэ?

### **Эрэгтэйчүүд санваарыг хэрхэн хүлээн авдаг вэ?**

Дэлхий дээрх Өөрийн хөвгүүддээ Түүний санваар дэг журамтай өгөгдөж байх замыг Их Эзэн бэлтгэсэн. Зохистой эрэгтэй Сүмийн гишүүн “сайн мэдээг номлох хийгээд ёслолуудыг гүйцэтгэхийн тулд хүн бошиглоолоор, мөн эрх мэдэл бүхний тэдний гар тавилтаар” (Итгэлийн тунхаг 1:5) санваарыг хүлээн авдаг.

Энэ бол олон жилийн өмнө бүр Мосегийн өдрүүдэд хүмүүс санваарыг хүлээн авч байсантай ижил зам бөгөөд: “Ямар ч хүн энэ хүндэтгэлийг авдаг бус, харин Аароны адил Бурханаар дуудагдсан хүн авдаг” (Еврей 5:4). Аарон өөрийн санваартан удирдагч, Мосегоос санваар хүлээн авсан (Египетээс гарсан нь 28:1). Томилолтыг хийх түлхүүрүүдийг атгасан тэдгээрээс бүрэн эрх мэдэл олгогдсон ба зөвхөн санваарыг атгагч тэд л бусдыг томилж чадна (энэ номны 14-р бүлгийг үз).

Санваарын эрх мэдэл, хүч худалдан авах юм уу худалдаалагдахгүй. Мөн тэд өөрсдөө энэ эрх мэдлийг авч чадах нь үгүй. Хуучин

Гэрээнд бид Христийн төлөөлөгчид сүмийг тэргүүлж байх үед амьдарч байсан Симон хэмээх эрийн тухай уншдаг. Симон сүмд хөрвүүлэгдэн, баптисм хүртсэн хүн байв. Тэр чадварлаг ид шидтэн байсан тул хүмүүс түүнд Бурханы хүч байгаа гэдэгт итгэдэг байв. Гэвч Симонд санваар байгаагүй, үүнийгээ ч тэр мэддэг байв.

Сүмийн төлөөлөгчид болон бусад санваарын удирдагчдад Бурханы жинхэнэ хүч байдаг гэдгийг Симон мэддэг байв. Их Эзэний ажлыг тэд өөрсдийн санваарыг ашиглан үйлдэхийг Симон харсан бөгөөд тэр хүчийг авахыг хүсч байв. Санваарыг худалдан авах саналыг тэр тавив (Үйлс 8:9–19). Гэвч ерөнхий Төлөөлөгч Петр түүнд “Мөнгө чинь чамтай хамт мөхөг. Учир нь Бурханы бэлгийг мөнгөөр авч болно гэж чи санажээ” (Үйлс 8:20).

- Яагаад “хэн ч энэ хүндэтгэлийг [санваар] авч чадахгүй” вэ?

### **Санваарыг эрэгтэйчүүд зүй ёсоор нь хэрхэн ашиглах вэ?**

Санваар дэлхий дээрх Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн амьдралыг адислахад хэрэглэгдэх ёстой. Санваарыг атгагчид хайр, нинжин сэтгэлээр гүйцэтгэх ёстой. Тэд өөрсдийн гэр бүл болон бусдыг тэдэнд дуулгавартай байхыг хүчилж болохгүй. Зөв шударгад бус аваас санваарын хүч нь хянагдаж чадахгүй гэдгийг Их Эзэн бидэнд хэлсэн (С ба Г 121:36). Бид хөрөнгө мөнгөтэй баян болохын төлөө юм уу нэр хүндийн төлөө эсвэл бусад хувиа хичээсэн зорилгын тул санваарыг хэрэглэхээр хичээх аваас “болгоогтун, тэнгэр өөрийгөө татан авдаг буюу; Их Эзэний Сүнс гашууддаг болой; мөн энэ нь буцаан татагдахад, тэр хүний санваарт эсвээс эрх мэдэл Амен” (С ба Г 121:37).

Хэн нэгэн санваарыг “санваарын ариун журмаар төдийгүй гагцхүү сэнхрүүлээр, тэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайраар тэтгэгдэж чадах”-аар (С ба Г 121:41) хэрэглэнэ тэр гэр бүл болон бусдын төлөө олон гайхамшигт зүйлсийг хийж чадна. Ёслолуудыг гүйцэтгэх түлхүүрүүдийг атгасан тэдгээрээс бүрэн эрх мэдэл олгогдсон үед тэр баптисм хүртээж, гишүүнээр батлаж, ариун ёслолыг

удирдан явуулж чадна. Тэр өвчтэйг адислаж чадна. Гэр бүлийн гишүүдэд нь онцгой шаардлага гарах үед хамгаалахаар мөн дэмжин урамшуулахаар санваарын адислалуудыг тэр өгч чадна. Мөн бусад гэр бүлд эдгээр ёслол ба адислалууд хэрэгтэй үед нь тусалж чадна.

Санваарын эрх мэдлийг салбарын ерөнхийлөгч, бишоп, чуулгын ерөнхийлөгч, гадасны ерөнхийлөгч болон номлолын ерөнхийлөгч зэрэг сүмийн дуудлагуудад тэргүүлэхэд ашигладаг. Сүмд албан хаагч болон багш зэрэг ямар нэгэн албан тушаалд байгаа эрэгтэй ба эмэгтэй хүмүүс санваартны удирдагчдын удирдлага болон Ариун Сүнсний удирдамжаар ажилладаг.

### **Бид санваарыг зүй ёсоор нь хэрэглэвэл ямар адислалууд ирдэг вэ?**

Бусдыг адислахаар санваарыг хэрэглэж буй зөв шударга санваартануудад Их Эзэн агуу адислалуудыг амласан.

“Итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй болох болно; мөн санваарын номлол тэнгэрээс буух шүүдэр лугаа адил чиний сүнсэн дээр намуухан буух болно.

“Ариун Сүнс чиний байнгын хамтрагч мөн чиний очир таяг, зөв шударга ёс хийгээд үнэний хувиршгүй очирт таяг байх болно; мөн эзэгнэл чинь үүрдийн эзэгнэл байх болно; мөн албадлагын арга хэрэгсэлгүйгээр энэ нь чам руу үүрд мөн мөнхөд урсах болно” (С ба Г 121:45–46).

Ерөнхийлөгч Дэвид О.МкКэй санваарыг зөв шударгад хэрэглэдэг эрэгтэй хүн бүрт “түүний амьдрал нь илүү тансаг сайхан болж, түүний сайн мууг ялгах чадвар нь хурцлагдах, түүний мэдрэмж нь зөөлөн энэрэнгүй, өрөвдөн хайрласан, ариун сүнс нь үнэнийг хамгаалах хүчтэй, зоримог шийдэмгий байж, санваар нь хэзээ ч дуусашгүй аз жаргалын ундарга—мөнхийн амьдрал уруу урсагч амьд усны булаг болохыг тэр мэдэх болно (*Teachings of Presidents of the Church: Дэвид О. МкКэй* [2003], 116).

- Санваараар дамжуулан хүлээн авсан зарим адислалууд тань юу вэ?

**Нэмэлт судрууд**

- С ба Г 84; 107 (С ба Г 84:33–40 дээрх санваарын тангараг ба гэрээг оролцуулан санваарын тухай илчлэлтүүд)
- С ба Г 20:38–67 (санваарын үүрэг хариуцлагуудын тайлбар)



# Санваартны байгууллага

Бүлэг 14

---

## Өнөөдөр дэлхий дээр санваар бий

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь санваараар удирдагддаг. Санваар нь үргэлж Бурханаас хамааралтай байдаг. Бурханы сүмд бүх үед үргэлжилдэг, мөн өдрүүдийн эхлэл буюу жилүүдийн төгсгөлгүй санваар болой” (С ба Г 84:17). Энэ нь өнөөдөр дэлхий дээр байна. Санваарыг Сүмд баптисм хүртсэн эрэгтэйчүүдийг зохистой байгаа нь тогтоогдсоны дагуу тэдэнд хүртээдэг. Тэдэнд дэлхий дээр Их Эзэний ажлыг хийж, Түүний нэрээр үйлдэх эрх мэдэл өгөгддөг.

## Санваарын хоёр ангилал

- Мелкизедек ба Аароны санваарын нэр хэрхэн өгөгдсөн бэ?

Санваар нь Мелкизедек санваар ба Аароны санваар гэсэн хоёр хэсэгт хуваагддаг (С ба Г 107:1). “Анхных нь Мелкизедек санваар хэмээн нэрлэгддэгийн учир нь Мелкизедек агуу дээд санваартан байсан бөлгөө.

“Түүнээс өмнөх үеүдэд энэ нь *Бурханы Хүүгийн жаягийн дагуу Ариун Санваар* хэмээн нэрлэгддэг байв.

Гэвч Агуу Нэгэний нэрийг хүндэтгэх буюу эрхэмлэн хүндлэхээс үүдэн, түүний нэрийг хэтэрхий олон удаа давтахаас зайлсхийж, тэд, сүмийнхэн эрт дээр үед энэ санваарыг Мелкизедекийн нэрээр, эсвээс Мелкизедек санваар хэмээн нэрлэдэг байжээ” (С ба Г 107:2–4; налуулсан хэсгүүд нь анхны эх).

---

**Багш нарт зориулж:** Хэсгийн эхэн дэх асуултуудаар ярилцлагыг эхлүүл. Мөн тэднийг хичээлээс дэлгэрэнгүй мэдээлэл авахыг сануул. Хэсгийн төгсгөл дэх асуултуудыг ашиглан тэдний уншсан зүйлийн утга учир мөн тэдгээрийг өөрсдийн амьдралд хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилц.

Доод санваар гэдэг нь Мелкизедек Санваарын хавсралт юм. Энэ нь Аарон болон түүний хөвгүүдийн бүх үеийнхэнд олгогдсон байсан учраас үнийг Аароны Санваар хэмээн нэрлэсэн. Аароны санваарыг атгагч нь баптисм хүртээх, ариун ёслол адислаж түгээхээс гадна бусад ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэлтэй байдаг (С ба Г 20:46; 107:13–14, 20).

Мелкизедек Санваар атгагчид Сүмийг тэргүүлэх, дэлхий дахинд сайн мэдээний номлолыг удирдах хүч, эрх мэдэл байдаг. Тэд Сүмийн бүх сүнсэлэг ажлуудыг гүйцэтгэдэг (С ба Г 84:19–22; 107:8). Тэд ариун сүмд хийгддэг ажлуудыг удирдаж; тойрог, салбар, гадас ба номлолыг тэргүүлдэг. Сүмийн Ерөнхийлөгчид болох Их Эзэний сонгосон бошиглогчид нь Мелкизедек Санваарын дээрх дээд пристийг тэргүүлдэг (С ба Г 107:65–67).

### **Санваарын түлхүүрүүд**

- Санваар болон санваарын түлхүүрүүд хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ? Ямар санваартан удирдагч нар түлхүүрүүдийг хүлээн авдаг вэ?

Санваарын түлхүүрүүдийг хүлээн авах болон санваарын албан тушаалд томилогдох хоёрын хооронд ялгаа байдаг. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит заахдаа:

“Санваар гэдэг нь ерөнхийдөө эрэгтэй хүнд Бурханы нэрийн өмнөөс үйлдэхэд өгөгддөг эрх мэдэл юм. Санваарын аль нэгэн зэргийг хүртдэг эрэгтэй хүн бүрт энэ эрх мэдэл олгогддог.

“Гэхдээ энэ эрх мэдлийн дор гүйцэтгэх үйлдэл бүр зөв цагт, зөв газар, зөв замаар, зөв жаягийн дагуу гүйцэтгэгдэх шаардлагатай. Эдгээр ажлыг удирдах хүчийг Санваарын *түлхүүрүүд* гэдэг. Бүрэн дүүрэн сэргээгдсэн үед түлхүүрүүдийг зөвхөн Сүмийн ерөнхийлөгч бөгөөд бошиглогч атгадаг. Энэхүү хүчийн аль нэгэн хэсгийг өөр хэн нэгэнд шилжүүлэн өгч болох ба энэ тохиолдолд тухайн хүн нь тухайн ажлын түлхүүрийг атгадаг болж байгаа юм. Иймд ариун сүмийн ерөнхийлөгч, гадасны ерөнхийлөгч, тойргийн бишоп, номлолын ерөнхийлөгч, чуулгын ерөнхийлөгч бүр тухайн газартаа ажлыг гүйцэтгэх түлхүүрүүдийг атгадаг. Түүний Санваар нь энэ онцгой дуудлагаар нэмэгддэг гэсэн үг

бус. Жишээ нь: ахлагчдын чуулгын ерөнхийлөгч чуулгынхаа аль нэгэн гишүүнээс илүү Санваартай гэсэн үг биш юм. Гэхдээ тэр чуулгад гүйцэтгэх албан ёсны ажлыг удирдах хүчийг атгадаг. Өөрөөр хэлбэл, тухайн хэсгийн ажлын *түлхүүрүүдийг* атгадаг” (*Teachings of Presidents of the Church: Жозеф Ф. Смит* [1998], 141; налуу бичилт анхны эх).

- Санваарын түлхүүрүүд сүмийг хэрхэн аюулгүйгээр удирдаж байна вэ?

### **Аароны санваарын албан тушаалууд ба үүрэг хариуцлагууд**

- Аароны санваарыг атгагчид ямар замаар үйлчилдэг вэ?

Аароны санваар хэн нэгэн эрэгтэй болон хөвгүүнд өгөгдснөөр тэр энэ санваарын албан тушаалд томилогддог. Аароны санваар нь дикон, багш, прист, бишоп гэсэн албан тушаалтай. Албан тушаал бүр тус тусдаа үүрэг ба хариуцлага хүлээнэ. Чуулга бүрийг чуулгын ерөнхийлөгч удирдаж, чуулгын гишүүдэд өөрсдийнх нь үүргүүдийг зааж, дуудлагуудаа бүрэн гүйцэтгэхийг хүсдэг.

Зарим эрэгтэйчүүд санваарын тухайн албан тушаалыг хүлээн авах наснаасаа хэтэрсэн үедээ сүмд элсэн мөн идэвхждэг. Тэд ихэвчлэн Аароны санваарын албан тушаалыг хүртдэг ба зохистой байх аваас өөр албан тушаалд томилогдож болно.

#### *Дикон*

Баптисм хийлгэн, ариун сүнсний бэлгийг хүртэж Сүмийн гишүүнээр батлагдсан зохистой, 12 настай залуу эрэгтэй диконы албан тушаал хүртдэг. Дикон нь Сүмийн гишүүдэд ариун ёслол түгээх, Сүмийн байр болон гаднах талбайг цэвэр цэмцгэр, бүрэн бүтэн байлгах, санваартны удирдагчдын зарлага элч хийх мөн мацгийн өргөл цуглуулах зэрэг онцгой даалгаврыг гүйцэтгэдэг.

#### *Багш*

14 буюу түүнээс дээш насны зохистой залуу эрэгтэй багшаар томилогдоно. Багш нарт диконы албан тушаалын хүч хэвээр байхаас гадна нэмэлт хүч, эрх, үүрэг өгөгддөг. Аароны санваарын



багш нар Сүмийн гишүүдэд зарлигийн дагуу амьдрахад туслах үүрэгтэй (С ба Г 20:53–59). Энэ үүрэг хариуцлагаа бүрэн гүйдэл-дүүлэхийн тул ихэвчлэн тэд гэрийн багшаар үйлчлэхээр дуудагддаг. Тэд Сүмийн гишүүдийн гэрээр зочилж, тэднийг сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахад дэмжин тусалдаг. Тэд судруудаас сайн мэдээний үнэнийг заахаар тушаагдсан байдаг (С ба Г 42:12). Багш нар ариун ёслолын талх, усыг бэлтгэдэг.

### *Прист*

16 ба түүнээс дээш насны зохистой залуу эрэгтэй пристийн албан тушаалыг гүйцэтгэж болно. Прист нарт дикон ба багш нарын албан тушаалын болон зарим нэмэлт хүчнүүд, эрх ба үүрэг хариуцлагууд байдаг (С ба Г 20:46–51). Прист баптисмын ёслол гүйцэтгэж болно. Тэр мөн ариун ёслолыг удирдан явуулж болно. Мөн прист, багш ба диконуудийг томилох эрхтэй. Мелкизедек санваартан байхгүй тохиолдолд цуглааныг прист удирдан явуулах эрхтэй. Тэр өөрийн эргэн тойронд байгаа хүмүүст сайн мэдээг номлоно.

### *Бишоп*

Бишоп нь тойрог дахь Аароны санваартнуудыг тэргүүлэхээр томилогдож, онцгой адислалыг авдаг. Тэр бол пристийн чуулгын ерөнхийлөгч юм (С ба Г 107:87–88). Тэр Аароны санваарын албан тушаал гүйцэтгэж байхдаа бишоп юуны түрүүнд санхүү, бүртгэл тайлан мэдээ мөн ядуус болон гачигдалтай хүмүүсийг халамжлан туслах ажлыг удирдах зэрэг дэлхийн материаллаг асуудлуудыг шийдэж ажилладаг (С ба Г 107:68).

Бишоп мөн дээд пристээр томилогддог. Ингэснээр тэр тойргийн бүх гишүүдийг тэргүүлэх болно (С ба Г 107:71–73; 68:15). Бишоп нь гишүүдтэй ариун сүмийн зөвшөөрөл авах ярилцлагыг хийх, санваарын томилгоонууд ба бусад хэрэгцээг хангах Изриалын шүүгч билээ (С ба Г 107:74). Тэдэнд ажигч гярхай, юмыг ялгаж таних бэлэг өгөгдсөн.

- Аароны санваартны үйлчлэлээр дамжуулан та нар хэрхэн адислагдаж байсан бэ?

## Мелкизедек санваарын албан тушаалууд ба үүргүүд

- Мелкизедек санваар атгагчид хэрхэн үйлчилдэг вэ?

Мелкизедек санваар нь ахлагч, дээд прист, патриарх, Дал ба Төлөөлөгч албан тушаалтай.

### *Ахлагч*

Ахдагчид Сүмийг харж хандах, заах, ойлгуулах, уриалах, баптисм хүртээх зэрэгт (С ба Г 20:42) дуудагддаг. Мелкизедек санваар атгагчид нь ахлагчид. Тэд гар тавилтаар Ариун Сүнсний бэлэг хүртээх эрх мэдэлтэй (С ба Г 20:43) байдаг. Ахлагчид Ариун Сүнсээр удирдагдан Сүмийн цуглаануудыг хөтлөн явуулах үүрэгтэй (С ба Г 20:45; 46:2). Ахлагчид өвчтөнийг (С ба Г 42:44) мөн хүүхдүүдийг адислаж (С ба Г 20:70) чадна. Ахлагчид дээд прист эзгүй тохиодолд Сүмийн цуглаануудыг тэргүүлдэг (С ба Г 107:11).

### *Дээд прист*

Дээд пристэд Сүм дээр албан үүрэг гүйцэтгэх ба сүнслэг зүйлүүдийг удирдан явуулах эрх мэдэл өгөгдсөн байдаг (С ба Г 107:10, 12). Тэр мөн бүх доод албан тушаалуудын албан үүргийг гүйцэтгэж болно (С ба Г 68:19). Гадасны ерөнхийлөгч, номлолын ерөнхийлөгч, дээд зөвлөхүүд, бишоп ба Сүмийн бусад удирдагч нар нь дээд пристээр томлогдсон байдаг.

### *Патриарх*

Патриархууд Сүмийн гишүүдэд патриархын адислал өгөхөөр Ерөнхий Эрх Мэдэлтнүүдээр томилогддог бөгөөд хэрэв Арванхоёрын Зөвлөлөөс зөвшөөрөн эрх мэдлийг нь олгосон бол гадасны ерөнхийлөгч томилж болдог. Эдгээр адислалууд дэлхий дээрх бидний дуудлагуудын талаар зарим ойлголттой болоход тусалдаг. Тэдгээр нь бидний хүн бүрт өгөгдсөн Их Эзэний үгс юм. Патриарх мөн дээд пристээр томилогддог (С ба Г 107:39–56).

### *Дал*

Далууд нь дэлхийд Есүс Христийг гэрчлэх онцгой гэрчлэгчид бөгөөд Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын

удирдлага дор Сүмийг хүчирхэгжүүлэх, журамлан зохицуулахад тусалдаг (С ба Г 107:25, 34, 38, 93–97).

### *Төлөөлөгч*

Төлөөлөгч нь дэлхий дахинд Есүс Христийг гэрчлэх онцгой гэрч юм (С ба Г 107:23). Төлөөлөгчид дэлхий даяарх Сүмийн үйл хэргийг удирдан явуулдаг. Мелкизедек санваар дахь Төлөөлөгчийн албан тушаалд томилогдсон хүн ихэвчлэн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээс онцгой адислагыг хүртдэг. Тэдгээр хүн бүрт дэлхий дээрх Бурханы хаант улсын бүх түлхүүр өгөгддөг. Харин ахмад Төлөөлөгч буюу Сүмийн Ерөнхийлөгч бүх түлхүүрүүдийг идэвхтэйгээр хэрэглэх эрхтэй байдаг. Бусад нь түүний удирдлага дор үйлддэг.

- Мелкизедек санваартнуудын үйлчлэлээр дамжуулан та нар хэрхэн адислагдаж байсан бэ?

### **Аароны санваарын чуулгууд**

Санваартнууд чуулгуудад зохион байгуулалттайгаар нэгдсэн байхыг Их Эзэн зааварласан. Чуулга нь ижил санваарын албан тушаалд байгаа ах нарын бүрэлдэхүүн юм.

Аароны санваарын гурван чуулга байдаг. Үүнд:

1. Диконы чуулгад 12 дикон хамрагддаг (С ба Г 107:85).  
Диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийг чуулгын гишүүдээс бишоп дууддаг.
2. Багш нарын чуулгад 24-н багш хамрагддаг (С ба Г 107:86).  
Багш нарын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийг чуулгын гишүүдээс бишоп дууддаг.
3. Пристийн чуулгад 48-н прист хамрагддаг (С ба Г 107:87–88).  
Энэ чуулгыг тухайн тойргийн бишоп тэргүүлэн удирддаг.  
Бишоп нь дээд прист бөгөөд дээд пристийн чуулгад харъяалагддаг.

Нэг чуулгад хамаарах тоо хэтрэх үед чуулгыг хувааж болно.

## Мелкизедек санваарын чуулгууд

Сүмийн хэмжээнд Тэргүүн Зөвлөлийн гишүүд болон Арванхоёр Төлөөлөгчид нь чуулгад хамрагддаг. Далууд мөн чуулгад хамрагддаг.

Орон нутгийн Сүмийн хэмжээнд тойрог, салбар, гадас ба дүүргүүд дэх Мелкизедек санваартнууд нь дараах чуулгуудад хамрагдана. Үүнд:

### *Ахлагчдын чуулга*

Ахлагчдын чуулга бүр “байнгын тохинуулагчдын тулд байгуулагддаг бөлгөө; тэд аялж болох хэдий ч, харин тэд миний сүмд байнгын тохинуулагчид байхаар томилогддог” (С ба Г 124:137). Тэд ажлаа голчлон өөрсдийн гэрийн ойролцоо хийдэг. Чуулга нь 96 хүртэлх ахлагчаас бүрдэх бөгөөд чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлөөр удирдуулдаг. Энэ тоо нь хэтрсэн тохиолдолд чуулгыг хувааж болно.

### *Дээд пристийн чуулга*

Чуулга нь патриарх, бишоп нарыг оролцуулан гадасны хэмжээн дэх бүх дээд прист нарыг багтаадаг Гадасны ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд нь энэ чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл юм. Тойрог бүрийн дээд пристүүд бүлэг болон хуваагдаж бүлэг бүр удирдагчтай байдаг.

## Санваарын чуулгуудын ач холбогдол

- Санваарын чуулгууд хувь хүн болон гэр бүлүүдийг хүчирхэгжихэд хэрхэн тусалж чадах вэ?

Санваар хүртсэн эрэгтэй хүн бүр эсвэл хөвгүүн бүр аяндаа шууд санваарын чуулгын гишүүн болдог. Эндээс эхлэн амьдралынхаа турш албан тушаалынхаа дагуух санваарын чуулгын гишүүнчлэлд байсаар байх болно (Бойд К.Пакер, “What Every Elder Should Know—and Every Sister as Well: A Primer on Principles of Priesthood Government,” *Ensign*, 1993 оны 2-р сар, 9).

Хэрэв санваарын чуулгын үйл ажиллагаа нь хэвийн байгаа бол чуулгын гишүүд өөрсдийн удирдагчдаар сайн мэдээг заалгаж, дэмжигдэн урамшигдаж, адислагдаж, нөхөрлөн найзалдаг. Хэдийгээр хэн нэгэн эрэгтэй багш, чуулгын ерөнхийлөгч, бишоп, дээд прист эсвэл гадасны ерөнхийлөгч зэрэг Сүмийн дуудлагаас буусан ч түүний чуулга дахь гишүүнчлэл өөрчлөгдөхгүй хэвээр байх болно. Санваарын чуулга дахь гишүүнчлэлийг нандин боломж мэт үзэх ёстой.

### **Санваарын туслах бүлгүүд**

- Санваарын туслах бүлгүүд хувь хүн болон гэр бүлүүдийг хүчирхэгжихэд хэрхэн тусалж чадах вэ?

Сүм дэх бүх байгууллагууд санваарын удирдагчдын удирдлага дор ажиллах ба тэдэнд Их Эзэний ажлыг хийхэд нь тусалдаг. Жишээ нь: тойргийн Нийгмийн халамжийн бүлэг, Залуу эмэгтэйчүүд, Залуу эрэгтэйчүүд, Хүүхдийн хэсэг, Ням гарагийн анги зэрэг байгууллагууд нь бишопын зөвлөлийн удирдлага дор үйлчилдэг. Эдгээр байгууллагуудыг санваарын туслах бүлгүүд хэмээн нэрлэдэг.

- Санваарын чуулгууд ба туслах бүлгүүдийг амжилттай байхад нь туслахад хувь хүний үүрэг ямар ач холбогдолтой вэ?

### **Нэмэлт судрууд**

- Алма 13:1–19 (ямар нөхцөлд эрэгтэйчүүд санваар хүртдэг вэ)
- Матай 16:19; С ба Г 68:12 (Төлөөлөгчдөд дэлхий дээр лацадсан нь тэнгэрт лацлагдах санваарын түлхүүрүүд ба хүч өгөгддөг)
- С ба Г 20:38–67 (ахлагч, прист, багш, диконы үүргүүд)
- С ба Г 84; 107 (санваарын тухай илчлэлтүүд)
- 1 Коринт 12:14–31 (санваарын албан тушаал бүр чухал ач холбогдолтой)

# Их Эзэний гэрээт хүмүүс

Бүлэг 15

---

## Гэрээнүүдийн мөн чанар

- Гэрээ гэж юу вэ? Яагаад Хожмын үеийн Гэгээнтнүүдийг гэрээт хүмүүс гэж нэрлэдэг вэ?

Эхлэлээс авахуулан Их Эзэн дэлхий дээрх Өөрийн хүүхдүүдтэйгээ гэрээнүүдийг хийсэн. Түүний хүмүүс Их Эзэнтэй гэрээнүүдийг (амлалтууд) хийхдээ, Тэр тэднийг юу хийгээсэй гэж хүсдэгийг мэддэг ба Түүнээс ямар адислалуудыг авч болохоо ч тэд мэддэг. Тэд дэлхий дээрх Түүний ажлыг илүү сайнаар авч явж чадна. Их Эзэнтэй гэрээ хийсэн мөн Их Эзэний гэрээ хийсэн хүмүүсийг Их Эзэний гэрээт хүмүүс гэдэг. Сүмийн гишүүд Их Эзэний гэрээт хүмүүсийн нэг хэсэг юм.

Сайн мэдээнд гэрээ гэдэг нь Бурхан ба хэн нэгэн хүн эсвэл бүлэг хүмүүсийн хоорондох хоёр талын амлалт буюу нандин хэлэлцээр юм. Гэрээнд зарлигуудыг дуулгавартай дагавал тодорхой адислалуудыг өгөхөөр Бурхан амласан. Тэр Өөрийн гэрээнүүдийн нөхцлийг тогтоодог ба тэдгээр нөхцлүүдийг бошиглогч нартаа илчилдэг. Хэрэв бид гэрээний нөхцлүүдэд дуулгавартай байхыг сонговол бид амлагдсан адислалуудыг хүлээн авдаг. Хэрэв бид дуулгаваргүй байхыг сонговол Тэр адислалуудыг далдалж, зарим нөхцөлд шийтгэл хүртдэг.

Жишээ нь: бид Сүмийн гишүүн болохдоо тодорхой гэрээнүүдийг Бурхантай хийдэг (энэ номны бүлэг 20-г үз). Бид баптисм хийлгэхдээ Аврагчтай Түүний нэрийг өөр дээрээ авна хэмээх гэрээг хийдэг. Тэр “Есүс Христ болох миний нэрээр баптисм хүртэж, мөн наманчилж мөн эцсээ хүртэл тэвчих болгон нь, мөнхүү тэд нь аврагдах болно” хэмээн амалсан (С ба Г 18:22).

---



Бид ариун ёслолоос хүртсэнээр Их Эзэнтэй гэрээнд ордог (Энэ номны бүлэг 23-г үз). Бид өөрсдийн дээр Түүний нэрийг авч, Түүнийг санаж, Түүний зарлигуудад дуулгавартай байна хэмээн амладаг. Ариун Сүнс бидэнтэй хамт байх болно хэмээн бидэнд амласан (С ба Г 20:77–79). Бид ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахдаа итгэлтэйгээр дуулгавартай байсны төлөөх өргөмжлөлийг амласан бусад нандин гэрээнүүдийг хийдэг (С ба Г 132; мөн энэ номны бүлэг 47-г үз).

Бурхан мөн тодорхой хэсэг бүлэг хүмүүстэй мөн хувь хүнтэй онцгой гэрээнүүдийг хийдэг. Тэр Адам, Инох, Ноа, Израилын хүүхдүүд ба Лихай нартай онцгой гэрээнүүдийг хийсэн (Мосе 6:31–36, 52; Эхлэл 9:9–17; Египетээс гарсан нь 19:5–6; 2 Нифай 1). Абрахамын үр удам болох дэлхийн өнөөгийн бүх үндэстэн ястан, Сүмийн гишүүдийг адислах онцгой нэгэн гэрээг Тэр түүнтэй хийсэн.

- Бурхантай хийсэн гэрээнүүдийнхээ талаар болон гэрээнүүдийг сахиснаар та нарт амлагдсан Бурханы адислалуудын талаар бод.

### **Бурханы Абрахамтай ба түүний үр удамтай хийсэн гэрээ**

- Абрахамын гэрээ гэж юу вэ?

Хуучин Гэрээний бошиглогч Абрахам нь маш зөв шударга хүн байсан (тус бүлгийн зургийг үз). Тэр эцгийнхээ хиймэл шүтээнийг шүтэхээс татгалзсан. Тэр Их Эзэний бүх зарлигуудыг сахьсан. Абрахам зөв шударга байсан учраас Их Эзэн түүнтэй болон түүний үр удамтай гэрээ хийсэн.

Абрахам тоо томшгүй үр удамтай болно хэмээн Их Эзэн амласан. Сайн мэдээг, санваарын адислалуудыг, өргөмжлөлийн бүх ёслолуудыг хүлээн авах болно гэдгийг Тэр амласан. Тэдгээр үр удам нь бүх үндэстэн ястны дунд сайн мэдээг санваарын хүчээр дамжуулан түгээх болно. Тэднээр дамжуулан дэлхийн бүх гэр бүлүүд адислагдах болно (Абрахам 2:11). Бурхан бас хэрэв тэд зөв шударга байх аваас Абрахамын хүүхдүүдийн бүх үе удамтай Тэр Өөрийн гэрээг байгуулна хэмээн амласан (Эхлэл 17:4–8).



- Абрахамын гэрээн дэх зарлиг ба амлалтууд нь бидэнд хэрхэн хамаарах вэ? (Гэр оронд, ажлын талбарт, нийгэмд, эсвэл бүрэн цагийн номлогчдоод хэрхэн энэ асуулт хамаарч болох талаар эргэцүүлэн бод.)

### **Сүмийн гишүүд бол гэрээт хүмүүс**

- Өнөөгийн Бурханы гэрээт хүмүүст ямар адислал ба хариуцлагууд байдаг вэ?

Абрахамын цусан үр удмынхан гэдэг зөвхөн Бурханы нэрлэсэн Түүний гэрээт хүмүүс биш. Бурхан Абрахамтай ярьж байхдаа, “Сайн мэдээг хүлээн авах болгон нь чиний нэрээр дуудагддаг байх болно, мөн чиний үр удам хэмээн тооцогддог байх болно, мөн босч зогсоод, тэдний эцгийн хувьд чамайг магтан дуулах болно” гэжээ (Абрахам 2:10). Иймд Абрахамтай хийсэн гэрээнд хоёр бүлэг хүмүүс байдаг. Үүнд: (1) Абрахамын зөв шударга цусан үр удмынхан ба (2) Есүс Христийн сайн мэдээг хүлээн авч, түүгээр амьдарснаар түүний үр удам хэмээн тооцогдох болсон хүмүүс болно (2 Нифай 30:2).

Бид Сүмд баптисм хүртэх үедээ Их Эзэн Абрахам, Исаак, Иаковтай хийсэн гэрээнд ордог (Галат 3:26–29). Хэрэв бид дуулгавартай байх аваас гэрээний адислалуудыг өвлөн авдаг. Бид Ариун Сүнсний удирдамж, тусламжийг хүлээн авах эрхтэй. Зохистой эрэгтэйчүүд санваарыг атгах эрхтэй байдаг. Гэр бүлүүд санваарын адислалуудыг хүлээн авч чадна. Бид селестиал хаант улс дахь мөнхийн амьдралыг олж авч чадна. Эдгээрээс илүү агуу адислалууд гэж үгүй.

Их Эзэний гэрээт хүмүүсийн хувьд хүлээн авах адислалуудын хамт бидэнд мөн агуу үүрэг хариуцлагууд байдаг. Түүний үр удамаар дамжуулан дэлхий дахинд сайн мэдээ өгөгдөх болно хэмээн Абрахамд Их Эзэн амласан. Бид эдгээр хариуцлагуудыг Сүмийн бүрэн цагийн номлогчид ба гишүүдийн номлолын ажлаараа бүрэн гүйцэлдүүлж байна. Дэлхий дахинд сайн мэдээг номлох боломж нь зөвхөн Их Эзэний Сүм ба Түүний гэрээт хүмүүст хамаатай.

---

**Багш нарт зориулж:** Та ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг өгсөн асуултны талаар гүн нухацтай бодох цаг өг. Хангалттай хугацаанд бодсоны дараа тэдний хариултыг сонс.

Их Эзэний гэрээт хүмүүсийн хувьд бид Түүний зарлигуудыг сахих ёстой. Их Эзэн хэлэхдээ: “Миний хэлснийг та нар хийхэд Их Эзэн бибээр үүрэг хүлээдэг; гэвч миний хэлснийг та нар үл хийхэд та нарт амлалт байх нь үгүй” гэжээ (С ба Г 82:10). Хэрэв бид сайн мэдээг хүлээн авсны дараа өөрсдийн гэрээнээс татгалзах аваас гэрээ нь хүчингүй болж, бид Бурханы өмнө яллагдахаар зогсох болно (С ба Г 132:4). Тэр “гашуун шүүлтүүд та нарын толгой дээр буухгүйн тулд нүглээс татгалзагтун. Учир нь их нь өгөгдсөн түүнээс их нь шаардагдах буюу; мөн агуу гэрлийн эсрэг агуу буруушаалтыг хүлээж авах болно” хэмээн хэлсэн (С ба Г 82:2–3).

### **Шинэ бөгөөд мөнхийн гэрээ**

- Сайн мэдээг хүлээн авахдаа бид юу хийхээр амладаг вэ? Бид тэдгээр амлалтуудыг сахьснаар Тэнгэрлэг Эцэг бидэнд ямар адислалууд өгдөг вэ?

Сайн мэдээний бүрэн бүтэн байдлыг шинэ ба мөнхийн гэрээ гэдэг. Энэ нь баптисм хүртэх үед хийсэн, ариун ёслолын үеийн, ариун сүм дэх мөн бусад үед хийсэн гэрээнүүдийг багтаадаг. Үүнийг мөнхийн Бурхан урьдчилан тодорхойлсон учраас мөн гэрээ хэзээ ч өөрчлөгдөхгүй учраас Их Эзэн үүнийг мөнхийн хэмээн нэрлэсэн. Тэр энэ гэрээг Адам, Инох, Ноа, Абрахам ба бусад бошиглогчдоод өгсөн. Энэ утгаараа энэ нь шинэ зүйл биш. Гэхдээ дэлхийгээс авагдсаны дараа сайн мэдээ дахин сэргээгдэх бүрт энийг хүлээн авч байгаа хүмүүст шинэ байдаг учраас Их Эзэн үүнийг шинэ хэмээн нэрлэдэг (Иеремиа 31:31–34; Езекиел 37:26).

Бид шинэ бөгөөд үүрдийн гэрээг хүлээн авах үед бид наманчлахыг, баптисм хүртэхийг, Ариун сүнснийг хүлээн авахыг, өөрсдийн хувийн хишгийг хүлээн авахыг, ариун сүм дэх гэрлэлтийн гэрээг хүлээн авахыг, мөн эцсээ хүртэл Христийг дагаж, дуулгавартай байхыг зөвшөөрдөг. Өөрсдийн гэрээг сахиснаар бид селестиал хаант улсын өргөмжлөлийг хүлээн авах болно хэмээн Тэнгэрлэг Эцэг бидэнд амладаг (С ба Г 132:20–24; мөн энэ номны 47-р бүлгээс үз).

Тэрхүү амлалтын хосгүйг мөнх бус хүмүүсийн хувьд ойлгоход хүндрэлтэй. Түүний зарлигууд нь бидний тусын тулд өгөгдсөн. Хэрэв бид итгэлтэй байх юм бол дэлхийн болоод тэнгэрийн сайн сайхан ба адислалуудыг үүрд авах болно. Бид Түүний оршихуйд амьдарч, Түүний хайр, нигүүлсэл, хүч, алдар суу, мэдлэг, мэргэн ухаан, сүр жавхлан болоод эзэмшлээс хүртэж чадна.

- Их Эзэний гэрээт хүмүүс байснаар бид хувцаслалт, үйлдэл ба Бурханы зарлигуудыг сахихдаа ямар байх ёстой вэ?

### **Нэмэлт судрууд ба бусад эх сурвалжууд**

- 1 Петр 2:9–10 (сонгогдсон хүмүүс)
- С ба Г 54:4–6 (гэрээг дагах ба зөрчихийн үр нөлөөнүүд)
- С ба Г 132:7 (зүй ёсны эрх мэдлээр хийгдсэн гэрээнүүд)
- С ба Г 133:57–60 (гэрээнүүдийн зорилго)
- С ба Г 35:24 (гэрээнд дуулгавартай байснаар ирэх амлалтууд)
- Еврей 8:6 (Есүс Христ бол илүү сайн гэрээний зуучлагч)
- Судруудын Удирдамж “Гэрээ” 54-р хуудас

# Эртний үеийн Есүс Христийн Сүм

Бүлэг 16

---

## **Есүс Христийн Сүмийг тодорхойлох зарим онцлогууд**

“Анхны Сүмд байсан тэрхүү зохион байгуулалтад, тухайлбал төлөөлөгчид, бошиглогчид, пасторууд, багш нар, евангелистууд болон бусдад бид итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:6).

Есүс дэлхий дээр байхдаа Өөрийн Сүмийг байгуулсан. Үүнийг Есүс Христийн Сүм хэмээн нэрлэдэг байсан (3 Нифай 27:8) ба гишүүдийг Гэгээнтнүүд хэмээн нэрлэдэг байв (Ефес 2:19–20).

### *Илчлэлт*

Есүс Өөрийн Сүмийг байгуулсны дараа Тэр сүмийн удирдагч нарыг биечлэн зөвлөж, удирдсан. Тэр мөн Тэнгэр дэх Өөрийн Эцэгээс удирдамжийг хүлээн авдаг байсан (Еврей 1:1–2).

Иймд Есүс Христийн Сүм хүнээр бус Бурханаар шууд удирдагддаг байсан. Илчлэлт нь Өөрийн Сүмийг дээр нь барих Түүний “хад” байсан гэдгийг Есүс Өөрийн дагалдагчдад заасан (Матай 16:16–18).

Өөрийн Амилалтын дараа Есүс тэнгэрт одохоос өмнө Өөрийнхөө дагалдагчдад “үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж байх болно” хэмээн хэлсэн (Матай 28:20). Түүний үгний үнэнийг баталж, Тэр тэнгэрээс тэднийг удирдан залсаар байна. Тэр тэдэнд тайвшруулагч нь, илчлэгч нь байх Ариун Сүнсийг илгээсэн (Лук 12:12; Иохан 14:26). Тэр үзэгдлээр Саултай ярьсан (Үйлс 9:3–6). Тэр сайн мэдээ зөвхөн Иудей нарт бус харин бүх

---

**Багш нарт зориулж:** Гэр бүлийн эсвэл ангийн гишүүн бүрийг Сүмийг тодорхойлох Илчлэлт ба Бурханы Эрх мэдэл гэх зэрэг налуу үсгээр бичсэн гарчгууд болон зургаан онцлогийн аль нэгийг талаар бодохыг хүс. (Олон хүнтэй ангийн гишүүдэд ижил даалгавар өгч болно. Гэр бүл ба цөөн хүнтэй ангийн гишүүдэд нэгээс илүү даалгаврыг өгч болно.) Тэдэнд судлах хугацааг өгч дараа нь сурсан зүйлсээ хуваалцахыг хүс.



дэлхий даяар заагдах ёстой гэдгийг Петрт илчилсэн (Үйлс 10). Тэр Иоханд Илчлэлт номонд бичигдсэн олон гайхамшигт үнэнийг илчилсэн. Өөрийн Сүмийг удирдах ба шавь нараа гэгээрүүлэх Өөрийн тааллыг бусад олон замаар илчилж байсныг Шинэ Гэрээнд бичсэн байдаг.

### *Бурханаас ирэх эрх мэдэл*

Сайн мэдээний ёслол ба зарчмууд санваарын хүчгүйгээр удирдагдан заагдах боломжгүй. Эцэг энэ эрх мэдлийг Есүс Христэд өгсөн (Еврей 5:4–6) ба Тэр Түүний Төлөөлөгчдийг томилж, тэдэнд санваарын хүч, эрх мэдлийг өгсөн (Лук 9:1–2; Марк 3:14). Тэр “Та нар намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон, мөн томилсон” гэдгийг тэдэнд сануулсан (Иохан 15:16).

Түүний Сүмд дэг журам байж болохын тулд Есүс Арванхоёр Төлөөлөгчдөд агуу үүрэг хариуцлага ба эрх мэдлийг өгсөн. Тэр ерөнхий Төлөөлөгч байхаар Петрийг томилж, түүнд тэнгэрт болон газарт адислалуудыг лацдах түлхүүрүүдийг өгсөн (Матай 16:19). Есүс мөн онцгой үүргийг гүйцэтгэх бусад албан тушаалтнуудыг томилсон. Түүнийг тэнгэр өөд өргөгдсөний дараа томилох ба сахил хүртээх арга замууд хэвээр үргэлжилсээр байна. Эрх мэдлийг хүлээн авсан тэдгээрээр дамжуулан бусад нь санваарт томилогддог. Есүс үүнийг Ариун Сүнсээр дамжуулан Тэр тэдгээрийн томилолтыг баталдагаа мэдүүлдэг (Үйлс 1:24).

### *Сүмийн зохион байгуулалт*

Есүс Христийн Сүм нь нарийн зохион байгуулагдсан нэгж юм. Үүнийг “та нар элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ дотор Бурханы орших газар болох” байгууламжтай зүйрлэсэн (Ефес 2:20).

Тохинуулах ажилд нь Төлөөлөгчдөд туслах бусад санваарын удирдагчдыг Есүс томилсон. Тэр сайн мэдээг номлох Далыг томилж, хоёр хоёроор нь илгээв (Лук 10:1). Сүмд евангелист (патриарх), пастор (тэргүүлэх удирдагч), дээд прист, ахлагч, бишоп, прист, багш, дикон гэсэн бусад албан тушаалтнууд байв (энэ номны 14-р бүлгийг үз). Эдгээр албан тушаалтнууд бүгд номлолын ажил, ёслолуудыг гүйцэтгэх, Сүмийн гишүүдийг зааж сурган,

дэмжин урамшуулах ажлыг хийх шаардлагатай байдаг. Эдгээр албан тушаалтнууд нь гишүүдийг “бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл” болтол нь тусалдаг (Ефес 4:13).

Библи бидэнд санваар эсвэл Сүмийн зохион байгуулалт, засаглалын талаар бүгдийг хэлдэггүй. Тэгсэн хэдий ч, Сүмийн зохион байгуулалтын сайн сайхан ба төгс төгөлдөр байдлыг Библид хангалттай үзүүлсэн байдаг. Төлөөлөгч нарт бүх дэлхий даяар явж, номлохоор тушаасан байв (Матай 28:19–20). Тэд аль нэг хотод үлдэж, шинэ хөрвөгсдийг удирдан зохион байгуулж чаддаггүй байв. Тийм учир орон нутгийн санваарын удирдагчдыг томилж, тэднийг Төлөөлөгчид тэргүүлдэг. Төлөөлөгчид ба Сүмийн удирдагчид олон салбаруудад захидал бичиж, зочилдог байв. Энэ мэтээр Паул, Петр, Иаков, Иохан ба Иуда нар орон нутгийн санваарын удирдагч нарт зөвлөмж, удирдамжийг өгч бичсэн захидлуудыг Шинэ Гэрээ агуулж байдаг.

Энэ Сүмийн зохион байгуулалт үргэлжлэх болно гэдгийг Шинэ Гэрээ харуулдаг. Жишээ нь: Иудас үхсэн учир арваннэгэн Төлөөлөгч үлдсэн. Есүс тэнгэр өөд өргөгдсөний дараа удалгүй Иудасын оронд хэн нэгнийг сонгохоор арваннэгэн Төлөөлөгч бүгд цугларсан. Ариун Сүнсний илчлэлтээр дамжуулан тэд Маттиасыг сонгов (Үйлс 1:23–26). Арванхоёр Төлөөлөгчид Сүмийг захиран удирдаж болохын тул Есүс загварыг бий болгосон. Тэр сүмийг байгуулсаны дагуу зохион байгуулалт нь үргэлжлэх ёстой байсан гэдэг нь тодорхой.

#### *Анхны зарчмууд ба ёслолууд*

Төлөөлөгчид үндсэн хоёр зарчмыг заасан: Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл ба наманчлал. Шинээр хөрвөгсөд Есүс Христ бол Бурханы Хүү бөгөөд тэдний Гэтэлэгч гэдэгт итгэх итгэлийг олж, өөрсдийн нүглийг наманчилсны дараа тэд хоёр үндсэн ёслол болох усанд булхуулан баптисм хүртэх, гар тавилтаар Ариун Сүнсний бэлгийг хүлээн авдаг (Үйлс 19:1–6). Эдгээр нь сайн мэдээний анхны зарчмууд ба ёслолууд юм. Есүс “Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй” хэмээн заасан (Иохан 3:5).

*Нас барагсдын төлөөх ёслолууд*

Есүс хүн бүр тэд дэлхий дээр байна уу эсвэл нас барсан байна уу хамаагүй сайн мэдээг сонсох боломжтой байхаар хангасан. Есүс үхэл ба Амиалтын хооронд нас барсан сүнснүүдийн дунд очсон. Тэр нас барагсдын дунд номлолын ажлыг зохион байгуулсан. Тэр зөв шударга элч нарыг томилж, тэдэнд нас барсан сүнснүүдэд сайн мэдээг номлох хүчийг өгсөн. Энэ нь тэдэнд сайн мэдээг хүлээн авах боломжийг олгосон (1 Петр 3:18–20; 4:6; С ба Г 138). Дэлхий дээрх Сүмийн гишүүд нас барагсдын өмнөөс ёслолуудыг гүйцэтгэдэг (1 Коринт 15:29). Баптисм ба гишүүнээр батлах ёслолууд нь дэлхий дээр хийгдэх ёстой.

*Сүнслэг бэлгүүд*

Сүмийн итгэлтэй гишүүд Сүнсний бэлгийг хүлээн авах эрхтэй. Эдгээр нь хувийн хэрэгцээ, авьяас чадвар, хүлээсэн үүрэг зорилгынх нь дагуу тэдэнд өгөгддөг. Итгэл, анагаах болон анагаагдах хүч, бошиглол ба үзэгдэл харах зэрэг нь бэлэг юм (Сүнсний бэлгүүдийн талаар 22-р бүлэгт илүү тодорхой байгаа). Сүнслэг бэлгүүд нь Есүс Христийн үнэн Сүмд үргэлж байдаг (1 Коринт 12:4–11; Моронай 10:8–18; С ба Г 46:8–29). Эдгээр тэмдэг эсвэл сүнслэг бэлгүүд итгэгч тэдэнд үргэлж хамт байх болно гэдгийг Есүс Өөрийн шавь нартаа хэлсэн (Марк 16:17–18). Түүний шавь нар гайхамшгийг үйлдэж, бошиглож эсвэл Ариун Сүнсний хүчээр үзэгдлийг харж байв.

- Есүс Христийн Сүмд эдгээр зургаан онцлог яагаад хэрэгтэй вэ?

**Америк тив дэх Есүс Христийн Сүм**

Есүс амилсаныхаа дараа Тэр Америк тивд байсан хүмүүс дээр зочилсон. Тэгээд Өөрийн Сүмийг тэдний дунд зохион байгуулж, гурван өдөр тэдэнд зааж, дараа нь түүний дараа зарим цаг мөчүүдэд эргэн ирж байсан (3 Нифай 11–28). Дараа нь Тэр тэднийг орхиж, тэнгэр өөд өргөгдсөн. Түүний дараа 200 гаруй жил тэд зөв шударга амьдарч, Бурханы бүтээсэн хүмүүсийн дунд хамгийн аз жаргалтай нь байлаа (4 Нифай 1:16).



## Үнэн Сүмээс урвасан урвалт

- *Урвалт* гэдэг нь ямар утгатай үг вэ?

Түүхийн туршид хилэнцэт хүмүүс Бурханы ажлыг устгахыг хичээсээр ирсэн. Энэ нь Төлөөлөгчид амьд, Сүм өсөн хөгжиж, шинэ хөрвөгсдийг хянан удирдаж байхад тохиолдсон. Зарим гишүүд хуучин цагийн худал шашны эсвэл Есүсийн заасан энгийн үнэний оронд Иудейчүүдийнхээ итгэл үнэмшлийг зааж байсан. Зарим нь ил тодоор эсэргүүцсэн. Дээр нь Сүмийн бус хүмүүсийн мөрдлөг хавчлага байсан. Сүмийн гишүүд итгэл үнэмшлийнхээ төлөө доромжлогдон тамлуулж, амиа алдаж байв. Нэг нэгээрээ Төлөөлөгчид алагдсан буюу дэлхийгээс авагдсан байлаа. Ёс суртахуунгүй, хар санасан их урвалтын учир дэлхийгээс төлөөлөгчийн эрх мэдэл ба санваарын түлхүүрүүд эргүүлэн авагдсан. Есүс Христийн үндэслэн байгуулсан зохион байгуулалт байхгүй болж, эмх замбараагүй байдал бий болсон байв. Сүмийн сургаалд маш олон алдаа төөрөгдөл шургалан орж, удалгүй Сүм бүрэн бутран задарсан. Үнэн Сүм дэлхий дээр хэсэг хугацаанд бүрмөсөн алга болсон үеийг Агуу Урвалт гэдэг.

Удалгүй өөрсдийгөө Христчүүд хэмээн нэрлэсэн худал шашинд итгэгчид олширсон. Ромын эзэнт улсын хаан энэ худал Христэд итгэгчдийн итгэлийг хүлээн зөвшөөрч, албан ёсны шашнаа болгов. Энэ сүм Есүсийн зохион байгуулсан сүмээс тэс өөр байлаа. Тэд Бурхан хэлбэр дүрс, биет юмгүй бодь хэмээн заадаг байв.

Тэдгээр хүмүүс биднийг гэсэн Бурханы хайрын ойлголтыг алдагдуулсан. Бид Түүний хүүхдүүд гэдгээ мэддэггүй байв. Тэд амьдралын зорилгыг ойлгодоггүй байв. Дэлхий дээр санваар ба илчлэлт байхгүй байсан учраас олон ёслолууд өөрчлөгдсөн.

Эзэн хаан тэднийг Христийн үнэн Сүм дэх санваарын удирдагчдын адил нэрээр нэрлэн өөрийн удирдагчдыг өөрөө сонгодог байв. Бурханы хүчийг атгасан Төлөөлөгчид эсвэл бусад санваарын удирдагчид байхгүй байлаа. Мөн сүнслэг бэлгүүд байхгүй байв. Бошиглогч Исаиа энэ нөхцөл байдлыг урьдчилан харсан байсан: “Дэлхий өөрийн оршин суугчдын доор бузарлагдав. Учир нь тэд хуулиудыг зөрчиж, тогтоолуудыг өөрчлөн, мөнхийн гэрээг эвдэв” (Исаиа 24:5). Энэ нь Есүс Христийн Сүм

---

байхаа больж, хүмүүний сүм болсон байв. Бүр нэр нь хүртэл солигдов. Америк тивд мөн урвалт болсон (4 Нифай).

### **Сэргээлт урьдчилан хэлэгдэв**

- Хуучин ба Шинэ Гэрээнүүдэд Сэргээлтийн талаар хэрхэн бошиглосон байдаг вэ?

Бурхан Урвалтыг урьдчилан харсан ба сайн мэдээг дахин сэргээхэд бэлтгэсэн байв. Төлөөлөгч Петр Иудейчүүдэд хандан эдгээрийг хэлсэн: “Та нарын төлөө томилогдсон Христ болох Есүсийг Тэр илгээх болно. Бурхан Өөрийнхөө ариун эш үзүүлэгчдийн амаар эрт цагаас айлдсанчлан бүхнийг сэргээх үе хүртэл Түүнийг тэнгэр хүлээн авах ёстой юм” (Үйлс 3:20–21).

Илчлэгч хэмээх Иохан мөн сайн мэдээ сэргэх тэр цагийг урьдчилан харсан. Тэр хэлэхдээ “Тэнгэрийн дундуур өөр нэгэн тэнгэр элч нисэж явахыг би харав. Газар дээр суугчид ба аливаа үндэстэн, овог, хэлтэн, ард түмэнд тунхаглах мөнхийн сайн мэдээ түүнд байна” (Илчлэлт 14:6) гэжээ.

- Яагаад Сэргээлт шаардлагатай байсан бэ?
- Дэлхийд Есүс Христийн Сүм дахин сэргээгдсний ачаар та нарт ирсэн адислалуудын талаар эргэцүүлэн бод.

### **Нэмэлт судрууд**

- Ефес 2:19 (гишүүдийг Гэгээнтнүүд хэмээдэг)
- 1 Коринт 12:12–31 (Сүм нэг бие адил)
- Лук 10:1; Үйлс 14:23; Тит 1:7; 1 Тимот 2:7 (Сүмийн албан тушаалуудыг тодорхойлов)
- Иохан 8:26–29 (Эцэг Есүсийг удирддаг)
- Лук 9:1; Иаков 1:17; 5:14–15 (сүнслэг бэлгүүд)
- Мозая 27:13 (гэм нүгэл алдаа зөрчлийн үр нөлөөгөөр урвалт ирдэг)
- 2 Петр 2:1; Матай 24:9–12; Иохан 16:1–3; Амос 8:11; 2 Тесалоник 2:3–4 (Урвалт урьдаас хэлэгдсэн)
- Даниел 2:44–45; Матай 24:14; Үйлс 3:19–21; Мика 4:1; Исаиа 2:2–4 (Сэргээлт урьдаас хэлэгдсэн)



# Есүс Христийн ӨНӨӨГИЙН СҮМ

Бүлэг 17

---

## **Дэлхийгээс Есүс Христийн Сүм авагдсан байсан**

- Яагаад Аврагчийн үхэл ба Амилалтын дараа удалгүй Есүс Христийн Сүм дэлхийгээс авагдсан бэ?

Дэлхий дээр Есүс амьдарч байхдаа Өөрийн цорын ганцхан үнэний Сүмийг үндэслэн байгуулсан. Сайн мэдээний үнэн бүх хүнд заагдаж, мөн сайн мэдээний ёслолууд эрх мэдэлтэйгээр зөв гүйцэтгэгдэж болохын тулд Тэр Өөрийн Сүмийг зохион байгуулсан. Энэ зохион байгуулалтаар дамжуулан Христ бүх хүмүүний авралын адислалуудыг авчирч чадна.

Аврагч тэнгэр өөд өргөгдсөний дараа ёслолууд мөн Есүс ба Түүний Төлөөлөгчдийн үндэслэн тавьсан ёслолууд болон сургаалуудыг хүмүүс өөрчилсөн. Урвалтын учир Бурханаас ирэх шууд илчлэлт байгаагүй. Үнэн Сүм дэлхий дээр байхаа больсон. Үнэн мэт харагдахыг хичээгч маргаантай сургаалыг заадаг өөр сүмүүдийг хүмүүс бий болгосон. Шашны талаар маш их төөрөгдөл гуйвуулга, өрсөлдөөн маргаан гардаг байв. Их Эзэн урвалтын эдгээр нөхцөл байдлуудыг урьдаас харж “галхаар өлсөх, усаар цангах бус, харин Эзэний үгийг сонсохын төлөө өлсгөлөн байх юм. Тэд Эзэний үгийг эрэн явах боловч түүнийг олохгүй” (Амос 8:11–12).

- Амос 8:11–12 дээр хэлэгдсэн өлсгөлөн хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?

## **Их Эзэн Өөрийн үнэн сүмийг сэргээхээ амласан**

- Дэлхийд сайн мэдээг сэргээх замыг бэлтгэсэн ямар нөхцөл байдлууд байсан бэ?
-

Аврагч Өөрийн Сүмийг хожмын өдрүүдэд сэргээхээ амласан. Тэр “Би энэ ард түмний дотор ер бусын гайхамшигт, гайхалтай зүйлийг дахин бүтээнэ” хэмээн хэлсэн (Исаиа 29:14).

Олон жилийн туршид хүмүүс сүнслэг байдлын харанхуйд амьдарсан. Христээс хойш ойролцоогоор 1700 жилийн дараа хүмүүс Бурхан ба шашны талаар үнэнийг мэдэхийг илүү ихээр хүсэх болсон. Тэдний зарим нь Есүсийн заасан сайн мэдээ дэлхий дээр байхгүй байна гэдгийг харж чаддаг болсон. Зарим нь Христийн байгуулсан Сүмийн илчлэлт ба жинхэнэ эрх мэдэл дэлхий дээр байхгүйг мэдэрсэн. Дэлхийд Есүс Христийн Сүмийг сэргээх цаг үе нь ирлээ.

- Сайн мэдээний бүрэн байдлын Сэргээлт нь ямар замаар “гайхамшигт ажил” болдог вэ?

### **Бурханы шинэ илчлэлт**

- Иосеф Смит Анхны үзэгдлийг хүлээн авахдаа Бурханы тухай юуг суралцсан бэ?

1820 оны хавар дэлхийн түүхэнд хамгийн чухал үйл явдлуудын нэг тохиосон. Их Эзэний ярьсан гайхамшигт бөгөөд ер бусын ажил гүйцэтгэгдэх цаг үе ирсэн байлаа. Залуу хөвгүүн Иосеф Смит эдгээр олон сүмүүдийн аль нь үнэн Есүс Христийн Сүм болохыг мэдэхийг хүсэв. Тэр гэрийнхээ ойролцоох ойд очиж, Тэнгэрлэг Эцэгт хандан аль сүмд нэгдэх ёстойгоо асуун, чин сэтгэлээсээ, даруухнаар залбирсан. Тэр өглөө гайхамшигт зүйл тохиов. Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христ Иосеф Смитэд үзэгджээ. Үнэн Сүм дэлхий дээр байхгүй учраас аль ч сүмд нэгдэх ёсгүй гэдгийг Аврагч түүнд хэлсэн. Тэр мөн одоо байгаа сүмүүдийн итгэл бишрэл нь “түүний мэлмийд жигшүүрт явдал” гэдгийг хэлсэн (Иосеф Смит—Түүх 1:19; мөн шүлэг 7–18, 20). Энэ үйл явдлаас хойш тэнгэрээс шууд илчлэлт дахин илчлэгдэж эхэлсэн. Их Эзэн шинэ бошиглогчийг сонгосон байв. Тэр цаг мөчөөс тэнгэр хаалттай байхаа больсон. Илчлэлт Түүний сонгосон бошиглогчдоор дамжуулан өнөөдрийг хүртэл илчлэгдсээр байна. Иосеф Есүс Христийн үнэн сайн мэдээг сэргээхэд туслах хүн нь байлаа.

- Яагаад дэлхийн түүхэнд Анхны үзэгдэл хамгийн чухал үйл явдлуудын нэг байсан бэ?

### **Бурханаас өгөгддөг эрх мэдэл сэргээгдсэн**

- Яагаад Аарон ба Мелкизедекийн санвааруудын сэргээлт шаардлагатай байсан бэ?

Сайн мэдээний сэргээлтээр Бурхан хүмүүст санваарыг дахин өгсөн. Иохан Баптист 1829 онд Иосеф Смит ба Оливер Каудери нарт Аароны санваар олгохоор ирсэн (С ба Г 13; 27:8). Дараа нь Петр, Иаков, Иохан нар буюу эртний Сүмийн ерөнхийлөгчийн зөвлөл Иосеф ба Оливер нарт Мелкизедек санваар болон Бурханы хаант улсын түлхүүрүүдийг өгөхөөр ирсэн (С ба Г 27:12–13). Дараахан нь санваарын нэмэлт түлхүүрүүд тэнгэрлэг элчүүд болох Мосе, Елиас, Елиа нараар дахин сэргээгдсэн (С ба Г 110:11–16). Сэргээлтээр дамжуулан дэлхийд санваар буцаан өгөгдсөн. Өнөөдөр энэ санваарыг атгагч хүмүүс нь баптисм зэрэг ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэлтэй байдаг. Тэд мөн Их Эзэний хаант улсыг дэлхий дээр удирдан залах эрх мэдэлтэй байдаг.

### **Христийн Сүм дахин зохион байгуулагдсан**

- Ямар үйл явдлууд дэлхий дээр дахин Сүмийг зохион байгуулахад хөтөлсөн бэ?

1830 оны 4-р сарын 6-нд Аврагч дэлхий дээр Өөрийн Сүмийг дахин зохион байгуулах ажлыг удирдсан (С ба Г 20:1). Түүний Сүмийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм гэдэг (С ба Г 115:4). Эрт үеийн адил Христ мөн өнөөдөр Өөрийн Сүмийнхээ тэргүүн нь. Их Эзэн хэлэхдээ энэ бол “Их Эзэн миний таалалд нийцдэг, бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” хэмээсэн (С ба Г 1:30).

Иосеф Смит Сүмийн бошиглогч бөгөөд “анхны ахлагч” байхаар томилогдсон (С ба Г 20:2–4). Удалгүй Тэргүүн Зөвлөл зохион байгуулагдаж, түүнийг Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжин батлав.

---

**Багш нарт зориулж:** Гэрчлэлээ хуваалцах нь Сүнсийг урьдаг. Энэ хичээлийн нэг хэсэг болгон Сэргээлтийн тухай гэрчлэлээ хуваалц. Мөн бусдад гэрчлэлээ хуваалцах боломж олго.

Анх Сүм зохион байгуулагдахад зөвхөн суурь зохион байгуулалт хийгдсэн. Сүм хөгжин дэвжих тусам зохион байгуулалт нь мөн хөгжих болно.

Сүм эртний Сүмийн адил албан тушаалуудтайгаар зохион байгуулагдав. Энэ зохион байгуулалтад төлөөлөгч, бошиглогч, дал, евангелист (патриарх), пастор (тэргүүлэх албан тушаалтан), дээд прист, ахлагч, прист, багш ба дикон багтдаг байв. Өнөөдөр Түүний Сүмд мөн эртний үетэй адил эдгээр албан тушаалууд байна (Итгэлийн тунхаг 1:6).

Бошиглогч нь Их Эзэний удирдлага дор Сүмийг удирддаг. Энэ бошиглогч нь мөн Сүмийн Ерөнхийлөгч юм. Тэр Их Эзэний ажлыг дэлхий дээр удирдахад шаардлагатай бүх эрх мэдлийг эзэмшдэг (С ба Г 107:65, 91). Ерөнхийлөгчид туслах хоёр зөвлөх байдаг. Есүс Христийн онцгой гэрчлэгчид болох Арванхоёр Төлөөлөгчид дэлхий дахины өнцөг булан бүрт сайн мэдээг зааж, Сүмийн ажил хэргийг зохицуулдаг. Онцгой үүрэг даалгавартай Сүмийн бусад ерөнхий албан тушаалтнууд болох Тэргүүлэх Бишопын зөвлөл, Далын Чуулгууд нь Тэргүүн Зөвлөл ба Арванхоёрын Чуулгын удирдлага дор үйлчилдэг.

Санваарын албан тушаалуудад төлөөлөгч, дал, патриарх, дээд прист, бишоп, ахлагч, прист, багш, дикон багтдаг. Жинхэнэ анхны Сүмд байсан тэдгээр албан тушаалууд өнөөдрийн сүмд байдаг.

Сүм Есүсийн өдрүүдэд байснаас илүү их өсч өргөжсөн. Сүм өссөн учраас Их Эзэн Сүмийн дотор нэмэлт зохион байгуулалтын нэгжүүдийг илчилсэн. Сүм тухайн газар оронд бүрэн байдлаар зохион байгуулагдсан үед тухайн орон нутагт нь гадасуудыг байгуулдаг. Гадасны ерөнхийлөгч ба түүний зөвлөхүүд тухайн гадасыг тэргүүлдэг. Гадаст Их Эзэний ажлыг явуулахад туслах 12 дээд зөвлөх байдаг. Гадасны ерөнхийлөгчийн удирдлага дор гадасны Мелкизедек санваарын чуулгуудыг зохион байгуулдаг (энэ номны 14-р бүлгийг үз) Гадас бүр тойрогт хуваагддаг. Бишоп ба түүний хоёр зөвлөх тойргийг тэргүүлдэг.

---

Сүм эхлэн хөгжиж буй дэлхийн аль нэг хэсэгт гадасны адил дүүргүүдийг байгуулдаг. Дүүргүүд нь тойрогтой адил салбар хэмээх жижиг нэгжүүдэд хуваагддаг.

### **Чухал үнэнүүд дахин сэргээгдсэн**

- Сүмийн сэргээлтээр ямар үнэнүүд буцаан авчрагдсан бэ?

Өнөөдөр Сүм Есүсийн өдрүүдэд гүйцэтгэгдэж байсан ёслолууд хийгээд ижил зарчмуудыг зааж байна. Сайн мэдээний анхны зарчмууд ба ёслолууд нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, усанд дүрэлтээр баптисм хийх, гар тавилтаар Ариун Сүнсний бэлэг хүртэх (Итгэлийн тунхаг 1:4). Сүм сэргээгдэх үед эдгээр эрхэм нандин үнэнүүд өөрсдийн бүрэн байдалд буцаан сэргээгдсэн.

Бурханы бэлэг ба хүчээр дамжуулан Иосеф Смит сайн мэдээний энгийн бөгөөд эрхэм үнэнүүдийг агуулсан Мормоны Номыг орчуулсан. Цаашид бусад олон илчлэлтээр судар болох Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувад бичигдсэн.

Их Эзэний сэргээсэн бусад чухал үнэнүүд нь:

1. Бидний Тэнгэрлэг Эцэг бол мэдрэгдэх яс, махнаас бүрдсэн төгс бие махбодтой бөгөөд Есүс Христ ч мөн адил. Ариун Сүнс бол сүнсэн хүн.
2. Бид дэлхийн өмнөх амьдралд Бурханы сүнсэн хүүхдүүд байсан.
3. Санваар нь сайн мэдээний ёслолуудыг удирдан явуулахад шаардлагатай.
4. Бид Адамын зөрчлийн улмаас бус харин өөрсдийн нүглүүдийн улмаас шийтгэгдэх болно.
5. Хүүхдүүд хариуцлага хүлээх насанд хүртлээ баптисм хийлгэх шаардлагагүй (найман нас).
6. Тэнгэрт алдар суугийн гурван хаант улс байдаг. Их Эзэн Есүс Христийн нигүүлслээр хүмүүс дэлхий дээр хийсэн өөрсдийн үйлдэл, тэдний зүрх сэтгэлийн хүслийн дагуу шагналыг авах болно.



7. Гэр бүл санваарын хүчийн лацдалтаар мөнхөд хамтдаа байж чадна.
  8. Авралд шаардлагатай ёслолууд болон гэрээнүүд нь амьд бөгөөд нас барагсдын аль алинд нь боломжтой.
- Эдгээр үнэн та нарт болон бусдад хэрхэн нөлөөлсөн бэ?

### **Есүс Христийн Сүм хэзээ ч устгагдахгүй**

- Сүмийн үүрэг юу вэ?

1830 онд Сүм сэргээгдсэнээс хойш Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнчлэл асар хурдан өссөн. Дэлхийн бараг бүх улс оронд сүмийн гишүүд байна. Сүм цаашид өргөжсөөр байх болно. Христийн хэлсэнчлэн “Мөн дахин бүх үндэстэнд гэрч байхын тулд Хаант улсын сайн мэдээ бүх дэлхийд номлогдох болно” (Иосеф Смит—Матай 1:31). Сүм дэлхийгээс хэзээ ч дахин авагдахгүй. Сүмийн үүрэг нь хүн бүрт үнэнийг мэдрүүлэх явдал. Мянга мянган жилийн өмнө Их Эзэн хэлэхдээ Тэр “хэзээ ч усташгүй нэг хаанчлалыг байгуулах бөгөөд тэр хаанчлалын эрх мэдэл нь бусад ард түмний гарт орохгүй” болно гэсэн (Даниел 2:44).

- Бурханы хаант улсын ажилд та нар хэрхэн тусалсан бэ? Энэ ажлыг үргэлжлүүлэхэд та нар юу хийж чадах вэ?

### **Нэмэлт судрууд**

- Үйлс 3:19–21; Илчлэлт 14:6; Даниел 2:44–45; Исаиа 2:2–4; 2 Нифай 3:6–15 (Сэргээлт урьдаас хэлэгдсэн)
- С ба Г 110; 128:19–21; 133:36–39, 57–58 (сайн мэдээний сэргээлт)
- Ефес 2:20 (Есүс Христ Сүмийн булангийн чулуу)
- С ба Г 20:38–67 (Сүмийн албан тушаалтнуудын үүрэг)
- Матай 24:14 (сайн мэдээ үндэстэн бүрт номлогдох болно)

# Есүс Христэд ИТГЭХ ИТГЭЛ

Бүлэг 18

---

## Итгэл гэж юу вэ?

Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл нь сайн мэдээний анхны зарчим юм. Энэ нь сүнслэг бэлэг бөгөөд бидний авралд шаардлагатай билээ. Хаан Бенжамин “Наманчлал мөн Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжихаас бусдаар бол . . . аврал ирэхгүй” хэмээн тунхагласан байдаг (Мозая 3:12).

Итгэл бол “үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд найдах” (Алма 32:21; мөн Еврей 11:1) гэсэн үг. Итгэл бол бидний өдөр бүрийн үйл ажиллагааг хөдөлгөгч хүч бөгөөд үйлдлийн зарчим.

Хэрэв бид мэргэн ухаан ба мэдлэгийг олж авна гэдэгт итгэхгүй байсан бол судалж мөн суралцах байсан болов уу? Хэрэв бид хийж, ажилласнаар ямар нэгэн зүйлийг амжилттай хийж дуусгана гэсэн найдлага байхгүй байсан бол өдөр бүр ажиллах байсан уу? Тариачин ургац авах найдлагагүйгээр тариалан тарих байсан уу? Бид өдөр бүр үр дүнг нь харж чадахгүй боловч найддаг ямар нэгэн зүйлийг үйлддэг. Энэ бол итгэл (Еврей 11:3).

Судруудын түүхүүд итгэлээр дамжин хэрхэн агуу зүйлс гүйцэлдэж байсныг хэлдэг.

Итгэлээр Ноа хөвөгч авдрыг барьж, гэр бүлээ үерээс аварсан (Еврей 11:7). Мосе Улаан тэнгисийн усыг хуваасан (Еврей 11:29).

---

**Багш нарт зориулж:** Энэ бүлэг нь дөрвөн хэсэгтэй. Гарчиг бүр нь итгэлийн тухай асуулт байх болно. Та эдгээр асуултуудыг хичээлийнхээ удирдамж болгон ашиглаж болно. Хэрэв ангийн гишүүдийг баг болгон хуваах боломжтой бол дөрвөн хүнтэй баг болгон хуваа. Баг бүр бүлгийн дөрвөн гарчгийг нэг нэгээр нь хуваан авахыг хүс. Дараа нь хүн бүрээс авсан гарчгийнхаа дагуу дараах зүйлсийг хийхийг хүс: (1) Сэдвээ унш. (2) Багийн гарчигт байгаа асуултын хариуг судраас олохыг хүс. (3) Сэдэвтэй холбоотой хувийн туршлагуудынхаа талаар бод. (4) Сэдвийн талаарх бодлоо бусад гишүүдтэй хуваалц.



Елиа тэнгэрээс галыг доош дуудсан (Хаадын дээд 18:17–40). Нифай өлсгөлөнг дуудсан (Хиламан 11:3–5). Тэр мөн Их Эзэнээс өлсгөлөнг дуусгахыг хүссэн (Хиламан 11:9–17). Итгэлийн хүчээр дамжуулан далайг номхотгож, үзэгдлүүдийг нээж, залбирлууд хариулагдаж байсан.

Бид судруудыг хичээнгүй судалснаар итгэл нь биднийг сайн зүйлс хийхэд хөтлөх сүнс дотор маань орших үнэний хүчтэй итгэл юм гэдгийг суралцах болно. Энэ нь дараах асуулыг асуух шалтгаан болж байна: Бид хэнд итгэх ёстой вэ?

- Өдөр бүр хийдэг зүйлсийнхээ талаар бод. Та нар үр дүнг нь харж чадахгүй ямар зүйлсийг өдөр бүр хийдэг вэ? Итгэл та нарыг хэрхэн үйлдэл хийхэд хөтөлдөг вэ?

### **Яагаад бид Есүс Христэд итгэх итгэлтэй байх ёстой вэ?**

Бид Их Эзэн Есүс Христийг итгэлийнхээ төв болгох ёстой.

Есүс Христэд итгэх итгэлтэй байна гэдэг Түүний тушаасан бүх зүйлд дуулгавартай байхуйц итгэл найдвартай байна гэсэн үг. Бид Есүс Христэд итгэснээр Түүний дуулгавартай шавь нар болж, Тэнгэрлэг Эцэг бидний нүглийг уучилж, Түүн уруу буцан очиход бэлтгэдэг.

Төлөөлөгч Петр “бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй” хэмээн номлосон (Үйлс 4:12; мөн Мозая 3:17). Иаков хүмүүс “тэд Израилын Ариун Нэгэнд [Есүс Христ] төгс итгэлтэй . . . бус аваас аврагдаж чадахгүй” хэмээн заасан (2 Нифай 9:23). Бид Аврагчид итгэх итгэл ба наманчлалаар дамжуулан Түүний Цагаатгалыг амьдралдаа үр дүнтэй болгодог. Итгэлээр дамжуулан бид мөн уруу таталтыг даван ялах хүчийг хүлээн авч чадна (Алма 37:33).

Мөн бид Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэлгүйгээр Есүс Христэд итгэх итгэлийг олж чадахгүй. Хэрэв бид Тэдэнд итгэх итгэлтэй байвал Тэдний илгээсэн Ариун Сүнсэнд мөн итгэлтэй байж, Тэр бидэнд үнэнийг зааж, амар амгаланг өгөх болно.

- Есүс Христэд итгэх итгэл хэрхэн бидний Сүмийн дуудлагуудад? гэр бүлийн харилцаанд? бидний ажилд нөлөөлж чадах

вэ? Есүс Христэд итгэх итгэл бидний мөнхийн амьдралын найдварт хэрхэн нөлөөлөх вэ?

### **Бид хэрхэн Есүс Христэд итгэх итгэлээ өсгөж чадах вэ?**

Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан ирэх олон адислалуудыг мэдсэнээр бид Түүнд итгэх итгэлээ өсгөхийг эрэлхийлэх болно. Аврагч “Хэрэв гичийн үр төдийхөн итгэл та нарт байвал . . . та нарт боломжгүй юм гэж байхгүй болно” хэмээн хэлсэн (Матай 17:20). Гичийн үр маш жижиг боловч том мод болон ургадаг.

Бид хэрхэн өөрсдийн итгэлийг өсгөж чадах вэ? Хэн нэгэн авьяас чадвараа хөгжүүлэхтэй адил замаар бид итгэлээ өсгөн, хөгжүүлдэг. Хэрхэн бид модоор урлах, нэхэх, зурах, хоол хийх, ваар сав урлах эсвэл хөгжим тоглох авьяасаа хөгжүүлдэг вэ?

Бид үүн дээр ажиллаж, суралцаж, дасгал хийдэг. Ингэснээр бид сайжирдаг. Итгэлээ мөн үүнтэй ижил замаар хөгжүүлдэг. Хэрэв бид Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхийг хүсч байвал үүн дээрээ бид ажиллах ёстой. Бошиглогч Алма Бурханы үгийг тэжээн тэтгэх ёстойг үртэй зүйрлэсэн:

“Гэвч болгоогтун, хэрэв та нар бүр миний үгсийг туршин, сэргж мөн чадвараа сэргээх аваас, мөн итгэлийн жижиг хэсгийг ч гэсэн бодит болговол, тийм ээ, бүр та нарт итгэх хүслээс илүү нь байхгүй ч гэсэн, энэ хүслийг өөрсөддөө хөгжихийг, бүр та нар миний үгсийн нэгэн хэсгийг өөртөө байрлуулж чадахаар ингэтлээ зөвшөөр.

“Эдүгээ, бид үгийг үртэй зүйрлэх болно. Эдүгээ, хэрэв та нар зүрх сэтгэлд тань үр суулгагдаж болохын тулд зай тавьж өгвөөс, болгоогтун, хэрэв энэ нь үнэн үр, эсвээс энэ нь сайн үр аваас, хэрэв та нар Их Эзэний Сүнснийг эсэргүүцэхээр итгэлгүй байдлаараа үүнийг та нар зайлуулахгүй аваас, болгоогтун, энэ нь та нарын цээжинд өсөж эхлэх болно; мөн та нар эдгээр өсөлтийг мэдрээд, та нар өөрсөддөө – Энэ нь сайн үр, өөрөөр хэлбэл үг нь сайн байх ёстой, учир нь энэ нь бодгалийг минь тэлж эхлэв; тийм ээ, энэ нь ойлголтыг минь гэгээрүүлж эхлэв, тийм ээ, энэ нь надад амтат байх болж эхлэв хэмээн хэлж эхлэх болно. . . .

“Эдүгээ болгоогтун, энэ нь та нарын итгэлийг өсгөх бус уу?”  
(Алма 32:27–29).

Иймийн тул бид Түүнд итгэх итгэлтэй байх өөрсдийн хүсэл дээр үйлдсэнээр Бурханд итгэх итгэлээ хөгжүүлж чадна.

Бид мөн Тэнгэрлэг Эцэгт хандан өөрсдийн найдвар, хүсэл, хэрэгцээний төлөө залбирснаар итгэлээ өсгөж чадна (Алма 34:17–26). Харин бидний хийх бүх зүйл асуун залбирах гэж бодох ёсгүй. Бидэнд судрууд “итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм” хэмээн хэлдэг (Иаков 2:17). Дараах түүх нь нэгэн эр өөрийн ажил үйлдлээр итгэлээ харуулсан тухай түүх юм.

Энэ эр судруудыг судлахыг хүссэн ч уншиж чаддаггүй байв. Тэр Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч түүнд уншиж сурахад туслахыг хүсчээ. Тэр үед түүний тосгонд нэгэн багш иржээ. Тэр түүнээс туслахыг хүсэв. Тэр цагаан толгойг сурав. Тэр үсэгнүүдийг нүдэлж, холбож үгс бүтээж сурав. Удалгүй тэр энгийн үгсийг уншиж сурсан байв. Тэр их давтан хичээллэх тусам улам ихийг суралцаж байв. Тэр Их Эзэнд багш илгээж, уншиж сурахад тусалсанд талархлаа илэрхийлэв. Тэр Сүм дэх салбарын ерөнхийлөгчөөр үйлчлэх хүртлээ өөрийн итгэл, төлөв даруу зан, мэдлэгийг хөгжүүлсэн байлаа.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбал тайлбарлахдаа, “Итгэлийн зэрэгцээ үйлдэл байх ёстой. Их Эзэнээс бидэнд мэдлэг *өгөхийг* гуйхын оронд харин мэдлэгийг олж авахын төлөө бүтээлч үр дүнтэй суралцах, саруул ухаантай байх, сурсан зүйлээ тогтоож үлдэхээр Их Эзэний тусламжийг гуйх нь мэргэн ухаан болно” (*Faith Precedes the Miracle* [1972], 205; налуу бичилт эх хувь).

Итгэл бидэнд бүхнийг хийх мөн найдаж, залбирдаг зүйлсийг гүйцэлдүүлэх боломжийг олгодог. Ерөнхийлөгч Кимбал: “Бид итгэлийн үрийг тарьж удалгүй үр цэцэглэн дэлбээлэхийн гайхамшгийг хардаг. Хүмүүс ихэвчлэн буруугаар ойлгож, үйл явцыг урвуугаар нь хийдэг.” Тэр үргэлжлүүлэн бидний олонх нь эрүүл мэндийн хуулийг сахихгүйгээр эрүүл чийрэг байхыг хүсдэг талаар тайлбарлажээ. Бид аравны нэгээ төлөхгүйгээр эд хөрөнгөтэй болохыг хүсдэг. Бид мацаг барьж, залбирлаа хийдэггүй

мөртлөө Их Эзэнтэй ойр байхыг хүсдэг. Бид Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалж, Их Эзэний бусад зарлигуудыг сахихгүйгээр тодорхой улиралд бороо ороосой, орон нутагт минь амар амгалан байгаасай хэмээн хүсдэг (*Teachings of Presidents of the Church: Спенсер В.Кимбал* [2006], 142).

Өөрсдийн итгэлийг өсгөх чухал ач холбогдолтой аргуудын нэг бол Их Эзэний үгсийг сонсож, судлах явдал юм. Бид Сүмийн цуглаанууд дээр Их Эзэний үгсийг сонсдог. Бид Түүний үгсийг судруудаас судалж чадна. “Мөн бүгдээр итгэлгүй байгаа учраас, та нар хичээнгүйлэн эрэлхийлж мөн мэргэн ухааны үгсийг бие биендээ заагтун; тийм ээ мэргэн ухааны үгсийг шилдэг номнуудаас эрэлхийлэгтүн та нар; бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн” (С ба Г 88:118).

- Өөрсдийн итгэл, үйлдэл хоёрын хооронд ямар холбоо байгааг та нар харж байна вэ?

### **Итгэлийг дагаж ирдэг ямар адислалууд байдаг вэ?**

Итгэлийн бэлгээр дамжуулан гайхамшгууд үйлдэгдэж, тэнгэрийн элчүүд үзэгдэж, Сүнсний бусад бэлгүүд өгөгдөж, залбирлууд хариулагдаж, хүмүүн Бурханы хөвгүүд болно (Моронай 7:25–26, 36–37).

“Итгэлээр төлөөлөгч, бошиглогч, евангелист, пастор, багш нар болон бэлгүүд, мэргэн ухаан, мэдлэг, ид шид, эдгээлт, хэл, хэлмэрч зэрэг нь ирдэг. Дэлхий дээр итгэл байхад энэ бүхэн бий болдог. Харин итгэл дэлхийгээс алга болоход энэ бүхэн үзэгдэхээ болино. Тэгэхээр энэ бүхэн хүмүүний итгэлийн үр нөлөө мөн. Итгэлийг өөртөө байлгах тэр нь түүгээрээ дамжуулан Бурханыг, мөн мөнхийн амьдрал болох Түүний илгээсэн Их Эзэн Есүс Христийг мэдэх хүртлээ бүх шаардлагатай мэдлэг, мэргэн ухааныг олж авдаг (*Lectures on Faith* [1985], 83).

- Есүс Христэд итгэх итгэлтэй байсан учир хүмүүс илүү чадалтай хүчирхэг болдог ямар түүхүүд судруудад байдаг вэ? Ийм зүйл таны амьдралд хэрхэн тохиолдож байсан бэ?

### **Нэмэлт судрууд**

- Еврей 11; Алма 32 (итгэлийн мөн чанар)
- Египетээс гарсан нь 14:19–22 (улаан тэнгисийн усыг хуваасан нь)
- Эхлэл 6–8 (Ноа ба үер)
- Матай 8:5–33 (өвчин эдгээгдэв, шуурга намдаав, итгэлийн гайхамшгууд)
- Марк 5:25–34 (итгэлээр эдгэрсэн)
- Ром 10:17 (Бурханы үгийг сонссоноор итгэл ирдэг)





# Наманчлал

Бүлэг 19

---

## **Бид бүгд наманчлах хэрэгтэй**

- Нүгэл гэж юу вэ? Бидний нүглүүд бидэнд ямар нөлөө үзүүлдэг вэ?

Есүс Христэд итгэх итгэл нь гарцаагүй наманчлалд хөтөлдөг. Адамын үеэс эхлэн өнөөгийн өдрүүдийг хүртэл дэлхий дээр наманчлал гарцаагүй шаардлагатай байсан. Их Эзэн Адамд “Иймийн тул хүмүүн хаа сайгүй наманчлах ёстой, үүнийг хүүхдүүдэдээ заагтун, эс бөгөөс тэд Бурханы Хаант улсыг өвлөж чадах нь үгүй, учир нь цэвэр ариун бус зүйл тэнд оршиж чадах нь үгүй” хэмээн зөвлөсөн (Мосе 6:57).

Бид дэлхийд өсөж, хөгжихийн тулд ирсэн. Энэ бол насан туршийн үйл явц. Энэ хугацаандаа бид бүгд нүгэл үйлддэг (Ром 3:23). Бид наманчлах хэрэгтэй. Заримдаа бид үл тоомсорлосноосоо болж, заримдаа бидний сул талуудын учир, заримдаа зориудаар дуулгаваргүй байсны учир бид нүгэл үйлддэг. Ариун Библид “газар дэлхий дээр үйлдээд, нүглийг ер үйлддэггүй зөв шударга хүн гэж үгүй” (Номлогчийн үгс 7:20) бөгөөд “хэрэв бид нүгэлгүй гэж хэлбэл өөрсдийгөө мэхэлж байгаа бөгөөд бидний дотор үнэн алга” (1 Иохан 1:8).

Нүгэл гэж юу вэ? Иаков “Тийм учир зөв юмыг үйлдэхийг мэддэг хэрнээ үл үйлддэг хүнд энэ нь нүгэл юм” хэмээн хэлсэн (Иаков 4:17). Иохан нүглийг дүрслэн хэлэхдээ нүгэл нь “бүх зөвт бус байдал” (1 Иохан 5:17) мөн “ёс бус хэрэг” гэжээ (1 Иохан 3:4).

Тийм учраас Их Эзэн “Бүх хүмүүн хаа сайгүй наманчлах ёстой” хэмээн хэлсэн (Мосе 6:57). Дэлхий дээр төгс байдлаар амьдарч байсан Есүс Христээс бусад хүн бүхэн нүгэл үйлддэг. Тэнгэрлэг Эцэг Өөрийн агуу хайраар бидэнд нүглүүдээ наманчлах боломжийг олгосон.

---

## Наманчлалаар дамжуулан өөрсдийн нүглүүдээс чөлөөлөгдөх нь

- Наманчлал гэж юу вэ?

Наманчлал нь бид нүглүүдээсээ чөлөөлөгдөж, уучлалыг олох боломж юм. Нүглүүд бидний сүнслэг өсөлтийг удаашруулж, бүр түүнийг зогсоож ч чадна. Наманчлал биднийг сүнслэгээр дахин өсч хөгжих боломжтой болгодог.

Наманчлах онцгой боломж нь Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан боломжтой болгогдсон юм. Бид гүйцэд бүрэн ойлгож чадахааргүй замаар Есүс бидний нүглийн төлөөсийг төлсөн. Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит үүний тухай хэлэхдээ:

“Би өвдөлтөөр зовсон, та нар ч өвдөлтөөр зовсон заримдаа энэ маш их хэцүү байдаг. Гэхдээ би биеийн сүв бүрээс хөлс мэт цусан дусал шүүрэн гарах өвдөлтийг ухаарч ойлгож чадахгүй. Энэ үнэхээр аймаар зүйл байсан. . . .

“. . . Энэ дэлхий дээр Бурханы Хүүгийн дээр ирсэн миний болон та нарын нүглийн ачааг даах ямар ч хүн хэзээ ч төрж байгаагүй бөгөөд энэ нь бидэнд нүглүүдээсээ салах боломжийг олгосон (*Doctrines of Salvation*, сон. Брюс Р. МкКонки, 3 боть. [1954–56], 1:130–31; налуу бичилт эх хувь).

Заримдаа наманчлал нь Их Эзэний зарлигуудаар амьдрах агуу эр зориг, маш их хүч, асар их нулимс, зогсолтгүй залбирал, цуцашгүй хичээл зүтгэлийг шаарддаг.

## Наманчлалын зарчмууд

- Наманчлалын зарчмууд юу вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбал “*наманчлалд хүргэх дөт зам*, уучлалыг хүртэх онцгой зам гэж байхгүй. Ядуу баян, боловсролтой боловсролгүй, өндөр нам, хунтайж гуйлгачин, хаан харц байна уу хамаагүй хүн бүр яг ижил арга замыг дагах

---

**Багш нарт зориулж:** Жагсаалт гарган бичих нь суралцагсдын сонирхлыг татаж, тэдний анхаарал төвлөрөхөд туслах болно. Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдтэй наманчлалын зарчмуудын талаар ярилцахдаа хэн нэгнээр самбар дээр юм уу том цаасан дээр зарчмуудыг бичүүл.

ёстой хэмээн тунхагласан (*Teachings of Presidents of the Church: Спенсер В.Кимбал* [2006], 38; налуу бичилт эх хувь).

*Бид өөрсдийн нүглийг ухамсарлах ёстой*

Наманчлахын тул бид нүгэл хийсэн гэдгээ өөрсдөө хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрөхгүй бол наманчилж чадахгүй.

Алма номлолынхоо дуудлагад итгэлгүй байж, ноцтой нүглүүд үйлдсэн хүү Кориантондоо “Хүү минь, чамайг эдгээр зүйл дахин бүү зовоогоосой, мөн зөвхөн доош наманчлалд авчрах зовлонгоор нүглүүд чинь чамайг зовоогоосой. . . . Нүглүүдээ хаацайлахыг огтхон ч бүү хичээ” хэмээн сургамжилсан (Алма 42:29–30). Цаашид өөрсдийгөө нүгэлгүй мэт зөвтгөх хэрэггүй гэдгийг судрууд бидэнд зөвлөдөг (Лук 16:15–16).

Бид өөрсдөөсөө эсвэл Бурханаас юуг ч, ямар ч үйлдлийг нууж чадахгүй.

*Бид өөрсдийн нүглүүдээ харуусах ёстой*

Нүглээ ухамсарлахын тул бид өөрсдийн хийсэн зүйлийнхээ төлөө чин сэтгэлээсээ харамсах ёстой. Бидний нүглүүд аймаар гэдгийг мэдрэх ёстой. Бид тэдгээр ачаанаас ангижирч, чөлөөтэй болохыг хүсэх ёстой. Судрууд бидэнд “Бурханы өмнө өөрсдийгөө даруусах тэд бүгд, мөн баптисм хүртэхийг хүсэгчид мөн харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэйгээр ирэгсэд, мөн үнэхээр бүх нүглүүдээс наманчилснаа гэрчлэгсэд, баптисмаар түүний сүмд хүлээн авагдах ёстой” хэмээн хэлдэг (С ба Г 20:37).

- 2 Коринт 7:9–10 ба Мормон 2:10–14 судал. “Бурханлаг харамсал” ба харамслын илэрхийлэл хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ?

*Бид нүглүүдээ орхих ёстой*

Бидний чин сэтгэлийн харамсал нь нүглээ орхиход (болих) хөтлөх ёстой. Хэрэв ямар нэгэн зүйл хулгайлсан бол бид дахин хулгай хийх ёсгүй. Хэрэв бид худлаа ярьсан бол дахин худал хэлэх ёсгүй. Хэрэв бид ариун явдлын хууль зөрчсөн бол үүнийг зогсоох ёстой. Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд “Хүн

нүглүүдээ наманчилдаг эсэхийг та нар үүгээр нь мэдэж болно – болгоогтун, тэрээр тэдгээрийг хүлээж мөн орхих болно” хэмээн илчилсэн (С ба Г 58:43).

*Бид нүглүүдээ хүлээн зөвшөөрөх ёстой*

Нүглээ наманчлах нь маш чухал. Их Эзэн бидэнд нүглийн буруугаа хүлээхийг тушаасан. Нүглээ хүлээн зөвшөөрөх нь нүгэлтнээс хүнд ачааг хөнгөлдөг. Их Эзэн “Их Эзэн, бибээр нүглүүдийг өршөөдөг, мөн даруухан зүрхээр нүглүүдээ гэмшдэг тэдэнд нигүүлсэнгүй байдаг” хэмээн амалсан (С ба Г 61:2).

Бид Их Эзэнд бүх нүгэлдээ гэмшин буруугаа хүлээх ёстой. Дээр нь завхайрах, порно, ижил хүйстэнтэй явалдах, эхнэр юм уу нөхрөө эсвэл хүүхэд хүчирхийлэх, мансууруулах бодис худалдаалах юм уу хууль бусаар хэрэглэх зэрэг ноцтой бидний Сүм дэх байр суурьт нөлөөлж болох гэм нүглийг зохих санваарын эрх мэдэлтэнд илчлэн буруугаа хүлээх ёстой. Хэрэв бид хэн нэгэнд нүгэл үйлдсэн бол хохироосон хүнээсээ уучлалт гуйж, нүглээ наманчлах ёстой. Зарим нүгэл ноцтой бус, хэн нэгнийг хохироодоггүй боловч биднийг өөрсдийг маань болон Их Эзэнээ оролцуудаг. Эдгээрийг хувиараа Их Эзэндээ хандан буруугаа хүлээн наманчилж болно.

*Бид нөхөн төлбөрийг хийж хохиролгүй болгох ёстой*

Нүглээ наманчлахын нэг хэсэг бол нөхөн төлбөрийг хийх явдал. Энэ нь өөрсдийн үйлдсэн аливаа буруу зүйлийг зөв болгох гэсэн үг юм. Жишээ нь: хулгайч хулгайлсан зүйлээ буцааж өгөх ёстой. Худал яригч үнэнийг мэдэгдэх ёстой. Хэн нэгний нэр хүндийг гутаасан хов живээр хөөцөлдөгч тухайн хүнийхээ нэрийг сэргээх ажлыг хийх ёстой. Бид эдгээр зүйлсийг хийх аваас шүүлтэд ирэх үед Бурхан бидэнд нүглийн маань талаар дахин дурсахгүй байх болно (Езекиел 33:15–16).

*Бид бусдыг уучлах ёстой*

Наманчлалын амин чухал хэсэг бол бидэнд нүгэл үйлдсэн тэднийг уучлах юм. Бидний зүрх сэтгэл бусад хүмүүсийн эсрэг үзэн ядалт, гашуун муу мэдрэмжүүдээс бүрэн цэвэрлэгдэхгүй аваас Их Эзэн мөн биднийг уучлахгүй байх болно 3 Нифай

---

13:14–15). “Иймийн тул, та нар бие биенээ уучлах ёстойг та нарт хэлнэ би; учир нь ах дүүгийнхээ зөрчлийг үл уучилдаг тэрээр Их Эзэний өмнө буруушаагдахаар зогсох буюу; учир нь түүнд илүү их нүгэл үлддэг болой” (С ба Г 64:9).

### *Бид Бурханы тушаалуудыг сахих ёстой*

Бид өөрсдийн нүглийн наманчлалыг бүрэн гүйцэлдүүлэхийн тул Их Эзэний тушаалуудыг сахих ёстой (С ба Г 1:32). Хэрэв бид аравны нэгээ төлөхгүй эсвэл Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгалахгүй эсвэл Мэргэн ухааны үгэнд дуулгавартай байхгүй аваас бид бүрэн гэмшсэн болохгүй. Хэрэв бид Сүмийн эрх мэдлүүдийг дэмжин батлахгүй аваас Их Эзэн болон өөрсдийн нэг үзэл санаатай нөхдийг хайрлахгүй аваас бид гэмшээгүй байна гэсэн үг. Хэрэв бид залибардаггүй, бусдад нөхөрсөг ханддаггүй бол бид жинхэнээсээ гэмшсэн биш. Бид гэмших аваас бидний амьдрал өөрчлөгдөнө.

Ерөнхийлөгч Кимбал, “Нэгдүгээрт, хүн гэмшдэг. Үүний дараа өөрийн давуу талыг хадгалж үлдэхийн тул Их Эзэний зарлигуудын дагуу амьдрах ёстой. Энэ нь бүрэн уучлалыг найдвартай ирүүлэхэд шаардлагатай” (*Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball*, 43).

- Энэ хэсэгт зааж буй сургаалууд наманчлал бол жагсааж бичсэн энгийн бөгөөд байнгын тогтмол хийгддэг үйлдлүүд юм гэсэн худал санаанаас хэрхэн ялгарч байна вэ?

### **Бидэнд наманчлал хэрхэн тусалдаг вэ**

- Ямар замаар наманчлал бидэнд тусалдаг вэ?

Биднийг нүглээ наманчлахад амьдралд маань Есүс Христийн Цагаатгал бүрэн нөлөөлж, Их Эзэн бидний нүглүүдийг уучилдаг. Бид нүглүүдийн боолчлолоос чөлөөлөгдөж, баяр баяслыг олдог.

Алма нүглийн наманчлалын туршлагаас хуваалцахдаа:

“Би мөнхийн зовлонд тамлагдаж байлаа, учир нь бодгаль минь хамгийн их хэмжээгээр тарчлагдаж мөн өөрийн бүх нүглүүдээр тамлагдав.

“Тийм ээ, би өөрийн бүх нүглүүд мөн алдсуудыг санаж байв, үүний учир би тамын өвдөлтөөр тарчлагдаж байлаа; тийм ээ би Бурханыхаа эсрэг тэмцсэнээ, мөн би түүний ариун зарлигуудыг дагаагүйгээ ойлгосон юм.

“ . . . Бурханыхаа дэргэд ирнэ гэдэг тэр л бодол бодгалийг минь илэрхийлэхийн аргагүй аймшигтайгаар тарчилгахаар миний алдсууд ийм агуу байв.

“ . . . Би тийн зовлонд тамлагдаж, өөрийн олон нүглийн дурсамжиндаа тарчлагдаж байхдаа би, болгоогтун, би түүнчлэн дэлхийн нүглүүдийг цагаатгахаар, Бурханы Хүү, Есүс Христ гэгч нэгний ирэлтийн талаар хүмүүст эцгийнхээ бошиглолыг дуулснаа санав.

“Эдүгээ, миний оюун энэ бодол дээр тогтож тунгаах зуур, би зүрх сэтгэлдээ хашгирч: Ай Есүс, Бурханы Хүү та, намайг нигүүлсээч. . . .

“Мөн эдүгээ, болгоогтун, би үүнийг бодмогц, би өвчнөө цаашид санаж чадсангүй. . . .

“Мөн ай ямар баясал, мөн ямар гайхамшигт гэрлийг болгоосон билээ би; тийм ээ, бодгаль минь ямархуу шаналалд байсан лугаа адил тийм үлэмжийн баяслаар дүүргэгдсэн байв!

“ . . . Миний баясал шиг ийм хурц бас амтлаг юм юу ч байж чадахгүй биз ээ” (Алма 36:12–14, 17–21).

- Наманчлал болон уучлал Алмад хэрхэн баяр баяслыг авчирсан бэ?

### **Наманчлалыг хойшлуулснаас ирэх аюулууд**

- Наманчлалыг хойш тавьснаас болж ямар үр дагаварууд гарч болох вэ?

Бошиглогчид “энэ амьдрал бол хүмүүн Бурхантай уулзахаар бэлтгэх үе” хэмээн тунхагласан (Алма 34:32). Бид одоо өдөр бүр наманчлах ёстой. Бид өглөө босоод Бурханы Ариун Сүнс бидэнтэй хамт байна уу гэдгийг шалгах хэрэгтэй. Орой орондоо орохоос өмнө бид өдөртөө хийсэн үйлдэл, хэлсэн

үгсийнхээ талаар эргэн бодож, өөрсдийн наманчлах шаардлагатай зүйлсийг мэдэхэд туслахыг Их Эзэнээс хүсэх хэрэгтэй. Наманчлалыг хийж, өдөр бүр өөрсдийн нүглүүдийн төлөөх Их Эзэний уучлалыг авснаар өдөр бүр бид төгс болох явцыг амсаж чадна. Алмагийн адил бидний аз жаргал, баяр баясал маань амтлаг, тансаг байж чадна.

### **Нэмэлт судрууд**

- Матай 9:10–13; Лук 13:3; Езекиел 18:30 (наманчлах эсвэл шийтгүүлэх)
- Алма 7:21 (Бурханы оршихуйд цэвэр бус зүйл байж чадахгүй)
- 2 Коринт 7:9–10 (бурханлиг гэмшил)
- Мозая 4:10–12 (наманчлалын алхмууд)
- Исаиа 1:18; Мозая 26:28–32 (наманчлал уучлалыг авчирдаг)
- С ба Г 58:42 (нүглийг дахин санахгүй)
- 2 Нифай 9:23 (авралд хүрэхэд наманчлал зайлшгүй хэрэгтэй )
- 2 Нифай 2:21 (махан биебодьтой байхдаа наманчил)
- С ба Г 19:15–20 (Их Эзэн зовсны адил зовохгүйн тулд наманчлахыг тушаасан Их Эзэн бидэнд тушаасан)





# БАПТИСМ

Бүлэг 20

---

## БAPTИCМ ХҮРТ ХЭМЭЭХ ЗАРЛИГ

• Яагаад бид баптисм хүртэх ёстой вэ?

Өнөөдөр Есүсийн өдрүүдийн адил бид суралцаж, дуулгавартай байх ёстой сайн мэдээний зарчмууд, ёслолууд байдаг. Сайн мэдээний зарчим нь үнэн итгэл буюу сургаал. Ёслол нь ёс жаяг буюу ёслолын ажиллагаа юм. Сайн мэдээний анхны хоёр зарчим нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл ба наманчлал. БAPTИCМ бол сайн мэдээний анхны ёслол. Их Эзэн Өөрийн Төлөөлөгчдөд өгсөн удирдамжуудын нэг нь “Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа” (Матай 28:19–20).

*Бид нүглүүдийнхээ ангижралын төлөө баптисм хийлгэх ёстой*

Өөрсдийн итгэлийг Есүс Христэд тавьж, наманчилж, баптисм хүртэхэд Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бидний нүгэл мартагддаг.

Бид судруудаас Иохан БAPTИCТ “нүглийн уучлалын төлөөх гэмшлийн баптисмыг тунхаглаж байв” гэдгийг суралцдаг (Марк 1:4). Төлөөлөгч Петр “Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ” хэмээн заасан (Үйлс 2:38). Паулын хөрвөлтийн дараа Ананиа түүнд, “Бос, баптисм хүрт. Нүглээ угаа” гэдэг (Үйлс 22:16).

---

**Багш нарт зориулж:** Хэсгийн эхэнд байгаа асуултуудаар ярилцлагаа эхэл. Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг хичээлээс дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүс. Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг уншсан зүйлсийнхээ талаар тунгаан бодож, ярилцахад нь туслахын тул хэсгийн төгсгөлд байгаа асуултуудыг ашигла.

*Бид Есүс Христийн Сүмийн гишүүд болохын тул баптисм хүртэх хэрэгтэй.*

“Бурханы өмнө өөрсдийгөө даруусгах тэд бүгд, мөн баптисм хүртэхийг хүсэгчид . . . мөн үнэхээр өөрсдийн бүх нүглүүдийг наманчилсан . . . тэд баптисмаар түүний сүмд хүлээн авагдах ёстой” (С ба Г 20:37).

*Бид Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахын өмнө баптисм хүртэх ёстой*

Их Эзэн “Хэрэв чи над руу эргэж, мөн өөрийн бүх бүх зөрчлөөс наманчлан, мөн бүр усан дотор Миний Төрсөн Ганц Хүү болох Есүс Христийн нэрээр баптисм хүртэх аваас, та нар Ариун Сүнсийг хүлээж авах болно” хэмээн хэлсэн (Моше 6:52).

*Бид дуулгавартай байдлаа харуулахын тул баптисм хүртэх ёстой*

Есүс Христ ямар ч нүгэлгүй байсан. Гэсэн ч Тэр баптисм хүртсэн. Тэр “аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэх” –ийн тул Түүний баптисм шаардлагатай байсан гэдгийг хэлсэн (Матай 3:15). Бошиглогч Нифай “Намайг дага, мөн миний хийхийг харсан тэр зүйлүүдээ хий . . . бүх зүрх сэтгэлээрээ Бурханы өмнө хоёр нүүр гаргах мөн мэхлэхийг үл үйлдэн, харин үнэн санаатайгаар Хүүг даган, нүглүүдээ наманчлан, Эцэгт та нар баптисмаар Христийн нэрийг өөрийн дээр авахад бэлэн байгаагаа гэрчлэн. . .” хэмээн Их Эзэн түүнд хэлснийг тайлбарласан (2 Нифай 31:12–13).

*Бид селестиал хаант улсад очихын тул баптисм хүртсэн байх ёстой*

Есүс “Надад итгэсэн, мөн баптисм хүртсэн хэн боловч . . . Бурханы хаант улсыг өвлөх хүмүүс юм. Мөн надад итгэхгүй, мөн баптисм хүртэхгүй хэн боловч, яллагдах болно” (3 Нифай 11:33–34). Баптисм нь селестиал хаант улс руу орох зам дээр гарах босго билээ (2 Нифай 31:17–18).

### **Баптисмын зөв хэлбэр**

- Бид хэрхэн баптисм хүртэх ёстой вэ?

Зөвхөн нэг л зөв арга зам байдаг. Есүс Бошиглогч Иосеф Смитэд зохих санваарын эрх мэдэлтэй хэн нэгэн хэрхэн баптисм хүртээх талаар илчилсэн. Тэр “өөрийгөө баптисмд авчирсан тэр хүний хамт ус руу орно. . . . Тэгээд тэрээр түүнийг усанд умбуулж, мөн уснаас дахин гаргана” (С ба Г 20:73–74). Усанд умбуулах нь гарцаагүй шаардлагатай. Төлөөлөгч Паул усанд умбуулж, дахин гаргаж ирэх нь үхэл, оршуулга мөн дахин Амилалтын бэлгэ тэмдэг хэмээн заасан. Баптисм хүртсэний дараа бидний шинэ амьдрал эхэлдэг. Паул хэлэхдээ:

“Эсвэл Христ Есүс уруу баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл уруу баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү?

“Тиймд Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явахын тулд үхэл уруу баптисм хүртсэнээр Түүнтэй хамт оршуулагдсан юм.

“Учир нь, хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж бас Түүний Амилуулалттай нь ч холбогдох болно” (Ром 6:3–5).

Усанд умбуулалтаар, зохих эрх мэдэлтэй хэн нэгнээс баптисм хүртэх нь баптисм хүртэх цорын ганц зөв зам.

- Яагаад баптисм хүртэхэд зохистой эрх мэдэл чухал вэ?
- Усанд умбалтаар баптисм хүртэх нь Аврагчийн оршуулга ба Амилуулалттай ямар замаар адилхан бэ?

### **Хариуцлага хүлээх болсон насандаа баптисм хүртдэг**

- Хэн баптисм хүртэх вэ?

Найман нас хүрсэн, өөрийн үйлдлүүдийн төлөө хариуцлага хүлээх чадвар бүхий хүн бүр баптисм хүртэх хэрэгтэй. Зарим сүм бяцхан хүүхэд ч баптисм хүртэх ёстой гэж заадаг. Энэ нь Аврагчийн сургаалтай зөрчилддөг. Есүс бяцхан хүүхдүүдийн талаар “гэнгэрийн хаанчлал бол эдний адил хүмүүсийнх” хэмээн Тэр хэлсэн (Матай 19:14).

Бяцхан хүүхдүүдийг усаар батлах нь Бурханы өмнө элэг доог болох зүйл, учир нь тэд нүгэл хийх чадваргүй хэмээн

Бошиглогч Мормон хэлсэн. Үүнтэй нэгэн адил зөв ба буруут мэдэхгүй оюун санааны хомсдолтой хүмүүст баптисм хүртээдэггүй (Моронай 8:9–22).

Бусад бүх хүмүүс баптисм хүртэнэ. Бид баптисмын ёслолыг хүлээн авч, өөрсдийн хийсэн баптисмын гэрээндээ итгэлтэй үнэнч үлдэх ёстой.

- Нярай хүүхдүүдэд баптисм хүртээх ёстой гэдэгт итгэдэг найздаа та нар юу гэж хэлэх вэ?

### **Бид баптисм хүртэхдээ гэрээ хийдэг**

Олон судрууд баптисмын талаар заадаг. Энэ судруудын нэгэнд бошиглогч Алма итгэл ба наманчлал нь биднийг баптисмд бэлтгэх алхам хэмээн заасан. Баптисм хүртэхдээ бид Бурхантай гэрээ хийдэг гэж Тэр заасан. Бид тодорхой хэдэн зүйлсийг хийхээр амласан ба Бурхан үүний хариуд биднийг адислахаар амласан.

Бид Бурханы хүмүүс хэмээн нэрлэгдэхийг хүсэх ёстой гэдгийг Алма тайлбарласан. Бид бие биедээ тусалж, тайвшруулах хүсэлтэй байх ёстой. Бид бүх цаг мөч, бүх зүйлс, бүх газарт Бурханы гэрч болон зогсох ёстой. Эдгээр зүйлсийг хийснээр бид баптисм хүртэж, Бурхан бидний нүглүүдийг уучлах болно. Алмагийн сайн мэдээний талаар заасан сургаалд итгэсэн хүмүүст тэрээр хэлэхдээ:

“Болгоогтун, Мормоны ус энэ байна. Мөн эдүгээ, та нар Бурханы хороонд орж, мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх хүсэлтэй байж, тэр өөрийн Сүнснийг та нар дээр илүү элбэгээр юүлж болохын тулд, та нар түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагана хэмээн гэрээ байгуулснаа түүний өмнө гэрчилж, Их Эзэний нэрээр баптисм хүртэхэд юу нь та нарт болохгүй байх билээ?” (Мозая 18:8, 10). Хүмүүс баярлалдан алгаа ташиж, энэ бол тэдний хүслэн гэдгийг хэлсэн. Алма тэднийг Мормоны усанд баптисм хүртээв (Мозая 18:7–17).

Бид баптисм хүртэхдээ Их Эзэнтэй дараах зүйлсийг хийхээр гэрээнүүд хийснийг заасан. Үүнд:

---

1. Бурханы хороонд ирэх нь.
2. Нэг нэгнийхээ ачааг хөнгөн болгох нь.
3. Ямар ч цагт, хаана ч байсан Бурханы гэрчлэгч болон зогсох.
4. Бурхандаа үйлчилж, Түүний зарлигуудыг сахих.

Бид баптисм хүртэж, баптисмын гэрээнүүдээ сахих аваас Их Эзэн бидэнд дараах зүйлсийг амласан. Үүнд:

1. Бидний нүглүүдийг уучлана (Үйлс 2:38; С ба Г 49:13).
  2. Бидний дээр Өөрийн Сүнсийг илүү элбэгээр юүлнэ (see Мозая 18:10).
  3. Өдөр бүр бидний дээр Ариун Сүнсний удирдамж, тусламжийг өгнө (Үйлс 2:38; С ба Г 20:77).
  4. Биднийг анхны Амилуулалтын дунд дахин амилуулна (Мозая 18:9).
  5. Бидэнд мөнхийн амьдралыг өгнө (Мозая 18:9).
- Нэг нэгнийхээ ачааг үүрэлцэх гэдэг юу гэсэн үг вэ? Ямар ч цагт, хаана ч Бурханы гэрчлэгч болон зогсох гэдэг юу гэсэн үг вэ?

### **Баптисм бидэнд шинэ эхлэлийг өгдөг**

Баптисмтай хамт бидний амьдралын шинэ зам эхэлдэг. Тийм учраас бид шинээр төрөх гэж нэрлэдэг юм. Есүс хэлэхдээ бид уснаас болон Сүнснээс төрөхгүй аваас Бурханы хаант улс уруу орж чадахгүй гэсэн (Иохан 3:3–5). Энэ зарчим Адамд яг тодорхой тайлбарлагдсан байдаг.

“Мөн та нар усаар мөн цусаар мөн миний хийсэн сүнсээр дэлхийд төрөхийн хэрээр мөн ийн тоосноос амьд бодгаль болон, бүр ийн та нар цэвэршигдэж тэнгэрийн хаань улсад усаар мөн сүнсээр дахин төрж мөн цусаар бүр миний Төрсөн Ганцын цусаар бүх нүглээс ариусгагдах ёстой” (Мосе 6:59).

Төлөөлөгч Паул бидний баптисмын дараа шинээр амьдрах талаар хэлэхдээ: “мөн шинэ амийн дотор явахын тулд баптисм хүртсэнээр Түүнтэй хамт оршуулагдсан” гэсэн (Ром 6:4).

Баптисмын агуу адислалуудын нэг нь биднийг мөнхийн зорилгынхоо зүг явах зам дээр гарч, бүхнийг шинээр эхлэх боломжийг олгодог.

- Та нарын баптисм хэрхэн шинэ эхлэл болж чадсан бэ?

### **Нэмэлт судрууд**

- 2 Нифай 31:4–7 (баптисмын зорилго ба шаардлага)
- 3 Нифай 11:21–27; С ба Г 20:72–74 (баптисмыг хэрхэн гүйцэтгэдэг вэ)
- Үйлс 2:38–39 (нүглүүдээс ангижрахын тул баптисм хийлгэдэг)
- Моронай 8:8–12; С ба Г 20:71–72 (бяцхан хүүхэд баптисм хийлгэхгүй, баптисм наманчлалыг хийсэн бүгдэд боломжтой)
- Алма 7:14–16 (баптисм нь цэвэршүүлж, мөнхийн амьдралын гэрээнд оруулдаг)

# Ариун Сүнсний бэлэг

Бүлэг 21

---

## Ариун Сүнсний бэлэг

Бид 7-р бүлэгт Ариун Сүнс нь Бурхан Тэргүүтний нэг гишүүн гэдгийг суралцсан. Тэр “Сүнсэн хүн” (С ба Г 130:22). Түүнд яс махан биебодь байхгүй. Түүний нөлөөлөл нэг дор газар сайгүй байж чадна. Түүний үүрэг бол Эцэг ба Хүү мөн бүх үнэнийг гэрчлэх явдал юм. Үүнээс гадна Ариун Сүнс биднийг ариутган цэвэршүүлж, Бурханы оршихуйд амьдрахад бэлтгэдэг. Ариун Сүнс бидний зүрх сэтгэлийг нүгэл үйлдэх хүсэлгүй болгон ариусгадаг.

Ариун Сүнс ба Ариун сүнсний бэлэг хоёрын хооронд ялгаа бий. Энэ бүлэгт бид Ариун Сүнсний бэлэг гэж юу болох талаар болон энэ агуу Бурханы бэлгийг хэрхэн хүлээж авах талаар суралцах болно.

## Ариун Сүнсний бэлэг

- Ариун Сүнс ба Ариун Сүнсний бэлэг хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ?

Ариун Сүнсний бэлэг нь өөрсдийн итгэлийг Есүс Христэд тавьж, баптисм хүртэж, Сүмийн гишүүнээр батлагдаж—Ариун Сүнсний өдөөлт болон удирдамжийг тогтмол хүлээн авдаг хүмүүст өгөгдсөн—давуу эрх юм.

---

**Багш нарт зориулж:** Та ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг дараах үйл ажиллагаануудын аль нэгэнд нь оролцохыг урьж болно. Үүнд: (1) Бүлгийн төгсгөл дэх нэмэлт судруудыг уншиж, Ариун Сүнс биднийг мөнх бус амьдралын маань хэрхэн тусалдаг талаар ярилц. (2) Ариун Сүнсний бэлэг байгаагийн улмаас амьдралд тань ирсэн зарим адислалуудын талаар хуваалцахын хүс. (3) Хүүхдүүддээ Ариун Сүнсний бэлгийн талаар болон Ариун Сүнс бидэнтэй хэрхэн холбоотой байдаг талаар ойлгоход нь туслахын тулд эцэг эхчүүд юу хийж чадах талаар ярилц.





Бид анхны Төлөөлөгчдийн өдрүүдэд байсны адил баяр баясалтай байлгах Ариун Сүнсний бэлэгт итгэдэг хэмээн Иосеф Смит хэлсэн. Бид энэ бэлгийн бүрэн байдалд, хүчинд, нэр сүр ба алдар сууд итгэдэг (*Teachings of Presidents of the Church: Иосеф Смит* [2007], 97–98).

Хэн нэгэн хүн Ариун Сүнсний бэлэг хүлээн авахгүйгээр Ариун Сүнсний удирдамжаар түр хугацаанд удирдагдаж болно (С ба Г 130:23). Гэсэн ч тэр хүн баптисм хүртэж, гар тавилтаар Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахгүй бол энэ удирдамж цаашид үргэлжлэхгүй. Бид Үйлс 10 дээр Есүс Христийн сайн мэдээ үнэн гэдгийг мэдсэн Ариун Сүнсний өдөөлтийг хүлээн авсан Ромын цэрэг Корнелын талаар уншдаг. Гэхдээ Корнел баптисм хүртэх хүртлээ Ариун Сүнсний бэлгийг хүлээн аваагүй байсан. Хэрэв Корнел баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн аваагүй байсан бол түүнийг Ариун Сүнс орхих байсан хэмээн Бошиглогч Иосеф Смит заасан (*Teachings of Presidents of the Church: Иосеф Смит* 97).

Өнөөдөр Сүмийн гишүүн бус хүмүүс Ариун Сүнсний хүчээр Мормоны Ном үнэн гэдгийг сурдаг (Моронай 10:4–5). Гэвч хэрэв тэд Ариун Сүнсний бэлэг хүлээн авахгүй бол энэ анхны гэрчлэл тэднийг орхидог. Тэд Ариун Сүнсний бэлэг хүлээн авсан тэдний адил үргэлжлэх тусламжийг хүлээн авч чадахгүй.

### **Ариун Сүнсний бэлэг хүлээн авах нь**

- Ариун Сүнсний нөхөрлөлийг тогмол байлгахын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?

Хүмүүс баптисм хүртсэний дараа Сүмийн гишүүнээр батлагдаж, гар тавилтаар Ариун Сүнсний бэлэг өгөгддөг. Их Эзэн “Мөн итгэл бүхий хэнийг ч гэсэн та нар гар тавилтаар миний сүмд батлах болно, мөн бибээр Ариун Сүнсний бэлгийг тэдэнд хүртээх болно” хэмээн хэлсэн (С ба Г 33:15).

Эрх мэдлийг авсан Сүмийн зохистой ахлагч бүр бусдад Ариун Сүнсний бэлгийг өгөх болно. Гэсэн хэдий ч ахлагчид өөрсдийн гарыг тэдний толгой дээр тавьснаар л тэр хүн Ариун Сүнсний өдөөлт ба удирдамжийг хүлээн авах болно гэсэн баталгаа

байхгүй. Хүн бүр “Ариун Сүнснийг хүлээн авах” хэрэгтэй. Энэ нь биднийг зөвхөн итгэлтэй байж мөн энэ тэнгэрлэг элчийн тусламжийг хүсч байх үед л Ариун Сүнс бидэн дээр ирнэ гэсэн үг.

Ариун Сүнсний тусламжийг авах зохистой байхын тулд бид Бурханы зарлигуудад чин сэтгэлээсээ дуулгавартай байхыг эрэлхийлэх хэрэгтэй. Бид өөрсдийн бодол ба үйлдлүүдийг цэвэр байлгах хэрэгтэй.

### **Ариун Сүнсний нөлөөг таних нь**

Гол төлөв Ариун Сүнс бидэнтэй намуухнаар харьцдаг. Түүний нөлөөлөл нь ихэвчлэн бидэнд “тайван дуу хоолой” –гоор ирдэг (Хаадын дээд 19:9–12; Хиламан 5:30; С ба Г 85:6). Ерөнхийлөгч Бойд К.Пакер тайлбарлахдаа: “Ариун Сүнс та нарын *сонсохоос* илүүтэй *мэдрэх дуу хоолойгоор ярьдаг*. . . . Тиймээс бид Сүнсний шивнээг “сонсох” үед ихэнх тохиолдолд “Надад . . . мэдрэмж төрсөн” хэмээн хэлэх сүнслэг өдөөлтийг хэн нэгэн тодорхойлдог. Энэ Сүнсний дуу хоолой та нарт юу хийх, юу хэлэх, эсвэл анхааруулах, болгоомжуулах өдөөлтийг намуухнаар хэлдэг” (Conference Report , 1994 оны 10-р сар, 77; эсвэл *Ensign*, 1994 оны 11-р сар, 60).

### **Бурханы агуу бэлгүүдийн нэг**

- Ариун Сүнсний бэлгээр дамжуулан ямар адислалуудыг бид хүлээн авч чадах вэ?

Ариун Сүнсний бэлэг нь бидэнд өгсөн Бурханы агуу бэлгүүдийн нэг билээ. Ариун Сүнсээр дамжуулан бид Бурхан амьд, Есүс бол Христ, Түүний Сүм дэлхий дээр дахин сэргээгдсэн гэдгийг мэдэж чадна. Бидэнд юу хийх хэрэгтэй зүйлсийг үзүүлэхийн тулд Ариун Сүнсний өдөөлт байдаг (2 Нифай 32:5). Ариун Сүнс биднийг ариусгаж, Бурханы оршихуйд байхад минь бэлтгэдэг. Бид Сүнсний бэлгүүдэд баярлан баясаж чадна (энэ номны 22-р бүлгээс үз). Тэнгэрлэг Эцэгийн энэ агуу бэлэг мөн бидний зүрх сэтгэлд амар амгалан авчирч, Бурханы зүйлсийг ойлгуулж чадна (1 Коринт 2:9–12).

- Яагаад Ариун Сүнсний бэлэг бидэнд өгсөн Бурханы агуу бэлгүүдийн нэг вэ?

### **Нэмэлт судрууд**

- 1 Коринт 3:16–17; С ба Г 130:22–23 (Ариун Сүнс итгэлтэй хүмүүст оршдог)
- Үйлс 19:1–7 (Ариун Сүнсний бэлэг эртнээс өгөгдсөн)
- Моронай 8:25–26 (Ариун Сүнсийг хэрхэн хүлээн авах вэ)
- Моронай 10:5 (Ариун Сүнс бол үнэнийг гэрчлэгч)
- Мозая 5:2 (Ариун Сүнс зүрх сэтгэлийг өөрчилдөг)
- Алма 5:54 (Ариун Сүнс ариусгадаг)



# СҮНСНИЙ БЭЛГҮҮД

Бүлэг 22

---

## Сүнсний бэлгүүд

- Их Эзэн бидэнд ямар сүнслэг бэлгүүд өгсөн бэ?

Баптисм хүртсэний дараа Ариун Сүнсний бэлэг хүлээн авахаар бидний толгой дээр гар тавилтаар адислал өгдөг. Хэрэв бид итгэлтэй байх юм бол Түүний нөлөөллийг үргэлжлүүлэн авсаар байх болно. Түүгээр дамжуулан хүн нэг бүр Сүнсний бэлгүүд хэмээн нэрлэгдэх тодорхой сүнслэг хүчнүүдээр адислагдаж чадна. Тэдгээр бэлгүүд нь Христэд итгэлтэй нэгэнд өгөгддөг. “Мөн эдгээр бүх бэлгүүд Бурханы хүүхдүүдийн ашиг тусын тулд, Бурханаас ирдэг болой” (С ба Г 46:26). Тэдгээр нь сайн мэдээний үнэнүүдийг мэдэж, заахад тусалдаг. Тэдгээр бэлгүүд нь бусдыг адислахад бидэнд тусалдаг. Тэдгээр бэлгүүд Тэнгэрлэг Эцэг уруугаа буцахад маань хөтөлдөг. Өөрсдийн бэлгүүдийг ухаалгаар ашиглахын тулд тэд юу болохыг, тэднийг бид хэрхэн хөгжүүлж болох, тэднийг Сатаны дууриамал зүйлээс хэрхэн ялган танихыг бид мэдэх шаардлагатай.

Судруудад олон Сүнсний бэлгүүдийн тухай дурьдсан байдаг. Үнэн Сүм дэлхий дээр байсан тэр цаг үе бүрт гишүүдэд нь эдгээр бэлгүүд өгөгддөг байсан (Марк 16:16–18). Сүнсний бэлгүүд:

*Хэлний бэлэг (С ба Г 46:24)*

Заримдаа бидэнд мэдэхгүй хэлээрээ сайн мэдээг хуваалцах шаардлага гардаг. Ийм тохиолдолд Их Эзэн бидэнд энэ хэлээр ярих чадвараар адислаж чадна. Олон бүрэн цагийн номлогч хэлнүүдээр ярих бэлгийг хүлээн авсан байдаг (бүлгийн зургийг үз). Жишээ нь: Голландад бүрэн цагийн номлогч байсан

---

**Багш нарт зориулж:** Ангийн эсвэл гэр бүлийн гишүүн бүрээс энэ бүлэг дэх сүнслэг бэлгүүдийн жагсаалтаас хоёр бэлгийг сонгохыг хүс. Хичээлийн нэг хэсэг болгон тэдэнд өөрсдийн сонгосон бэлгүүдийн талаарх судрууд болон гарын авлагаас унших цаг өг. Дараа нь суралцсан зүйлсийнхээ талаар ярилц.

Ахлагч Алонзо А.Хинклей хэдийгээр маш их залбирч, суралцаж байсан ч нидерланд хэлээр муухан ярьж ойлгодог байв. Урьд нь зочилж байсан нэгэн байшинд эргэн ирэхэд нэг эмэгтэй хаалгыг онгойлгон маш ууртайгаар нидерланд хэл дээр ярьж эхлэв. Гайхалтай нь тэр үг бүрийг ойлгож байв. Тэр эмэгтэйтэй гэрчлэлээ нидерланд хэл дээр хуваалцахыг маш ихээр хүсч байгаагаа мэдрэв. Түүнийг ярьж эхлэхэд үгс нидерландаар маш цэвэрхэн урсан гарч байлаа. Харин тэр буцаж ирээд номлолын ерөнхийлөгчдөө нидерландаар ярьж чаддагаа харуулахыг хүссэн боловч ярьж чадахгүй байв. Олон итгэлтэй гишүүд хэлний бэлгээр адислагдсан байдаг (Жозеф Филдинг Смит *Answers to Gospel Questions*, comp. Бага Жозеф Филдинг Смит, 5 боть. [1957–66], 2:32–33).

*Хэлнүүдийн хөрвүүлэг хийх бэлэг (С ба Г 46:25)*

Энэ бэлэг нь бид ямар нэгэн хэлийг ойлгохгүй, Бурханаас чухал ач холбогдолтой захиасыг хүлээн авах хэрэгтэй үеүдэд бидэнд өгөгддөг. Жишээ нь: Ерөнхийлөгч Дэвид О.МакКей Шинэ Зеландахь гэгээнтнүүдэд орчуулагчгүйгээр ярихыг маш их хүсчээ. Их Эзэн тэдэнд түүний ярьж байгааг ойлгохоор адислах болно гэдэгт найдаж байгаагаа тэр хэлжээ. Тэр англи хэл дээр ярив. Түүний захиас 40 минут орчим үргэлжлэв. Тэр ярьж байхдаа тэдний нүүрний хувирал, нүдэнд дэх нулимсаар нь түүний захиасыг хүлээн авч байгааг хэлж чадахаар байв (*Answers to Gospel Questions*, 2:30–31).

*Орчуулгын бэлэг (С ба Г 5:4)*

Хэрэв бид Сүмийн удирдагчдаар Их Эзэний үгийг орчуулах дуудлагад дуудагдсан бол бид өөрсдийн чадвараас дээгүүр бэлгийг хүлээн авна. Бүх бэлгүүдийн адил, бид зөв шударга амьдарч, хичээнгүйгээр судалж, бэлгийг хүлээн авахын төлөө залбирах ёстой. Бид эдгээр зүйлсийг хийхэд орчуулга зөв аваас Их Эзэн биднийг цээжин дотор маань шатах мэт мэдрэмжтэй болгодог (С ба Г 9:8–9). Иосеф Смит Мормоны Номыг орчуулах үедээ орчуулгын бэлэгтэй байсан. Энэ бэлэг түүнийг зөвхөн Сүнстэй байхад л түүнд ирдэг байв.

*Мэргэн ухааны бэлэг (С ба Г 46:17)*

Бидний зарим нь хүмүүсийг болоод бидний амьдралд хэрэгжих сайн мэдээний зарчмуудыг ойлгох чадвараар адислагдсан байдаг. Бидэнд хэлэхдээ:

“Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно.

“Харин тэр ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйг. Учир нь эргэлзэгч нэгэн нь салхиар туугдан давалгаалах тэнгисийн долгио мэт ажээ.

“Тийм хүн Эзэнээс юм авна гэж бүү найдаг” (Иаков 1:5–7).

Их Эзэн “Баялгуудыг бус мэргэн ухааныг эрэлхийлэгтүн, мөн болгоогтун, Бурханы нууцууд чамд нээгдэх болно” (С ба Г 6:7).

*Мэдлэгийн бэлэг (С ба Г 46:18)*

Тэнгэрлэг Эцэгтэй адил болох хүн бүхэн яваандаа бүх зүйлийг мэддэг болно. Бурханы мэдлэг ба Түүний хууль нь Ариун Сүнсээр илчлэгдсэн (С ба Г 121:26). Хэрэв бид эдгээр хуулиудыг ор тас мэдэхгүй байсан бол бид аврагдаж чадахгүй (С ба Г 131:6).

Их Эзэн “Хэрэв хүн өөрийн хичээл зүтгэл мөн дуулгавартай байдлаар дамжуулан бусдаас илүү мэдлэг мөн оюун билгийг энэ амьдралд хуримтлуулах аваас тэрээр ирэх дэлхийд маш их давуу талтай байх болно” хэмээн илчилсэн (С ба Г 130:19). Их Эзэн Түүний ажлын талаар аль болох их мэдлэгийг суралцахыг бидэнд тушаасан. Тэнгэрүүд, дэлхий, болсон болон болох зүйлс, гэрт болон гадаад орнуудад болж байгаа зүйлсийн талаар суралцахыг Тэр биднээс хүсдэг (С ба Г 88:78–79). Гэсэн ч зарим нь өөрсдөө бие даан суралцсанаар мэдлэгийг олж авахыг хичээдэг. Тэд Ариун Сүнсний тусламжийг хүсдэггүй. Тэд үргэлж суралцавч үнэний мэдлэгт хэзээ ч хүрч чадахгүй (2 Тимот 3:7). Бид Ариун Сүнсний илчлэлтээр мэдлэгийг хүлээн авахад Түүний Ариун Сүнс бидний оюун бодолд мөн бидний зүрх сэтгэлд ярьдаг (С ба Г 6:15, 22–24; 8:2; 9:7–9).



*Мэргэн ухаан болон Мэдлэгийг заах бэлэг (Моронай 10:9–10)*

Зарим хүмүүст сайн мэдээний үнэнүүдийг тайлбарлаж, гэрчлэх онцгой чадвар өгөгдсөн байдаг. Энэ бэлгийг ангид хичээл заахад ашиглаж болно. Энэ бэлгийг эцэг эхчүүд хүүхдүүддээ заахад хэрэглэж болно. Энэ бэлэг мөн хүмүүс сайн мэдээг ойлгож болохын тул бид бусдад зааварчлахад бидэнд тусалдаг.

*Есүс Христ Бурханы Хүү гэдгийг мэдэх бэлэг (С ба Г 46:13)*

Энэ нь Есүс Христийн онцгой гэрчлэгч байхаар дуудагдсан бошиглогчид болон төлөөлөгчдийн бэлэг юм. Гэхдээ бусдад энэ бэлэг мөн өгөгдсөн. Хүн бүр Ариун Сүнсний шивнээгээр дамжуулан гэрчлэлтэй болж чадна. Ерөнхийлөгч Дэвид О.МкКей заахдаа: “Энэ нь заримд нь Есүс бол Бурханы Хүү, Тэр дэлхийн нүглүүдийн учир загалмай дээр цовдлогдсон гэдгийг Ариун Сүнсээр мэдэх нь өгөгдсөн хэмээн Их Эзэн Сургаал ба Гэрээнд хэлсэн [С ба Г 46:13]. Үүнийг би гэрчлэл дэх илчлэлтийн бат бөх хадан дээр зогсож, дэлхийд үнэн гэрчлэлийг гэрчлэх хүмүүст хамааруулж байна (*Teachings of Presidents of the Church: Дэвид О. МкКей* [2003], 166).

*Бусдын гэрчлэлд итгэх бэлэг (С ба Г 46:14)*

Ариун Сүнсний хүчээр бид бүх зүйлийн үнэнийг мэдэж болно. Бид хэн нэгэн үнэнийг ярьж байна уу гэдгийг мэдэхийн тулд итгэлтэйгээр Бурханаас асуух хэрэгтэй. Хэрэв бидний залбирал асууж байгаа зүйл үнэн бол Их Эзэн бидний оюун санаанд амар амгаланг ярих болно (С ба Г 6:22–23). Энэ замаар хэн нэгэн, бүр бошиглогчийг ч, илчлэлт хүлээн авсныг нь бид мэдэх болно. Нифай Их Эзэнээс түүний эцэгийн зүүд үнэн гэдгийг мэдэж, зүүдийг харж, мэдрэхийг тэр хүссэн (1 Нифай 10:17–19).

*Бошиглолын бэлэг (С ба Г 46:22)*

Өнгөрсөн, одоо эсвэл ирээдүйн талаар үнэн гэрчлэлт хүлээн авдаг тэднийг бошиглолын бэлэгтэй гэдэг. Бошиглогчид ийм бэлэгтэй. Бид ч бас өөрсдийн амьдралыг захиран удирдахын тулд үүнийг байлгаж чадна (1 Коринт 14:39). Бид өөрсдийнхөө болон дуудлагууддаа Бурханаас илчлэлтийг хүлээн авч болно. Харин Сүм эсвэл Сүмийн удирдагчдын төлөө хэзээ ч авч

---

чадахгүй. Хэн нэгэн хүн тэргүүлэх эрхийг аваагүй мөртлөө аль нэг хүний төлөө илчлэлт хүлээн авах нь тэнгэрийн дэг журамд нийцэхгүй. Хэрэв бидэнд бошиглолын бэлэг гарцаагүй байгаа бол бид суудрууд дээр хэлсэнчлэн Их Эзэнтэй үл зөвшилцөх аливаа нэгэн илчлэлтийг хүлээн авахгүй болно.

*Эдгээх бэлэг (С ба Г 46:19–20)*

Зарим нь эдгээх итгэлтэй, бусад нь эдгэрэх итгэлтэй байдаг. Бид бүгд өвчтэй байхдаа эдгэрэх итгэлтэй байж чадна (С ба Г 42:48). Санваарыг атгагчдын олонх нь өвчнийг эдгээх бэлэгтэй байдаг. Бусдад нь өвчин эмгэгийг хэрхэн эмчлэх мэдлэг өгөгдсөн байж болно.

*Гайхамшигуудыг үйлдэх бэлэг (С ба Г 46:21)*

Их Эзэн Өөрийн хүмүүсийг олон удаа гайхамшигт арга замуудаар адисалсан. Ютагийн анхдагч нар анхны тариалангаа тариалах үед царцааны нүүдэл болж бараг бүх ургацыг сүйтгэв. Анхдагчид Их Эзэнд хандан тэдний ургацыг хамгаалахыг гуйн залбирав. Тэр царцаануудыг залгих цахлайнудыг илгээв. Бид тусламж хэрэгтэй үедээ итгэлтэйгээр гуйх аваас хэрэв энэ нь бидний тусын тулд Их Эзэн бидэнд гайхамшигийг өгөх болно (Матай 17:20; С ба Г 24:13–14).

*Итгэлийн бэлэг (Моронай 10:11)*

Жаредын ах агуу итгэлтэй хүн байсан. Түүний итгэлийн учир тэр бусад бэлгүүдийг хүлээн авсан. Түүний итгэл үнэхээр агуу байсан тул түүнд Аврагч үзэгдсэн (Ефер 3:9–15). Итгэлгүйгээр ямар ч бэлгүүд өгөгдөж чадахгүй. Моронай амлахдаа “Христэд эргэлзээгүйгээр итгэх хэн боловч, тэрбээр Эцэгээс Христийн нэрээр юуг ч гуйсан тэр нь түүнд өгөгдөх болно” (Мормон 9:21). Бид өөрсдийн итгэлийг хөгжүүлэх, өөрсдийн бэлгүүдийг олох, тэднийг ашиглахыг эрэлхийлэх ёстой.

Зарим хүмүүс итгэлээр дутагдаж, тэдгээр бэлгүүдийг Сүнснээс ирдэг гэдгийг үгүйсгэдэг. Тэдэнд хандан Моронай хэлэхдээ:

“Мөн түүнчлэн Бурханы илчлэлтүүдийг үгүйсгэж, мөн тэдгээр нь зогссон, илчлэлтүүд мөн бошиглолууд, мөн бэлгүүд, мөн

эдгээх хүч, мөн хэлээр ярих, мөн хэлийг хөрвүүлэх нь үгүй болсон хэмээн хэлэх та нарт би ярина;

“Болгоогтун би та нарт хэлнэ, эдгээр зүйлсийг үгүйсгэдэг тэр нь Христийн сайн мэдээг мэддэггүй, тийм ээ, тэрээр судруудыг уншсан нь үгүй, хэрэв уншсан аваас, тэрээр тэдгээрийг ойлгосон нь үгүй” (Мормон 9:7–8).

- Яагаад Их Эзэн бидэнд сүнслэг бэлгүүдийг өгдөг вэ?

### **Бид өөрсдийн бэлгүүдийг хөгжүүлж чадна**

- Бид хэрхэн “шилдэг бэлгүүдийг хичээнгүйгээр эрэлхийлж” чадах вэ? (С ба Г 46:8).

Их Эзэн хэлэхдээ: “Учир нь бүгдэд бэлэг бүхэн өгөгддөггүй, учир нь олон бэлэг байдаг, мөн хүн болгонд Бурханы Сүнсээр бэлэг өгөгддөг болой. Үүгээр бүгд ашиг тусыг олж болохын тулд заримд нь нэг бэлэг өгөгдсөн байдаг, мөн заримд нь өөр бэлэг өгөгддөг болой” (С ба Г 46:11–12).

Өөрсдийн бэлгүүдийг хөгжүүлэхийн тулд бидэнд ямар бэлэг байгааг олж мэдэх хэрэгтэй. Бид үүнийг залбирлаар мөн мацаг барилтаар хийж чадна. Бид хамгийн шилдэг бэлгүүдийг хичээнгүйлэн эрэлхийлэх ёстой (С ба Г 46:8). Заримдаа патриархын адислалууд бидэнд ямар бэлгүүд өгөгдсөн болохыг олж мэдэхэд тусалдаг.

Бидэнд бэлгүүд өгөгдсөн байхын тулд бид дуулгавартай, итгэлтэй байх ёстой. Дараа нь бид бэлгүүдээ ашиглан Их Эзэний ажлыг хийх ёстой. Тэдгээр нь бидний сонирхолд нийцүүлэхийн тулд эсвэл бидний итгэл бага учир ямар нэгэн зүйлийг нотлохын тулд өгөгддөггүй. Сүнслэг бэлгүүдийн талаар Их Эзэн хэлэхдээ “Тэдгээр нь намайг хайрладаг хийгээд миний бүх зарлигуудыг сахьдаг мөн үйлдэхийг эрэлхийлдэг тэдний ашиг тусын төлөө өгөгддөг болой” гэжээ (С ба Г 46:9).

- Хувь хүний хувьд та нарыг хүчирхэгжүүлж болох эсвэл Их Эзэн болон бусдад үйлчлэхэд тусалж болох сүнслэг бэлгүүдийн талаар бод. Эдгээр бэлгүүдийг эрэлхийлэхийн тулд та нар юу хийж чадах вэ?

## **Сатан Сүнсний Бэлгүүдийг хуурамчаар дууриадаг**

- Бид Сүнсний үнэн бэлэг ба Сатаны хуулбар хоёрын ялгааг хэрхэн таньж чадах вэ?

Сатан хэлнүүдээр ярих, бошиглох, үзэгдэл үзэх, эдгээх болон бусад гайхамшгуудыг дуурайж чадна. Мосе Фараоны талбай дээр Сатаны дууриамал зүйлстэй тэмцэлддэг (Египетээс гарсан нь 7:8–22). Сатан биднийг түүний хуурмаг бошиглогч, хуурамч эдгээгчид, хуурамч гайхамшгийг үйлдэгчдэд итгүүлэхийг хүсдэг. Тэд үнэхээр жинхэнэ мэт харагдахаар байдаг. Түүнийг ялган таних ганц зам бол Бурханаас ялган таних бэлэг хүсэн асуух явдал юм. Хилэнцэт өөрөө гэрлийн элч мэт харагдаж болно (2 Нифай 9:9).

Сатан биднийг Сүнсний үнэн бэлгүүдийг эрэлхийлэхээс мөн үнэнээс сохолж харалган болгохыг хүсдэг. Бурханыг дагадаг хэмээн тэд хэлж байгаа ч тэдгээр үзмэрчид, зурхайчид, мэргэ төлөгчид болон шидтэнгүүд Сатанаар өдөөгдсөн байдаг. Тэдний ажлууд Их Эзэнд жигшүүртэй юм (Исаиа 47:12–14; Дэд хууль 18:9–10). Бид Сатаны хүчтэй холбоотой бүхнээс зайлхийх ёстой.

## **Бид өөрсдийн Сүнсний бэлгүүдтэй болгоомжтой байх ёстой**

- Бид хэрхэн сүнслэг бэлгүүдийн нандин байдалд хүндэтгэлтэй хандаж чадах вэ?

Их Эзэн хэлэхдээ “Эдгээр зүйлүүдээр тэд өөрсдөө сагсуурах ч, мөн дэлхийн өмнө тэдгээрийг ярих ч ёсгүй хэмээх зарлигийг би тэдэнд өгч байна, учир нь эдгээр зүйлүүд та нарын ашиг тус хийгээд авралын төлөө та нарт өгөгдсөн бөлгөө” (С ба Г 84:73). Бид сүнслэг бэлгүүд нь ариун нандин гэдгийг санах ёстой (С ба Г 6:10).

Эдгээр бэлгүүдийг өгсний хариуд бид “Бурханд талархлаа Сүнсээр илэрхийлэх ёстой” гэдгийг Их Эзэн хэлсэн (С ба Г 46:32).

### **Нэмэлт судрууд**

- 3 Нифай 29:6–7 (бэлгүүдийг үгүйсгэх тэдний хувь тавилан)
- Моронай 10:7–19 (бэлгүүд итгэлээс хамаардаг)
- 3 Нифай 26:17; 27:20; С ба Г 84:64 (баптисмаар дамжин бэлэг өгөгддөг)
- 1 Коринт 12 (эртний Есүс Христийн Сүм дэх Сүнсний бэлгүүд)
- С ба Г 46:9–26 (өнөөгийн Сүм дэх Сүнсний бэлгүүд)

# Ариун ёслол

Бүлэг 23

---

## **Христ Ариун ёслолыг танилцуулсан**

- Ариун ёслолын бэлгэдэлүүд Есүс Христийн цагаатгалын талаар юу заадаг вэ?

Аврагч маань зарлигуудаа сахиж, агуу цагаатгагч золиослолыг нь санахыг биднээс хүсдэг. Үүнийг хийхэд бидэнд туслахын тулд Тэр биднийг ойр ойрхон уулзалдаж, ариун ёслолоос хүртэж байхыг тушаасан.

Ариун ёслол бол Аврагчийн цагаатгалыг бидэнд сануулахад туслах санваарын нандин ёслол юм. Ариун ёслолын үеэр бид талх, ус хүртдэг. Бидний төлөө золиослол болгосон Түүний бие, Түүний цусыг дурсан санахын тулд бид үүнийг үйлддэг. Ариун ёслолоос хүртсэнээр бид Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн нандин гэрээгээ шинэчилдэг.

Цовдлогдохынхоо өмнөхөн Есүс Христ Өөрийн төлөөлөгчдийг дээд давхрын өрөөндөө цуглуулсан. Тэр удахгүй загалмай дээр нас барна гэдгээ мэдэж байсан. Энэ нь Тэр нас барахынхаа өмнө хайрт хүмүүстэйгээ уулзсан сүүлчийн уулзалт байсан. Тэд үргэлж хүчтэй мөн итгэлтэй байж болохын тулд Түүнийг санахыг Тэр тэднээс хүссэн.

Тэдэнд санахад нь туслахын тулд Тэр ариун ёслолыг танилцуулсан. Тэр талхыг жижиг хэсгүүд болгон хувааж, тэдгээрийг адислав. Дараа нь Тэр “Ав, ид; энэ нь та нарын төлөө төлөөсийг нь би хийсэн миний биеийг төлөөлөн дурсахад байдаг” гэж хэлэв (Иосеф Смитийн орчуулга, Матай 26:22). Дараа нь Тэр аяга дарсыг авч, түүнийг адислан Өөрийн Төлөөлөгчдөд уулгахаар өгөв. Тэгээд Тэр “Энэ бол миний нэрэнд итгэсэн болгоны төлөө нүглүүдийн ангижралын төлөө урссан миний шинэ гэрээний цусыг

---



Simon Dewey

төлөөлөн дурсахад байдаг” гэж хэлэв (Иосеф Смитийн орчуулга, Матай 26:24; мөн Матай 26:26–28; Марк 14:22–24; Лук 22:15–20).

Түүний Амилуулалтын дараа Аврагч америк тивд ирж, Нифайчуудад яг ижил ёслолыг заасан (3 Нифай 18:1–11; 20:1–9). Хожмын өдүүдэд Сүм сэргээгдсэний дараа Есүс Өөрийн хүмүүст Түүнийг дурсан санаж ариун ёслолоос хүртэхийг “Сүм нь Их Эзэн Есүсийг дурсан санаж, талх болон дарсыг хүртэхийн тулд олонтаа хамтдаа цуглах нь зүйтэй болой” хэмээн хэлж дахин тушаасан (С ба Г 20:75).

### **Ариун ёслол хэрхэн удирдагддаг вэ**

Ариун ёслол хэрхэн удирдагдах ёстойг судрууд тодорхой заасан байдаг. Сүмийн гишүүд Хүндэтгэлийн өдөр бүр ариун ёслолоос хүртэж, Бурханаа бишрэн шүтэхээр цуглардаг (С ба Г 20:75). Ариун ёслолыг зохих санваарын эрх мэдлийг атгасан санваартнууд удирдан явуулдаг. Прист юм уу Мелкизедек санваартан талхыг хувааж, өвдөг сөгдөн адисалдаг (С ба Г 20:76). Дикон юм уу бусад санваартнууд дараа нь оролцогчдоод ариун ёслолын талхыг түгээдэг. Дараа нь прист юм уу Мелкизедек санваартан усыг адислан мөн гишүүдэд түгээдэг. Есүс ариун ёслолыг танилцуулахдаа Өөрийн шавь нартаа дарс өгсөн. Гэхдээ Түүнийг дурсан үйлдэх аваас, ариун ёслолоос хүртэхдээ юу идэх буюу юу уух нь хамаагүй хэмээн хожмын өдрийн илчлэлтэд Тэр хэлсэн (С ба Г 27:2–3). Өнөөдөр Хожмын Үеийн гэгээнтнүүд дарсны оронд ус хэрэглэдэг.

Есүс ариун ёслолын хоёр залбиралд хэлэх тодорхой үгсийг илчилсэн. Бид эдгээр сайхан залбирлын үгсийг анхааралтайгаар сонсож, бид юуг амалж байгаа болон бидэнд юу амлагдаж буйг ойлгох ёстой. Талх адислах тэдгээр үгс нь:

“Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, үүнээс хүртэх тэд бүгдийн бодгалийн тулд, тэд түүний Сүнснийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд таны Хүүгийн биеийг төлөөлөн дурсаж, тэд үүнийг идэж, Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, тэд өөрсөдөд нь өгсөн түүний зарлигуудыг дагахад бэлэн гэдгээ танд гэрчилж болохын тулд, энэ талхыг адисалж мөн ариулахыг



таны Хүү, Есүс Христийн нэрээр бид танаас гуйж байна. Амен” (С ба Г 20:77).

Усыг адислахад хэлэх тэдгээр үгс нь:

“Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, үүнээс уух тэд бүгдийн бод-  
галийн тулд, тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгаж  
болохын тулд, өөрсдийнх нь төлөө асгаруулсан таны Хүүгийн  
цусыг төлөөлөн дурсаж, тэд үүнийг үйлдэж болохын тулд;  
Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, тэд үргэлж түүнийг санана  
гэдгээ танд гэрчилж болохын тулд, энэ дарсыг адисалж, мөн  
ариулахыг таны Хүү, Есүс Христийн нэрээр гуйж байна. Амен”  
(С ба Г 20:79).

Ариун ёслолын жаяг нь маш энгийн бөгөөд хүндэтгэл бишрэл-  
тэй гүйцэтгэгддэг.

- Анхааралтайгаар ариун ёслолын залбирлыг дахин унш.  
Үг бүрийн утга учрын талаар тунгаан бод.

### **Ариун ёслолоор шинэчлэх гэрээнүүд**

- Ариун ёслолоор бид ямар гэрээнүүдийг шинэчилдэг вэ? Бид  
тэдгээр гэрээнүүдийг сахих аваас Их Эзэний бидэнд амласан  
ямар адислалууд байдаг вэ?

Ариун ёслолоос хүртэх бүрдээ бид Их Эзэнтэй хийсэн гэрээ-  
нүүдээ шинэчилдэг. Гэрээ нь Их Эзэн ба Түүний хүүхдүүдийн  
хооронд хийгдсэн ариун нандин амлалт юм. Бидний хийсэн  
гэрээнүүд нь ариун ёслолын залбиралд тодорхой тусгагдсан  
байдаг. Эдгээр нь ямар гэрээнүүд болох мөн тэдгээр нь ямар  
утгатай болохыг мэдэх нь маш чухал.

Бид өөрсөд дээрээ Есүс Христийн нэрийг авахыг хүссэн гэрээ  
хийдэг. Үүгээрээ бид Түүний Сүм болон Түүний нэрээр танигдах  
хүсэлтэй байгаагаа харуулдаг. Бид Түүнд болон бусад хүмүүст  
үйлчлэх шийдвэр төгс болдог. Бид энэ нэрийг доромжлох эсвэл  
буруушаах зүйл хийхгүй гэдгээ амладаг.

Бид үргэлж Есүс Христийг санах гэрээтэй. Бидний бүх бодол  
санаа, мэдрэмж ба үйлдлүүд нь Түүний ажил болон Түүний  
нөлөөгөөр хийгдэх болно.

Бид Түүний зарлигуудыг сахихаа амладаг.

Бид баптисм хүртэхдээ эдгээр амлалтуудыг өөрсөд дээрээ авдаг (С ба Г 20:37; Мозая 18:6–10). Тиймээс бид ариун ёслолоос хүртэхдээ баптисм хүртэхдээ хийсэн тэдгээр гэрээнүүдээ шинэчилдэг. Есүс бидэнд ариун ёслолоос хүртэх арга замыг өгсөн (3 Нифай 18:1–12) ба энэ замын дагуу нүглүүдээ наманчилж, Түүний нэрэнд итгэх аваас бид нүглүүдийн ангижралыг олох болно (Иосеф Смитийн Орчуулга, Матай 26:24).

Хэрэв бид гэрээнүүдээ сахих аваас Түүний Сүнс үргэлж бидэнтэй хамт байх болно гэдгийг Их Эзэн амласан. Сүнсээр удирдагдсан хувь хүн мөнхийн амьдралыг олж авах мэдлэг, итгэл, зөв шударгыг авах болно.

- Долоо хоногийн турш эдгээр амлалтуудыг санаж байхын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?

### **Ариун ёслолыг хүртэх үеийн бидний хандлага**

- Ариун ёслолыг хүртэхийн тулд бид хэрхэн өөрсдийгөө бэлтгэх вэ? Ариун ёслолын үеэр бидэнд Аврагчийн Цагаатгалыг дурсан санахад туслах юун тухай бодох ёстой вэ?

Ариун ёслолоос хүртэхийн өмнө бид өөрсдийгөө сүнслэгээр бэлтгэж болно. Ариун ёслолоос зохисгүй хэн боловч хүртэх ёсгүйг Их Эзэн цохон хэлсэн. Энэ нь ариун ёслолоос хүртэхийн өмнө бид өөрсдийн нүглүүдийг наманчлах ёстой гэсэн үг. Судруудад “Хэрэв хэн нэгэн нүгэл үйлдвээс тэрээр дахин засрах хүртлээ ариун ёслолоос бүү хүртэг” хэмээн заасан байдаг (С ба Г 46:4). Их Эзэн Өөрийн арван хоёр Нифай шавь нартаа “Та нар үүнийг адислан түгээхдээ хэн нэгэн миний махан биебодь болон цусыг зохисгүйгээр хүртэхийг та нар мэдсээр байж хүлцэж болохгүй; учир нь миний бие махбодь болон цусыг зохисгүйгээр идэж мөн уух хэн боловч бодгальдаа ялыг идэж мөн уудаг” (3 Нифай 18:28–29).

Ариун ёслолын үйлчлэлийн үед дэлхийн бүх бодол санааг оюун ухаанаасаа бид гаргах ёстой. Бид залбиралтай,

---

**Багш нарт зориулж:** Хэрэв таны зааж байгаа хүмүүсийн ихэнх нь эцэг эх нар бол та тэднээс өөрсдийн хүүхдүүддээ ариун ёслолоос хүндэтгэл бишрэлтэйгээр хүртэхэд нь хэрхэн тусалж чадах талаар асууж болно.

бишрэл хүндэтгэлтэй байх ёстой. Бид өөрсдийн Аврагчийн Цагаатгалын талаар бодож, түүнд талархалтай байх ёстой. Бид амьдралаа дүгнэн, хөгжүүлэх арга замыг эрэлхийлэх ёстой. Мөн бид зарлигуудыг сахих шийдвэрүүдээ шинэчлэх ёстой.

Ариун ёслолыг хүртэхийн өмнө өөрсдийгөө төгс болгох шаардлагагүй. Харин бид өөрсдийн зүрх сэтгэлдээ наманчлалын сүнс буюу хандлагыг байлгах ёстой. Ариун ёслолоос хүртэх бидний хандлага нь бидний түүнээс хүртэх байдалд нөлөөлдөг. Хэрэв бид ариун ёслолоос цэвэр зүрх сэтгэлтэйгээр хүртэх аваас Их Эзэний амласан адислалуудыг хүлээн авдаг.

- Ариун ёслолоос зохистойгоор хүртэх нь яагаад бидний сүнслэг хүчийг өсгөдөг вэ?

### **Нэмэлт судрууд**

- 1 Коринт 11:27–29 (ариун ёслолоос зохистой хүртэх нь)
- Иохан 4:5–14 (Есүс бол Амьд ус)
- Иохан 6:30–35 (Есүс бол Амьдралын талх)

# ХҮНДЭТГЭЛИЙН ӨДӨР

Бүлэг 24

---

## Хүндэтгэлийн өдрийн утга учир

- Хүндэтгэлийн өдөр гэж юу вэ?

“Хүндэтгэлийн өдрийг чанд мөрдөж, үүнийг ариунаар нь сахих ёстой” (Египетээс гарсан нь 20:8; мөн С ба Г 68:29).

*Хүндэтгэл буюу Ариун* гэдэг үг нь Еврей хэлнээс гарсан бөгөөд *амралт гэсэн утгатай*. Есүс Христийн Амилалтаас өмнө Бурхан Бүтээлийг хийж дууссаны дараа Бурханы амралтын өдөр болгон Хүндэтгэлийн өдөр хэмээн түүхэн үйл явдлыг дурсах өдөр болгосон. Энэ нь Бурхан ба Түүний хүмүүсийн хооронд хийсэн гэрээний тэмдэг болсон. Эхлэл номноос бид Бурхан тэнгэр ба дэлхийг Түүнээс хэлснээр өдрүүд хэмээх зургаан үеийн цаг мөчид бүтээсэн: “Долоо дахь өдөр болоход Бурхан Өөрийн хийж бүтээсэн ажлаа дуусгаж, хийж бүтээсэн ажил нь дууссан учир долоо дахь өдөртөө Тэрээр амарчээ. Бурхан долоо дахь өдрийг ерөөж, ариун болгов” (Эхлэл 2:2–3). Одоо Хүндэтгэлийн өдөр нь мөн Есүс Христийн Амилалтыг дурсан хүндэтгэх өдөр болсон.

Хүндэтгэлийн өдөр нь долоо дахь өдөр бүр юм. Энэ нь бид өдөр тутмын ажлаасаа амралтыг олж, Түүнийг бишрэн хүндлэх Бурханаар ерөөгдсөн ариун өдөр юм.

## Хүндэтгэлийн өдрийн зорилго

- Хүндэтгэлийн өдрийн талаар мэдэхгүй хүмүүст та нар хэрхэн тайлбарлах вэ?

Хүндэтгэлийн өдөр нь бидний тусын тулд байдаг хэмээн Есүс заасан (Марк 2:27). Хүндэтгэлийн өдрийн зорилго нь бидний бодол санаа, үйлдлийг Бурханы зүгт чиглүүлэх долоо хоногийн тодорхой нэг өдрийг өгсөн явдал юм. Энэ нь зөвхөн ажлаасаа амрах биш. Энэ нь Бурханаа магтан дуулах, бишрэн

---



шүтэхэд зориулагдсан нандин өдөр юм. Бид өөрсдийн дадсан өдөр тутмынхаа үйл ажлаас амарч, сүнслэг зүйлсийн талаар тунгаан бодохын тулд оюун санаагаа чөлөөлдөг. Энэ өдөр бид Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ шинэчилж, Сүнсний зүйлсээр өөрсдийн бодгалийг тэжээдэг.

- Хүндэтгэлийн өдрийн зорилгыг хадгалахын тулд та нар долоо хоногийн өдөр бүр юу хийж болох талаар бод.

### **Хүндэтгэлийн өдрийн түүх**

Дэлхийн эхлэлд долоо дахь өдөр Хүндэтгэлийн өдөр байхаар Бурханаар ариулан адислагдсан байжээ (Эхлэл 2:2–3). Эртний үеэс эхлэн дэлхийн хүмүүсийн дунд долоо дахь өдрийг ариунаар байлгах заншил хадгалагдсаар иржээ. Бурхан энэ өдөртэй холбоотой зарлигийг шинэчлэн Израилчуудад хандан “Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтун” хэмээн хэлсэн (Египетээс гарсан нь 20:8). Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгалах нь Израилчууд Түүний гэрээт хүмүүс болох тэмдэг байсан (Египетээс гарсан нь 31:12–13, 16; Исаиа 56:1–8; Иеремиа 17:19–27).

Гэхдээ зарим Иудей удирдагчид Хүндэтгэлийн өдрийн талаар олон шаардлагагүй дүрэм журмуудыг гаргасан. Тэд хүмүүс хэр хол явж чадахыг, ямар төрлийн бүлэгт хамаарагдаж болохыг гэх мэт олон зүйлийг тогтоосон. Есүс Христ Хүндэтгэлийн өдөр өвчтөнийг эдгээж буйг харсан зарим Иудей удирдагчид Түүнийг шүүмжлэхэд Тэр тэдэнд Хүндэтгэлийн өдөр хүмүүний тусын тулд хийгдсэнийг сануулдаг.

Нифайчууд мөн Бурханы зарлигуудын дагуу Хүндэтгэлийн өдрийг мөрддөг байсан (Жером 1:5).

Орчин үед Их Эзэн Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалахыг бидэнд сануулан Өөрийн зарлигийг давтан хэлсэн (С ба Г 68:29).

### **Их Эзэний Өдөр**

- Яагаад Хүндэтгэлийн өдөр долоо дахь өдөр байхыг нэг дэх өдөр болгон сольсон бэ?

Түүний Амилалтыг хүртэл Есүс Христ болон Түүний шавь нар долоо дахь өдрийг Хүндэтгэлийн өдөр хэмээн хүндэтгэж байсан. Түүний Амилалтын дараа Ням гарагийг Түүний Амилалтын өдрийг дурсан санахын тулд Их Эзэний өдөр болгон ариунаар хадгалсан (Үйлс 20:7; 1 Коринт 16:2). Энэ үеэс эхлэн Түүний дагалдагчид тэдний Хүндэтгэлийн өдөр долоо хоногийн эхний өдөр байхаар тогтоожээ. Энэ хоёрын аль ч тохиолдолд зургаан өдөр хөдөлмөрлөж, нэг өдрийг амралт болон сүсэг бишрэлийн өдөр байлгадаг.

Их Эзэн бидний үед мөн Ням гарагийг хүндэтгэж Их Эзэний өдөр, Хүндэтгэлийн өдөр байлгах шууд зарлигийг өгсөн (С ба Г 59:12).

- Амилалтыг дурсан санах нь хэрхэн бидний Хүндэтгэлийн өдрийн сүсэг бишрэлд нөлөөлдөг вэ?

### **Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгалах нь**

- Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалах гэдэг юу гэсэн үг вэ?

Их Эзэн биднээс хамгийн эхэнд Хүндэтгэлийн өдрийг ариунаар хадгахыг хүссэн. 1831 онд Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлтэнд Их Эзэн гэгээнтнүүдийг залбирлын өргөөнд очиж, өөрсдийн ариун ёслолуудыг өргөж, өөрсдийн хөдөлмөрүүдээсээ амрахаар мөн Бүхний Дээдэд өөрсдийн бүхнээ зориулахыг тушаасан (С ба Г 59:9–12).

Хоёрдугаарт: өдөр тутмын ажлаасаа амрахыг биднээс Тэр хүссэн. Энэ нь өөрсдийн бүх анхаарлыг сүнслэг зүйлүүдэд өгөхөөс биднийг холдуулах ажил хөдөлмөр хийх ёсгүй гэсэн үг. Их Эзэн Израилчуудад “Чи болон чиний хүү, чиний охин, чиний зарц, шивэгчин, чиний мал, танайд байгаа зочин ямар ч ажил хийж болохгүй” гэж хэлсэн (Египетээс гарсан нь 20:10). Энэ өдөр бид худалдаа хийж, анд явж, загасчилж, спортын тоглоомуудад оролцох эсвэл эдгээртэй адил төстэй үйл ажиллагаануудад оролцож болохгүй гэдгийг бошиглогчид бидэнд хэлсэн.

---

**Багш нарт зориулж:** Та ангийн эсвэл гэр бүлийн гишүүдэд цаг гарган өгсөн асуултын талаар илүү гүнзгийгээр бодож үзэхэд нь тусал. Тэдэнд хангалттай цагийг өгсний дараа тэдний хариултыг сонс.

Гэхдээ хэрэв бид Хүндэтгэлийн өдөр юу ч хийхгүй зөвхөн залууран хэвтэх аваас бид ариун өдрийг ариунаар нь хадгалж байгаа хэрэг бус хэмээн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбал анхааруулсан. Хүндэтгэлийн өдөр нь бүтээлч бодол болон үйлдлүүдийг бий болгодог (*Teachings of Presidents of the Church: Спенсер В.Кимбал* [2006], 170).

Бид Хүндэтгэлийн өдөр юу *хийж болох* вэ? Бошиглогч Исаиа бид өөрт тааламжтай зүйлийг хийхээс зайлсхийж, “амралтын өдрийг баясгалант, Эзэний ариун өдрийг эрхэм хүндэт гэж нэрлэх” ёстой хэмээн захьсан (Исаиа 58:13).

Бид Хүндэтгэлийн өдөр хийж болох зөв шударга зүйлсийг анхааралдаа авах ёстой. Жишээ нь: бид Хүндэтгэлийн өдөр Сүмийн цуглаануудад оролцож; судруудыг болон Сүмийн удирдагчдын үгсийг уншиж, өвчтөнийг, өндөр настангууд болон өөрсдийн хайртай нэгнийд зочлон эргэж, сүнслэгээр урамшуулах дуу хөгжим сонсож, дууллыг дуулж, Тэнгэрлэг Эцэгийг магтан дуулж талархсан залбирлыг өргөж, Сүмийн үйлчлэлийг гүйцэлдүүлж, гэр бүлийн түүх ба хувийн түүхийн баримтыг бэлтгэж, итгэлийг өсгөх түүхийг ярьж, өөрсдийн гэрчлэл мөн сүнслэг туршлагуудыг гэр бүлийнхэнтэйгээ хуваалцаж, бүрэн цагийн номлогч нарт болон гэр бүл дотны хүмүүстээ захидал бичиж, зорилготойгоор мацаг барьж, гэртээ хүүхдүүдтэйгээ болон бусадтай хамт цагийг сайхан өнгөрөөж ариунаар хадгалж чадна.

Хүндэтгэлийн өдрийг ариунаар байлгаж болох бусад ямар нэгэн үйл ажиллагаануудад оролцохдоо бид өөрсдөөсөө дараах асуулуудыг асуух ёстой: Энэ нь миний сэтгэл санааг өргөж, урамшуулан зоригжуулах уу? Энэ нь Их Эзэнд хүндэтгэлийг үзүүлж байна уу? Энэ нь миний бодлыг Их Эзэн уруу хөтөлж байна уу?

Хүндэтгэлийн өдөр хөдөлмөрлөх шаардлагатай болох тохиолдол бидэнд тулгарч болно. Бид аль болох үүнээс зайлхийх хэрэгтэй бөгөөд харин энэ нь гарцаагүй шаардлагатай болох аваас бид Хүндэтгэлийн өдрийн сүнсийг өөрсдийн зүрх сэтгэлд байлгах хэрэгтэй.

- Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалахад өөрийн чармайлтыг хөгжүүлэхийн тулд хийж чадах ямар нэгэн зүйлийн



талаар бод. Хэрэв та эцэг эх эсвэл эмээ өвөө бол хүүхдүүддээ эсвэл ач зээ нартаа Хүндэтгэлийн өдрийн утга учрыг ойлгоход нь туслах ямар нэгэн зүйлийн талаар бод.

### **Хүндэтгэлийн өдрийг сахиснаар ирэх адислалууд**

- Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалснаар бид ямар адислалуудыг хүлээн авдаг вэ?

Хэрэв бид Хүндэтгэлийн өдөр хүндэтгэлтэй байх аваас бид агуу сүнслэг болон материаллаг адислалуудыг хүлээн авч чадна. Хэрэв бид талархалтай, баяртай зүрх сэтгэлээр Хүндэтгэлийн өдрийг хадгалах аваас бид баяр баяслаар дүүрэн байх болно хэмээн Их Эзэн хэлсэн. Тэр дараах зүйлсийг амласан:

“Дэлхийн бүрэн байдал та нарынх бөлгөө, тийм ээ, хоол хүнс эсвээс хувцас хунарын тулд, эсвээс орон гэр буюу оромжийн тулд, эсвээс жимсний цэцэрлэгүүдийн тулд, эсвээс усан үзмийн талбайн тулд,

“Тийм ээ, дэлхийгээс, өөр өөрсдийн цагт ирдэг бүх зүйл, хүмүүний тусын тулд мөн ашиглалтын тулд, нүд баясах хийгээд сэтгэл баярлуулах аль алиных нь тулд хийгдсэн болой;

“Тийм ээ, хоол хүнс хийгээд хувцас хунарын тулд, амт хийгээд үнэрийн тулд, бие махбодийг хүчирхэгжүүлэх хийгээд сүнсэнд эрч хүч өгөхийн тулд болой” (С ба Г 59:16–19).

### **Нэмэлт судрууд**

- Египетээс гарсан нь 31:16–17 (Хүндэтгэлийн өдөр нь Их Эзэн ба Түүний хүмүүсийн хооронд хийсэн мөнхийн гэрээ)
- Мозая 13:16–19; 18:23; Египетээс гарсан нь 35:1–3; Левит 26:2–4, 6, 12 (Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь байлга)
- Лук 6:1–11 (Хүндэтгэлийн өдөр сайн зүйлсийг хийх нь хуулийн дагуу болно)
- Лук 13:11–17; Иохан 5:1–18 (Хүндэтгэлийн өдөр Есүсийн хийсэн сайн зүйлсийн жишээ)

# Мацаг барилт

Бүлэг 25

---

## Хэрхэн зөв мацаг барих вэ?

- Бид мацаг барилтыг баяр баясгалантай байлгахын тулд юу хийж чадах вэ?

Адамын үеэс эхлэн Бурханы хүмүүс Түүнд ойр байх, Түүнийг бишрэн шүтэхэд нь тусладаг тул мацаг барьдаг байв. Есүс Өөрийн үлгэр жишээгээр мацаг барилтын чухал ач холбогдлыг үзүүлсэн (Лук 4:1–4). Хожмын үеийн илчлэлтээр дамжуулан бид Их Эзэн Өөрийн хүмүүсийг ойр ойрхон мацаг барьж, залбирахыг хүлээсээр буйг суралцдаг (С ба Г 88:76).

Мацаг барилт гэдэг хоол хүнс, уух зүйлгүйгээр байхыг хэлдэг. Хааяа нэг мацаг барих нь бидний бие махбодид сайн бөгөөд бидний оюун санааг илүү идэвхтэй болгодог.

Аврагч бидэнд зорилготой мацаг барилт нь зүгээр нэг хоол хүнс, уух зүйлгүй байхаас илүү хэмээн заасан. Бид мөн сүнслэг зүйлс дээр төвлөрөх хэрэгтэй.

### *Бид мацаг барихдаа залбирах ёстой*

Залбирал нь мацаг барилтын зайлшгүй нэг хэсэг мөн. Сүдрүүдэд залбирал ба мацаг барилтын талаар хамтад нь дурьдсан байдаг. Бидний мацаг барилт чин сэтгэлийн залбиралтай хамт хийгдэх ёстой бөгөөд бид мацаг барилтыг залбирлаар эхлүүлж, залбирлаар дуусгадаг.

### *Бид зорилготойгоор мацаг барих ёстой*

Мацаг барилтыг олон зорилго шалтгаанаар барьж болно. Бид мацаг барьж залбирснаар сул дорой байдлууд эсвэл асуудлуудаа

---

**Багш нарт зориулж:** Та ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг хоёр болон дөрвөн хүнтэй баг болго. Тэгээд баг бүрд мацаг барилтыг баяр баясгалантай байлгах арга замуудын талаар ярилцах боломжийг олго. Дараа нь хүн бүрийн санаануудыг магадгүй самбар дээр эсвэл том цаасан дээр бичиж хамтдаа жагсаалт гарга.



даван ялж чадна. Заримдаа бид гэр бүлийнхээ өвчтэй болон ямар нэгэн хэрэгцээ шаардлагатай хэн нэгний төлөө тусламж эсвэл бусдын төлөө заавар зөвлөмжийг хүсч мацаг барьж, залбирч болно (Мозая 27:22–23). Мацаг барилгаар дамжуулан бид Мормоны Номны бошиглогч Алмагийн адил аливаа зүйлсийн үнэнийг мэдэж чадна. Тэр хэлэхдээ: “Би өөрөө эдгээр зүйлийг мэдэж болохын тулд олон хоног мацаг барьж бас залбирсан. Мөн эдүгээ би өөрөө тэдгээр нь үнэнийг би мэднэ; учир нь Их Эзэн Бурхан өөрийн Ариун Сүнсээр надад тэдгээрийг үзүүлсэн юм” (Алма 5:46).

Бид бусад хүмүүс үнэнийг хүлээн авахад нь туслахын тулд мацаг барьж болно. Мацаг барилт уй гашуу, харууслын цагт биднийг амар амгалан болгож, тайтгарахад тусалж чадна (Алма 28:4–6). Мацаг барилт биднийг Тэнгэрлэг Эцэгтэй ойр байж, даруу номхон болоход тусалж чадна (Хиламан 3:35).

Мацаг барилтын зорилго нь бусдад сэтгэгдэл төрүүлэхийн төлөө байх ёсгүй. Их Эзэн зөвлөхдөө:

“Чи мацаг барихдаа хоёр нүүрт хүмүүс шиг бүү баргар царайл. Учир нь тэд мацаг барьж байгаагаа хүмүүст харуулахын тулд нүүр царайгаа барайлгадаг юм.

“Үнэнээр Би та нарт хэлье, тэд шагналаа бүрэн авсан юм.

“Харин та нар мацаг барихдаа толгойгоо тослоод, нүүрээ угаа. Ингэснээр та нар мацаг барьж байгаагаа хүмүүст харуулахгүй” (Матай 6:16–18).

Бид мацаг барихдаа баяртай байж бусдад өөрсдийн мацаг барьж байгаагаа зарлах ёсгүй.

- Бид мацаг барихад бидний хандлага туршлагад маань хэрхэн нөлөөлдөг вэ?

### **Мацгийн өдөр**

Сар бүрийн нэг Ням гарагийг Хожмын үеийн Гэгээнтнүүд мацгийн өдөр болгон мөрддөг. Энэ өдөр бид дараалсан хоёр хоолыг идэхгүй мөн уухгүй байж өнгөрөөдөг. Хэрэв бид Бямба

гарагийн оройн хоолоо идвэл Ням гарагийн оройн хоолыг хүртэл ууж идэхгүй.

Бие эрүүл мацаг барих боломжтой бүх гишүүд мацаг барьдаг. Бид хүүхдүүдээ баптисм хүртсэнийх нь дараа мацаг барихыг урамшуулан дэмждэг. Харин бид тэднийг хэзээ ч хүчилж болохгүй. Мацгийн өдөр нь бидний хувьд мацаг барилт ба залбирлаар Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгах онцгой өдөр мөн. Энэ өдөр нүглүүдийнхээ уучлаын төлөө мөн өөрсдийн бурууг даван туулах хүч болон бусдыг уучлахын төлөө залбирах өдөр.

Мацгийн ням гарагт Сүмийн гишүүд хамтдаа цугларч, ариун ёслолоос хүртдэг. Тэд мацаг барилтын уулзалтанд гэрчлэлээ хуваалцан өөрсдийгөө болон бие биеэ хүчирхэгжүүлдэг.

- Мацгийн цуглаанд гэрчлэлээ хуваалцах нь танд хэрхэн ашиг тусыг өгдөг вэ? Бусад хүмүүсийн гэрчлэлийг сонссоноор энэ нь та нарт хэрхэн тус болдог вэ?

### **Мацгийн өргөл**

- Яагаад бид мацгийн өргөлийг өгдөг вэ?

Бид сар бүр мацаг барихдаа гачигдалтай нэгэнд туслахыг Их Эзэн биднээс хүссэн. Бид мацгийн өргөлийг хийх нэг зам бол зохих санваарын эрх мэдлээр дамжуулан хоёр хоолонд зарлагдах мөнгийг өгөх юм. Бид аль болох өгөөмрөөр өгөх ёстой. Мацгийн өргөлөөрөө дамжуулан бид өөрсдийн ах эгч нартаа туслах үйлсэд Их Эзэнтэй хамтрагч болдог.

### **Бид мацаг барьснаар адислагддаг**

- Бид зохистой мацаг барьснаар хэрхэн адислагддаг вэ?

Хуучин Гэрээнд бошиглогч Исаиа мацаг барьж гачигдагсдад тусалдаг хүмүүст Их Эзэний амласан баялаг амлалтуудыг бичсэн. Бидэнд амар амгалан, эрүүл мэнд, сүнслэг удирдамжийг амласан. Мацаг барьснаар ирдэг адислалуудыг Исаиа бидэнд хэлсэн. “Тэгвэл чиний гэрэл үүрийн гэгээ шиг цацарч, чиний эдгэрэлт үтэр түргэн болж, чиний үнэн зөв өмнө чинь явж, Эзэний цог жавхлан чиний арын хамгаалалт болно. Тэгэхэд

чамайг дуудахад Эзэн хариулж, чамайг хашхирахад Тэр “Би энд байна” гэж айлдана (Исаиа 58:8–9).

Мацаг барилт бидний амьдралыг сайжруулж, бидэнд хүч тэнхээг өгдөг. Энэ бидэнд сайн мэдээний бусад зарчмуудаар амьдрахад тусалдаг. Учир нь энэ биднийг Их Эзэнтэй ойр байлгадаг.

### *Мацаг барилт биеэ барих чадварыг заадаг*

Мацаг барилт зан төлөвөө бэхжүүлэхэд бидэнд тусалдаг. Мацаг зөв барихад бид өөрсдийн шохоорхол болон дур сонирхлыг хянаж сурдаг. Бид өөрсдийгөө хянах чадвартай хэмээн батлах нь бага зэрэг хатуу юм шиг байж болох юм. Хэрэв бид хүүхдүүдэдээ мацаг барихыг заах аваас дараа нь тэдний амьдралд тулгарах томоохон уруу таталтуудыг даван туулах сүнслэг хүчийг хөгжүүлэх болно.

### *Мацаг барилт нь бидэнд сүнслэг хүчийг өгдөг*

Бид мэргэн ухаантайгаар мөн залбиралтайгаар мацаг барьснаар итгэлээ хөгжүүлдэг. Энэ итгэлээр бид агуу сүнслэг хүчийг авч болно. Жишээлбэл: Алма (Мормоны Номын бошиглогч) Мозаягийн хөвгүүдтэй тэдний гайхамшигт хөрвүүлэлтээс олон жилийн дараа дахин уулзсан тухай түүхээ ярьдаг. Тэдний итгэл хүчирхэгжиж, агуу сүнслэг хүчийг хөгжүүлснийг тэр хараад агуу баяр баяслыг мэдэрдэг. Тэд энэ хүчийг олж авсан учир нь “тэд өөрсдийгөө их залбирал, мөн мацаг барилтанд зориулсан байв; тиймийн тул тэдэнд бошиглолын суу билэг, мөн илчлэлтийн суу билэг байлаа” (Алма 17:3).

Мозаягийн хөвгүүд лэмэнчүүдэд 14 жилийн турш Бурханы үгийг заан, номлосон байв. Мозаягийн хөвгүүд залбирч, мацаг барьсан тул Их Эзэний Ариун Сүнс тэдний үгсийн хүчийг улам нэмэгдүүлсэн ажээ. Энэ нь тэдний номлолын ажилд агуу амжилтыг өгсөн (Алма 17:4).

Аврагч зохистойгоор мацаг барьдаг тэдэнд хандан “Тэгээд нууцаар хардаг Эцэг тань та нарт буцааж төлнө” хэмээн хэлсэн (Матай 6:18).

- Мацаг барилт уруу татаалтыг эсэргүүцэх бидний сүнслэг хүчийг хэрхэн өсгөдөг вэ? илчлэлтийг хүлээн авахыг? зөв үйлдлийг хийхийг?

### **Нэмэлт судрууд**

- Лук 2:37; Алма 45:1 (мацаг барилтаар дамжуулан Бурханыг шүтэх)
- Исаиа 58:3–11 (зохистой мацаг барилт)
- Мозая 27:19, 23 (өвчтөний төлөө мацаг барих)
- 3 Нифай 27:1–3; Египетээс гарсан нь 34:27–28 (илчлэлт ба гэрчлэлийн төлөө мацаг барих)
- Алма 6:6; 17:9 (Бурханыг мэддэггүй хүмүүсийн төлөө мацаг барих)
- Үйлс 13:2–3 (Сүмийн ажилтныг сонгохын төлөө мацаг барих)
- Мозая 4:26 (гачигдагсдад тусалсанаар нүглүүдийнхээ ангижралыг хадгалан үлдэх)

# ЗОЛИОСЛОЛ

Бүлэг 26

---

## **Золиослолын утга учир**

Золиослол гэдэг Их Эзэний хүслээр, Түүний ажлыг хийхийн тул өөрсдийн цаг, дэлхийн зүйлс, хүч чадлаа зориулахыг хэлнэ. Их Эзэн “Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун” хэмээн зарлигласан (Матай 6:33). Бидний золиослол хийх хүсэл нь Бурханаа бишрэн хайрлах бидний илэрхийлэл юм. Хүмүүс амьдралдаа Бурханы зүйлсийг эхэнд нь тавих эсэхэд үргэлж шалгагдан соригдсоор иржээ.

- Их эзэний хүссэний дагуу оронд нь ямар ч хариу нэхэлгүй золиослол хийх нь яагаад чухал вэ?

## **Эртний үеэс золиослолын хууль байсан**

- Эрт цагийн Их Эзэний гэрээт хүмүүсийн хийсэн золиослолуудын юу нь гайхалтай байсан бэ?

Адам Евагийн үеэс Есүс Христийн цаг үеийг хүртэл Их Эзэний хүмүүс золиослолын хуулийг мөрдөж ирсэн. Тэднийг өөрсдийн сүргийн ууган үр төлийг өргөж байхыг зарлигласан. Тэдгээр амьтад ямар ч сэв толбогүй төгс төгөлдөр байх ёстой. Ёслол нь дэлхийд ирэх Эцэгийн Төрсөн Ганц Есүс Христийн тухай хүмүүст сануулахаар өгөгдсөн байв. Тэр бүх талаараа төгс төгөлдөр бөгөөд Өөрийгөө бидний нүглүүдийн төлөө Тэр өргөх болно (Моце 5:5–8).

Тэр хүмүүст заасны дагуу Өөрийгөө золиослол болгон өргөхөөр Есүс ирсэн. Түүний золиослолын учир хүн болгон Амилуулалтаар биеийн үхлээс аврагдаж, Есүс Христэд итгэх

---

**Багш нарт зориулж:** Та бүлэг бүрийн юм бүгдийг заах хэрэггүй. Заахад залбиралтайгаар бэлтгэж, бүлгийн аль хэсэг, ямар асуултыг асуух хэрэгтэйг мэдэхийн тул Сүнсний удирдамжийг эрэлхийл.





итгэлээр дамжуулан бүгд өөрсдийн нүглүүдээс аврагдах болно (Энэ номын 12-р бүлгийг үз)

Христийн цагаатгалын золиослол нь цус асгаруулах золиослолыг төгсгөл болгосон юм. Уг золиослолыг ариун ёслолын жаягаар сольсон юм. Ариун ёслол нь Аврагчийн агуу золиослолыг сануулж байхын тулд өгөгдсөн. Бид ариун ёслолоос тогтмол хүртэх ёстой. Талх ба ус нь бидэнд Аврагчийн бие болон бидний төлөө асгаруулсан Түүний цусыг сануулдаг (Энэ номын 23-р бүлгийг үз).

- Яагаад Цагаатгалыг агуу бөгөөд сүүлчийн золиослол хэмээн үзэх болсон бэ?

### **Бид золиослолыг үргэлжлүүлэн хийх ёстой**

- Өнөөдөр бид золиослолын хуулийг хэрхэн мөрддөг вэ?

Хэдийгээр цус асгаруулалтаар дамжуулан золиослол хийхийг Их Эзэн эцэс болгосон ч биднийг үргэлжлүүлэн золиослол үйлдэхийг хүсдэг. Гэхдээ одоо Тэр өөр маягийн өргөлийг шаарддаг. Тэр “Та нар цаашид цус урсган надад өргөл өргөхгүй, тийм ээ, та нарын тахилууд мөн хайлах өргөл тань зогсоогдох болно. Мөн та нар харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг надад өргөл болгон өргөх болно” (3 Нифай 9:19–20). “Харууссан зүрх, гэмшсэн сэтгэл” гэдэг нь бид өөрсдийгөө даруусган, нүглүүдээ наманчилж чин сэтгэлээсээ харуусахыг хэлнэ.

### **Бид байгаа бүхнээ Их Эзэндээ золиослох хүсэлтэй байх ёстой**

- Яагаад хүмүүс золиослол хийх хүсэлтэй байдаг вэ?

Бид өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөх ёстойг Төлөөлөгч Паул бичсэн (Ром 12:1).

Амьд тахил байхын тулд өөрт байгаа бүхнээ дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулж, Сионыг авчрах Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ажилд зориулах хүсэлтэй байх ёстой (1 Нифай 13:37).

Нэгэн баян залуу Аврагчаас “Мөнх амийг өвлөхийн тулд би юу хийх ёстой вэ?” хэмээн асуув. Есүс түүнд “Бүү завхайр. Бүү ал. Бүү хулгайл. Бүү худал гэрчил. Эцэг эхээ хүндэл гэсэн тушаалуудыг чи мэднэ шүү дээ”. Гэхэд баян залуу “Би энэ бүгдийг хар багаасаа л сахьсан” гэв. Есүс үүнийг сонсоод, Тэр түүнд “Чамд нэг л зүйл дутуу байна. Эзэмшиж байгаа бүхнээ худалдаж, ядууст тарааж өг. Тэгвэл чи тэнгэрт баялагтай болно. Тэгээд ирж, Намайг дага” гэв. Харин залуу үүнийг сонсоод ихэд гунигтай болов. Тэр маш баян учраас түүний зүрх сэтгэл баялагт нь байжээ (Лук 18:18–23; мөн энэ бүлгийн зургийг үз).

Залуу эзэн сайн хүн байлаа. Гэхдээ түүний итгэл сорилтонд орох үед өөрийн дэлхийн баялагуудыг золиослох хүсэл түүнд байсангүй. Харин нөгөө талд, Их Эзэний шавь нар болох Петр ба Андреу нар Бурханы хаант улсыг эрэлхийлэхийн төлөө бүхнээ золиослох хүслээр дүүрэн байсан. Есүс тэдэнд “Намайг дага гэхэд тэд тэр даруй тороо орхиж Түүнийг дагалаа” (Матай 4:19–20).

Бид шавь нарын адил өөрсдийнхөө өдөр тутмын үйл ажиллагаануудыг Их Эзэнд золиослол болгон өргөж чадна. Бид “Таны хүсэл биелэх болтугай” гэж хэлж чадна. Абрахам үүнийг хийсэн. Тэр Христээс өмнө тахилын өргөлийг золиос болгон өргөдөг цаг үед дэлхий дээр амьдарч байсан. Абрахамын итгэлийн сорилт болгон Их Эзэн түүнд өөрийн хүү Исаагыг тахил болгон өргөхийг зарлигласан. Исаак нь Абрахам, Сара нарын цорын ганц хүү байлаа. Хүүгээ золиослол болгон өргөхийг хүссэн тушаал нь Абрахамын хувьд туйлын хүнд байлаа.

Гэсэн хэдий ч тэр хүү Исаагын хамт тахил өргөх Мориа уулын зүг урт замыг туулав. Тэд гурван өдөр аялав. Абрахамын бодол санаа, түүний зүрх хэрхэн шимшрэн шархирч байсныг төсөөлөн бод доо. Түүний хүү Их Эзэнд өргөх золиос байлаа. Тэднийг Мориа ууланд ирэхэд өөрсдийн босгосон тахилын ширээ уруу Исаак тахилын модыг үүрэн, Абрахам гал, хутга хоёроо авч явлаа. Исаак “Аав минь ээ, хараач гал ба мод энд байна. Харин шатаалт тахилын хурга нь хаана байна вэ?” гэв. Абрахам хариуд нь “Хүү минь, шатаалт тахилд зориулж Бурхан Өөрийгөө хургаар хангана” гэлээ. Дараа нь Абрахам тахилын ширээ босгож,

---

модоо бэлтгэжээ. Тэр Исаагыг ороож, тахилын модон дээр хэвтүүлэв. Тэгээд гараа сунган, хүү Исаагыг алахаар хутгаа далайв. Яг тэр үед Их Эзэний тэнгэр элч түүнийг зогсоож, “Абрахам аа, Хөвгүүнд гар бүү хүр! Түүнд юу ч бүү хий! Учир нь чи хүүтээ, цорын ганц хүүтээ надаас харамлаагүй тул чамайг Бурханаас эмээдгийг чинь одоо Би мэдлээ” гэв (Эхлэл 22:1–14).

Хүүтээ золиослох шаардлагагүй болсонд Абрахам баяр баяс­лаар дүүрэн байсан нь гарцаагүй. Гэхдээ тэр үнэнээсээ Их Эзэнд хайртай Их Эзэний хэлсэн бүхнийг хийх үнэн хүсэлтэй байсан байв.

- Та нарын мэддэг хүмүүсийн амьдралд золиослолын ямар жишээнүүд харагддаг вэ? Өвөг дээдсийнхээ амьдралаас золиослолын ямар жишээнүүдийг та нар харсан бэ? Сүмийн анхдагч нарын амьдралаас? судруудад гардаг хүмүүсийн амьдралаас? Та нар эдгээр жишээнүүдээс юу суралцсан бэ?

### **Зосиолол нь биднийг Бурханы оршихуйд хамт амьдрахад бэлтгэдэг**

Зөвхөн золиослолоор дамжуулан бид Бурхантай хамт амьдрах зохистой болж чадна. Зөвхөн золиослолоор дамжуулан мөнхийн амьдралын баяр баяслыг олж чадна. Биднээс өмнө амьдарч байсан олон хүн өөрсдөдөө байсан бүхнийг золиослосон. Хэрэв бид тэдэнтэй адил баяр баяслын баялаг шагналыг хүртэхийг хүсч байвал тэдэнтэй адил зүйлийг хийх хүсэлтэй байх ёстой.

Биднээс бүх зүйлсээ золиослохыг шаардахгүй байж магад. Гэхдээ Абрахамын адил бүтдийг золиослоход бэлэн байх хүсэлтэй байснаар л бид Бурхантай хамт амьдрахаар зохистой болж чадна.

Их Эзэний хүмүүс олон замаар агуу зосиослолуудыг үргэлж хийдэг байв. Зарим нь сайн мэдээний төлөө гачигдал зүдгүүрийг туулж, дооглон доромжлуулж зовсон. Сүмийн зарим шинэ хөрвөгчид гэр бүлээсээ хөөгдөн цөлөгдөж байсан. Насан туршийн хэмээж байсан найз нөхөд нь тэднээс нүүрээ буруулж байв. Зарим гишүүд өөрсдийн ажлаа алдаж, зарим нь бүр амиа алдаж байв. Гэхдээ Их Эзэн бидний золиослолуудыг мэдэж, Тэр

“Миний нэрийн төлөө өөрийн гэр орноо, ах дүүсээ, эгч дүүсээ, эсвэл эцэг эхээ, хүүхдүүдээ, эсвэл эдлэн газраа орхисон хүн бүр зуу дахин ихийг хүртэх бөгөөд мөнх амийг өвлөх болно” хэмээн амласан (Матай 19:29).

Сайн мэдээний тухай бидний гэрчлэл өсөх тусам бид Их Эзэнд агуу золиослолуудыг хийх чадвартай болдог. Золиослолын бодитоор жишээг толилуулъя.

Германы нэгэн сүмийн гишүүн санваарын эрх мэдэлтэй хэн нэгнийг хайсаар, аравны нэгийн өргөлөө өгөх хүртэл олон жил хадгалсан байв.

Нийгмийн халамжийн бүлгийн айлчлагч багш эмэгтэй 30 жилийн турш дуудлагадаа тасралтгүй үйлчилжээ.

Өмнөд Африкийн хэсэг Гэгээнтнүүд Их Эзэний бошиглогчийн үгийг сонсож, түүнийг харахын тулд гурван хоногийн турш дугуйгаар цуцралтгүй аялажээ.

Мексикт бүсийн чуулганаар Сүмийн гишүүд чуулган болсон өдрүүдийн турш газарт унтаж, мацаг барьсан. Тэд өөрсдийн бүх мөнгийг зөвхөн чуулгандаа ирэх замын зардалдаа зарцуулсан тул хоол хүнс, оромжонд орох ямар ч мөнгө үлдээгүй аж.

Нэгэн гэр бүл ариун сүм барих санд мөнгө хандивлахыг хүссэн тул машинаа заржээ.

Өөр нэгэн гэр бүл ариун сүм явахын тул байшингаа зарсан.

Олон итгэлтэй Хожмын үеийн Гэгээнтнүүд амьдрах мөнгөөр маш хомс ч өөрсдийн аравны нэг ба мацгийн өргөлөө бүрэн төлдөг.

Нэгэн ах Ням гарагт ажиллахыг хүсээгүй тул ажлаасаа татгалзжээ.

Нэгэн салбарын залуучууд эцэг эхчүүд нь сүмийн цуглааны байр барих ажилд туслах үед тэдний бага насны хүүхдүүдийг нь харж халамжлах ажилд сайн дураараа, хүсэл тэмүүлэлтэйгээр цаг заваа зарцуулжээ.

Залуу эрэгтэй ба эмэгтэйчүүд номлолд үйлчлэхийн тулд боловсрол олох, сайн ажил эсвэл спортод амжилт гаргах боломжуудаасаа татгалзах юм уу түүнийгээ хойшлуулдаг.

Их Эзэний төлөө золиослол хийгч хүмүүсийн тухай олон жишээ байдаг. Их Эзэний хаант улсад зориулан цаг, авьяас билэг, хүч чадал, мөнгө, амь амьдралаа өгөх аливаа золиослол бүр үнэ цэнэтэй. Золиослолоор дамжуулан Их Эзэнээс бид Түүгээр хүлээн зөвшөөрөгдөж байгаагаа мэдэх мэдлэгийг олж авч чадна (С ба Г 97:8).

- Яагаад бидний золиослол хийх хүсэл ба Бурханы оршихуйд амьдрах бэлэн байдал хоёр хамаатай гэж бодож байна вэ?

### **Нэмэлт судрууд**

- Лук 12:16–34 (хаана баялаг байна зүрх сэтгэл тэнд байдаг)
- Лук 9:57–62 (хаант улсад багтахын төлөөх золиослол)
- С ба Г 64:23; 97:12 (өнөөдөр золиослолын өдөр)
- С ба Г 98:13–15 (Их Эзэний төлөө амиа өгөх тэд түүнийгээ олж авна)
- Алма 24 (Аммоны хүмүүс Их Эзэнд өгсөн тангаргаа зөрчихийн оронд өөрсдийн амийг золиослосон)



# Ажил ба хувийн үүрэг хариуцлага

Бүлэг 27

---

## **Ажил бол мөнхийн зарчим**

- Та нарт ажил хөдөлмөрийн ач холбогдлын чухлыг харуулах ямар туршлага байдаг вэ?

Бидний Тэнгэрлэг Эцэг Есүс Христ нар Өөрсдийн үлгэр жишээ ба сургаалуудаар ажил нь тэнгэрт болон газарт чухал ач холбогдолтой гэдгийг харуулсан. Бурхан тэнгэр ба газрыг бүтээхээр ажилласан. Тэр далай тэнгисийг нэг дор цуглуулж, хуурай газрыг харагдуулахуйц ил болгосон. Тэр газар дээр өвс ургамал, модод ургахаар болгосон. Тэр нар, сар, оддыг бүтээсэн. Тэр далай тэнгис эсвэл хуурай газар дээр амьдрах амьтай бүхнийг бүтээсэн. Дараа нь Тэр Адам ба Ева хоёрыг дэлхий дээрх бүхнийг харж хандаж, амьд бүхний дээр ноёрхлыг ав хэмээн байрлуулсан (Эхлэл 1:1–28).

Есүс “Миний Эцэг одоо болтол ажилласаар байна. Би Өөрөө ч ажиллаж байна” гэж хэлсэн (Иохан 5:17). Тэр мөн “Намайг Илгээгчийн ажлыг Би хийх ёстой” гэж хэлсэн (Иохан 9:4).

## **Бидэнд ажиллахыг тушаасан**

Адам Ева нар Едены цэцэрлэгийг орхисон үеэс эхлэн ажил нь дэлхий дээрх амьдрах арга зам болсон. Их Эзэн Адамд “Духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ” гэж хэлсэн (Эхлэл 3:19). Адам Ева нар өөрсдийн болон хүүхдүүдийнхээ хэрэгцээг хангахын тулд газар боловсруулж эхлэв (Мосе 5:1).

---

**Багш нарт зориулж:** Ангийн эсвэл гэр бүлийн гишүүн бүрийг хичээлд идэвхтэй хамруулахыг хичээ. Сандал зөөн байрлуулах, нээлтийн болон хаалтын залбирал хийлгэх, самбар дээр бичих, чангаар судраас унших, асуултанд хариулах, гэрчлэлээ хуваалцах болон хичээлээс ойлгосон зүйлээ товч хуваалцах зэргээр бүх гишүүдийг оролцуулж болно.



Их Эзэн Израилын хүмүүст хандан “Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, бүх ажлаа хий” гэсэн (Египетээс гарсан нь 20:9).

Сэргээгдсэн сүмийн эхэн үед Их Эзэн Хожмын үеийн Гэгээнтнүүдэд “Эдүгээ Сионы оршин суугчид Их Эзэн миний таалалд үл нийцнэ, учир нь тэдний дунд залхуурагчид буй” гэж хэлсэн (С ба Г 68:31).

Их Эзэний нэгэн бошиглогч “Ажил нь манай Сүмийн гишүүдийн амьдралыг жолоодох гол зарчим байснаар дахин өргөмжлөгдөх болно (Хебер Ж. Грант, *Teachings of Presidents of the Church: Хебер Ж. Грант* [2002], 115) хэмээн хэлсэн.

### **Гэр бүлийн үүрэг хариуцлага**

- Аав, ээж, хүүхдүүдэд гэр орноо авч явах ямар үүрэг хариуцлагууд байдаг вэ? Гэр бүлийн гишүүд хэрхэн хамтран ажиллаж чадах вэ?

Гэр бүлийнхээ эрүүл мэнд, сүнслэг байдал, сэтгэл санааны сайн сайхан байдлыг хангахын тул эцэг эх нь хамтдаа ажилладаг. Энэ үүрэг хариуцлагыг гүйцэлдүүлэх нэгнийг хэзээ ч хүлээх ёсгүй. Төлөөлөгч Паул “Харин хэрэв хэн нэгэн нь өөрийнхнийгөө, ялангуяа төрсөн гэр бүлийнхээ хүмүүсийг тэтгэхгүй байвал тэр хүн итгэлийг үгүйсгэсэн хэрэг” хэмээн бичсэн байдаг (1 Тимот 5:8).

Эхнэр нөхөр хоёр үүрэг хариуцлагаа хуваарилахдаа бошиглогчдын зөвлөгөөг дагаж, Их Эзэнээс сүнслэг өдөөлтийг эрэлхийлэх ёстой. Өдөр бүр сайн мэдээний зарчмуудыг заадаг хайр ба дэг журмаар элбэг дүүрэн орон гэрийг байгуулах нь үндсэн хоол хүнс, хувцас хунарын хэрэгцээгээр хангагдахтай адил чухал ач холбогдолтой.

Хүүхдүүд гэр бүлийн ажил дахь өөрсдийн хэсгийг хийх ёстой. Хүүхдүүд өөрсдийн чадварт тохирсон ажил хийх шаардлагатай. Тэдний амжилтыг бахдан сайшаах хэрэгтэй. Гэр орондоо сурсан амжилттай туршлагуудаар дамжуулан сайн ажиллах ухамсар, зуршил, чадварт суралцдаг.

Заримдаа хүмүүс гэр бүлээ хэрэгцээтэй бүхнээр хангахын тулд нэлээд бэрхшээл зовлонтой тулгардаг. Архаг өвчин, хань ижлээ

алдах эсвэл өндөр настай эцэг эхээ асрах зэрэг нь гэрт нэмэлт үүрэг хариуцлагыг авчирдаг. Бидний Тэнгэрлэг Эцэг эдгээр нөхцөл байдалд байгаа гэр бүлүүдийг мартдаггүй бөгөөд тэдэнд үүрэг хариуцлагаа биелүүлэх хүч тэнхээг өгдөг. Хэрэв тэд итгэлтэйгээр Түүнээс гуйх аваас Тэр үргэлж тэднийг адисална.

### **Бид ажилдаа сэтгэл хангалуун тааламжтай байж чадна**

- Бидний хандлага ажилд маань хэрхэн нөлөөлдөг вэ?

Зарим хүмүүсийн хувьд ажил нь хүнд уйтгартай зүйл байдаг. Бусад хүмүүст ажил нь амьдралынх нь сэтгэл сэргээх нэгэн хэсэг байдаг. Амьдралын бүрэн ач тусыг мэдэн баяр баясалтай байх нэгэн арга зам бол ажлыг хайрлаж сурах явдал юм.

Бидний ихэнх нь ямар ажил хийхээ сонгож чаддаггүй. Бидний зарим нь энгийн хэрэгцээний төлөө олон цагаар ажилладаг. Ийм ажлаас баяр баяслыг авахад хэцүү. Ямар ч ажлыг баяр баясал болгон хүлээн авч сурсан хүмүүс л хамгийн аз жаргалтай байдаг.

Бид бие биеийнхээ ажилд тусалж чадна. Хэн нэгэн туслахад хүнд ачаа ч хөнгөрдөг.

Бидний ажилд хандах хандлага маш чухал. Дараах түүхэнд нэгэн эр өөрийн өдөр тутмын хөдөлмөрийн чухлыг хэрхэн харсан тухай өгүүлдэг. Нэгэн жуулчин чулуу олборлох газрын хажуугаар өнгөрч явахдаа гурван эр ажиллаж байхыг харжээ. Тэднээс тэр юу хийж байгааг нь асуув. Адилхан ажил хийж байгаа хүн бүрийн хариулт өөр өөр байлаа. “Би чулуу зүсэж байна” гэж нэг дэх хүн хариулав. Хоёр дахь нь “Би өдөр бүр гурван алтан зоосны ажил хийдэг” гэж хариулав. Гурав дахь эр инээмсэглээд “Би Бурханы өргөөг барихад тусалж байна” гэж хариулжээ.

Аливаа шударга хөдөлмөрөөр бид Бурханд үйлчилж чадна. Нифай үндэстэн бошиглогч, Бенжамин хаан “Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу” гэж хэлсэн (Мозая 2:17). Бидний ажил зөвхөн өөрсдийгөө болон гэр бүлийнхээ энгийн хэрэгцээг хангахад зориулагдсан байсан ч бид Бурханы хүүхдүүдэд тусалж байна гэсэн үг.

- Бид ажилд хандах хандлагаа хэрхэн хөгжүүлж чадах вэ?

### **Бурхан ажилгүй зүгээр суухыг зөвшөөрдөггүй**

Их Эзэн залхуу, ажилгүй нэгнийг таалдаггүй. Тэр “Мөн тэрээр наманчилж мөн өөрийн замуудыг өөрчлөхгүй бол залхуурагч сүмд байргүй болно” гэж хэлсэн (С ба Г 75:29). Тэр мөн “Чи залхуу байх ёсгүй; учир нь залхуу тэрээр хөдөлмөрлөгчийн талхыг ч идэх, мөн өмсгөлүүдийг ч өмсөх ёсгүй бөлгөө” хэмээн зарлигласан (С ба Г 42:42).

Сүмийн эхэн үеэс эхлэн бошиглогчид Хожмын үеийн Гэгээнтнүүд залхуурлаас зайлсхийж биеэ даасан, амьдралаа тэтгэх чадвартай байхыг заасан. Шударга Хожмын үеийн Гэгээнтнүүд өөрсдийн амьдралыг тэтгэх ачааг бусдад хэзээ ч шилжүүлдэггүй. Тиймээс тэд амьдралын энгийн хэрэгцээт бүхнээр өөрсдийгөө болон гэр бүлээ болохоос нь болохгүйг хүртэл зүтгэн хангах болно.

Сүмийн бүх гишүүд өөрсдийгөө тэтгээд зогсохгүй мөн боломжоороо өөрсдийгөө тэтгэх чадваргүй тэдгээр ахан дүүсээ тэтгэн дэмжих үүрэг хариуцлагыг хүлээн авах хэрэгтэй.

- Залхууран ажилгүй суух нь хувь хүнд хэрхэн нөлөөлдөг вэ? гэр бүлд? нийгэмд?

### **Ажил, амралт ба чөлөөт цаг**

- Амьдралд ажил, амралт ба чөлөөт цагийг тэнцвэртэй байлгах нь яагаад чухал вэ?

Хүн бүр ажил, амралт ба чөлөөт цагийг зохих ёсны тэнцвэртэй байдалд байлгах хэрэгтэй. Эртний нэгэн үгэнд “Юу ч хийхгүй байх нь хамгийн хэцүү ажил. Учир нь хүн амрахаа хэзээ ч зогсоож чадахгүй” гэсэн байдаг. Ажилгүйгээр амралт ба зугаа ямар ч утгагүй юм.

Амрах нь зөвхөн ганц тааламжтай бөгөөд шаардлагатай зүйл ч бус, биднийг Хүндэтгэлийн өдөр амрахыг зарлигласан (Египетээс гарсан нь 20:10; С ба Г 59:9–12). Зургаан өдөр хөдөлмөрлөсний

эцэст энэ өдөр амрах нь ирэх өдрүүдэд ажиллах хүч тэнхээг сэлбэдэг. Хүндэтгэлийн өдрийг сахих тэдэнд Их Эзэн мөн “дэлхийн бүрэн байдлыг” амалсан (С ба Г 59:16–20; мөн энэ номны 24-р бүлгийг үз).

Долоо хоногийн бусад өдрүүдэд ажиллахаас гадна чөлөөт цагаараа авьяас чадвараа хөгжүүлэх, сонирхолтой зүйлсээ хийж баясах зэрэг бусад үйл ажиллагаануудаар хүч тэнхээгээ сэлбэж болно.

- Ажил, амралт ба чөлөөт цагаа зөв тэнцвэртэй сахихын тул бид юу хийж чадах вэ? Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ энэ тэнцвэрийг барихад хэрхэн тусалж чадах вэ?

### **Ажил хөдөлмөрөөс ирэх адислалууд**

- Шударга ажил хөдөлмөрөөс ямар адислалууд ирж болох вэ?

Бурхан Адамд “Духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ” хэмээн илчилсэн (Эхлэл 3:19). Энэ нь дэлхийн амьдралд шаардлагатай байхаас гадна Адамын бодгалийн авралын төлөөх хууль юм. Сүнслэг, оюуны болон биеийн ажлын хооронд жинхэнэ бодит зааг ялгаа гэж үгүй. Ажил нь бидний хүн нэг бүр өсөн хөгжих, зан төлөвийн төлөвшилт болон залхуурагчид хэзээ ч амт шимийг нь мэдэхгүй олон сэтгэл ханамжуудыг эдлэхэд зайлшгүй хэрэгтэй.

Ерөнхийлөгч Дэвид О. МакКей “Ажил хийх боломж нь бэлэг, ажил хийх чадвар нь адислал, ажилд дурлах нь амжилт гэдгийг бид ойлгох хэрэгтэй” (*Pathways to Happiness* [1957], 381).

“Мөн тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө” (2 Нифай 2:25). Ажил нь Бурханы төлөвлөгөөний бүрэн баяр баяслын түлхүүр юм. Хэрэв бид зөв шударга байх аваас Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахаар буцаж очих болно. Бид мөн хийх ажилтай байх болно. Бид Түүнтэй адил болсноор бидний ажил Түүний ажил болох болно. “Үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь” Түүний ажил билээ (Моисе 1:39).

### **Нэмэлт судрууд**

- Мосе 4:23–25 (Адам амьдралынхаа турш өөрийн хоол хүнсний төлөө ажиллах болно гэдгийг хэлсэн)
- С ба Г 56:16–17 (Бурхан баян болон ядууст ховдог шунахай, атаа жетөө, залхуурлын эсрэг байхыг анхааруулсан)
- С ба Г 58:26–29 (хүмүүс сайн зүйлийн төлөө сэтгэлээ бүрэн зориулах ёстой)
- Матай 25:14–30 (талантынтухай сургаалт үлгэр)
- Ефес 4:28 (хулгайлахын оронд хөдөлмөрлө)
- 1 Тесалоник 4:11–12 (өөрийн гараар ажилла)
- 2 Нифай 5:17 (Нифай өөрийн хүмүүст ажил хийж, хөдөлмөрмөрч байхыг заасан)

# ҮЙЛЧЛЭЛ

Бүлэг 28

---

## **Бид хэрхэн үйлчилж чадах вэ**

- Хүмүүс танд болон танай гэр бүлд үйлчилсэн арга замуудын талаар бод.

Есүс “Харин би та нарын дунд үйлчлэгч мэт байдаг” хэмээн хэлсэн (Лук 22:27). Есүсийн үнэн шавь нарын хувьд бид ч мөн бусдад үйлчлэх ёстой.

Үйлчлэл гэдэг тусламж шаардлагатай байгаа хэн нэгэнд тусална гэсэн үг. Аврагчийг хайрлах агуу хайр болон Түүний биднээр туслуулахаар боломж, удирдамжийг өгөх тэдгээр хүмүүсийг харйлах хайр ба зовних сэтгэлээс Христ шиг үйлчлэл урган гардаг юм. Хайр нь мэдрэмжээс илүү зүйл. Бид бусдыг хайрлахаараа тэдэнд туслахыг хүсдэг.

Бидний амьдралын орлого, нас эсвэл нийгмийн байдал ямар байх нь хамаагүй бид бүгд үйлчлэх хүсэлтэй байх ёстой. Зарим хүмүүс ядуус болон доод түвшингийнхэнд үйлчлэх ёстой гэж итгэдэг. Бусад нь зөвхөн баячууд үйлчлэл хийж өгөх ёстой гэж боддог. Харин Есүс өөр зүйлийг заасан. Түүний хоёр шавийн ээж Түүнээс хөвгүүдийг нь Өөрийн хаант улсдаа байлгахыг хүсэхэд Есүс “Та нарын дунд хэн чинь агуу нэгэн болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог” хэмээн хариулав (Матай 20:26–27).

Үйлчлэх маш олон арга зам байдаг. Бусдад бид эдийн засгаар, нийгмийн байдлаар, биенийн хөдөлмөрөөр мөн сүнслэг байдлаар тусалж чадна. Жишээ нь: бид гачигдаж зовсон хүнтэй хоол хүнс болон бусад зүйлсээ хуваалцаж болно. Бид мацгийн өргөлөө өгөөмрөөр төлж хэрэгцээтэй хүнд тусалж чадна. Бид шинээр ирэгч хүмүүстэй найз байж чадна. Бид өндөр настангуудын

---



цэцэрлэгийн ажилд нь тусалж, өвчтэй нэгнийг асран халамжилж болно. Бид үнэн хэрэгтэй тэдэнтэй сайн мэдээг зааж эсвэл уй гашууд орсон тэднийг тайвшруулж болно.

Бид их бага ямар ч үйлчлэлийн хэмжээнд тусалж чадна. Бид агуу зүйлсийг чадахгүй юм чинь хэмээн бодож хэн нэгэнд туслахгүй байж болохгүй. Нэгэн шинэ хотод нүүж ирээд удаагүй байхад нь хоёр хүүхэд ирж хаалгыг нь тогшсон тухай нэгэн бэлэвсэн эмэгтэй хуваалцсан байдаг. Хүүхдүүд түүнд савтай өдрийн хоол авчирсан байсан бөгөөд “Хэрэв танд зарлага хэрэгтэй бол биднийг дуудаарай” гэсэн бичгийг үлдээсэн байв. Бэлэвсэн эмэгтэй энэ өчүүхэн анхаарал тавьсанд талархалтай байсан ба үүнийг хэзээ ч мартдаггүй ажээ.

Гэвч заримдаа бид хэн нэгэнд үйлчлэхийн тулд том золиослолыг хийх хэрэгтэй болдог. Аврагч бидэнд үйлчилснээр Өөрийн амийг бидний төлөө өгсөн.

- Өөрийн гэр бүл болон хамт олны дунд эдийн засгийн, нийгмийн, биеийн эсвэл сүнслэг хэрэгцээ шаардлагатай байгаа хүмүүсийн талаар бод. Тэдэнд хэрхэн үйлчилж болох талаар тунгаан бод.

### **Яагаад Аврагч биднийг бусдад туслаасай хэмээн хүсдэг вэ**

- Яагаад Их Эзэн биднийг бусдад үйлчлэхийг хүсдэг вэ?

Бүх хүн үйлчлэлээр дамжуулан Бурханы ажлыг хийдэг. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбал “Бурхан биднийг анзаарч, харж байдаг. Гэхдээ энэ нь ихэвчлэн бидний хэрэгцээг өөр хэн нэгнээр дамжуулан хангадаг” (*Teachings of Presidents of the Church: Спенсер В.Кимбал* [2006], 82).

Бид амьдралынхаа турш хэн нэгний тусламжаас хамааралтай байдаг. Биднийг нялах нярай байхад эцэг эх маань биднийг хооллож, хувцаслаж, асран халамжилж байсан. Энэ анхаарал халамжгүйгээр бид амьд үлдэхгүй байх байсан. Хүмүүс бидэнд ур чадвар, зан харилцааг заадаг. Бидний олонх нь өвчтэй байхдаа сувилагч асрагчаар халамжлуулж, эдийн засгийн хямралын үед хэн нэгэн мөнгөн тусламж үзүүлдэг. Бидний зарим нь Бурханаас зовж байгаа хүмүүсийг адислахыг хүсэн залбирч,



өөрсдөө тэдний төлөө юу ч хийдэггүй. Бурхан биднээр дамжуулан ажилладаг гэдгийг санах хэрэгтэй.

Бид бие биедээ тусалснаар Бурхандаа үйлчилдэг. Мормоны Номны нэгэн агуу Хаан Бенжамин өөрийн хүмүүст амьдралынхаа жишээгээр энэ зарчмыг заасан. Тэр амьдралынхаа турш бусдад үйлчилж хүмүүсээр хувийн амьдралаа тэтгүүлэхийн оронд өөрөө хөдөлмөрлөж амьдралаа залгуулдаг байсан. Тэр нэгэн сүнслэг номлолд яагаад үйлчлэл дуртай тухайгаа тайлбарлан хэлэхдээ:

“Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу. . . .

“Мөн хэрэв та нарын хаан болгосон тэрбээр, та нарт үйлчлэхээр хөдөлмөрлөх аваас та нар нэг нэгэндээ үйлчлэхээр хөдөлмөрлөх ёстой бус уу?” (Мозая 2:17–18).

- Бид бусдын хэрэгцээг хангахад бэлэн байхын тулд юу хийж чадах вэ?

### **Бид үйлчлэлээр дамжуулан адислалуудыг хүлээн авдаг**

- Бид бусдад үйлчилснээр ямар адислалуудыг хүлээн авдаг вэ?

Бид бусдад үйлчилснээр чухал адислалуудыг хүртдэг.

Үйлчлэлээр дамжуулан бидний хайрлах чадвар өсдөг. Бидний хувиа хичээх чанар багасдаг. Бид бусдын асуудлуудын талаар сэтгэл тавин бодоход бидний асуудлууд хажууд нь юу ч биш мэт санагддаг. Бид мөнхийн амийг олохын тулд бусдад үйлчлэх ёстой. Бурхан Түүнтэй хамт байсан тэдэнд Түүний хүүхдүүдийг хайрлаж, үйлчлэх ёстойг хэлсэн (Матай 25:34–40).

Амин хувиа бодолгүй бусдын төлөө үйлчилж байгаа хүмүүсийн амьдралыг бид эргэцүүлэн бодоход тэд өгч байгаагаасаа илүүтэй олж авч байгааг бид харж чадна. Ийм хүмүүсийн нэг бол Хожмын үеийн гэгээнтэн ослын улмаас хоёр хөлөө алдсан Паул юм. Зарим хүмүүс ийм болоод уй гашууд унаж, ямар ч хэрэгцээгүй хүн болж болох. Харин Паул өөрийгөө мартаж бусдын тухай бодохыг сонгосон аж. Тэр худалдаа эрхлэн мөнгө цуглуулж байшин худалдаж авав. Тэр эхнэртэйгээ байшиндаа орон гэргүй хүмүүс, эх эцэгтээ хаягдсан хүүхдүүдэд зориулан

өрөө гаргажээ. Тэдний зарим нь нэлээд хүнд хөгжлийн бэрхшээлтэй болсон байв. Паул 20 жилийн турш бусдад үйлчилжээ. Үйлчлэлийнхээ хариуд тэр агуу хайраар хайрлуулж, өөрийн зэрэмдэг болсон хөлнийхөө талаар мартсан байв. Тэр Их Эзэнтэй ойр байж өсөн хөгжиж байв.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбал “Бид бусдад үйлчилснээр илүү бие даасан, хэрэгтэй зүйлд ач холбогдол өгөхийн үнэ цэнэ, үр дүнг мэддэг болдог. Энэ нь өөрсдийгөө ойлгож олж мэдэхэд амар болгодог. Учир нь биднээс гадна “олох” хэрэгтэй маш олон хүмүүс байна!” (*Teachings of Presidents of the Church: Спенсер В.Кимбал*, 85–86).

### **Үйлчлэх боломжууд**

Бидний зарим нь зөвхөн хайртай хүмүүстээ үйлчлээд бусдаас зайлсхийдэг. Гэхдээ Есүс хүн бүрийг хайрлаж, хүн бүрт үйлчлэхийг бидэнд зарлигласан. Үйлчлэл хийх маш олон боломж байна (Мозая 4:15–19).

Бид гэрийнхэндээ үйлчлэл хийж болно. Эхнэр, нөхрүүд бие биеийхээ хэрэгцээг мэддэг байх ёстой. Эцэг эхчүүд хүүхдүүдээ зөвхөн хооллож, хувцаслахаас гадна мөн тэдэнд зааж, тэдэнтэй тоглож, хамт ажиллаж тэдэнд үйлчлэх ёстой. Хүүхдүүд гэр орны ажил болон ах эгч нартаа тусалж болно.

Эхнэр нөхрүүд бие биедээ үйлчилж тусалдаг. Тэд бие биедээ хүүхдүүдээ асран халамжилж, мөн нэг нэгнийхээ сонирхол, ажил төрөлд нь дэмжин тусалж чадна. Номлолд хүүхдээ илгээхийн тул аав ээж нар золиослол гаргадаг. Том ах нь харанхуйгаас айдаг эмэгтэй дүүгээ тайвшруулж эсвэл түүнд уншиж сурахад нь тусалж болно. Бидний бошиглогчид гэр бүл бол нийгмийн дундах хамгийн чухал нэгж мөн хэмээн бидэнд хэлсэн байдаг. Бид гэр бүлийнхэндээ маш сайн туслах ёстой (Мозая 4:14–15).

Бид өөрсдийн хөрш, найз нөхөд тэр ч бүү хэл танихгүй хүмүүст ч туслах олон боломж байдаг. Хэрэв хөрш маань ширүүн шуурганы өмнө тариагаа хураах гэж зовж байвал бид түүнд тусалж чадна. Өвдсөн ээжид хүүхдийг нь харж

асрамжлан, гэр орных нь ажлыг хийхэд тусалж болно. Хэн нэгэн залуу сүмээс холдож байхад нь түүнийг эргүүлэн авчирч болно. Хэн нэгэн тохуурхагдан шоовдорлогдсон хүүхдийг тайвшруулан түүний найз нь байж, бусдыг нь түүнд найрсаг байхыг ухуулж болно. Бид үйлчлэл хийхийн тулд тэр хүнээ заавал таньдаг байх албагүй. Бид Тэнгэрлэг Эцэгийнхээ аль болох олон хүүхдүүдэд туслах арга замуудыг эрэлхийлэх ёстой.

Хэрэв бидэнд онцгой нэгэн авьяас байвал бид түүнийгээ бусдад туслахын төлөө ашиглах ёстой. Бурхан биднийг бусдын амьдрал ахуйг дээшлүүлэхэд туслуулахын тулд авьяас билэг, ур чадваруудаар адисалсан.

Сүмдээ үйлчлэх боломж бидэнд байдаг. Сүмийн байгууллагын нэгэн зорилго бол бидэнд бусдад туслах боломжийг олгох явдал юм. Сүмийн гишүүд бүрэн цагийн номлол, удирдах томилолтуудыг хүлээн авч, сүмийн гишүүдийнхээр айлчлах, багшлах мөн сүмийн бусад ажлуудыг хийж үйлчилдэг. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд мэргэжлийн ямар ч төлбөр цалин өгдөггүй. Тиймээс сүмийн гишүүд бүгд сүмийн бүх үйл ажиллагааг зохион байгуулан удирдан явуулдаг.

- Сүмд болон туслах бүлгүүдэд үйлчлэхээс гадна бид гэр бүлдээ хэрхэн хангалттай цагийг зориулж чадах вэ?

### **Есүс Христ үйлчлэлийн төгс жишээ мөн**

- Аврагч үйлчлэлийн үлгэр жишээг үзүүлдэг та нарын дуртай ямар судрууд байдаг вэ?

Аврагч үйлчлэлийн төгс жишээг үзүүлсэн. Тэр энэ дэлхийд үйлчлүүлэхээр ирээгүй харин үйлчлэхээр, Өөрийн амийг бидний төлөө өгөхөөр ирсэн гэдгээ Тэр тайлбарласан (Матай 20:28).

Есүс Христ бидний ойлгож мэдэрч чадахаас илүүтэйгээр бидэнд хайртай. Тэр дэлхий дээр байхдаа ядуус, шоовдорлогдод, нүгэлтэнгүүд, үзэн ядагдагсдад үйлчилсэн. Тэр сонсох бүхэнд сайн мэдээг зааж, Түүн уруу ирсэн өлсгөлөн хүмүүсийг хооллож, өвчтөнийг эдгээж, үхсэнийг амьдруулсан.

---

**Багш нарт зориулж:** Бид Есүс Христийн тухай гэрчлэлээ хуваалцахад Ариун Сүнсийг мэдэрдэг. Та заахад бэлтгэхдээ Аврагчийг гэрчлэх арга замуудыг байнга эрэлхийл. Ангийнхныгаа үүнтэй адил үйлдэхийг хүс.

Тэр бол дэлхийн Бүтээгч мөн бидний Аврагч. Тэр үйлчлэлийн олон даруухан үйлсийг хийсэн. Өөрийн Цовдлолтын өмнөхөн Тэр шавь нартайгаа уулзсан. Тэдэнд заасны дараа Тэр савтай ус, алчуур авч тэдний хөлийг угаасан (Иохан 13:4–10; энэ бүлгийн зурагнуудыг үз). Тэр үед зочны хөлийг угаана гэдэг хүндэтгэлийн тэмдэг байсан бөгөөд үүнийг ихэвчлэн зарц боолууд гүйцэтгэдэг байв. Есүс үүнийг хайр ба үйлчлэлийн жишээ болгон хийсэн. Бид бусдад хайрын сүнсээр, хүсэл тэмүүлэлтэйгээр үйлчлэх аваас Христтэй илүү адил болдог.

- Бид Аврагчийн үйлчлэлийн жишээнээс юут суралцаж чадах вэ?

### **Нэмэлт судрууд**

- Мозая 2 (Хаан Бенжамины үйлчлэлийн талаарх яриа)
- С ба Г 81:5 (тусла, өргө, хүчирхэгжүүл)
- Колоссай 3:23–24 (Их Эзэндээ үйлчилж буй мэт бусдад үйлчил)
- Алма 17–18 (Аммон хаанд үйлчилсэн нь)
- Галат 5:13 (хайраар бие биедээ үйлчил)



# Их Эзэний Өгсөн Эрүүл Мэндийн Хууль

Бүлэг 29

---

## **Бидний бие Бурханы ариун сүм**

Дэлхийд ирэхдээ хүлээн авсан агуу адислалуудын маань нэг бол махан биебодь юм. Бидний махан биебодь Тэнгэрлэг Эцэгтэй адил болоход маань хэрэгтэй. Бидний бие Их Эзэнд маш чухал учраас Тэр түүнийг Бурханы ариун сүм хэмээн нэрлэсэн (1 Коринт 3:16–17; 6:19–20). Бидний бие ариун.

Бидний бие чухал учраас Тэнгэр дэх Эцэг маань бие махбодьдоо сайн анхаарал халамж тавьж явахыг хүсдэг. Бид эрүүл чийрэг байх аваас илүү аз жаргалтай, илүү сайн хүмүүс байж чадна гэдгийг Тэр мэддэг. Хэрэв бид бие, бодол санаагаа цэвэр байлгах аваас Ариун Сүнс бидэнтэй хамт байж чадна. Өөрсдийн биебодид ухаалаг бус хандах эсвэл биедээ хор хөнөөлтэй зүйлсийг хэрэглэх уруу таталтуудтай бид учрахыг Эцэг маань мэдэж байв. Үүний учир ямар зүйлс эрүүл мэндэд сайн, ямар зүйлс нь муу болохыг Тэр хэлж өгсөн. Бурхан бидэнд эрүүл чийрэг байх зүйлсийн талаар асар их мэдээллийг Сургаал ба Гэрээ 89 дээр бидэнд өгсөн. Энэ илчлэлтийг Мэргэн Ухааны Үг гэж нэрлэдэг.

Бид ариун сүмд орж болохоор зохистой байхын тулд Мэргэн ухааны үгийг дуулгавартай сахих ёстой. Хэрэв бид Мэргэн ухааны үгэнд дуулгаваргүй байх юм бол Их Эзэний Ариун сүнс биднээс холдон явдаг. Хэрэв бид өөрсдийн бие болох “Бурханы ариун сүм”-ийг бузарлах аваас бие махбодийн болон сүнслэг байдлаар өөрсдийгөө гэмтээдэг.

---

## **Бидэнд өөрсдийн биед тодорхой зүйлсийг хэрэглэх ёсгүйг зарлигласан**

- Их Эзэн өөрсдийн биед юуг хэрэглэж болохгүй хэмээн бидэнд зарлигласан бэ?

Их Эзэн бидэнд дарс, архи агуулсан хатуу ундаа хэрэглэж болохгүй хэмээн зарлигласан. Согтууруулах хатуу ундаа гэрт хэрцгий балмад явдал, ядуу тарчиг байдал, өвчин эмгэг, тахал авчирдаг хэмээн Тэргүүн Зөвлөл бидэнд заасан. Энэ нь ихэвчлэн ариун явдлыг зөрчих, шударга бус явдлын шалтгаан болдог. Согтууруулах бодис хэрэглэгч тэдэнд энэ нь хараал зүхэл мэт байдаг (“Message of the First Presidency,” *Improvement Era*, 1942 оны 11-р сар, 686). Жирэмсэн эхчүүд согтууруулах ундаа хэрэглэх нь бие болон сэтгэхүйн гэмтэлтэй хүүхэд төрүүлэх шалтгаан болдог. Жил бүр авто хэрэгслийн аваар ослыг архи дарс хэрэглэсэн хүмүүс гаргадаг.

Их Эзэн мөн бидэнд “тамхи нь бидний биед зориулагдаагүй” гэдгийг хэлсэн (С ба Г 89:8). Энэ нь бидний бие болон сүнсэнд хор хөнөөлтэй. Бид тамхи татах буюу захилах ёсгүй. Эрдэмтэд тамхи хүний биед хортой бөгөөд олон өвчин эмгэгийн шалтгаан болж, хэвлий дэх үрсэд маань ч хор хөнөөлтэй болохыг батлан үзүүлсэн.

Их Эзэн мөн “халуун унд” уухгүй байхыг бидэнд зөвлөсөн (С ба Г 89:9). Энэ нь хортой агууламж бүхий цай, кофег хэлж буй юм гэдгийг Сүмийн удирдагчид хэлсэн. Бид хор хөнөөлийг авчрах аливаа зүйлийн ундаанаас зайлсхийх ёстой.

Хэрэв эмийг эмчилгээний зориулалтаас өөр шалтгаанаар хэрэглэх ёсгүй. Зарим эм тан нь бүр архи дарс, тамхинаас ч илүү биед хор хөнөөлтэй байж болно (эм тан, мансууруулах бодис). Эм танг буруу хэрэглэдэг хүмүүс бүрэн цэвэршихийн тулд тусламжийг эрэлхийлж, хүчирхэгжүүлэхийг гуйн залбирч, бишоптойгоо зөвлөлдөх хэрэгтэй.

---

**Багш нарт зориулж:** Жагсаалт гарган бичих нь суралцагсдын анхаарлыг төвлөрүүлж, сонирхлыг татаж чадна. Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдтэй Их Эзэн биднийг бие махбодиоо хэрэглэж болохгүй гэсэн зүйлсийн талаар ярилц. Та хэн нэгнээс хариултыг самбар дээр эсвэл том цаасан дээр бичихийг хүсэж болно. Бидний биед хэрэгтэй эрүүл чийрэг байлгах зүйлсийн талаар ярилцахдаа мөн үүнчлэн хийж болно.

Биедээ хор хөнөөл учруулах элдэв зүйлсээс бид зайлсхийх ёстой. Биднийг донтолттой болгох аливаа зүйлсийг хэрэглэхгүй байх хэрэгтэй. Бид мөн их идэхээс зайлсхийх ёстой. Мэргэн ухааны үг нь бидний зайлсхийх эсвэл хэрэглэх ёстой бүгдийг хэлэх бус харин бидэнд удирдамж заавар өгдөг. Энэ нь үнэ цэнэтэй дэлхийн хууль. Энэ нь мөн агуу сүнслэг хууль юм. Мэргэн ухааны үгийн дагуу амьдарснаар бид сүнслэгээр хүчирхэгждэг. Бид биебодио цэвэршүүлэн ариусгаснаар Их Эзэний Сүнс бидэнтэй хамт байж чадна.

- Мэргэн ухааны үгэнд онцгойлон дурьдагдаагүй боловч бид зайлсхийх ёстой ямар зүйлс байдаг вэ?

### **Бидний биед хэрэгтэй тодорхой зүйлсийг заасан**

- Мэргэн ухааны үгийн дагуу бидний бие махбодид хэрэгтэй ямар зүйлсийг Их Эзэн бидэнд хэлсэн бэ?

Жимс, ногоо болон бүх төрлийн ургамал. Бид тэднийг ухаалгаар, талархалтайгаар хэрэглэх ёстой.

Шувуу, амьтны мах нь бидний хоол хүнсэнд зориулан өгөгдсөн. Гэхдээ бид махыг арвич хямгачаар идэх ёстой (С ба Г 49:18; 89:12). Загас нь мөн бидэнд сайн.

Үр тариа бидэнд сайн. Ялангуяа улаан буудай бидэнд маш сайн.

- Эдгээр зүйлсийг хэрэглэх нь биднийг хэрхэн адисалдаг вэ?

### **Ажил, амралт, дасгал хөдөлгөөн чухал ач холбогдолтой**

- Их Эзэний эрүүл мэндийн хуулинд ажил, амралт, дасгал хөдөлгөөн нь ямар хамааралтай вэ?

Сургаал ба Гэрээ 89 дээр нэмэлт болгон бусад судрууд хэрхэн эрүүл байх тухай бидэнд хэлдэг. Тэд бидэнд “залхуу байхаа болигтун; цэвэр ариун биш байхаа боль, шаардлагатайгаас илүү удаан унтахаа боль; та нар ядрахгүй байхын тулд; эрт босч бай, та нарын бие хийгээд оюун чинь амарч болохын тулд орондоо эрт орж бай” (С ба Г 88:124). Бидэнд мөн “Зургаан өдөр хөдөлмөрлөж, бүх ажлаа хий” гэж хэлсэн (Египетээс гарсан нь 20:9).



Их Эзэн бидэнд өөрийн хүч чадлаас илүүгээр бүү ажилла хэмээн зөвлөсөн (С ба Г 10:4).

Хожмын үеийн бошиглогч бидэнд биеийг эрүүл чийрэг байлгах ёстой хэмээн хэлсэн байдаг. Бошиглогч бидэнд “Тэжээллэг хоол хүнс, тогтмол дасгал хийж, зөв унтаж амрах нь яг л бодол санаа ба сүнснийг хүчирхэгжүүлдэг тогтвортой судраас судлах болон залбиралтай адил эрүүл чийрэг бие махбодтой байхад шаардлагатай” гэж зөвлөсөн (Томас С. Монсон Ерөнхий Чуулган, 1990 оны 10-р сар, 60; эсвэл *Ensign*, 1990 оны 11-р сар, 46).

### **Их Эзэний Эрүүл мэндийн хуулийн дагуу амьдарснаар ирэх амлагдсан адислалууд**

- Мэргэн ухааны үгийг сахиснаар бид ямар адислалуудыг хүлээн авах вэ?

Тэнгэрлэг Эцэг минь бидэнд биеэ халамжлан авч явахыг заасан эрүүл мэндийн хуулийг өгсөн. Судрууд бидэнд Бурханы хуулийн талаар заадаг. Үүнд: “Гэвч би түүнд цаг зуурын зарлиг өгсөн нь үгүй, учир нь миний зарлигууд сүнслэг болой” гэжээ (С ба Г 29:35). Энэ нь бидний бие махбодийн болон сүнслэг байдлын сайн сайхны төлөө өгөгдсөн болохыг хэлж байна.

Бид Их Эзэний эрүүл мэндийн хуулийг сахиж Түүний бусад зарлигуудад дуулгавартай байх аваас Их Эзэн биднийг биеийн болон сүнслэг байдлаар адислахаа амласан.

Бидний биеийн байдал сайн эрүүл энх байна хэмээн бидэнд амласан. Энэ сайн эрүүл мэндийн үр дүн болж бид “мөн гүйхэд мөн ядрах нь үгүй, мөн алхахад мөн цуцах нь үгүй” байх болно (С ба Г 89:20). Энэ бол агуу адислал. Харин Түүний бидэнд амласан сүнслэг адислалууд нь биеийн адислалаас илүү агуу юм.

Их Эзэн бидэнд “мэргэн ухаан хийгээд мэдлэгийн агуу сан хөмрөгүүдийг, бүр нуугдмал сан хөмрөгүүдийг олж авах болно” гэж амалсан (С ба Г 89:19). Бид Ариун Сүнсний илчлэлтээр дамжуулан үнэний чухал ач холбогдодлыг сурах болно. Ерөнхийлөгч Бойд К.Пакер заахдаа: “Бие махбодь маань бидний сүнсний багаж зэмсэг юм. Энэ гайхамшигтай илчлэлт болох Мэргэн

ухааны үг нь биднийг бие махбодио сүнслэг харилцаа холбоотой бие махбодийн торгомсог нарийн мэдрэмжүүдийг маань зогсонги болгож бүр магадгүй устгаж ч болох бохир заваанаас хэрхэн ангид байлгахыг хэлж өгсөн. Мэргэн ухааны үг нь хувийн илчлэлтийн гол түлхүүр мөн” (Conference Report, 1989 оны 10-р сар, 16; эсвэл 1989 оны 11-р сарын *Ensign*, сэтгүүл).

Их Эзэн мөн устгагч тэнгэр элч бидний дээгүүр өнгөрөн явах болно гэдгийг амласан. Ерөнхийлөгч Хебер Ж. Грант хэлэхдээ “Хэрэв бид амьдралын, эрүүл мэндийн, бие болон ухаан бодлын хүч тэнхээтэй байх адислалуудыг хүсч байвал, хэрэв бид эртний Израилын хүүхдүүдийн өдрүүдэд Түүний хийсний адил устгагч тэнгэр элч бидний дээгүүр өнгөрөн явахыг хүсч байвал Мэргэн ухааны үгийг дуулгавартай сахисан цагт Бурхан үргэлж бидэнтэй байж, бидний дээр адислалууд ирэх болно” (*Teachings of Presidents of the Church: Хебер Ж. Грант* [2002], 192).

- Мэргэн ухааны үгийн мөнхийн ач холбогдлыг хүүхэд залуучууд ойлгож мэдэхэд бид хэрхэн тусалж чадах вэ?
- Мэргэн ухааны үгийг сахихад хүндрэлтэй байгаа гэр бүлийн гишүүд эсвэл найз нөхдөдөө бид хэрхэн тусалж чадах вэ?

### Нэмэлт судрууд

- Шүүгчид 13:13–14; Сургаалт үгс 20:1; Исаиа 5:11–12; Даниел 1 (хатуу ундаанаас зайлсхий)
- С ба Г 59:16–20 (дэлхий дээрх юмс хүмүүний тусын тулд)
- Сургаалт үгс 23:20–21 (дарс уух, ховдоглон идэх, залхуурахын эсрэг анхааруулга)
- С ба Г 136:24 (согтуурахыг зогсоо)



# ЭНЭРЭЛ

Бүлэг 30

---

## **Энэрэл гэж юу вэ?**

- Та нар энэрлийг хэрхэн тодорхойлох вэ?

Аврагчийн амьдрал бүх хүмүүсийн төлөөх Түүний цэвэр хайрыг харуулдаг. Тэр бүр Өөрийн амийг бидний төлөө өгсөн. Энэрэл бол Аврагч Есүс Христэд байдаг цэвэр хайр юм. Тэр бидэнд Түүний адил бусдыг хайрлахыг зарлигласан. Судрууд бидэнд энэрэл нь цэвэр зүрхнээс ирдэг гэдгийг хэлдэг (1 Тимот 1:5). Өөрсдийн бүх ах, эгч нарын төлөө үнэн зүрх сэтгэлээсээ бодитоор санаа тавьж, өрөвдөн энэрэх аваас бидэнд цэвэр хайр байх болно.

## **Энэрэл бол бүх шударга журамт ёсны хамгийн агуу нь**

Бошиглогч Мормон бидэнд “энэрэл хэзээ ч дуусдаггүй; иймийн тул, бүхнээс илүү агуу тэрхүү энэрлээс зууран барь, учир нь бүх зүйл дуусах ёстой, гэвч энэрэл бол Христийн цэвэр хайр, мөн энэ нь үүрд үл цөхрөх ажгуу” гэж хэлсэн (Моронай 7:46–47; мөн 1 Коринт 13; 2 Нифай 26:30; Моронай 7:44–45, 48).

Бидний дагах ёстой амьдралын жишээг Аврагч бидэнд өгсөн. Тэр Бурханы Хүү байсан. Тэр төгс хайраар хайрладаг бөгөөд хэрхэн хайрлахыг Тэр бидэнд харуулсан. Үлгэр жишээгээрээ бидний ойр дотныхон, найз нөхдийн маань сүнсний болон биеийн хэрэгцээнүүд нь биднийхтэй адил чухал ач холбогдолтой гэдгийг Тэр бидэнд үзүүлсэн. Тэр Өөрийн амийг бидний төлөө өгөхийн өмнө хэлэхдээ:

“Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагтун. Энэ бол миний тушаал.

Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас өөр агуу хайр байхгүй” (Иохан 15:12–13).

---

Моронай Их Эзэнд хандан:

“Та дэлхийнхэнд хайртай, бүр өөрийн амийг дэлхийнхний төлөө өгөх хүртлээ, хүмүүний үрсэд нэгэн байрыг бэлтгэхийн тулд үүнийг эргүүлж авна хэмээн хэлснийг тань би санаж байна. . . .

“Мөн эдүгээ хүмүүний үрсэд зориулсан таны хайр бол энэрэл гэдгийг би мэднэ; иймийн тул, хүмүүс энэрэлтэй байхаас бусдаар, Эцэгийнхээ эзэмшлүүдэд таны бэлтгэсэн тэрхүү байрыг өвлөж чадахгүй” (Ифер 12:33–34).

Бид өөрсдийнхөө амийг Аврагчийн адил зориулах шаардлагагүй. Хэрэв бид Түүнийг амьдралынхаа төвөө болгон Түүний үлгэр жишээ, сургаалуудыг дагах юм бол бид энэрэлтэй байж чадна. Аврагчтай адил бид мөн энэ дэлхий дээрх ах эгч нарынхаа амьдралыг адислаж чадна.

- Яагаад энэрэл хамаг шударга ёсны хамгийн агуу нь вэ?

### **Өвчтэй, шоовдорлогдсон, ядуу зүдүү хүмүүст өгөх нь энэрэл юм**

Аврагч бидэнд түүх эсвэл сургаалт үлгэрүүдээр олон сургаалыг заасан. Сайн Самари хүний тухай сургаалт үлгэр гачигдалтай байгаа тэдэнд бидний найз байна уу үгүй юу хамаагүй тусламж өгөх ёстой гэдгийг бидэнд заадаг (Лук 10:30–37; мөн Жэймс И. Талмэйж, *Jesus the Christ*, 3-р хэвлэл. [1916], 430–32). Аврагч сургаалт үлгэрт хэлэхдээ, нэгэн эр өөр хот уруу явж байжээ. Замд нь түүн уруу дээрэмчид дайрсан аж. Тэд түүний хувцас, мөнгийг дээрэмдэн, түүнийг зодож, дөнгөж амьтай төдий болгон орхижээ. Нэгэн прист түүнийг хараад, хажуугаар нь өнгөрөн явав. Дараа нь нэгэн Леви хүн түүнийг харсан ч өнгөрөн одов. Харин Иудейчүүдийн үзэн яддаг нэгэн Самари хүн дэргэд нь ирээд түүнийг харангуутаа, өрөвдөн энэрэх сэтгэл түүнд төржээ. Түүний дэргэд өвдөглөн сайн Самари хүн түүний шархыг боож, илжгэн дээрээ тавин, буудлын зүг явав. Тэр буудлын эзэнд түүнийг эргэн иртэл тэр хүнийг асран халамжилж байхыг захин мөнгө төлөв.

Бид өлсгөлөнд хоол хүнс, оромжгүй нэгэнд орон гэрийг, ядууст хувцас өгөх ёстойг Есүс бидэнд заасан. Бид өвчтэй болон шоронд байгаа тэднийг эргэн тойрох аваас эдгээр зүйлсийг Түүнд хийсэнтэй адил юм. Бид эдгээрийг хийх аваас Түүний хаант улсыг өвлөн авах болно гэдгийг Тэр амласан (Матай 25:34–46).

Хэн нэгэнд бидний тусламж аргагүй хэрэгтэй байна уу үгүй юу гэдгийг бид заавал шийдэх гэсний хэрэгтэй (Мозая 4:16–24). Эхлээд гэр бүлийнхнийгээ асран халамжлаад, дараа нь тусламж хэрэгтэй байгаа нэгэнд туслах хэрэгтэй. Ийм замаар бид бороог сайн, муу аль хүмүүсийн дээр оруулагч Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болох болно (Матай 5:44–45).

Ерөнхийлөгч Томас С.Монсон материаллаг хэрэгцээнээс илүүтэйгээр тусламж хэрэгтэй олон хүн байгааг бидэнд сануулсан.

“Өөрсдөөсөө ‘Өнөөгийн дэлхийд миний хийсэн сайн зүйл юу вэ?’ гэж асууцгаана уу. Гачигдалд байгаа хэн нэгэнд би тусалсан бил үү? [Сүмийн дуулал, 223-р дуу]. Аз жаргалын томьёо нь юу вэ! Энэ нь ямар сайхан жор гээч хүмүүний дотоод сэтгэлийг амар амгалан болгож, өөр нэгэнд сэтгэл хангалуун байдлыг өгдөг.

“Өөрсдийгөө өгөх бидний боломжууд нь хязгааргүй ч хурдан мууддаг. Баярлуулах зүрх олон байна. Хэлэх эелдэг зөөлөн үгс зөндөө байна. Өгөх бэлгүүд дүүрэн байна. Хийх ёстой үйл хэрэг ч их байна. Аврах бодгалиуд дүүрэн байна (2001 оны 10-р сарын Ерөнхий Чуулган, 72; эсвэл *Ensign*, 2001 оны 11-р сар, 60).

- Сайн Самари хүний тухай сургаалт үлгэрт гарсан гэмтсэн хүнийг хажуугаар өнгөрөн явдаг тэдгээрийг та нар хэрхэн тайлбарлах вэ? Самари хүнийг та нар хэрхэн дүрслэх вэ? Энэ сургаалт үлгэрт заах захиасыг амьдралдаа ямар арга замаар хэрхэн хэрэгжүүлэх вэ?

### **Энэрэл зүрх сэтгэлээс ирдэг**

- Өөрсдийн нүгэл, алдаануудаа үл хайхрах хүмүүсийг бид хэрхэн хайрлах вэ?

Гачигдалтай тэдэнд бид өгсөн ч тэднийг хайрлах сэтгэл гаргахгүй юм бол бидэнд энэрэл гэж байхгүйтэй адил (1 Иохан 3:16–17). Бидэнд энэрэл байхад бүх хүмүүсийн төлөө сайхан мэдрэмжтэй байдаг хэмээн Төлөөлөгч Паул бидэнд заасан. Бид тэвчээртэй, нинжин сэтгэлтэй. Бид сагсуу, бардам, амиа хичээсэн бүдүүлэг нэгэн биш. Бидэнд энэрэлтэй бусдын хийсэн хилэнцийг санадаггүй мөн түүнд нь баясдаггүй. Харин ч бид сайн зүйлсийг хийдэг. Учир нь энэ нь зөвхөн бидний давуу чанар юм. Харин бид үнэнээр амьдардаг хүмүүний баяр баясгаланг хуваалцдаг. Бид энэрэлтэй байснаар үнэнч шударга, бусдын сайн сайханд итгэж, элэгсэг хандадаг. Судрууд “энэрэл хэзээ ч мөхөхгүй” хэмээн заадаг (1 Коринт 13:4–8).

Аврагч бидэнд бусдын төлөө үйлчлэх үлгэр жишээг үзүүлсэн. Тэр ёс бус явдлыг үзэн яддаг ч нүгэлтнүүдийг Тэр хайрладаг. Тэр хүүхэд, хөгшид, ядуус болон гачигдагсдад нигүүслийг үзүүлсэн. Түүнд үнэхээр агуу хайр байсан учраас Түүний гар болон хөл рүү хадаас хадаж байсан цэргүүдийг уучлахыг Тэнгэрлэг Эцэгээсээ Тэр гуйсан (Лук 23:34). Тэр бидэнд хэрэв бид бусдыг уучлахгүй аваас Тэнгэрлэг Эцэг биднийг мөн уучлахгүй гэдгийг бидэнд заасан (Матай 18:33–35). Тэр хэлэхдээ: “Харин Би та нарт хэлье. Дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир. . . . Хэрэв та нар өөрсдийг чинь хайрладаг хүмүүсийг хайрлавал, та нарт ямар шагнал байх вэ? Татвар хураагчид ч хүртэл үүнтэй адилыг хийдэг бус уу?” (Матай 5:44, 46). Бид Есүстэй адил бусдын төлөө байхыг суралцах ёстой.

### **Энэрлийн ариун журмыг хөгжүүлэх нь**

- Хэрхэн бид илүү энэрэнгүй болох вэ?

Бид энэрэнгүй болох замын нэг бол Есүс Христийн амьдралыг судалж, Түүний зарлигуудыг сахих явдал мөн. Тодорхой нөхцөл

---

**Багш нарт зориулж:** “Энэрлийн ариун журмыг хөгжүүлэх нь” сэдвийн дор эхний дөрвөн догол мөр бид хэрхэн илүү энэрэнгүй болох талаар заадаг. Хэрэв боломжтой бол ангийн болон гэр бүлийн гишүүдийг дөрвөн баг болгон хуваа. Баг бүрд нэг догол мөрийг өгч, хүн нэг бүр уншихыг хүс. Оролцогсдыг тус бүрдээ авсан хэсгийг суралцахыг хүс. Тэднийг энэрэнгүй болох замыг үзүүлсэн өөрсдийн мэдэх эсвэл судар дээр гардаг хүмүүсийн жишээнүүдийн талаар бодохыг хүс. Дараа нь багийнхантайгаа жишээг хуваалцахыг хүс.

байдлуудад Есүс юу хийснийг судалж болно. Түүнтэй ижил зүйлийг бид хийж чадна.

Хоёрдугаарт, бид энэрэнгүй бус байхдаа агуу энэрлийг хүсэн залбирч болно. Мормон “та нар түүний Хүү, Есүс Христийн үнэн дагалдагчид бүгдийн дээр цутгасан хайраар [энэрлээр] дүүргэгдэж болохын төлөө зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирагтун” хэмээн бидэнд уриалдаг (Моронай 7:48).

Гуравдугаарт, бид өөрсдийгөө хайрлахыг суралцаж чадна. Энэ нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд болох өөрсдийн үнэн үнэ цэнийг ойлгоно гэсэн үг. Өөрсдийгөө хайрладаг шиг бусдыг хайрла хэмээн Аврагч бидэнд заасан (Матай 22:39). Өөрсдийгөө хайрлахын тулд бид өөрийгөө хүндэтгэж, өөртөө итгэх хэрэгтэй. Энэ нь бид сайн мэдээний зарчмуудад дуулгавартай байна гэсэн үг мөн. Бид буруу үйлдлийнхээ төлөө наманчлах хэрэгтэй. Бид наманчилсан үедээ өөрсдийгөө уучлах хэрэгтэй. Бидэнд Аврагч үнэнээсээ хайртай гэдгийг гүнзгийгээр мэдэрч, тайтгарлыг олсон үед бид өөрсдийгөө хайрлах болно.

Дөрөвдүгээрт, өөрийгөө бусдаас дээгүүрт тавихаас зайлсхийж чадна. Бид бусдын алдаанд тэвчээртэй байж чадна. Иосеф Смит хэлэхдээ, “Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ ойртох тусам бодгалийг шийтгэлийн нүдээр бус энэрэнгүйгээр харж эхэлдэг. Бид тэдний нүглүүдийг өөрсдийн мөрөн дээр авч, түүнийг нь мартахыг хүсдэг” (*Teachings of Presidents of the Church: Иосеф Смит* [2007], 428–29).

Мормоны Номонд нүглүүд нь уучлагдсан гэдгийг мэдэхийг хүссэн залуу эр Иносын тухай бид уншдаг. Тэр бидэнд:

“Мөн бодгаль минь өлссөн байв; мөн намайг Бий Болгогчийн өмнө сөхөрсөн би, мөн хүчит залбирлаар мөн бодгалийнхаа төлөө гйултаар түүнээс гуйв; мөн бүхэл өдрийн турш би түүнээс гуйв; тийм ээ, мөн шөнө ирэхэд би дуугаа өндөрсгөн үргэлжлүүлсээр байсан учир энэ нь тэнгэрт хүрсэн бөлгөө.

“Мөн тэгтэл нэгэн дуу хоолой надад ирж, өгүүлсэн нь: Инос нүглүүд чинь өршөөгдсөн, мөн чи адислагдах болно хэмээв” гэж хэлсэн (Инос 1:4–5).



Их Эзэн Иност түүний Христэд итгэх итгэлийн учир түүний нүглүүд уучлагдсан гэдгийг тайлбарласан. Инос эдгээр үгсийг сонсоод өөртөө санаа зовохоо больсон. Тэр Их Эзэн түүнд хайртай бөгөөд түүнийг адисална гэдгийг мэдсэн. Тэр өөрийн найз нөхөд, хамаатан садан, Нифайчуудад халамжийг үзүүлэх талаар санаа тавьж эхэлсэн. Тэдний төлөө Бурханд хандан өөрийн бүх хүчээр залбирсан. Тэд өөрсдийн итгэлийн дагуу тэдэнд өгсөн зарлигуудыг сахиснаар адислагдах болно гэдгийг Их Эзэн түүнд хэлсэн. Эдгээр үгсийн дараа удалгүй Иносын хайр улам ихсэж, тэр Нифайчуудын дайсан болох Лэмэнчүүдийн төлөө маш ихээр санаа зовон залбирсан. Их Эзэн түүний хүслийг хүлээн зөвшөөрсөн ба тэр өөрийн үлдсэн амьдралыг Нифайчууд болон Лэмэнчүүдийн бодгалийг аврахын төлөө хичээн зүтгэсээр байсан (Инос 1:6–26).

Инос Их Эзэний хайр ба өршөөлд маш их талархалтай байсан тул бусад хүмүүс түүнтэй адил бэлгийг хүлээн авахад туслахын төлөө сайн дараар өөрийн үлдсэн амьдралыг зориулсан. Инос үнэхээр энэрэнгүй болсон байв. Бид ч түүнтэй адил зүйлийг хийж чадна. Эцэгийн хаант улсад бидэнд зориулан бэлтгэсэн байрыг өвлөн авахын тулд бид үүнийг хийх хэрэгтэй.

### **Нэмэлт судрууд**

- Колоссай 3:12–14 (энэрэл нь төгс байдлын баталгаа)
- Алма 34:28–29 (хэрэв бид энэрэлтэйгээр үйлдэхгүй бол бидний залбирал дэмий хоосон)
- 1 Коринт 12:29–13:3 (энэрлийн тодорхойлолт)
- С ба Г 121:45–46 (бүх хүмүүсийн төлөө энэрлээр дүүрэн байцгаая)

# Шударга ёс

Бүлэг 31

---

## Шударга ёс нь Авралын зарчим

- Хэрэв хүн бүхэн шударга байсан бол нийгэм маань ямар байх байсан бэ?

Итгэлийн тунхагийн 13 дээр “Бид шударга ёсонд итгэдэг” гэсэн байдаг. Мормоны Ном бидэнд “тэд түүнчлэн Бурханд хандсан, мөн хүмүүст хандсан өөрсдийн хичээл зүтгэлээр онцгойлогдсон байв; учир нь тэд бүх зүйлд төгс шударга мөн зөв шулуун байв; мөн тэд Христэд итгэх итгэлдээ бүр эцсээ хүртэл гуйвшгүй” байсан бүлэг хүмүүсийн талаар хэлдэг (Алма 27:27). Тэдний шударга байдлын тул хүмүүс нөхдөдөө болон Бурханаар дурсагдан сайн мэдэгдэх болжээ. Энэ нь шударга ёс юу болох, бид хэрхэн шударга бус байдалд уруу татагддаг мөн бид энэ уруу таталтыг даван дийлэх талаар суралцахад чухал ач холбогдолтой.

Бидний авралд бүрэн төгс шударга ёс хэрэгтэй. Ерөнхийлөгч Бригам Янг хэлэхдээ, “Бидэнд өгөгдсөн байдлаар нь авралыг хүлээн авахын тулд бид бодолдоо, эргэцүүлэлдээ, бясалгалдаа, өөрсдийн хувийн харьцаандаа, үйл хэрэгтээ, өөрсдийн тунхаглалдаа мөн амьдралын үйлдэл бүрдээ шударга байх хэрэгтэй” гэсэн (*Teachings of Presidents of the Church: Бригам Янг* [1997], 293).

Бурхан бүх зүйлд шударга байдаг (Алма 7:20). Бид бас Түүнтэй адил болохын тулд бүх зүйлд шударга байх ёстой. Жаредын ах “Тийм ээ, Их Эзэн, та үнэн Бурхан болохыг, мөн худал хэлж эс чадахыг би мэднэ” гэж гэрчилсэн (Ифер 3:12). Үүний эсрэгээр хилэнцэт бол худалч. Тэр худалч хуурмагийн эцэг (2 Нифай 9:9). Худлаа ярьж, мэхлэн хуурах мөн гуйвуулагчид байхыг сонгосон тэдгээр нь түүний боол болдог (Марк И. Петерсен, 1971 оны 10р сарын Ерөнхий Чуулган, 65; эсвэл *Ensign*, 1971 оны 12-р сар, 73).

---



Шударга хүмүүс үнэн ба шударга ёсонд дуртай. Тэд үг ба үйлдлээрээ шударга байдаг. Тэд худал хэлдэггүй, хулгай хийдэггүй мөн залилан мэхэлдэггүй.

### **Худал хэлэх нь шударга бус**

Худал хэлэх нь бусдыг санаатайгаар хууран мэхэлж байсан гэсэн үг юм. Буруу гэрчлэлийг хуваалцах нь худал хэлэх нэг хэлбэр мөн. “Чи хөршийнхөө эсрэг худал бүү гэрчил” хэмээх зарлигийг Израилын хүүхдүүдэд Их Эзэн өгсөн (Египетээс гарсан нь 20:16). Есүс мөн дэлхий дээр байхдаа үүнийг заасан (Матай 19:18). Худлаа хэлэх олон хэлбэрүүд байдаг. Бид үнэн бус зүйлийг ярихдаа худлаа ярьсны буруутан болдог. Бид мөн зөвхөн хэсэгхэн үнэнийг хэлж эсвэл чимээгүй байж, дохио зангаа юм уу харцаараа санаатайгаар бусдыг залилан мэхэлж болно. Ямар ч байдлаар бай хэн нэгнийг бид үнэн биш зүйлд итгүүлэхээр зүтгэх аваас бид шударга бус байна гэсэн үг.

Их Эзэн ийм шударга бус зүйлд дургүй. Бид өөрсдийн худал хуурмагийн төлөө төлөөсийг төлөх болно. Сатан бидэнд худлаа хэлэх нь муу зүйл биш гэж итгүүлэхийг хүсэх болно. Тэр “бяцхан худал хэл үүнд хор хөнөөл гэж үгүй” гэж хэлдэг (2 Нифай 28:8). Сатан худал хэлснээ өөрсдөөр маань батлуулахыг ятган өөгшүүлдэг. Шударга хүмүүс сатаны уруу таталтыг мэдэх болно. Хэдий бэрхшээлтэй байсан ч тэд бүх үнэнийг ярьдаг.

### **Хулгай хийх нь шударга бус**

Есүс “Чи бүү хулгайл” гэж заасан (Матай 19:18). Хулгай хийх гэдэг нь бусдын ямар нэгэн юмыг асуулгүйгээр авахыг хэлнэ. Хэн нэгний юмыг авах эсвэл хадгалах эсвэл зөвшөөрөлгүйгээр нийгэмлэгтээ авах нь хулгай хийж байна гэсэн үг. Хамтран ажиллагсдын бараа таваар, эд зүйлсийг авах нь хулгай. Дуу хөгжим, кино, зураг хуулбарлах эсвэл хэвлэх эрхийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бичих нь шударга бус бөгөөд энэ нь хулгайн нэг

---

**Багш нарт зориулж:** Энэ бүлэг нь шударга бус байх: худал хэлэх, хулгай хийх, залилах гэсэн гурван хэлбэрийг тайлбарласан. Та нар ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг гурван баг болгож болох юм. Баг бүрт гурван хэсгийг нэг нэгээр нь өг. Хүн нэг бүрийг өөрсдийн авсан хэсгийг дор бүрнээ уншиж, хэсэгт тайлбарласан шударга бус ёсны хэлбэрийн талаар бодож үзэхийг хүс. Дараа нь ангид юм уу гэр бүлдээ хамтдаа хэсгүүдийг хэлэлцэн ярилц. Тайлбарласан нөхцөл байдал бүрд бид хэрхэн шударга байж болохыг асуу.

хэлбэр. Хэн нэгнээс авах ёстойгоосоо илүү мөнгөний хариулт эсвэл илүү бараа авах нь шударга бус. Авах ёстой зүйлээсээ илүүг хэн нэгнээс авах аливаа нэгэн хэлбэр нь хулгай юм.

### **Залилах нь шударга бус**

Зохих ёсоор үнэлэгдэх ямар нэгэн зүйлийг авах эсвэл өгөх ёстой зүйлээсээ дутуу өгөх нь залилан хийж байна гэсэн үг. Зарим ажилчид ажиллах ёстой цагаараа ажиллаагүй мөртлөө бүрэн ажилласан цагаар төлбөрийг авч ажил олгогчоо залилдаг. Зарим ажилд олгогчид ажилчиддаа төлөх ёстой төлбөрийг бүрэн өгөхгүй шударга бус байдаг. Сатан “өөр нэгнийг түүний үгсийнх нь учир далимдуул, хөршүүддээ нүх малт” гэж хэлдэг (2 Нифай 28:8). Зөв бус зүйлийг авч далимдуулах нь шударга бус байдлын нэгэн хэлбэр мөн. Муухан үйлчлэл эсвэл муу бараа таваар өгөх нь залилан мөн.

### **Өөрсдийн шударга бус байдлыг уучлах ёсгүй**

- Бид шударга бус байдлыг уучлан өнгөрөөхөд бидний сүнслэг байдал ямар болох вэ?

Хүмүүс шударга бус байдлыг олон янзаар уучилдаг. Хүмүүс өөрсдийгөө хамгаалах мөн бусад хүмүүс тэдний талаар сайн сайхнаар бодоосой гэсэндээ тэд худлаа ярьдаг. Зарим хүмүүс авах ёстой зүйлээ авсан, буцаагаад өгчихнө гэж бодоод эсвэл эзэмшигчээс нь илүү надад хэрэгтэй гэж үзэн хулгай хийснээ уучилдаг. Зарим нь сургуульдаа сайн дүн авахын тулд эсвэл “хүн бүхэн ингэж байна” эсвэл даагаа нэхсэн гэж үзэн залилан хийдэг.

Эдгээр болон бусад олон уучлалтууд шударга бус байхыг өөгшүүлэх шалтгаан болдог. Шударга бус байдлыг хүлээн зөвшөөрөх ямар ч шалтгаан байхгүй хэмээн Их Эзэн хэлсэн. Өөрсдийгөө уучилж, өөрсдийгөө залилах нь Бурханы Сүнс бидэнтэй байхыг зогсоодог. Бид улам бүр шударга бус болдог.

## Бид бүрэн төгс шударга байж чадна

- Бүрэн шударга байна гэдэг юу гэсэн үг вэ?

Бид бүрэн төгс шударга болохын тулд амьдралаа анхаарал-тайгаар ажиглах хэрэгтэй. Хэрэв бид жижиг зүйл дээр ч болов шударга бус байсан бол даруйхан наманчлах хэрэгтэй.

Бид бүрэн төгс шударга байхад бид уруу таталтанд орохгүй. Бид тэр бүү хэл энэ нь биднээс мөнгөн зардал гаргах шаардлагатай байсан ч, найз нөхөд эсвэл амь амьдралын үнэтэй байсан ч итгэл, үүрэг, хэлэлцээр эсвэл гэрээндээ үнэнч байх ёстой. Дараа нь бид Их Эзэн, өөртэйгөө, бусадтай ичих зүйлгүй нүүр тулж чадна. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит “Хүн бүрийн амьдрал ямар нэгэн зүйлээс жихүүрхэх юм уу ичих зүйлгүй түүний нэр хүнд ямар ч хүнд шалгалтыг хүлээн авч, өнгөрөөх чадвартай байж, энэ нь яг л дэлгэсэн ном шиг харагдаж байх болтугай” (*Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл. [1939], 252).

- Ямар замаар бидний шударга болон шударга бус байдал нь бид ямар мэдрэмжтэй байхад хэрхэн нөлөөлдөг вэ?

## Нэмэлт судрууд

- С ба Г 50:17 (зөвхөн үнэний сүнсээр ярь)
- С ба Г 76:103–6 (худал хэлэгчдийн зориулалт)
- С ба Г 42:27 (хөршүүдийнхээ талаар хилэнцгийг үл ярих зарлиг)
- Египетээс гарсан нь 20:15–16 (буруу гэрчлэл болон хулгай хийхгүй байх зарлиг)
- С ба Г 42:20, 84–85; 59:6 (хулгай хийхэд хүртэх шийтгэл)
- С ба Г 3:2 (Бурхан бол шударга)
- С ба Г 10:25–28 (сатан мэхэлдэг)



# Аравны нэг ба өргөлүүд

Бүлэг 32

---

## **Аравны нэг ба өргөлүүдээ төлөх нь**

- Бидний чин хүсэлтэйгээр төлөх аравны нэг ба мацгийн өргөл нь Түүний бидэнд өгсөн адислалуудынх нь төлөөх бидний талархлыг Тэнгэрлэг Эцэгт хэрхэн харуулдаг вэ?

Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд амьдрахад бэлтгэхэд маань туслах бүхий л арга замуудыг зарлигуудаар бидэнд өгсөн. Тэр бидэнд адислалуудынхаа төлөө Түүнд талархах арга замыг өгсөн. Чин хүсэлтэйгээр аравны нэг ба мацгийн өргөлөө төлөх нь Түүнд талархах нэг арга зам юм. Эдгээр өргөлүүдийг төлснөөр бид Түүнд хайртай бөгөөд Түүний зөвлөгөөнд дуулгавартай гэдгээ харуулж байгаа хэрэг юм.

- Аравны нэг ба мацгийн өргөлөө төлөх нь Тэнгэрлэг Эцэгтээ талархлаа илэрхийлэхэд бидэнд хэрхэн тусалдаг вэ?

## **Аравны нэгийн хуулинд дуулгавартай байх нь**

- Шударгаар аравны нэг төлөх гэдэг юу гэсэн үг вэ?

Эрт үеэс Абрахам Иакоб нар орлогынхоо аравны нэгийг төлөх зарлигт дуулгавартай байсан (Еврей 7:1–10; Эхлэл 14:19–20; 28:20–22).

Орчин үед Бошиглогч Иосеф Смит “Ай Их Эзэн минь, Аравны нэгийн тул та өөрийн хүмүүсийн өмч хөрөнгөнөөс хичнээнийг шаардахыг өөрийн үйлчлэгчид үзүүлнэ үү” хэмээн залбирсан (С ба Г 119, хэсгийн тайлбар). Их Эзэн хариулахдаа: “Мөн энэ

---

**Багш нарт зориулж:** Хэсгийн эхэнд байгаа асуултуудыг ашиглан ярилцлагыг эхлүүл. Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг номноос дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүс. Хэсгийн төгсгөл дэх асуултуудыг ашиглан суралцсан зүйлсийнхээ талаар тунгаан бодож амьдралдаа хэрэгжүүлэх талаар ярилцахад нь ангийн болон гэр бүлийн гишүүддээ тусал.



нь миний хүмүүсийн аравны нэгийн эхлэл болой. Мөн үүний дараа, ийнхүү аравны нэгийг төлөх тэд жил тутмын ашгийнхаа аравны нэг хэсгийг төлөх ёстой; мөн энэ нь миний ариун санваарын тулд тэдэнд үүрд үйлчлэх хууль байх ёстой” хэмээдэг (С ба Г 119:3–4). Тэргүүн Зөвлөл үүнийг “жил тутмын бүх орлогын аравны нэг” буюу бидний орлоготой хамаатай хэмээн тайлбарласан (Тэргүүн Зөвлөлийн захидал, 1970 оны 3-р сарын 19).

Бид аравны нэгээ төлснөөр Их Эзэндээ итгэлээ харуулдаг. Мөн хүүхдүүддээ энэ хуулийн үнэ цэнийг заадаг. Тэд бидний үлгэр жишээг дагаж, орлогынхоо аравны нэгийг төлөхийг хүсэх болно.

- Аравны нэг нь санхүүгийн зарчим байхаасаа илүүтэйгээр ямар талаараа итгэлийн зарчим болдог вэ?
- Эцэг эхчүүд хүүхдүүддээ аравны нэг төлөх ба түүний чухал ач холбогдлын талаар заахын тулд юу хийж чадах вэ?

### **Бид үргэлж чин хүсэлтэйгээр өгөх ёстой**

- Аравны нэгийг төлөхөд яагаад бидний зан төлөвийн хандлага чухал вэ?

Чин хүсэлтэйгээр төлөх нь маш чухал. “Дурамжхан аравны нэгээ төлөх тэр нь адислалаасаа хулгайлж байгаатай адил юм. Тэр урамтай, бэлэн байдалтай, баяр баясалтай өгөхийг суралцах хэрэгтэй. Тэгсэн үед түүний бэлэг нь адислал болох болно (Stephen L Richards, *The Law of Tithing* [эмхэтгэл, 1983], 8).

Бид хэрхэн өгөх нь юу өгч байгаатай адил чухал хэмээн Төлөөлөгч Паул заасан. Тэр хэлэхдээ, “Хүн бүр зүрхэндээ шийдсэнчлэн дурамжхан бус, албадлага бусаар өгөгтүн. Учир нь Бурхан урамтайгаар өгөгчийг хайрладаг” гэсэн (2 Коринт 9:7).

- “Урамтайгаар өгөгч” гэдэг нь та нарын хувьд юу гэсэн үг вэ?

### **Аравны нэг ба бусад өргөлүүд**

- Аравны нэгийн ба бусад өргөлүүдийг Сүм юунд ашигладаг вэ? Сүмийн гишүүдийн хувьд бид аравны нэг ба бусад өргөлөө Их Эзэнд өгдөг.
-

*Аравны нэг*

Аравны нэгийг Сүм олон зүйлд ашигладаг. Үүнд:

1. Ариун сүмүүд, цуглааны байрууд ба бусад байшин барилгыг барих, засварлаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг хангах.
2. Сүмийн гадас, тойрог ба бусад нэгжүүдийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах санг бүрдүүлэн хангах (Эдгээр нэгжүүд сайн мэдээ заах, олон нийтийн үйл ажиллагаануудыг явуулах зэрэг Сүмийн санваартны үйл ажиллагаануудыг зохион явуулахад ашигладаг).
3. Бүрэн цагийн номлогчийн хөтөлбөрт туслах.
4. Сүмийн сургууль, семинар ба институтэд залуучуудыг хамруулан боловсрол олгоход.
5. Хичээлийн материалуудыг хэвлэх, түгээх.
6. Гэр бүлийн түүх ба ариун сүмийн ажилд туслах.

*Бусад өргөлүүд*

*Мацгийн Өргөл.* Сүмийн гишүүд дараалсан хоёр хоол идэхгүй, юм уухгүй байж, сар бүр мацаг барьдаг. Тэд дор хаяж энэ хоёр хоолонд зарцуулах хэмжээний мөнгийг хандивладаг. Тэд боломжоороо өгөөмрөөр өгдөг. Энэ өргөлийг мацгийн өргөл гэж нэрлэдэг. Бишопууд эдгээр өргөлийг гачигдагсдын хоол хүнс, орон гэр, хувцас хунар ба эмчилгээний зардалд зориулан зарцуулдаг (Энэ номны 25-р бүлгийг үз).

Мацгийн өдөр гишүүд мацаг ба гэрчлэлийн цуглаанд оролцож, Христ ба Түүний сайн мэдээний тухай гэрчлэлээ хуваалцдаг.

*Бусад хандивууд.* Номлогчийн ажил, Тасралтгүй Үргэлжлэх Боловсролын сан, ариун сүм барих ба хүмүүнлэгийн тусламж зэрэг сүмийн бусад үйл ажиллагаануудад гишүүд хандив өргөж болно.

*Үйлчлэл.* Мөн гишүүд цаг зав, авьяас чадвар болон эд бараагаар бусдад тусалдаг. Энэ үйлчлэл нь дэлхий даяарх нийгэмлэг, үндэстэн, ялангуяа олон улсын хэмжээнд байгалийн гамшиг

болох үед гачигдалтай сүмийн гишүүд болон гишүүн бус хүмүүст сүмээс туслах боломжийг олгодог.

### **Бид аравны нэг ба бусад өргөлүүдийг өгснөөр адислагддаг**

Их Эзэн биднийг итгэлтэйгээр аравны нэг ба мацгийн өргөлөө өгвөл адисална хэмээн амласан. Тэр хэлэхдээ, “Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга” гэсэн (Малахи 3:10).

Хожмын үеийн илчлэлтэд аравны нэгийг төлөгч тэдгээрт ирэх өөр адислалын талаар хэлсэн байдаг. “Мөн үнэнээр энэ нь золиослолын өдөр, мөн миний хүмүүсийн аравны нэгийг төлүүлэх өдөр бөлгөө, учир нь аравны нэгээ төлдөг тэрээр миний ирэлтээр шатаагдах нь үгүй” (С ба Г 64:23).

Бидэнд амласан адислалууд нь материаллаг болон сүнслэг байдлаар ирдэг. Хэрэв бид өгөөмрөөр өгөх аваас Тэнгэрлэг Эцэг биднийг өдөр тутмын хоол хүнс, хувцас хунар, орон байраар хангаж туслах болно. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Филлиппиний хожмын үеийн гэгээнтнүүдэд хандан ярихдаа хэрэв хүмүүс “сайн мэдээг хүлээн авч, бүр хомс тачирхан байсан ч аравны нэг ба мацгийн өргөлөө төлж сайн мэдээний дагуу амьдрах аваас Их Эзэн тэдний тусын тулд Өөрийн эртний амлалтаа биелүүлэх болно. Мөн тэд аягандаа будаатай, мөрөндөө хувцастай толгой хоргодох байртай байх болно. Би үүнээс өөр шийдлийг харахгүй байна. Тэднийг дэлхийн ямар ч хүчнээс илүүтэйгээр урамшуулан, туслах өөр нэгэн агуу хүч тэдэнд хэрэгтэй” хэмээсэн (“Inspirational Thoughts,” *Ensign*, 1997 оны 8-р сар, 7). Их Эзэн мөн биднийг “Бурханы мэдлэг, гэрчлэл, сайн мэдээгээр амьдрах ба гэр бүлийнхнийгээ яг ижил зүйлийг хийхээр урамшуулан өдөөхөд” мөн өсөн хөгжихөд минь тусалдаг (*Teachings of Presidents of the Church: Heber J. Grant* [2002], 124).

Аравны нэг ба өргөлүүдээ төлдөг хүн агуу ихээр адислагддаг. Дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулахад тусалж байна гэдэг сайхан мэдрэмж тэдэнд төрнө.

- Та болон таны гэр бүлийн гишүүд эсвэл та нарын найз нөхөд аравны нэг ба бусад өргөлүүдээ төлснөөр дамжуулан ирсэн ямар адислалууд байдаг вэ?

### **Нэмэлт судрууд**

- С ба Г 119:1–4 (аравны нэгийн хууль)
- Эхлэл 14:18–20; Алма 13:13–16 (Абрахам аравны нэгээ төлдөг байсан)



# НОМЛОЛЫН АЖИЛ

Бүлэг 33

---

## Их Эзэний Сүм бол Номлогчийн Сүм

- Номлогчийн ажил хэрхэн Бурханы хүүхдүүдийн төлөөх төлөвлөгөөний нэг хэсэг болдог вэ?

Их Эзэн Адамд сайн мэдээний төлөвлөгөөг илчилсэн: “Ийн тунхаглагдсан сайн мэдээ эхлэлээс номлогдож эхлэв” (Мосе 5:58). Хожим нь, Адамын зөв шударга үр удам сайн мэдээг тунхаглахаар илгээгдсэн. “Тэд бүх хүмүүнийг, хаа сайгүй, наманчлахад дууддаг байлаа, мөн итгэл нь хүмүүний үрст заагддаг байв” (Мосе 6:23).

Бүх бошиглогчид номлогч нар байсан. Тэд амьдарч байсан цаг хугацаандаа сайн мэдээг тунхагла хэмээх зарлигийг хүлээн авсан. Санваар дэлхий дээр байсан тэр бүх цаг үеүдэд Их Эзэний хүүхдүүдэд сайн мэдээний мөнхийн зарчмуудыг номлох номлогчид Түүнд хэрэгтэй байсан.

Их Эзэний Сүм үргэлж номлогч сүм байсаар ирсэн. Аврагч дэлхий дээр амьдарч байхдаа Төлөөлөгчид ба Далуудыг томилж, сайн мэдээг номлох эрх мэдэл, үүрэг хариуцлагыг өгсөн. Тэд ихэнх номлолоо өөрсдийн хүмүүс буюу Иудей нарт номлосон (Матай 10:5–6). Есүс амилсныхаа дараа харийнханд сайн мэдээг номлуулахаар Төлөөлөгчдийг илгээсэн. Тэр Төлөөлөгчдөдөө “Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагтун” хэмээн зарлигласан (Марк 16:15).

Төлөөлөгч Паул харийнханд илгээгдсэн агуу номлогчдын нэг байсан. Тэр сүмд хөрвүүлэгдсэнээс хойш үлдсэн амьдралаа сайн мэдээг номлоход зориулсан. Номлол хийх хунацаандаа

---

**Багш нарт зориулж:** Сайн мэдээний зарчмуудыг хуваалцах нь Сүнснийг урьдаг. Та ангийн эсвэл гэр бүлийн зарим гишүүдтэй урьдчилан холбоо тогтоож, бусдад тусалж болох тэдний хувьд онцгой нэгэн тохиолдлоосоо хуваалцахыг хүсч болно.

ташуурдуулан, чулуугаар шидүүлж, шоронд хоригдож байсан. Гэсэн хэдий ч тэр сайн мэдээг номлосоор байсан (Үйлс 23:10–12; 26).

Их Эзэний Сүм Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээгдсэнээр номлолын ажил дахин эхэлсэн. Өнөөдөр сайн мэдээг номлох, энэ нь дэлхий даяар номлогдож байгаа эсэхийг хянах гол үүрэг хариуцлага Төлөөлөгчид ба Далынханд өгөгдсөн байдаг. Их Эзэн Иосеф Смитэд “Миний сайн мэдээг нутгаас нутагт, хотоос хотод тунхагла. Газар бүрд хүн болгонд гэрчлэгтүн” гэж хэлсэн (С ба Г 66:5, 7). 1830 оны 6-р сард Бошиглогчийн ах Самуел Харрисон Смит сүмийн анхны номлогчийн аянаа эхэлсэн.

Тэр үеэс эхлэн нэг сая гаруй номлогч сайн мэдээг номлохоор дуудагдан, газар бүрд илгээгдсэн байна. Тэдний дэлхийд Есүс Христ бол Бурханы Хүү, бидний Аврагч гэсэн мэдээг тунхагладаг юм. Сайн мэдээ дэлхий дээр Бурханы бошиглогчоор дамжуулан сэргээгдсэн гэдгийг тэд гэрчилдэг. Бүх хүмүүст сайн мэдээг номлох, тэднийг усаар батлах, Их Эзэний зарлигласан бүх зүйлсийг хийхийг заах үүрэг номлогчдод өгөгдсөн (Матай 28:19–20). Хожмын үеийн Гэгээнтэн номлогчид өөрсдийн зардлаар сайн мэдээний захиасыг дэлхийн өнцөг булан бүрт номлохоор явдаг.

### **Сайн мэдээ дэлхий дахинд номлогдсон байх болно**

- Их Эзэн бидэнд сайн мэдээг хуваалцах ямар замуудыг бэлтгэсэн бэ?

Хожмын үеийн илчлэлтэд бид сайн мэдээг бүх үндэстэн, бүх хүмүүст өгөх ёстойг хэлсэн байдаг (С ба Г 133:37). Их Эзэн бидэнд түүнийг гүйцэлдүүлэх замыг бэлтгэхгүйгээр ямар ч зарлигийг хэзээ ч өгдөггүй (1 Нифай 3:7). Их Эзэн нэгэн цагт бидний хувьд хаалттай байсан үндэстнүүдэд сайн мэдээг номлох замуудыг бэлтгэсэн. Бид итгэлтэйгээр залбирахаа үргэлжлүүлэх аваас Их Эзэн номлолын ажилд бусад үндэстэнүүдийг нээлттэй болгох болно.

Их Эзэн мөн “энэ дэлхийд урьд өмнө нь хэзээ ч байгаагүйгээр Их Эзэний ажилд тус дэм болох шинэ бүтээл оновчтой саналыг бүтээхээр агуу хүмүүсийн оюун санааг урамшуулан өдөөдөг”(Russell M. Nelson, “Computerized Scriptures Now Available,” *Ensign*, 1988 оны 4-р сар, 73). Сонин, сэтгүүл, радио, телевиз, хиймэл дагуул, компьютер, интернет ба шинэ техник технологийг олон сая хүнд сайн мэдээний захиасыг хүргэхэд туслуулахаар өгсөн. Сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авсан бид эдгээр шинэ нээлт, бүтээлүүдийг “Учир нь, үнэнээр, уг дуу хоолой энэ газраас бүх дэлхийд, мөн дэлхийн хязгааруудад очиж сайн мэдээг хүн болгонд, итгэгч тэднийг дагалддаг тэмдгүүдийн хамт номлогдох ёстой” гэсэн Их Эзэний зарлигийг гүйцэлдүүлэхэд ашиглах хэрэгтэй (С ба Г 58:64).

- Сайн мэдээг хуваалцахад шинэ технологи ямар замаар үр ашигтай хэрэглэгдэхийг та харсан бэ?

### **Номлолын ажил нь чухал ач холбогдогдолтой**

- Сайн мэдээг хүн бүр сонсож, ойлгох нь яагаад чухал вэ?

“Энэ бол Сүмийн хувьд хүмүүний хүүхдүүдийн бодгалийг аврах мөн өргөмжлөх бидний анхны хүсэл сонирхол юм” (Ezra Taft Benson, Conference Report, 1974 оны 4-р сар, 151; эсвэл *Ensign*, 1974 оны 5-р сар, 104). Номлолын ажил нь дэлхийн хүмүүст сайн мэдээг сонсон, хүлээн авах боломж олгоход зайлшгүй шаардлагатай. Тэд үнэнийг суралцаж, өөрсдийгөө Бурханд зориулж, нүглүүдийнхээ уучлалыг хүлээн авах хэрэгтэй.

Дэлхий дээрх бидний олон ах эгч нар хуурамч сургаалуудаар харалган болж мөн “тэд үүнийг хаанаас олохыг мэддэггүйн улмаас гагцхүү үнэнээс хол байдаг” (С ба Г 123:12). Номлолын ажлаар дамжуулан бид хүмүүсийг үнэнд авчирч чадна.

Их Эзэн “сүүлчийн удаа миний талбайд хөдөлмөрлөгтүн та нар, сүүлчийн удаа дэлхийн оршин суугчдыг дууд” хэмээн зарлигласан (С ба Г 43:28). Ах эгч нартаа сайн мэдээг номлосноор бид Аврагчийн хоёр дахь ирэлтэд, замыг нь бэлтгэдэг (С ба Г 34:6).



## Бид бүгд номлогч байх ёстой

- Бусадтай сайн мэдээг хуваалцах боломжуудыг ямар арга замаар идэвхтэй эрэлхийлж чадах вэ? Энэ боломжуудад өөрсдийгөө хэрхэн бэлтгэх вэ?

Сүмийн гишүүн бүр номлогч. Хэдийгээр албан ёсоор номлолд дуудагдан, онцгойлон адислагдаагүй ч гэсэн бид номлогчид байх ёстой. Бид Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүдэд үг ба үйлсээрээ сайн мэдээг заах үүргийг хүлээсэн. Их Эзэн бидэнд “Сэрэмжлүүлэгдсэн хүн болгон хөршөө сэрэмжлүүлэх нь хэрэгтэй болой” гэж хэлсэн (С ба Г 88:81). Бид хөршүүддээ анхааруулахаас өмнө тэднийг хайрлах ёстой гэдгийг бошиглогч бидэнд анхааруулсан (*Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* [2006], 262). Тэд бидний нөхөрсөг, нигүүлсэнгүй харьцааг мэдрэх хэрэгтэй.

Мозаягийн хөвгүүд сайн мэдээг заах үүргээ урам зоригтойгоор хүлээн авсан. Тэд Сүмд хөрвүүлэгдэхдээ зүрх сэтгэлээ бусдын төлөөх нинжин сэтгэлээр дүүргэсэн байсан. Тэд өөрсдийн дайсан Леменчүүдэд “тэд аль ч хүмүүний бодгаль мөхнө гэдгийг тэвчиж үл чадах байсан ажгуу, тийм ээ, бүр ямар нэгэн бодголь төгсгөлгүй тарчлалыг амсана гэдэг чухам тэрхүү бодлууд тэднийг чичирч мөн дагжихад хүргэсэн” тул сайн мэдээг номлохыг хүссэн (Мозая 28:3). Сайн мэдээ бидний амьдралыг баяр баяслаар дүүргэхэд мөн бид ах эгч нарынхаа төлөө яг тийм хайр, нинжин сэтгэлийг мэдэрдэг. Сонсохыг хүссэн хүн бүртэй бид сайн мэдээний захиасыг хуваалцахыг хүсэх болно.

Сайн мэдээг хуваалцах олон арга зам байдаг. Дараах санаануудыг үзнэ үү:

1. Найз нөхөд болон бусдад сайн мэдээний үнэнээр амьдарснаар ирэх баяр баяслыг мэдэрч байгаагаа бид харуулж болно. Ийм замаар бид дэлхийн гэрэл байж болно (Матай 5:16).
2. Бид бусдад сайн зүйлсийг хийж, тэдний найз нөхөд байснаар өөрсдийн унаган ичимхий занг ялан дийлж чадна. Бид

- хувийн ашиг тусын тулд бус үнэн сэтгэлээсээ туслахыг хүсч байгаагаа харуулснаар тэдэнд тусалж чадна.
3. Бид сүмийн гишүүн бус найз нөхөд болон бусад хүмүүст сайн мэдээг тайлбарлаж чадна.
  4. Сайн мэдээний талаар илүү мэдэхийг хүсч байгаа найз нөхдөө гэртээ урьж номлогчидтой уулзуулж болно. Хэрэв гишүүн бус найз нөхөд маань хол амьдардаг бол тэдний амьдардаг газрын номлогчдод хүсэлт тавин зуучилж болно.
  5. Хүүхдүүддээ сайн мэдээг хуваалцахын ач холбогдлыг зааж, тэднийг номлолд явахаар бэлтгэхэд нь сүнслэгээр мөн санхүүгийн хувьд тусалж чадна. Бид мөн өөрсдийгөө нас ахисан үедээ бүрэн цагийн номлолд үйлчлэхэд бэлтгэж болно.
  6. Бид аравны нэгээ төлж мөн номлолын санд хандив өгч болно. Эдгээр ханвидууд нь номлолын ажилд дэм болдог.
  7. Бид тойрог, салбар, эсвэл номлолын ерөнхий санд гэр бүлүүд нь дэмжих боломжгүй номлогч нарт туслахаар өгч болно.
  8. Бид гэр бүлийн түүхийн судалгаа хийж, ариун сүмийн ажилд өвөг дээдсээ сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авахад нь тусалж болно.
  9. Бид гишүүн бус хүмүүсийг гэр бүлийн үдэш, Сүмийн үйл ажиллагаанууд, чуулганууд болон цуглаануудад урьж болно.
  10. Бид Сүмийн сонин сэтгүүлийг өгч болно. Бид мөн сүмийн албан ёсны LDS.org ба Mormon.org сайтуудыг ашиглан сайн мэдээний захиас хуваалцаж болно.

Бид сайн мэдээг хуваалцах хүсэлтэй бөгөөд удирдамжийн төлөө залбирах юм бол Тэнгэрлэг Эцэг маань бидэнд идэвхтэй номлогчид байхад тусална. Тэр эргэн тойрондоо байгаа хүмүүстэй сайн мэдээг хуваалцах арга замыг олоход бидэнд тусална.

- Сайн мэдээг хуваалцаж болох хүмүүсийн талаар бод. Хэрхэн үүнийг хийхээ шийд. Тэдгээр хүмүүстэй сайн мэдээг хуваалцах тодорхой зорилго тавь.

## **Номлолын ажил хийсний төлөө Их Эзэн бидэнд адислалуудыг амласан**

Номлогчид агуу адислалуудыг хүлээн авна гэдгийг Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд хэлсэн. Номлолоос буцаж ирсэн ахлагч нарт хандан ярихдаа Их Эзэн “адислагдсан болой та нар, учир нь та нарын гэрчилсэн гэрчлэл тэнгэр элчүүд харж байхын тулд тэнгэрт цэдэглэгддэг болой, мөн тэд та нарт баясдаг бөлгөө” гэж хэлсэн (С ба Г 62:3). Тэр мөн бусдын авралын төлөө ажилладаг тэдгээрийн нүглүүд нь уучлагдаж, өөрсдийн бодгальд авралыг авчирах болно хэмээн хэлсэн (С ба Г 4:4; 31:5; 84:61).

Их Эзэн бидэнд:

“Хэрэв та нар энэ хүмүүст наманчлалыг тунхаглахад өөрсдийн бүхий л өдрүүдэд хөдөлмөрлөж мөн зөвхөн нэг бодгалийг надад авчрах аваас, миний Эцэгийн хаант улсад түүнтэй хамт та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ!

“Мөн эдүгээ, хэрэв миний Эцэгийн хаант улсад надад авчирсан нэг бодгальтай хамт та нар агуу баяр хөөртэй байх аваас, хэрэв та нар олон бодгалийг надад авчрах юм бол та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ!” (С ба Г 18:15–16).

- Та нар хэзээ номлолын ажлын баяр баяслыг мэдэрсэн бэ?

## **Нэмэлт судрууд**

- С ба Г 1:17–23 (Иосеф Смитэд номлохыг тушаасан)
- С ба Г 24:12 (Их Эзэн Түүний сайн мэдээг тунхаглахыг үргэлж хүсдэг тэднийг хүчирхэгжүүлдэг)
- С ба Г 38:41 (эвтэй зөөлөн, номхон дөлгөөнөөр сайн мэдээг хуваалц)
- С ба Г 34:4–6; Үйлс 5:42 (сайн мэдээг номлосон байх ёстой)
- С ба Г 60:1–2 (Их Эзэн сайн мэдээг хуваалцахаас айдаг тэдэнд анхааруулсан)
- С ба Г 75:2–5 (итгэлтэйгээр сайн мэдээг тунхаглагч тэдгээр нь мөнхийн амьдралаар адислагдах болно)

- С ба Г 88:81–82 (сэрэмжлүүлэгдсэн тэдгээр нь өөрсдийн хөршийг сэрэмжлүүлэх ёстой)
- Матай 24:14 (төгсгөл ирэхээс өмнө сайн мэдээ номлогдсон байх)
- Абрахам 2:9–11 (сайн мэдээ ба санваар үндэстэн бүрт өгөгдсөн байх)



# АВЬЯАСАА ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Бүлэг 34

---

## **Бид бүгд өөр өөр авьяас, чадваруудтай**

Тэнгэрлэг Эцэг маань бидэнд онцгой бэлэг, авьяас, чадваруудыг өгсөн байдаг. Бид эхээс төрөхдөө л эдгээр бэлгүүд, авьяас, чадваруудтай төрдөг (энэ номны 2-р бүлгийг үз).

Бошиглогч Мосе агуу удирдагч байсан. Гэсэн ч түүнд түүнийг төлөөлөн ярих Аарон дүүгийнх нь тусламж хэрэгтэй байсан (Египетээс гарсан нь 4:14–16). Бидний зарим нь Мосе шиг удирдагч, зарим нь Аарон шиг сайн яригч. Бидний зарим нь сайн дуулдаг байхад харин зарим нь сайхан хөгжимддөг. Бусад нь сайн тамирчин эсвэл гарын ур дүйтэй байж болно. Мөн бусдыг ойлгодог, тэвчээртэй, хөгжилтэй эсвэл бусдад заах авьяастай байж болно.

- Бусдын авьяасаас та нар хэрхэн тус дэмийг авсан бэ?

## **Бид авьяасаа ашиглан мөн хөгжүүлэх хэрэгтэй**

- Бид хэрхэн авьяасаа хөгжүүлэх вэ?

Бидэнд өгсөн авьяасыг хөгжүүлэх нь бидний үүрэг юм. Заримдаа бид ямар ч авьяасгүй мэт эсвэл бусад хүмүүс илүү олон авьяасаар адислагдсан юм шиг санагдах үе байдаг. Заримдаа бид хүмүүсийн шүүмжлэл эсвэл бүтэлтгүйтэхээс айгаад авьяасаа ашигладаггүй. Бид авьяас билгээ нуух ёсгүй. Бид авьяас билгээ ашиглах ёстой. Тэгсэн цагт бусад хүмүүс бидний сайн ажлыг хараад Тэнгэрлэг Эцэгийг магтан дуулах болно (Матай 5:16).

Бид авьяасаа хөгжүүлэхийн тулд хийх ёстой хэд хэдэн зүйл байдаг. Нэгдүгээрт: бид өөрсдийн авьяасыг тодруулах хэрэгтэй. Бид давуу тал ба ур чадвараа олохын тулд өөрсдийгөө үнэлэх

---

**Багш нарт зориулж:** Ангийн гишүүдээ нэг бүрчлэн анхаардаг гэдгээ үзүүлэх нэг арга бол хүн бүрийг нэрээр нь дуудах юм. Тэдний нэрийг цээжил. Шинэ хүн ангид ирэхэд бусдад нь түүнийг танилцуул.

хэрэгтэй. Гэр бүлийнхэн ба найз нөхөд маань үүнийг хийхэд минь тусалж болно. Бид мөн Тэнгэрлэг Эцэгээс өөрсдийн авьяасаа нээхэд туслахыг хүсч болно.

Хоёрдугаарт: өөрийнхөө хүсч байгаа авьяасаа хөгжүүлэхийн тулд бид цаг зав, хүч чармайлт гаргах хэрэгтэй.

Гуравдугаарт: Тэнгэрлэг Эцэг бидэнд туслах болно гэсэн итгэлтэй байх хэрэгтэй. Мөн бид өөртөө итгэх хэрэгтэй.

Дөрөвдүгээрт: авьяасаа хөгжүүлэхэд шаардлагатай ур чадварыг суралцах хэрэгтэй. Бид үүнийг хичээлээс, найз нөхдөөсөө номноос уншиж суралцаж болно.

Тавдугаарт: авьяасаа ашиглах хэрэгтэй. Авьяас бүрийг хөгжүүлэхэд хичээл зүтгэл, оролдлого мөн хөдөлмөр хэрэгтэй. Авьяас билгийг төгс эзэмшихийн тулд хөдөлмөрлөх хэрэгтэй.

Зургадугаарт: бид бусадтай авьяасаа хуваалцах хэрэгтэй. Авьяасыг ашигласнаар энэ нь улам өсдөг (Матай 25:29).

Хэрэв бид залбирч, Их Эзэний тусламжийг эрэлхийлэх аваас эдгээр үе шатууд нь хялбархан байх болно. Тэр биднийг авьяасаа хөгжүүлээсэй хэмээн хүсдэг ба Тэр бидэнд туслах болно.

### **Бид сул талаа даван туулж авьяасаа хөгжүүлнэ**

• Бид хэрхэн сул талаа давж авьяасаа хөгжүүлэх вэ?

Бид мөнх бус, уналтанд орсон учраас бидэнд сул талууд байдаг. Их Эзэний тусламжтайгаар бид сул талууд болон эгэл байдлаа даван ялж чадна (Ифер 12:27, 37). Бетховен өөрийн хамгийн агуу хөгжмүүдийг дүлий болсон хойноо зохиосон. Енох хүчтэй багш болохын тулд өөрийн удаан ярьдаг сул талыг ялсан (Мосе 6:26–47).

Хөнгөн атлетикийн зарим нэртэй тамирчид авьяасаа хөгжүүлж, амжилтанд хүрэхийн өмнө бие махбодынхоо хүндрэлийг ялан дийлсэн байдаг. Шелли Манн үүний үлгэр жишээ юм. “Тэр таван настай байхдаа полиомиелит өвчтэй байв. Түүний эцэг эх нь өдөр бүр усан санд авчирч, ус түүнд гараа өргөхөд нь тусалж, тэр дахин гараа хөдөлгөж чадна гэдэгт найдаж байв. Тэр өөрөө

бусдын тусламжгүйгээр уснаас гараа өргөн гаргасандаа баярлан уйлж байв. Дараа нь түүний зорилго усан санг хөндлөн сэлж сурах, дараа нь уртаар нь, тэгээд дараа нь хэд хэдэн удаа уртаар нь сэлэх байлаа. Тэр сэлэлтийн нэлээд хүнд хэлбэрийн нэг болох эрвээхэй сэлэлтээр (даллалт) [Олимпийн] алтан медаль авах хүртлээ өдөр өдрөөр хичээсээр, сэлсээр, эцсээ хүртэл тэмцсээр байсан” (Marvin J. Ashton, in Conference Report, 1975 оны 4-р сар, 127; эсвэл *Ensign*, 1975 оны 5-р сар, 86).

Хебер Ж. Грант өөрийн олон сул талуудаа ялан дийлж, тэдгээрийг авьяасаа болгон эргүүлсэн. Тэр эдгээр үгсийг өөрийн лоозон болгосон: “Бидний шаргуу зүтгэн хийсэн бүхэн дараа нь амархан болдог. Юмсын мөн чанар нь өөрчлөгддөг бус харин бидний хийх хүч чадал өсдөг” (*Teachings of Presidents of the Church: Хебер Ж. Грант* [2002], 35).

### **Хэрэв бид авьяасаа ухаалгаар ашиглах аваас Их Эзэн биднийг адислах болно**

Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит “Бурханы хүү, охин бүр янз бүрийн авьяасыг хүлээн авсан байдаг. Хүн бүр өгөгдсөн авьяас ашигласан уу алдсан уу хамаагүй тэдгээрийн төлөө хариуцлагыг гарцаагүй хүлээх болно” (*Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл. [1939], 370). Авьяас нь нэгэн төрлийн үүрэг юм (Бурханы хаант улс дахь үүрэг хариуцлага) Бид үүргээ сайн биелүүлэх аваас бидэнд улам агуу үүрэг хариуцлагууд өгдөг гэдгийг авьяасын талаарх сургаалт үлгэр бидэнд хэлж өгдөг. Хэрэв бид сайн үйлчлэхгүй бол үүрэг маань яваандаа биднээс авагддаг (Матай 25:14–30).

Сударт хэлснээр өөрсдийн үйлс үйлдлийн дагуу бид шүүгдэх болно (Матай 16:27). Авьяасаа бусдын төлөө зориулж, түүнийгээ хөгжүүлснээр бид сайн үйлсийг хийдэг.

Биднийг авьяасаа ухаалгаар ашиглавал Их Эзэн таашаадаг. Бусдын тусын тулд мөн энэ дэлхий дээр Түүний хаант улсыг байгуулахад авьяасаа ашиглах аваас Тэр биднийг адислах болно. Энэ дэлхий дээрх өөрсдийн ах эгч нарт үйлчилснээр бид баяр баясгалан, хайр гэх мэт адислалуудыг олж авдаг.



Бид мөн өөрсдийгөө хянах чадварт суралцдаг. Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин хамт амьдрахаар зохистой байхад минь эдгээр зүйлс нь гарцаагүй шаардлагатай.

- Авьяас чадвараа ухаалгаар ашигласан тул авьяас нь тодорсон хүмүүсийн тухай ямар жишээнүүд байдаг вэ? (Өөрийн мэдэх эсвэл судар эсвэл Сүмийн түүхэн дэх хүмүүсийн талаар бод.)

### **Нэмэлт судрууд**

- Иаков 1:17 (бэлгүүд Бурханаас ирдэг)
- С ба Г 46:8–11; 1 Тимот 4:14 (бэлгүүдийг эрэлхийлж, түүнийгээ хөгжүүл)
- 2 Коринт 12:9 (сул талаа хүчирхэгжүүлэх)
- Илчлэлт 20:13; 1 Нифай 15:33; С ба Г 19:3 (өөрсдийн үйлсээр шүүгдэнэ)
- Еврей 13:21 (сайн үйлсээ харуул)

# Дуулгавартай байдал

Бүлэг 35

---

## **Бид хүслээрээ Бурханд дуулгавартай байх ёстой**

- Хүсэлгүйгээр дуулгавартай байснаас хүсэлтэйгээр дуулгавартай байх нь юмсыг хэрхэн өөрчилдөг вэ?

Есүс дэлхий дээр байхад нэгэн хуульч Түүнээс:

“Багш аа, Хууль дахь агуу тушаал нь аль вэ? хэмээн асуудаг.

“Есүс түүнд, Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла.

“Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн.

“Удаах нь, Чи хөршөө өөрийн адил хайрла.

“Энэ хоёр тушаал дээр бүх Хууль болоод Эш үзүүлэгчид тулгуурладаг юм” гэлээ (Матай 22:36–40).

Эдгээр судраас бид Их Эзэн болон хөршүүдээ хайрлах нь ямар чухал болохыг суралцдаг. Гэхдээ бид Их Эзэнд хайраа хэрхэн үзүүлэх вэ?

Есүс энэ асуултанд дараах үгсээр хариулсан, “Миний тушаалуудыг сахьдаг хүн Намайг хайрлагч мөн. Намайг хайрладаг хүн Миний Эцэгт хайрлагдана. Би тэр хүнийг хайрлаж, Өөрийгөө түүнд илчилнэ” (Иохан 14:21).

Хүн бүр өөрөөсөө яагаад бид Бурханы тушаалуудад дуулгавартай байдаг вэ гэж асуух ёстой. Бид шийтгэлээс айдаг болохоор уу? Бид сайн сайхан амьдарсаныхаа төлөөх шагналыг хүссэн учраас уу? Бид Бурхан Есүс Христэд хайртай бөгөөд Тэдэнд үйлчлэхийг хүссэн учраас уу?

---

**Багш нарт зориулж:** Та ангийн эсвэл гэр бүлийн гишүүдэд асуултын талаар гүн тунгаан бодох хугацааг өгч болно. Тэдэнд хангалттай хугацааг өгсний дараа хариултыг сонс.



Тушаалуудад огт дуулгаваргүй байснаас шийтгэлээс айн дуулгавартай сахих нь нь хавьгүй дээр. Хэрэв бид Бурхандаа хайртай, дуулгавартай байхыг хүссэн учраас, Түүнд дуулгавартай байх юм бол бид илүү аз жаргалтай байх болно. Бид Түүнд чөлөөт хүсэл зоригоор дуулгавартай байх аваас Тэр биднийг мөн чөлөөт хүсэл зоригоороо адислах болно. Тэр хэлэхдээ, “Их Эзэн бибээр зөв шударга ёсонд хийгээд үнэнд эцсээ хүртэл надад үйлчилдэг тэднийг хүндэтгэхдээ баяртай байдаг билээ” (С ба Г 76:5). Дуулгавартай байдал биднийг Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болоход мөн өсөн хөгжихөд тусалдаг. Гэхдээ тушаахаас нааш юу ч хийдэггүй, дараа нь тушаалуудыг хүсэлгүйгээр сахьдаг тэдгээр нь өөрсдийн шагналыг алддаг (С ба Г 58:26–29).

- Бид дуулгавартай байх хүслээ хэрхэн нэмэгдүүлэх вэ?

### **Яагаад гэдгийг нь ойлгоогүй ч бид дуулгавартай байж болно**

- Яагаад бид үргэлж Их Эзэний зорилгыг ойлгох шаардлагагүйгээр дуулгавартай байх ёстой вэ?

Бурханы зарлиг, тушаалуудыг сахиснаар бид мөнхийн амьдрал болон өргөмжлөлд бэлтгэдэг. Заримдаа бид ямар нэгэн чухал зарлигийн шалтгааныг мэддэггүй. Гэсэн хэдий ч бид яагаад гэдгийг мэдэхгүйгээр Түүнд дуулгавартай байж итгэл болон найдвараа Бурханд харуулдаг.

Адам Ева хоёрыг Бурханд золиослол хийж байхыг зарлигласан. Нэгэн өдөр тэнгэрийн элч Адамд үзэгдэн, түүнээс яагаад золиослол хийж буйг асуусан. Адам хариуд нь үүний шалтгааныг мэдэхгүй гэдгээ хэлэв. Тэр Их Эзэн түүнд зарлигласан учир хийсэн байв (Моисе 5:5–6 мөн энэ бүлгийн зургуудыг үз).

Дараа нь тэнгэр элч Адамд сайн мэдээ зааж, ирэх Аврагчийн талаар хэлсэн. Ариун Сүнс Адамын дээр бууж, Адам дэлхийн хожмын үеийнхний талаар бошиглов (Моисе 5:7–10; С ба Г 107:56). Адам дуулгавартай байсан учир мэдлэг болон агуу адислалууд ирсэн.

## **Бурхан замыг бэлтгэдэг**

Мормоны Ном бидэнд Нифай ба түүний ах нар Их Эзэнээс маш хэцүү даалгавар хүлээн авсан тухай хэлдэг (1 Нифай 3:1–6). Нифайн ах нар гомдоллож, Их Эзэн тэднээс хэцүү зүйл хийхийг шаардаж байна гэж хэлж байв. Гэсэн ч Нифай “Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно” гэж хэлдэг (1 Нифай 3:7). Бид Их Эзэний зарлигийг биелүүлэхэд хэцүү гэж үзэх үедээ Нифайн үгсийг санах ёстой.

- Түүнд дуулгавартай байх замыг Их Эзэн та нарт хэзээ бэлтгэсэн бэ?

## **Дуулгавартай байхад хэтэрхий жижиг, хэтэрхий агуу зарлиг гэж үгүй**

Заримдаа бид энэ зарлиг тийм ч чухал биш гэж бодож магадгүй. Яг ингэж бодож байсан Нааман хэмээх хүний тухай сударт өгүүлдэг. Нааман уяман өвчтэй байсан ба бошиглогч Елишагаар эмчлүүлэхээр Сири улсаас Израил уруу аялав. Нааман өөрийн улсдаа их нэр хүндтэй хүн байлаа. Тиймээс тэр Елиша түүн дээр биечлэн ирж мэндлэлгүй зарцаа илгээсэнд нь гомдов. Нааман түүний Иордан голд долоон удаа орж угаа гэж хэлүүлснийг сонсоод бүр уурлав. “Дамаскийн голууд нь Израилийн бүх л уснаас илүү дээр биш гэж үү? би тэнд угаагаад, цэвэр болж болохгүй байсан гэж үү?” гэж тэр уцаарлав. Тэр эргэж, уурласаар буцав. Тэгтэл түүний зарц нар нь түүнд: “тэр эш үзүүдэгч танд агуу зүйлсийг хэлсэн бол та хийхгүй байх байсан уу? гэтэл тэр танд “Угааж, цэвэр бол” гэж байхад та хийхгүй гэж үү?” Хэдий энэ нь өчүүхэн зүйл ч гэсэн Бурханы бошиглогчид дуулгавартай байх нь чухал гэдгийг Нааман ойлгохоор ухаалаг хүн байсан. Тиймээс тэр Иордан голд угаалга хийж, эдгэрсэн (Хаадын дэд 5:1–14).

Заримдаа бид энэ зарлигийг дуулгавартай дагахад их хэцүү гэж боддог. Нифайн ах нарын адил бид “Бурхан биднээс хэцүү зүйлийг шаардаж байна” гэдэг. Гэсэн ч Нифайн адил Түүнд

дуулгавартай байх замыг нь зэхэлгүйгээр Бурхан бидэнд зарлигийг өгдөггүй гэдэгт бид итгэлтэй байж болно.

Их Эзэн Абрахамд өөрийн цорын ганц хайртай хүү Исаакаа тахил болгон өргөхийг зарлигласан нь “хэцүү зүйл” байсан (Эхлэл 22:1–13; мөн энэ номны 26-р бүлгийг үз). Абрахам Бурханы амласан Исаак хүүг төрөхийг хүлээж олон жил болсон байсан. Тэр хүүгээ хэрхэн алдах байсан бэ? Энэ зарлиг Абрахамын хувьд хэтэрхий хүнд байсан байх. Гэсэн ч тэр Бурханд дуулгавартай байхыг сонгосон.

Бид бас Бурханы биднээс хүссэн бүгдийг дуртайгаар хийх хүсэлтэй байх хэрэгтэй. Бошиглогч Иосеф Смит “Би *Их Эзэн үүнийг хий хэмээн зарлиглавал, түүнчлэн хий* хэмээх үгсийг өөртөө дүрэм болгосон” хэмээн хэлсэн (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 160). Энэ мөн бидний баримтлах дүрэм байж болно.

- Танд жижиг зүйл мэт санагдсан зарлигт дуулгавартай байснаар хүлээн авсан ямар адислалууд байдаг вэ?

### **Есүс Христ Эцэгтээ дуулгавартай байсан**

- Есүс Христ Эцэгтээ дуулгавартай байсан ямар жишээ таны санаанд орж ирж байна вэ?

Есүс Христ Тэнгэрлэг Эцэгт дуулгавартай байхын гайхамшигтай жишээ байсан. Тэр хэлэхдээ, “Би Өөрийнхөө хүслийг хийхийн тулд бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хийхийн тулд тэнгэрээс бууж ирсэн юм” гэсэн (Иохан 6:38). Түүний бүх амьдрал Эцэгтээ дуулгавартай байхын төлөө зориулагдсан. Энэ нь Түүнд үргэлж хялбар байгаагүй. Тэр бусад мөнх бусчуудын адил бүхий л замаар соригдсон (Еврей 4:15). Гетменийн цэцэрлэгт Тэр “Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог” гэж залбирсан (Матай 26:39).

Есүс бүх зүйлд Эцэгийн хүсэлд дуулгавартай байсан учраас Тэр бид бүгдийн төлөө авралыг боломжтой болгосон юм.

- Авралын жишээг санах нь бидэнд дуулгавартай байхад хэрхэн тусалдаг вэ?

### **Дуулгавартай ба дуулгаваргүй байхын үр дүн**

- Их Эзэний зарлигт дуулгавартай ба дуулгаваргүй байх нь ямар үр дагавруудыг авчирдаг вэ?

Тэнгэрийн хаант улс нь хуулиар зохицуулагддаг. Тиймээс бид ямар нэгэн адислалыг хүлээн авах үед энэ нь тухайн адислал тулгуурлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байсны учир болой (С ба Г 130:20–21; 132:5). Бид хичээл зүтгэл, дуулгавартай байдалаараа дамжуулан мэдлэг ба ухааныг олж авах болно гэдгийг Их Эзэн бидэнд заасан (С ба Г 130:18–19). Бид мөн сүнслэгээр өсдөг (Иеремиа 7:23–24). Өөрөөр хэлбэл дуулгаваргүй байдал гунихралыг авчирч, адислалыг алдах шалтгаан болдог. “Амлаад мөн биелүүлээгүй бибээр хэн бэ? хэмээн Их Эзэн хэлдэг. Бибээр зарлигладаг мөн хүмүүн дуулгавартай дагадаггүй билээ, бибээр цуцалдаг мөн тэд адислал хүлээн авдаггүй. Тэгээд тэд зүрх сэтгэлдээ өгүүлдэг: Энэ бол Их Эзэний ажил биш, учир нь түүний амлалтууд биелэгдсэнгүй (С ба Г 58:31–33).

Бид Бурханы зарлигуудыг сахих үед Тэр Өөрийн амлалтыг биелүүлдэг. Хаан Бенжамин өөрийн хүмүүст “Тэр та нарт өөрийнхөө зарлигласныг хийхийг та нараас шаарддаг, хэрэв та нар үүнийг хийвэл оронд нь, тэрээр та нарыг тэр даруй адисалдаг” гэдгийг хэлсэн (Мозая 2:24).

### **Дуулгавартай байгчид мөнхийн амьдралыг олж авдаг**

Их Эзэн бидэнд, “Хэрэв чи миний зарлигуудыг сахиж мөн эцсээ хүртэл тэвчих аваас, чи Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу бэлэг болох мөнх амьдралтай байх болно” гэсэн (С ба Г 14:7).

Их Эзэнд, зөв шударга, үнэнд эцсээ хүртэл дуулгавартай байх нэгэнд бусад адислалууд ирэх болно гэдгийг Тэрээр тайлбарласан байдаг.

“Учир нь Их Эзэн ийн хэлдэг, Их Эзэн бибээр надаас эмээдэг тэдэнд нигүүлсэнгүй хийгээд ач ивээлтэй бөлгөө, мөн зөв

шударга ёсонд хийгээд үнэнд эцсээ хүртэл надад үйлчилдэг тэднийг хүндэтгэхдээ баяртай байдаг билээ.

“Тэдний шагнал агуу байх болно, мөн тэдний алдар суу мөнхөд байх болно.

“Мөн бибээр тэдэнд бүх нууцыг тийм ээ, эрт дээр үеэс нууцлаг байсан хаант улсынхаа бүх нууцыг илчлэх болно, мөн ирэх үеүдэд, хаант улсдаа хамаарах бүх зүйлийн талаарх өөрийн тааллыг сайн таашаалыг би тэдэнд мэдүүлэх болно.

“Тийм ээ, бүр үүрд мөнхийн гайхамшгуудыг тэд мэдэх болно, мөн ирэх тэр зүйлүүдийг, бүр олон үеийн зүйлүүдийг би тэдэнд үзүүлэх болно.

“Мөн тэдний мэргэн ухаан агуу байх болно, мөн тэдний ойлголт тэнгэрт тулах бөлгөө. . . .

“Учир нь бибээр Сүнсээр тэднийг гэгээрүүлэх болно, мөн бибээр өөрийн сүр хүчээр тааллынхаа нууцуудыг тэдэнд мэдүүлэх болно, тийм ээ, бүр нүд хараагүй, чих сонсоогүй, хүмүүний зүрх сэтгэлд ороогүй тэдгээр зүйлүүдийг буюу” (С ба Г 76:5–10).

- “Эцсээ хүртэл тэвчих” гэдэг үг танд ямар утгатай вэ?
- Хэдийгээр энэ нь хийхэд түгээмэл биш боловч сайн мэдээний зарчмуудад итгэлтэй үлдэхийн тулд бид юу хийж чадах вэ? Сайн мэдээний зарчмуудад хүүхэд залуучуудыг үнэнч итгэлтэй байхад нь бид хэрхэн тусалж чадах вэ?

### **Нэмэлт судрууд**

- Абрахам 3:25 (бид өөрсдийн дуулгавартай байдлаа үзүүлэхээр дэлхийд ирсэн)
- 1 Самуел 15:22 (дуулгавартай байдал нь золиосолоос дээр)
- Номлогчийн үгс 12:13; Иохан 14:15; Ром 6:16; С ба Г 78:7; 132:36; Дэд хууль 4:1–40 (бид Бурханд дуулгавартай байх ёстой)
- 2 Нифай 31:7 (Есүс Христ дуулгавартай байсан)



- Сургаалт Үгс 3:1–4; 6:20–22; 7:1–3; Ефес 6:1–3; Колоссай 3:20 (хүүхдүүд өөрсдийн эцэг эхдээ дуулгавартай байх ёстой)
- С ба Г 21:4–6 (бошиглогчид дуулгавартай бай)
- Иохан 8:29–32; Мозая 2:22, 41; С ба Г 82:10; 1 Нифай 2:20 (дуулгавартай байдлаар ирэх адислалууд)
- С ба Г 58:21–22; 98:4–6; 134:5–7 (улсынхаа хуулинд дуулгавартай бай)
- Исаиа 60:12; С ба Г 1:14; 93:39; 132:6, 39 (дуулгаваргүй байсны үр дагавар)
- 2 Нифай 31:16; С ба Г 53:7; Матай 24:13; Лук 9:62 (эцсээ хүртэл тэвчих)

# Гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна

Бүлэг 36

---

## Гэр бүлийн чухал ач холбогдол

• Тэнгэрлэг Эцэг яагаад биднийг гэр бүлтэй байхаар илгээдэг вэ?

“Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гэрлэлт Бурханаас заяатай байдаг. Гэр бүл нь өөрийн хүүхдүүдийн мөнхийн хувь тавилангийн төлөө бүтээсэн Бурханы айлдварын төвд багтдаг” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign*, Nov. 1995, 102).

Тэнгэрлэг Эцэг Адам Ева нарыг гэрлүүлсэний дараа Тэр тэдэнд хүүхдүүдтэй байхыг зарлигласан (Эхлэл 1:28). Гэрлэлтийн нэг зорилго нь Түүний сүнсэн хүүхдүүдийг мөнх бус биеэр хангах гэдгийг илчилсэн. Эцэг эхчүүд маань Тэнгэрлэг эцэгтэй хамтрагчид юм. Тэр Өөрийн сүнсэн хүүхэд бүр дэлхийн амьдралыг амсаж, бие махбодийг хүлээн аваасай гэж хүсдэг. Эрэгтэй эмэгтэй хоёр энэ дэлхийд хүүхэд төрүүлэх нь Тэнгэрлэг Эцэгт төлөвлөгөөгөө биелүүлэхэд тусалдаг.

Шинэ хүүхэд бүрийг гэр бүлд баяр хөөртэй, хүсэн хүлээсэн байдлаар угтах ёстой. Хүүхэд бүр Бурханы хүүхэд мөн. Бид хүүхдүүдтэйгээ хамт тоглох, заах цаг гаргаж тэдэнтэйгээ цагийг сайхан өнгөрүүлэх хэрэгтэй.

Ерөнхийлөгч Дэвид О.МакКей “Мөнхийн амьдралд бэлтгэх хамгийн шилдэг газар бол орон гэр мөн гэдэгт би бүх зүрх сэтгэлээрээ итгэдэг” гэжээ (“Blueprint for Family Living,” *Improvement Era*, Apr. 1963, 252). Гэртээ, гэр бүлийнхэнтэйгээ хамтдаа бид өөрийгөө хянах байдал, золиослол, үнэнч шударга зан, хөдөлмөрийн

---

**Багш нарт зориулж:** Та гэр бүлийн тухай энэ бүлэг болон дараах хоёр бүлгийг заахдаа орон гэртээ аятай нөхцөл байдалд байдаггүй бусдын мэдрэмжинд мэдрэмтгий бай.



үнэ цэнийг мэдэхэд суралцаж чадна. Бид бусдыг хайрлах, бусдадтай хуваалцах, бусдад үйлчлэхэд суралцаж чадна.

Хүүхдүүдэд Тэнгэрлэг Эцэгийн тухай заах нь аав ээж нарын үүрэг мөн. Тэд Бурханд хайртай учраас Түүний зарлигуудыг сахидаг гэдгээ өөрсдийн жишээгээр үзүүлэх ёстой. Эцэг эхчүүд мөн өөрсдийн хүүхдүүдэд залбирах, зарлигуудад дуулгавартай байхыг заах ёстой (Сургаалт үгс 22:6).

- Яагаад гэр орон мөнхийн амьдралд бэлтгэх хамгийн шилдэг газар вэ?
- Сүмийн залуучуудад бид хэрхэн гэр бүл ба гэрлэлтийн гэрээний ариун нандин байдлыг ойлгоход нь туслах вэ?

### **Мөнхийн гэр бүл**

Гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна. Энэ адислалын баяр баясгаланг мэдрэхийн тулд бид ариун сүмд гэрлэх хэрэгтэй. Ариун сүмээс гадуур гэрлэсэн хүмүүсийн гэрлэлт хэн нэгэн нь нас барахад төгсгөл болдог. Харин ариун сүмд Мелкизедек санваарын эрх мэдлээр гэрлэсэн бол бид үеийн үед үүрд мөнхөд гэрлэдэг. Хэрэв бид Их Эзэнтэй хийсэн гэрээгээ сахих аваас бидний гэр бүлүүд эхнэр, нөхөр, үр хүүхдүүд бүгд хамтдаа үүрд мөнхөд нэгдэх болно. Үхэл биднийг салгаж чадахгүй.

### **Гэр бүлийн халуун дотно харьцаа**

- Бид хэрхэн гэр орондоо сайхан таарамж зохицлыг бий болгох вэ?

Эхнэр нөхрүүд бие биедээ элэгсэг дотно байж санаа тавьдаг байх ёстой. Тэд хэн нэгнийгээ гомдоох үг хэлэх юм уу ямар нэгэн муу зүйлийг хэзээ ч хийх ёсгүй. Тэд мөн хэн нэгнийгээ баярлуулахаар аливаа боломжит бүхнийг хийхийг хичээх хэрэгтэй.

Эцэг эхийн хувьд Бурханыг мэдэж, Түүнтэй адил болохыг хичээх тусам бие биеэ хайрлахыг хүүхдүүддээ заах болно.

Мормоны Номонд Хаан Бенжамин тайлбарлахдаа:

“Мөн та нар хүүхдүүдээ нэг нэгэнтэйгээ хэрэлдэн тэмцэлдэхийг тэвчихгүй болой. . . .

“Харин үнэний мөн чанд байдлын замуудаар алхахыг та нар тэдэнд заах болно, бие биенээ хайрлах, мөн нэг нэгэндээ үйлчлэхийг та нар тэдэнд заах болно” (Мозая 4:14–15).

Гэр бүлийн гишүүд бид нэг нэгэндээ урам зоригийг өгч, чин сэтгэлээсээ магтан урамшуулж өөртөө итгэлтэй байхад нь тусалж чадна. Хүүхэд бүр чухал гэдгээ мэдрэх ёстой. Эцэг эхчүүд хүүхдүүд нь юу хийдгийг сонирхож буйгаа үзүүлж, хайраа илэрхийлж, хүүхдүүдийнхээ төлөө санаа тавьж буйгаа харуулах хэрэгтэй. Хүүхдүүд мөн эцэг эхдээ хайраа үзүүлэх хэрэгтэй. Тэд дуулгавартай байж, эцэг эх болон гэр бүлийнхээ нэр хүндийг өргөхөөр амьдралаар амьдрахыг хичээх ёстой.

- Өөрсдийн охид, хөвгүүдийг нэг нэгэнтэйгээ сайн найз нөхөд байхыг нь урамшуулан дэмжихийн тулд эцэг эхчүүд юу хийж болох вэ? Ах дүүсийнхээ болон өөрсдийнхөө нөхөрлөлийг тэтгэхийн тулд юу хийж болох вэ?
- Эхнэр нөхрүүд нэг нэгнийгээ аз жаргалтай байлгахын тулд юу хийж чадах вэ?

### **Хэрхэн сайн сайхан гэр бүлтэй байх вэ**

- Гэр бүлээ хүчирхэгжүүлэн, өөдрөг сайн сайхан байлгахын тулд та юу хийж байна вэ?

Ерөнхийлөгч Харолд Б.Лий заахдаа, “Та нарын хэзээ нэгэн цагт хийх Их Эзэний хамгийн чухал ажил нь гэрийн чинь ханан дунд байх болно” (*Teachings of Presidents of the Church: Harold B. Lee* [2000], 134).

Гэр бүлүүд Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд ямар чухал болохыг Сатан мэддэг. Тэр биднийг Их Эзэнээс хол байлгаж, гэр бүлүүдийг устгахыг эрэлхийлдэг. Тэр биднийг гэр бүлээсээ хол байлгах зүйлсийг хийлгэхээр уруу татах болно.

Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр төлөөлөгчийн Чуулга “Бүтэмжтэй гэрлэлт ба гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, уучлалт, хүндэтгэл, хайр, энэрэл ба нигүүлсэл, ажил мөн чөлөөт цагаа ашиг тустай өнгөрөөх аливаа үйл ажиллагааны зарчмууд дээр тогтдог” (*Ensign*, 1995 оны 11-р сар, 102) хэмээн тунхагласан.

Бид бүгд аз жаргалтай, элэг бүтэн гэр бүлтэй байхыг хүсдэг. Дараах зүйлс үүнийг гүйцэлдүүлэхэд бидэнд туслах болно. Үүнд:

1. Өглөө, оройд тогтмол гэр бүлийн залбирлыг хий (3 Нифай 18:21). Эхнэр нөхөр хоёр хамтдаа залбир.
2. Долоо хоног бүрийн гэр бүлийн үдшээр сайн мэдээг хүүхдүүддээ заа.
3. Гэр бүлээрээ судраас тогтмол суралц.
4. Ажлаа төлөвлөх, зугаалгаар явах, шийдвэр гаргах зэрэг зүйлсийг гэр бүлээрээ хэлэлц.
5. Энэрэл, тэвчээр, тэсвэртэй мөн өглөгч энэрэнгүй байхад суралц (Моронай 7:45–48).
6. Сүмийн цуглаандуудад тогтмол оролц (С ба Г 59:9–10).
7. Их Эзэний С ба Г 88:119 дээр өгсөн зөвлөмжийг дага: “Өөрсдийгөө зохион байгуул; хэрэгтэй зүйл болгоныг бэлтгэ; мөн өргөө, бүр залбирлын өргөө, мацгийн өргөө, алдар суугийн өргөө, дэг журмын өргөө, Бурханы өргөөг байгуулагтун.”
8. Гэр бүлийн түүхийг хөтөлж, ариун сүмийн ажлыг хамтдаа хий. Ариун сүмийн лацдах ёслолуудыг хүлээн ав.

Гэр бүл нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хамгийн чухал нандин нэгж мөн. Сүм гэр бүлүүдийг мөнхийн адислалууд болон өргөмжлөлийг хүртэхэд нь туслахын тулд оршдог. Сүмийн доторх байгууллагууд болон хөтөлбөрүүд нь биднийг хувь хүний хувьд хүчирхэгжүүлэх, гэр бүлээрээ мөнхөд хамтдаа амьдрахад туслахад зориулагдсан байдаг.

- Хүнд хэцүү үеүдийг даван туулахын тулд гэр бүлүүд юу хийж чадах вэ?
- Гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судраас суралцах, гэр бүлээрээ зөвлөлдөх, гэр бүлийн хоолны цаг, гэр бүлийн үдэш зэрэг нь өөрчлөлт хийсэн ямар баталгааг та нар харсан бэ?

### **Нэмэлт судрууд ба бусад эх үүсвэрүүд**

- Мосе 2:27–28 (эрэгтэй эмэгтэй хүмүүс бүтээгдэн адислагдсан)
- Эхлэл 2:24 (эр хүн эхнэртэйгээ нийлэн нэгэн бие болдог)
- С ба Г 49:15–16 (Бурхан гэрлэлтийг томилсон)
- Ефес 6:4 (хүүхдүүдээ зөв шударгад сурга)
- С ба Г 132:15–21 (мөнхийн гэрлэлт)
- С ба Г 88:119–26 (бүтэмжтэй гэр бүлийн удирдамж)
- С ба Г 93:40–50 (Их Эзэн эцэг эхчүүдэд өөрсдийн хүүхдүүдийг гэрэл ба үнэнд авчирахыг зарлигласан)
- “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” (LDS.org ба including *Ensign*, 1995 оны 11-р сар, 102-р хуудас *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө: Бурханы өмнө хүлээх үүргээ биелүүлэх нь* [36550], 44-р хуудас ба *Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт* [36863], 59-61-р хуудас)

# Гэр бүлийн үүрэг хариуцлага

Бүлэг 37

---

## Эцэг эхчүүдийн үүрэг хариуцлага

- Хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэхэд эхнэр нөхрүүдийн хүлээх үүрэг юу вэ?

Гэр бүлд хүн бүхэн чухал байр суурийг эзэлдэг. Их Эзэн бошиглогчдоор дамжуулан эцэг, эх, хүүхдүүд хэрхэн биеэ авч явах, бие биедээ хэрхэн хандах талаар тайлбарласан байдаг. Бид нөхөр, эхнэр, хүүхэд болон нэгэн гэр бүл болсны хувьд өөр өөрсдийн зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд Их Эзэний хийгээсэй хэмээн найдан хүлээдэг зүйлсийг хийхэд суралцах хэрэгтэй. Хэрэв хүн бүхэн өөрсдөөс шалтгаалах бүхнийг хийх аваас бид мөнхөд хамтдаа нэгдэх болно.

Эцэг эх байх ариун үүрэгтээ, “эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой” (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign*, Nov. 1995, 102). Тэд гэр бүлийнхээ сүнслэг байдлын, сэтгэлийн, оюун ухааны болон бие махбодын хэрэгцээнүүдийг хангахын тулд хамтдаа ажиллах ёстой.

Зарим үүргүүдийг нөхөр эхнэр хуваан үүрэх ёстой. Эцэг эхчүүд хүүхдүүддээ сайн мэдээг заах ёстой. Хэрэв эцэг эхчүүд хүүхдүүддээ итгэл, наманчлал, баптисм, Ариун сүнсний бэлгийн талаар заадаггүй бол нүгэл эцэг эхчүүдийн толгой дээр буух болно гэдгийг Их Эзэн анхааруулсан. Эцэг эхчүүд мөн өөрсдийн хүүхдүүдэд залбирахыг, Их Эзэний зарлигуудад дуулгавартай байхыг заах ёстой (С ба Г 68:25, 28).

---

**Багш нарт зориулж:** 36-р бүлэгт дурьдсаны адил орон гэртээ аятай нөхцөл байдалд байдаггүй бусдын мэдрэмжинд мэдрэмтгий бай. Их Эзэний удирдамж, сүмийн болон гэр бүлийн гишүүдийн тусламжтайгаар ганц бие эцэг эхчүүд хүүхдүүдээ сайн сайхан өсгөн хүмүүжүүлж чадна.





Эцэг эхчүүд хүүхдүүдээ заах нэгэн шилдэг арга бол үлгэр жишээч байх явдал юм. Хайрыг нөхөр, эхнэрүүд бие биедээ үйлдэл болон үгээрээ үзүүлэх ёстой. Гэр бүлийн гишүүн бүр Бурханы хүүхэд гэдгийг санах нь чухал. Эцэг эхчүүд өөрсдийн хүүхдүүдэд чанга боловч элэгсэг байж, хайр, хүндэтгэлтэй харьцах ёстой.

Хэдийгээр тэдэнд үнэнийг заасан ч заримдаа хүүхдүүд буруу сонголт хийх болно гэдгийг ойлгох ёстой. Ийм зүйл тохиолдоход эцэг эхчүүд хэзээ ч бууж өгч болохгүй. Тэд үргэлжлүүлэн хүүхдүүдээ зааж, хайраа үзүүлж, сайн жишээ байж, тэдний төлөө залбиран мацаг барих хэрэгтэй.

Мормоны Ном эцгийн залбирал хэрхэн дуулгаваргүй хүүт Их Эзэний замд буцаан авчирсан тухай өгүүлдэг. Залуу Алма өөрийн зөв шударга эцгийн сургаалаас холдож, унасан байв. Алма сүмийг устгахыг эрэлхийлдэг байлаа. Эцэг хүүгийнхээ төлөө итгэлтэйгээр залбирдаг байв. Залуу Алма дээр тэнгэрийн элч айлчилж, өөрийн хилэнцэт амьдралын замналаа наманчилдаг. Тэр сүмийн агуу удирдагч болдог (Мозая 27:8–32).

Хэрэв эцэг эхчүүд өөрсдийн хүүхдүүдэд хайраар зааж, удирдах аваас гэртээ бишрэл сүсэглэл, хүндэтгэлийн орчинг бүрдүүлж чадна. Эцэг эхчүүд мөн өөрсдийн хүүхдүүдэд аз жаргалтай байх нөхцлүүдээр хангах ёстой.

- Нөхөр ба эхнэрүүд үүргээ гүйцэтгэхэд нь хэрхэн бие биеэ дэмжих вэ? Ганц бие эцэг эхчүүд хаанаас дэмийг олох вэ?

### Эцэг хүний үүрэг

- Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд эцгийн үзүүлдэг ямар эерэг зөв жишээнүүдийг мэдэх вэ?

“Бурханлаг загварын дагуу эцгүүд гэр бүлээ хайраар, зөв шударга байдлаар тэргүүлж, гэр бүлийн амьдралын хэрэгцээг хангаж, гэр бүлээ хамгаална” (*Ensign*, 1995 оны 11-р сар, 102). Сүмийн гишүүн зохистой эцэг санваарыг атгах боломжтой болж, энэ нь түүнийг гэр бүлийнх нь санваарын удирдагч болгодог. Тэр өөрийн гэр бүлийг хүчирхийлэх эсвэл дарамтлахын оронд төлөв төвшин, нинжин сэтгэлээр удирдах ёстой. Судруудад санваарыг

атгагч тэдгээр нь бусдыг санваарын ариун журмаар, эелдэг зөөлөн, хайр ба нинжин сэтгэлээр удирдах ёстой гэдгийг заадаг (С ба Г 121:41–44; Ефес 6:4).

Эцэг гэр бүлийн гишүүдтэйгээ санваарын адислалуудыг хуваалцдаг. Эрэгтэй хүн Мелкизедек санваарыг атгадаг бол өвчтөн ба санваарын онцгой адислалуудыг өгч эдгээр адислалуудыг бусадтай хуваалцаж чадна. Тэргүүлэх санваарын удирдагчийн удирдлага дор тэр бяцхан хүүхдүүдийг адислаж, баптисм хүртээж, гишүүнээр баталж, санваарын ёслолуудыг гүйцэтгэж чадна. Тэр зарлигуудыг сахиж, өөрийн гэр бүлд сайн үлгэр дууриалыг үзүүлэх ёстой. Тэр мөн гэр бүлийн залбирлыг өдөрт хоёр удаа хийж, гэр бүлийн үдэш хийж байгаа эсэхэд анхаарал тавих ёстой.

Эцэг хүн хүүхэд бүртэй цагийг хамтдаа өнгөрөөх ёстой. Тэр өөрийн хүүхдүүдэд зөв зарчмуудыг зааж, тэдний асуудлууд болон санааг нь зовоож буй зүйлсийн талаар ярилцаж, хайр энхрийлэлтэйгээр тэдэнд зөвлөх ёстой. Мормоны Номноос зарим сайн жишээнүүдийг олж болно (2 Нифай 1:14–3:25; Алма 36–42).

Гэр бүлийнхнийхээ эрүүл чийрэг бие, шаардлагатай хоол хүнс, байр сууц, хувцас ба боловсролоор хангагдаж буйд анхаарах нь мөн эцэг хүний үүрэг мөн. Хэрэв тэр өөрөө эдгээр бүх зүйлсээр хангаж чадахгүй байсан ч тэр гэр бүлээ асран тэтгэх үүргээ орхиж болохгүй.

### **Эх хүний үүрэг**

- Өөрийн хүүхдүүдийг өсгөн хүмүүжүүлэхэд эхийн үзүүлсэн ямар эерэг сайн жишээг та нар мэдэх вэ?

Ерөнхийлөгч Дэвид О. МакКей эх хүн байна гэдэг хамгийн агуу дуудлага гэж хэлсэн (*Teachings of Presidents of the Church: David O. McKay* [2003], 156). Энэ нь Түүний сүнсэн хүүхдүүдийг дэлхийд авчирахад Бурхантай хамтран ажилладаг ариун нандин дуудлага юм. Хүүхэд тээнэ гэдэг бүх адислалуудын хамгийн агуугийн нэг мөн. Хэрэв гэрт эцэг байхгүй бол эх гэр бүлийг тэргүүлдэг.

Ерөнхийлөгч Боид К. Пакер өөрсдөө хүүхэдтэй байх боломжгүй боловч бусдын хүүхдүүдийг асран хүмүүжүүлэхийг эрэлхийлсэн эмэгтэйчүүдийг магтан биширсэн. Тэр хэлэхдээ: “Би эхчүүдийн

талаар ярихдаа зөвхөн хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн талаар бус харин мөн бусдын хүүхдүүдийг асран өсгөсөн, өөрийн хүүхэдгүй боловч бусдын хүүхдүүдэд эх болсон олон эмэгтэйчүүдийн талаар би ярьж байна” (*Mothers* [1977], 8).

Хожмын үеийн бошиглогчид “Эхчүүд өөрсдийн хүүхдүүдийг халамжлан тэжээн тэтгэх үүрэгтэй” (*Ensign*, 1995 оны 11-р сар, 102). Эх хүн хүүхдүүдтэйгээ хамт байж, тэдэнд сайн мэдээг заах ёстой. Тэдний эргэн тойрон буй дэлхийг таньж мэдэж болохын тулд тэр тэдэнтэй тоглож, ажиллах ёстой. Тэр мөн орон гэрээ хэрхэн ая тухтай газар байлгахыг гэрийнхэн нь мэдэж болохын тулд гэр бүлдээ туслах хэрэгтэй. Хэрэв тэр энхрий дулаан байх аваас хүүхдүүд өөртөө итгэлтэй сайхан мэдрэмжтэй байдаг.

Мормоны Номонд эхчүүд нь заасан тул агуу зүйлсийг хийсэн 2000 залуу эрсийн тухай өгүүлдэг (Алма 53:16–23). Бошиглогч Хиламанаар удирдуулсан тэд дайсныхаа эсрэг тулаанд ордог. Тэд үнэнч шударга, эрэлхэг зоригтой, итгэл хүлээсэн байхыг өөрсдийн эхчүүдээс суралцсан байв. Хэрэв тэд эргэлзэхгүй аваас Бурхан тэдэнд амласнаа хийх болно гэдгийг тэдний эхчүүд мөн тэдэнд заасан (Алма 56:47). Тэд бүгд тулаанаас амьд үлдсэн. Тэд “Эхчүүд маань үүнийг мэдэж байсан гэдэгт эргэлзэхгүй байна” хэмээн хэлж ээж нарынхаа сургаалд итгэлтэй байгаагаа харуулсан (Алма 56:48). Гэрчлэлтэй эх бүр өөрсдийн хүүхдүүдэд хүчтэй нөлөө болж чадна.

### **Хүүхдүүдийн үүрэг**

- Аз жаргалтай гэр бүлийг бий болгоход хүүхдүүд эцэг эхдээ хэрхэн тусалж чадах вэ?

Хүүхдүүд эцэг эхтэйгээ аз жаргалтай гэр бүлийг босгоход хуваалцах үүрэгтэй. Тэд зарлигуудыг сахиж, гэр бүлийн бусад гишүүдтэй хамтран ажиллах ёстой. Хүүхэд хоорондоо хэрэлдэн маргалдахад Их Эзэн дургүй (Мозая 4:14).

Их Эзэн хүүхдүүдийг эцэг эхээ хүндэтгэхийг зарлигласан. Тэр “Эцэг эхээ хүндэл. Тэгвэл чиний Бурхан Эзэний чамд өгсөн газар дээр чи урт наслах болно” (Египетээс гарсан нь 20:12). Эцэг эхээ хүндэл гэдэг нь тэднийг хайрла, хүндэтгэ гэсэн үг. Энэ мөн

тэдэнд дуулгавартай байна гэсэн үг. Судрууд хүүхдүүдэд хандан “Их Эзэн дотор эцэг эхээ дага. Учир нь энэ нь зөв юм” гэж хэлсэн (Ефес 6:1).

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбал хүүхэд гэр орондоо болон ногооны талбай дээрээ ажиллаж, үүрэг хариуцлагаа хуваалцаж сурах хэрэгтэй гэж хэлсэн. Тэдэнд орон гэрээ цэвэр цэмцгэр байлгах даалгавар өгөгдөх ёстой (*Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* [2006], 120).

- Эцэг эхээ хүндэтгэхийн тулд хүүхдүүд юу хийх хэрэгтэй вэ?
- Эцэг эхээ хүндэтгэхэд хөтөлсөн ямар зүйлийг танай эцэг эх хийсэн бэ?

### **Үүрэг хүлээх нь адислалуудыг авчирдаг**

- Гэр бүлийн гишүүн бүр гэрээ аз жаргалтай газар болгохын тулд юу хийж чадах вэ?

Аз жаргалтай хайраар дүүрэн гэр бүл гэнэтийн тохиодлоор бий болдоггүй. Гэр бүлийн гишүүн бүр өөрсдөөсөө шалтгаалах бүхнийг хийх ёстой. Их Эзэн эцэг эх болон хүүхдүүдэд үүрэг хариуцлагуудыг өгсөн. Бид халамжтай, сайхан зантай, бусдын төлөө ухаалаг бодолтой байхыг судрууд заадаг. Бид ярих, залбирах, дуулах эсвэл хамт ажиллах үедээ таарамж зохицолтой байдлын адислалуудыг хүлээн авч жаргалтай байж чадна (Колоссай 3).

- Айл гэрийг аз жаргалтай газар болгох ямар уламжлал, туршлагууд байдаг вэ?

### **Нэмэлт судрууд ба бусад эх үүсвэрүүд**

- Сургаалт үгс 22:6 (хүүхдийг сурга)
  - Ефес 6:1–3 (хүүхдүүд эцэг эхдээ дуулгавартай байх)
  - С ба Г 68:25–28; Ефес 6:4 (эцэг эхийн үүрэг)
  - “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” (LDS.org ба *Ensign*, 1995 оны 11-р сар, хуудас 102; *Залуучуудын бат бөх байдлын төлөө* [36550], хуудас 44; ба *Итгэлдээ үнэнч байх нь* [36863], хуудас 59–61)
  - *Гэр бүлийн гарын авлага* (31180)
-

# МӨНХИЙН ГЭРЛЭЛТ

Бүлэг 38

---

## **Гэрлэлт нь Бурханаас томилогдсон**

Эрэгтэй эмэгтэй хоёрын гэрлэлт нь Бурханы төлөвлөгөөний амин чухал хэсгийн нэг Их Эзэн “Гэрлэхийг хориглодог хэн боловч Бурханаас томилогдоогүй болой, учир нь гэрлэлт нь Бурханаас хүмүүнд томилогдсон билээ” гэж хэлсэн (С ба Г 49:15). Эхлэлээс эхлэн гэрлэлт нь сайн мэдээний нэгэн хууль байсан. Гэрлэлт нь зөвхөн мөнх бус амьдралын тулд бус үүрд мөнхөд үргэлжлэх учиртай.

Адам Ева хоёрыг дэлхий дээр үхэл гэж байхгүй байх үед Бурхан гэрлүүлсэн. Тэд мөнхөд гэрлэсэн байсан. Тэд өөрсдийн хүүхдүүд болон хүүхдийнхээ хүүхдүүдэд мөнхийн гэрлэлтийн хуулийг заасан. Он жилүүд өнгөрөх тусам ёсон бус явдал хүмүүсийн зүрх сэтгэлд орж, дэлхийгээс энэ нандин ёслолыг гүйцэтгэх эрх мэдэл буцаан татагдсан. Сайн мэдээний Сэргээлтээр дамжуулан дэлхийд дахин мөнхийн гэрлэлт сэргээгдсэн.

- Эрэгтэй эмэгтэй хоёрын гэрлэлт нь Бурханаар томилогдсон гэдгийг мэдэх нь яагаад чухал вэ?

## **Мөнхийн гэрлэлт нь Өргөмжлөлд зайлшгүй чухал**

- Их Эзэний гэрлэлтийн тухай ямар сургаал байдаг вэ? Энэ нь дэлхийн үзлээс юугаараа өөр вэ?

Дэлхийн олон хүн гэрлэлтийг зөвхөн эрэгтэй эмэгтэй хоёрын хооронд хамт амьдрахад зориулсан хууль эрхийн хэлэлцээр, нийгмийн хэвшсэн ёс заншил гэж үздэг. Гэвч Хожмын үеийн Гэгээнтнүүднүүдийн хувьд гэрлэлт нь түүнээс илүү зүйл. Бидний өргөмжлөл нь итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах зэрэг бусад зарчим ёслолуудын адил мөн гэрлэлтээс хамаардаг. Бид гэрлэлт нь эрэгтэй эмэгтэй хоёрын хооронд байж

---



болох хамгийн ариун нандин харьцаа гэдэгт итгэдэг. Энэ нандин харилцаа одоо болон үеийн үед үүрд мөнхийн аз жаргалд минь нөлөөлдөг.

Тэнгэрлэг Эцэг маань бид Түүнтэй адил болж болох мөнхийн гэрлэлтийн хуулийг бидэнд өгсөн. Их Эзэн бидэнд:

“Селестиел алдар сууд гурван тэнгэр буюу зэрэглэл буй;

“Мөн хамгийн дээдхийг нь олж авахын тулд хүн санваарын энэхүү ариун жаягт [гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээг хэлж буй] орох ёстой;

“Мөн хэрэв тэрээр үгүй аваас, тэрээр үүнийг олж авч чадах нь үгүй” (С ба Г 131:1–3).

### **Мөнхийн гэрлэлтийг зохих эрх мэдэлтэн Ариун сүмд гүйцэтгэх ёстой.**

- Гэрлэлт нь яагаад зохистой эрх мэдэлтнээр ариун сүмд гүйцэтгэж байж мөнхийн болдог вэ?

Мөнхийн гэрлэлт буюу лацдалт хийх хүчийг атгасан нэгэн гүйцэтгэх ёстой. Их Эзэн “Хэрэв эр хүн шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр нэг эхнэртэй гэрлэж, миний томилсон, тослогдсон түүгээр тэдэн дээр лацлагдаж, хэрэв [тэд] миний [Их Эзэний] гэрээг дагах аваас мөн тэднийг дэлхийгээс гадна байхад бүрэн хүчтэй хэвээр байх болно” гэж амалсан (С ба Г 132:19).

Мөнхийн гэрлэлтийг зөвхөн зохистой санваарын эрх мэдэлтэн гүйцэтгээд зогсохгүй Их Эзэний ариун сүмүүдийн аль нэгэнд хийгдэх ёстой. Ариун сүм нь энэ нандин ёслол гүйцэтгэгдэж болох цорын ганц газар.

Ариун сүмд Хожмын үеийн Гэгээнтэн хосууд ариун сүмийн хувийн хишгээ хүртсэн гэр бүл, найз нөхдийнхөө өмнө ариун тахилын ширээний өмнө өвдөглөн суудаг. Тэд Бурханы өмнө гэрлэлтийн гэрээгээ хийдэг. Тэд энэ үе болон үеийн үед үүрд

---

**Багш нарт зориулж:** Гэрлэсэн болон гэрлээгүй бүх гишүүд мөнхийн гэрлэлтийн сургаалыг ойлгох хэрэгтэй. Та гэрлээгүй насанд хүрсэн хүмүүсийн мэдрэмжинд мэдрэмтгий байх ёстой. Шаардлагатай бол өөрсдийн энэ амьдралын гэрээнүүддээ итгэлтэй Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүд сайн мэдээний мөнхөд өгөгдөх, мөнхийн гэр бүлтэй болох боломжийг оролцуулан, бүх адислалуудыг хүлээн авах болно гэдгийг ангийн эсвэл гэр бүлийн гишүүдэд ойлгоход нь тусал.



мөнхөд нөхөр эхнэр хэмээн албан ёсоор тунхаглагддаг. Энэ нь Бурханы ариун санваарыг атгасан, энэ нандин ёслолыг гүйцэтгэх эрх мэдэл бүхий нэгэн гүйцэтгэдэг. Тэр Их Эзэний удирдлагаар үйлдэж, хосуудад өргөмжлөлийн адислалуудыг амладаг. Тэр эдгээр адислалуудыг хүлээн авахын тулд хийх ёстой зүйлүүдийг зааварладаг. Тэр Бурханы хуулиудад дуулгавартай байснаар бүх адислалуудыг хүлээн авна гэдгийг тэдэнд сануулдаг.

Хэрэв бид ариун сүмд санваарын хүчээр бус бусад эрх мэдлээр гэрлэсэн бол гэрлэлт нь зөвхөн энэ амьдралынх болно. Үхлийн дараа гэрлэсэн хосууд бие биеэ мөн хүүхдүүдээ гэх боломжгүй. Мөнхийн гэрлэлт энэ амьдралын дараа гэр бүлүүд хамтдаа байх боломжийг өгдөг.

### **Мөнхийн гэрлэлтийн ач тус**

- Мөнхийн гэрлэлт нь энэ амьдралд болон үүрд мөнхөд ямар адислалууд авчирдаг вэ?

Хожмын үеийн Гэгээнтнүүдийн хувьд хэсэг зуурын бус харин мөнхийн бүх зүйлсийг харж амьдардаг. Гэхдээ бид мөнхийн гэрлэлтийг хийлгэсний үр дүнд энэ амьдралдаа ч адислалуудыг хүлээн авч чадна. Эдгээр адислалуудын зарим нь:

1. Гэрлэлт маань үүрдийнх гэдгийг бид мэддэг. Үхэл биднийг зөвхөн түр зуур л бие биенээс минь салгадаг. Бидний дуулгаваргүй байдлаас өөр юу ч биднийг мөнхөд салгаж чадахгүй. Энэ мэдлэг биднийг аз жаргалтай, сайн сайхан гэрлэлтийг бий болгохын тул улам зүтгэлтэй ажиллахад маань бидэнд тусалдаг.
2. Бидний гэр бүлийн харилцаа үүрд мөнхөд үргэлжилнэ гэдгийг бид мэддэг. Энэ мэдлэг хүүхдүүддээ зааж, сургахдаа болгоомжтой байхад минь тусалдаг. Энэ нь мөн тэдэнд агуу тэвчээр, хайрыг үзүүлэхэд тусалдаг. Үүний үр дүнд бид аз жаргалтай орон гэртэй болдог.
3. Бид Бурханы томилсон замаар гэрлэсэн учраас хэрэв бид зохистой байх аваас бидэн дээр Их Эзэний Сүнс асгарах болно.

Мөнхөд бидэнтэй байх зарим адислалууд нь:

1. Бид Бурханы селестиел хаант улсын хамгийн дээд зэрэгт амьдарч чадна.
  2. Бид Бурханы адил өргөмжлөгдөж, бүрэн дүүрэн баяр баяслыг хүлээн авч чадна.
- Мөнхийн гэсэн ойлголт хэрхэн бидний гэрлэлт ба гэр бүлийн талаарх мэдрэмжинд нөлөөлдөг вэ?

### **Бид мөнхийн гэрлэлтэнд бэлтгэх ёстой**

- Бид залуучуудыг мөнхийн гэрлэлтэнд бэлтгэхийн тулд хийж чадах вэ?

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбал “Гэрлэлт нь алс холын үр дагавартай, түр зуурын аз жаргалтай хамаатай бус мөнхийн баяр хөөртөй холбоотой хамгийн чухал шийдвэр байж болох юм” гэж заасан. Энэ нь зөвхөн хоёр хүний асуудал бус тэдний гэр бүл, тэр дундаа хүүхдүүд, ач гуч гээд олон үе удамд нөлөөлдөг. Энэ амьдрал болон үүрд мөнхийн хамтрагчаа сонгохдоо бүх шийдвэрүүдээс хамгийн онцгой. бат найдвартай шийдвэрийг гаргахын тулд хамгийн хянамгай төлөвлөлт, эргэцүүлэл, залбирал, мацаг барилтыг хийх ёстой (*Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* [2006], 193).

Мөнхийн гэрлэлт нь Хожмын үеийн Гэгээнтэн бүрийн зорилго байх ёстой. Энэ нь иргэний хуулиар гэрлэсэн хосуудад ч хамааралтай. Мөнхийн гэрлэлтэнд бэлтгэхийн тулд маш сайн тунгаан бодох, залбирахыг шаардах болно. Зөвхөн зөв шударга амьдардаг сүмийн гишүүд ариун сүмд орох зөвшөөрлийг авдаг (С ба Г 97:15–17). Бид гэнэт нэг өдөр ариун сүмд гэрлэмээр байна гэж шийдээд тэр өдрөө ариун сүмд ороод гэрлэнэ гэж байдаггүй. Бид юуны өмнө тодорхой шаардлагуудыг хангасан байх ёстой.

Ариун сүмд орохын өмнө бид нэгээс доошгүй жил сүмийн идэвхтэй, зохистой гишүүн байх ёстой. Эрэгтэйчүүд Мелкизедек санваар атгагч байх ёстой. Бид салбарын ерөнхийлөгч юм уу бишоптойгоо ярилцлаганд орсон байх ёстой. Тэр биднийг зохистой гэж үзвэл ариун сүмийн зөвшөөрлийн бичгийг олгодог.

Хэрэв бид зохисгүй бол бидэнд зөвлөж, ариун сүмд орохоор зохистой болох зорилго тавихад тусалдаг.

Бид бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөс зөвшөөрлийн бичгээ авсны дараа гадасны эсвэл номлолын ерөнхийлөгчтэй ярилцлаганд орох ёстой. Бид ариун сүмийн зөвшөөрлийн бичгийг авахын тул дараах асуултанд хариулах ярилцлаганд ордог. Үүнд:

1. Та Бурхан, Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ ба Ариун Сүнсэнд итгэдэг, мөн гэрчлэлтэй юу? Танд сайн мэдээний баттай гэрчлэл бий юу?
2. Та Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгчийг бошиглогч, үзмэрч бөгөөд илчлэгч гэдгийг хүлээн зөвшөөрдөг үү? Та түүнийг дэлхий дээр санваарын түлхүүрүүдийг атгах эрх мэдэлтэй ганц хүн гэдэгт итгэдэг үү?
3. Та ариун явдлын хуулиар амьдардаг уу?
4. Та аравны нэгийг бүрэн төлөгч үү?
5. Та мэргэн ухааны үгийг сахьдаг уу?
6. Та бусадтай шударга байдаг уу?
7. Та хийсэн гэрээгээ сахиж, ариун ёслол болон санваарын цуглаануудад оролцож, сайн мэдээний зарлиг хуулиудаар амьдардаг уу?

Та нар ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахыг хүсэхдээ ариун сүмд орох нь нандин эрх гэдгийг санах ёстой. Энэ нь өнгөцхөн авч үзэх зүйл биш харин нухацтай хийх үйлдэл мөн.

Бид ариун сүмд хийх гэрээ бүхэндээ дуулгавартай байхыг чин сэтгэлээсээ эрэлхийлэх ёстой. Хэрэв бид үнэн итгэлтэй байх аваас өргөмжлөлд орох болно гэдгийг Их Эзэн хэлсэн. Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болох болно (С ба Г 132:19–20). Ариун сүмийн гэрлэлт нь ямар ч золиослолоос үнэ цэнэтэй. Энэ нь хэмжээлшгүй их мөнхийн адислалуудыг олж авах арга зам мөн.

- Бид залуучуудыг ариун сүмд гэрлэх зорилгыг тавихад нь хэрхэн урамшуулан дэмжих вэ? Үүнд бэлтгэхэд нь бид хэрхэн тусалж чадах вэ?

### **Нэмэлт судрууд**

- Эхлэл 1:26–28 (бид үржин өсөж, дэлхийг бүрхэх ёстой)
- Эхлэл 2:21–24 (эхний гэрлэлт Бурханаар гүйцэтгэгдсэн)
- Матай 19:3–8 (Бурхан юуг холбосон бэ)
- С ба Г 132 (гэрлэлтийн хуулийн мөнхийн шинж)
- С ба Г 42:22–26 (гэрлэлтийн тангараг сахигдах ёстой)
- Иаков 3:5–7 (нөхөр эхнэрүүд бие биедээ үнэнч байх ёстой)



# Ариун явдлын хууль

Бүлэг 39

---

## Эцэг эхчүүдэд зориулсан тайлбар

Энэ бүлэг насанд хүрээгүй хүүхдүүдийн бус зүйлүүдийг хамруулсан. Энэ бүлгийн хэсгүүдийг хүүхдүүдэд заахын өмнө эр эмийн харьцаа болон өсөн үржих талаар ойлгох хангалттай насанд хүртэл хүлээх нь зүйтэй. Сүмийн удирдагчид өөрсдийн хүүхдүүдэд нөхөн үржихүйн (жирэмслэх болон хүүхэд төрүүлэх үйл явц) талаар заах нь эцэг эхчүүдийн үүрэг гэж бидэнд хэлсэн байдаг. Эцэг эхчүүд мөн тэдэнд энэ бүлэгт тайлбарласан ариун явдлын хуулийг заах ёстой.

Эцэг эхчүүд хүүхдүүдэд бага наснаас нь биеэ зохистой байлгахыг зааж эхэлж болно. Хүүхдүүдтэйгээ шууд илэн далангүй боловч хүндэтгэлтэйгээр, биеийн хэсгүүдийн нэр ба үүргийнх нь нэрийг зөв хэрэглэж ярих нь тэднийг өөрсдийн биеийн талаар ичингүйрэлгүйгээр өсч бойжиход нь туслах болно.

Хүүхдүүд төрөлхийн их сонинч. Тэд биеийнхээ бүтцийн талаар мэдэхийг хүсдэг. Тэд хүүхэд хаанаас ирдгийг мэдэхийг хүсдэг. Хэрэв эцэг эхчүүд эдгээр асуултуудад нь хүүхэд ойлгохоор тодорхой ойлгомжтой хариулах аваас, тэд эцэг эхчүүдээсээ асуулт асууж эргэн хандах болно. Харин эцэг эхчүүд асуултуудад нь хариулахдаа ичээх, татгалзах эсвэл хангалттай мэдрэмжийг өгөх аваас тэд өөр хэн нэгэнд хандан магадгүй буруу, зохисгүй хандлага олж авч мэдэх юм.

Гэвч хүүхдүүдэд бүгдийг нэг дор хэлж өгөх нь ухаалаг эсвэл тийм шаардлагатай алхам биш. Эцэг эхчүүд зөвхөн тэдний асуусан зүйлд нь таарсан мэдээллийг ойлгогдохоор өгөх хэрэгтэй. Эдгээр асуултуудад хариулахдаа өөрсдийн болон бусдын биеийг хүндэтгэхийн ач холбогдлын чухлыг зааж чадна. Эцэг эхчүүд хүүхдүүдэд даруухан зохистой хувцаслахыг заах ёстой.

---

Тэд бусдаас сурсан бүдүүлэг үг хэллэг, хуурамч үзлийг засч, залруулах хэрэгтэй.

Хүүхдүүд өсч, нас бие гүйцэхдээ эцэг эхчүүд тэдэнтэй өсөн үржихүйн талаар илэн далангүй ярилцах хэрэгтэй. Эдгээр хүч нь сайн зүйл бөгөөд Их Эзэн бидэнд өгсөн гэдгийг хүүхдүүд ойлгох ёстой. Өөрсдийн биеийг Өөрийнхөө өгсөн хязгаарын хүрээнд ашиглаасай хэмээн Бурханы найдан хүлээдэг.

Дэлхийд цэвэр ариун, гэм буруугүй бяцхан хүүхдүүд Тэнгэрлэг Эцэгээс ирдэг. Эцэг эхчүүдийн хувьд удирдамжийг хүсэн залбирахад Их Эзэн тэднийг хүүхдүүдээ зөв цагт, зөв замаар заахад нь удирдан чиглүүлэх болно.

### **Өсөн үржихүйн хүч**

- Яагаад эцэг эхчүүд хүүхдүүддээ өсөн үржих болон ариун явдлын хуулийн талаар заах ёстой вэ? Тэд үүнийг хэрхэн зөв нийцтэйгээр хийж чадах вэ?

Бурхан амьд бүхнийг өөрсдийн төрлөөр өсөн үржихийг зарлигласан (Эхлэл 1:22). Өсөн үржих нь Түүний төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд амьд бүхэн дэлхий дээр оршин тогтнохын тулд юм.

Дараа нь Тэр дэлхий дээр Адам Ева нарыг бүтээсэн. Тэд Түүний бусад бүтээлүүдээс ялгаатай байлаа. Учир нь тэд Түүний сүнсэн хүүхдүүд байв. Едены цэцэрлэгт Тэр Адам Ева хоёрыг авчиран гэрлүүлж, тэдэнд өсөн нэмэгдэж өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ хэмээн зарлиглав (Эхлэл 1:28). Тэдний амьдрал зөнгөөр бус сургаалын хуулиар зохицуулагдах ёстой байв.

Бурхан сүнсэн хүүхдүүдээ зохих ёсоор хүмүүжих, суралцаж болохын тул гэр бүлүүдэд төрөхийг хүссэн. Бид Адам Евагийн адил сүнсэн хүүхдүүдийг махан биебодтой болгодог. Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга “Бид амьдралыг бий болгох замыг Бурхан бүтээсэн болохыг тунхагладаг” хэмээн тунхагласан (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Ensign*, Nov. 1995, 102). Бурхан зөвхөн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хооронд гэрлэлт, бэлгийн харьцаа байхыг бидэнд зарлигласан. Энэ зарлигийг ариун явдлын хууль гэдэг.

---

## Ариун явдлын хууль

- Ариун явдлын хууль гэж юу вэ?

Бид зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр буюу нөхөртэйгээ бэлгийн харьцаатай байх ёстой. Эрэгтэй, эмэгтэй аль нь ч гэрлэхээс өмнө бэлгийн харьцаанд орж болохгүй. Гэрлэсний дараа зөвхөн хосуудын хоорондох бэлгийн харьцааг зөвшөөрнө.

Израилчуудад Их Эзэн, “Чи бүү завхайр” хэмээн хэлсэн (Египетээс гарсан нь 20:14). Энэ зарлигийг зөрчсөн тэдгээр Израилчуудад хатуу шийтгэл ирдэг байв. Их Эзэн энэ зарлигийг хожмын өдрүүдэд давтан хэлсэн (С ба Г 42:24).

Ариун явдлын хууль бэлгийн харьцаанаас илүү зүйлсийг багтаадаг гэдгийг бид мэднэ. Залуучуудыг бусад эр эмийн харьцааны нүглүүдээс хол байхыг Тэргүүн Зөвлөл анхааруулсан.

“Зөвхөн гэрлэлтийн дараа илэрхийлэгдэх ёстой энэ хүчирхэг сэтгэлийн хөөрлийг өдөөх ямар нэгэн зүйлийг гэрлэлтээс өмнө бүү хий. Тачаангуй үнсэлцэх, өөр хүний дээр гарч хэвтэх эсвэл өөр хүний нууцлаг, нандин газруудад хувцастай болон хувцасгүйгээр хүрэх зэрэг зүйлсийг хийж болохгүй. Мөн эдгээр зүйлсийг та нартай хийхийг хэн нэгэнд зөвшөөрч болохгүй (*Залуучуудын бат бөх байдлын төлөө* [pamphlet, 2001], 27).

Ижил хүйстнээ сонирхох нь ариун явдлын хуулийг зөрчих бусад зөрчлүүдтэй адил ноцтой нүгэл юм. Хожмын үеийн бошиглогчид ижил хүйстнээ сонирхох аюулын болон ийм хандлагатай хүмүүсийн төлөөх Сүмийн зовнилын тухай ярьсан. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ:

Юуны түрүүнд бид Бурханы томилсон эрэгтэй эмэгтэй хоёрын хоорондох гэрлэлтэд итгэдэг. Бид Их Эзэний өргөөнд мөнхийн санваарын хүчээр дамжуулан хийгдсэн мөнхийн гэрлэлтэд итгэдэг.

“Хүмүүс ижил хүйстэнтэйгээ явалддаг “гомо” ба “лесби” гэж нэрлэдэг хүмүүсийн талаарх бидний байр суурийг их асуудаг. Миний хариулт бол бид тэдэнд Бурханы охид хөвгүүдийнх нь хувьд хайртай. Тэд өөр хүсэл сонирхолтой түүнийгээ хянахад хүндрэлтэй байж магадгүй. Ихэнх хүмүүс өөр өөр үед өөр өөр



хүсэл сонирхолтой байдаг. Хэрэв тэд тэдгээр зохисгүй сонирхолоо үйлдэл болгохгүй аваас сүмийн бусад гишүүдийн адил тэд урагш алхаж чадна. Хэрэв тэд сүмийн ариун явдлын хууль болон ёс зүйн хэм хэмжүүрийг зөрчих аваас сүмийн сахилга батыг зөрчигч болох болно.

“Бид тэднийг хүчирхэгжүүлж, тэдний хүндрэлтэй асуудлаа шийдэхэд нь дэмжин, туслахыг хүсдэг. Хэрэв тэд садар самуун ёс суртахуунгүй үйл ажиллагааг хөөцөлдөж, ижил хүйстэнтэйгээ гэрлэх, хамгаалах тохиолдолд бид зүгээр хараад зогсох ёсгүй. Ийм дур зуршилд автах нь маш ноцтой зүйл бөгөөд Бурханы дэмждэг гэрлэлтийн ариун нандин үндэс болсон гэр бүлүүдийг төвхнүүлэх туйлын үнэн зорилгод харшлах болно (1998 оны 10-р сар, Ерөнхий Чуулган, 91; эсвэл *Ensign*, 1998 оны 11-р сар, 71).

### **Сатан биднийг ариун явдлын хууль зөрчихийг хүсдэг**

- Сатан ямар арга замуудаар хүмүүсийг ариун явдлын хууль зөрчихийг дэмждэг вэ?

Сатаны төлөвлөгөө бол аль болох олон хүнийг Тэнгэрлэг Эцэгтээ буцан очиж, Түүнтэй хамт амьдрахад саад болох юм. Түүний хийж чадах хамгийн аюултай зүйлсийн нэг бол ариун явдлын хуулийг зөрчихөд биднийг хөтлөх явдал. Тэр маш овжин бөгөөд хүчтэй. Энэ хуулийг зөрчих нь нүгэл биш гэж бидэнд тэр итгүүлэхийг хүсдэг. Олон хүмүүс түүнд мэхлэгдсэн. Бид хилэнцтийн нөлөөллөөс өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй.

Сатан даруу зохистой байдлын жишгүүд уруу дайралт хийдэг. Тэр хүмүүний бие гоо үзэсгэлэнтэй, гайхуулан, ил гаргах зүйл гэж бидэнд итгүүлэхийг хүсдэг. Тэнгэрлэг Эцэг маань бусдын хүсэл бодолд буруу сэтгэгдлийг төрүүлэн өөгшүүлэхгүйн тулд бид биеэ хаахыг хүсдэг.

Сатан биднийг зөвхөн зохисгүй хувцаслахыг дэмжээд зогсохгүй тэр мөн ёс суртахуунгүй бодол эсвэл буруу зохисгүй бодлыг дэмжин урамшуулдаг. Тэр зураг, кино, хошин шог, хөгжим болон бүжгээр дамжуулан ийм ёс суртахуунгүй үйлдлүүдийг санал болгодог. Ариун явдлын хууль нь бидний бодол санаа

болоод үйлдлийг цэвэр ариун байхыг шаарддаг. Бошиглогч Алма Бурханаар шүүгдэх үед “мөн түүнчлэн бодлууд маань ч биднийг буруутгах болно; мөн энэ аймшигт нөхцөлд бид өөрсдийн Бурхан өөд маань харж үл зүрхлэх болно” гэж заасан (Алма 12:14).

Есүс заахдаа, “Завхайрч болохгүй гэснийг та нар дуулсан:

“Харин Би та нарт хэлье, эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм” гэсэн (Матай 5:27–28).

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли “Та нар аймшигтай уруу таталтаар дүүрэн дэлхийд амьдарч байна. Порнограф нь аймшигт усны эргүүлэг мэт дэлхийг устгаж байна. Энэ бол хор. Түүнийг бүү үз эсвэл бүү унш. Хэрэв та нар үүнийг хийх аваас энэ та нарыг устгах болно. Та нарыг өөрийгөө хүндэтгэх ёсноос холдуулах болно. Та нарын амьдралын гоо сайхныг мэдрэх мэдрэмжийг тань хулгайлах болно. Та нарыг хилэнцэт бодол магадгүй бүр хилэнцэт үйлдлийн намагт живүүлэх болно. Үүнээс хол бай. Та нар энэ бохир, үхэлд авчрах өвчинөөс зугаах мэт сэргийлэн зугт. Бодол болоод үйлстээ ариун журамтай бай. Бурхан тусгай зорилгын учир сүйтгэлд хүргэх хилэнцэт зүйлст амархан түлхэгдэн унах тэнгэрлэг хүслийг та нарт суулгасан. Та нар бага залуу насандаа гүнзгий хийсвэр харьцаанд бүү ор. Харин гэрлэх насанд хүрээд иймэрхүү харьцаанд орж болно. Харин ахлах ангийн охид, хөвгүүд минь та нарт энэ хэрэггүй (Conference Report, 1997 оны 10-р сар, 71–72; эсвэл *Ensign*, 1997 оны 11-р сар, 51).

Заримдаа сатан сэтгэлийн хөдлөлөөр дамжуулан биднийг уруу татдаг. Биднийг ганцаардмал, эргэлзсэн эсвэл сэтгэлийн хямралтай байхыг тэр мэддэг. Тэр энэ хүнд цаг мөчийг ашиглан ариун явдлын хууль зөрчихөд биднийг уруу татдаг. Тэнгэрлэг Эцэг энэ саад тотгорыг бие болон сүнслэг байдлаар өртөж гэмтэлгүйгээр даван туулах хүчийг бидэнд өгч чадна.

Судруудад өөрийн эзэн Потиферт агуу итгэлтэй байсан Иосеф хэмээх зөв шударга залуу хөвгүүний талаар өгүүлдэг. Потифер

өөрт байсан бүхний дээр захирах эрхийг Иосефт өгсөн. Потиферын эхнэр Иосефын араас тачаадан зуурч, түүнийг завхайрах үйлдэлд уруу татсан. Гэвч Иосеф түүнийг эсэргүүцэн, зугтсан (Эхлэл 39:1–18).

Паул “Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм” гэж заасан (1 Коринт 10:13). Бид “Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган, түүний ариун нэрийг дуудаж, мөн та нар өөрсдийн үүрч чадахаас илүүгээр уруу таталтанд автагдахгүйн тулд үргэлж сэрэмжилж мөн залбираасай” гэдгийг Алма тодотгосон (Алма 13:28).

- Даруу байдал ариун явдал хоёр ямар холбоотой вэ? Эцэг эхчүүд хүүхдүүдээ хувцаслалт, хэл яриа болон зан төлөвөөрөө даруу байхыг хэрхэн зааж чадах вэ?
- Порнографын тархалт болон нөлөөтэй бид хэрхэн тэмцэлдэж чадах вэ?
- Сатаны уруу таталтыг даван ялахад туслах ямар амлалтуудыг Их Эзэн бидэнд өгсөн бэ?

### **Ариун явдлын хуулийг зөрчих нь тун ноцтой нүгэл**

Түүний хөвгүүдийн нэг нь ариун явдлын хуулийг зөрчсөнд бошиглогч Алма гүнээ харууссан. Алма өөрийн хүү Кориантонд “Хүү минь, Их Эзэний мэлмийд эдгээр зүйл жигшүүрт хэрэг гэдгийг; тийм ээ, гэмгүй цусыг урсгах эсвээс Ариун Сүнснийг үгүйсгэхээс бусад бүх нүглүүдээс хамгийн жигшүүрт зүйл болохыг чи мэдэхгүй гэж үү?” гэж хэлсэн (Алма 39:5). Ариун явдалгүй байх нь аллага үйлдсэнтэй зэрэгцэх ноцтой үйлдэл.

Хэрэв эрэгтэй эмэгтэй хоёр хүн ариун явдлын хуулийг зөрчин хүүхэдтэй болсон аваас тэд бас нэгэн нүгэл болох үр хөндүүлэх үйлдэлд уруу татагддаг. Үр хөндүүлэх маш цөөхөн шалтгаан

---

**Багш нарт зориулж:** Даруу зохистой байдал ба ариун явдлын талаарх асуултуудад хариулахдаа тусламж авахыг хүсвэл та хангамжийн алба, цуглааны байрууд болон *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (36550) гарын авлагыг LDS.org хаягаас авч болно.

байдаг. Сүмийн удирдагчид жирэмслэлт нь цус холилдох эсвэл хүчиндүүлсэн, эхийн амь нас эсвэл эрүүл мэндэд онцгой аюул учруулах эсвэл ноцтой гаж согогтойн учир үр хөрвөл нь төрсний дараа амьдрах боломжгүй гэдгийг чадварлаг эмч нар тогтоосон зэрэг тохиолдолд үр хөндөлтийг зөвтгөх боломжтой гэж хэлсэн. Гэхдээ эдгээр шалтгаанууд ч үр хөндөлтийг шууд зөвтгөх боломжгүй. Эдгээр нөхцөлүүд тулгарсан хүмүүс үр хөндөлтийг зөвхөн орон нутгийнхаа сүмийн удирдагч нартай зөвлөлдөж, чин сэтгэлийн залбирлаар дамжуулан баталгааг хүлээн авах ёстой.

“Гэрлэлтээс гадуур хүүхэдтэй болсон эрэгтэй юм уу эмэгтэйг бүх талаар нь гэрлэхийг дэмжин урамшуулах ёстой. Насны болон бусад шалтгааны улмаас гэрлэлтээс гадуур эцэг эх болсон хүмүүс хүүхдээ ариун сүмд орох зөв зохистой эцэг эхтэй лацлагдагдаж болохын тул Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Гэр бүлийн Үйлчлэлээр дамжуулан хүүхдээ өргүүлэх ажлыг зохион байгуулах талаар зөвлөлдөх ёстой (2002 оны 6-р сарын 26 ба 2002 оны 7-р сарын 19-ны Тэргүүн Зөвлөлийн захидал).

Түүний хүүхэд ариун явдлын хуулинд дуулгавартай байх нь Тэнгэрлэг Эцэгт маш чухал. Хуулийг зөрчсөн буюу үүнийг хийлгэхээр бусдад нөлөөлсөн сүмийн гишүүд сүмийн сахилга батыг зөрчигч болно.

### **Ариун явдлын хуулийг зөрчсөн ч уучлагдаж чадна**

Ариун явдлын хуулийг зөрчсөн тэдгээрт амар амгалан ирж болно. Их Эзэн бидэнд “Гэвч хэрэв хорон муу хүн өөрийн үйлдсэн хамаг нүглээс эргэж, Миний бүх тогтоолыг сахин, шударга, үнэн зөвийг үйлдэх аваас тэр нь заавал амьдарна. Тэр үхэхгүй” гэж заасан (Езекиел 18:21–22). Амар амгалан зөвхөн уучлалтаар ирдэг.

Ерөнхийлөгч Кимбал “Бүх уучлалт өөрийн нөхцөлтэй байдаг. Мацаг барилт, залбирал, даруу төлөв зан нь нүгэлтэй адил эсвэл илүү агуу байх ёстой. Гэмшсэн сэтгэл, харууссан зүрхтэй байх ёстой. Зүрх сэтгэлийн жинхэнэ өөрчлөлт, харууслын нулимс байх ёстой. Нүглээ хүлээн зөвшөөрч, хилэнцийг бүрэн

орхиж, Их Эзэнээс зохистой эрх мэдлийг олгогдсон сүмийн удирдагчдын өмнө буруугаа хүлээх ёстой” (*The Miracle of Forgiveness* [1969], 353).

Олон хүний хувьд буруугаа хүлээх нь наманчлалын хамгийн хүнд хэсэг байдаг. Бид зөвхөн Их Эзэнд буруугаа хүлээх бус нөхөр юм уу эхнэр, зохистой санваарын эрх мэдэлтэн болон гомдоосон хүндээ буруугаа хүлээх ёстой. Санваарын удирдагч (бишоп эсвэл гадасны ерөнхийлөгч) нар сүм дэх байр суурийг маань шийдэх болно. Их Эзэн Алмад: “Миний эсрэг зөрчил үйлдэх хэнийг боловч, мөн хэрэв тэр чиний өмнө мөн миний өмнө нүглүүдээ тоочиж, мөн чин зүрхний угаас наманчлах аваас, түүнийг та нар уучлах болно; мөн түүнчлэн би түүнийг өршөөх болно” гэж хэлсэн (Мозая 26:29).

Харин Ерөнхийлөгч Кимбал: “Хэдийгээр уучлалт нь элбэгээр амлагдсан ч бүрэн наманчлаагүй бодгальд уучлалын амлалт, шинж тэмдэг гэж үгүй. Бид хүмүүсийг нүглээ олон дахин давтан хийж, давтагдсан уучлалд найдах бүрт нүгэл бүү үйлд, уучлагдсан бай хэмээн тэднийг хүчээр сануулж чадахгүй (*The Miracle of Forgiveness* 353, 360). Уучлалыг хүлээн авагч тэдгээр нь нүглээ давтан хийх аваас урьдын нүглүүд нь эргэж ирэх болно (С ба Г 82:7; Ефер 2:15).

### **Ариун явдлын хуулийг сахигч нь агуу ихээр адислагдана**

- Ариун явдлын хуулийг сахиснаар ямар адислалуудыг бид хүлээн авдаг вэ?

Бид ариун явдлын хуульд дуулгавартай байх аваас гэмшил харуусал эсвэл ичих зүйлгүй амьдрах болно. Бид Их Эзэний өмнө толбогүй цэвэр байх аваас бидний болон хүүхдүүдийн минь амьдрал адислагдах болно. Хүүхдүүд маань бидний үлгэр жишээг харж, бидний мөрийг дагах болно.

### **Нэмэлт судрууд**

- Матай 19:5–9; Эхлэл 2:24 (гэрлэлтийн харилцаа нь ариун нандин зүйл)
- Тит 2:4–12 (ариун явдлын зааврууд)
- 1 Коринт 7:2–5; Ефес 5:28 (хосдоо үнэнч шударга бай)
- Илчлэлт 14:4–5 (ариун явдлын хуулинд дуулгавартай байснаар ирэх адислалууд)
- Сургаалт үгс 31:10 (ариун журам магтагддаг)
- Алма 39:9 (өөрийн нүдээр тачаадахыг бүү хий)
- С ба Г 121:45 (ариун журам тасралтгүйгээр чиний бодлыг тань чимэг)
- Алма 42:16 (наманчлал шийтгэлгүйгээр ирдэггүй)
- Алма 42:30 (нүгэл үйлдсэнээ бүү шалтаглан зөвтгө)
- С ба Г 58:42–43 (наманчлагч нь буруугаа хүлээж нүглүүдээ орхидог)



# Гэр бүлийн түүх ба Ариун Сүмийн ажил

Бүлэг 40

---

## **Тэнгэрлэг Эцэг хүүхдүүдээ эргэн ирээсэй гэж хүсдэг**

Бид амилуулагдаж, мөнхөд амьдрах боломжийг Есүс Христийн Цагаатгал өгсөн. Гэхдээ Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд гэр бүлээрээ хамтдаа амьдрахын тулд бид Аврагчийн хий гэж зарлигласан бүгдийг хийх ёстой. Үүнд баптисм хүртэж, гишүүнээр батлагдах, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авах ордог.

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бид зохих ёсны санваарын эрх мэдлээр баптисм хүртэж, гишүүнээр батлагдсан. Бид ариун сүмд очиж тэнд гүйцэтгэгддэг авралын ёслолуудыг хүлээн авдаг. Гэхдээ Бурханы олон хүүхдэд ийм боломж байдаггүй. Тэд сайн мэдээг хүлээн авах боломжгүй цаг үед юм уу газар нутагт амьдарч байсан байж болно.

Тэнгэрлэг Эцэг бүх хүүхдээ эргэн ирж, Өөртэй нь хамт амьдраасай хэмээн хүсдэг. Тэрээр баптисм эсвэл ариун сүмийн ёслолуудыг хүлээн авалгүй нас барсан хүмүүст боломж олгосон. Тэр биднийг ариун сүмд өвөг дээдсийнхээ төлөө ёслолуудыг гүйцэтгэхийг хүсдэг.

## **Их Эзэний Ариун сүмүүд**

- Бидний амьдралд ариун сүм яагаад чухал вэ?

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ариун Сүмүүд нь Их Эзэнд зориулан онцгойлон адисалсан чухал барилгууд юм. Зөв зохистой сүмийн гишүүд тийш орж, бурхантай гэрээ хийж, нандин ёслолуудыг хүлээн авдаг. Эдгээр гэрээ болон ёслолууд нь

---

**Багш нарт зориулж:** Зургууд суралцагсдын сонирхлыг татаж ойлголтыг нэмэгдүүлнэ. Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдийг энэ бүлэгт буй ариун сүмийн зургуудыг харах үедээ ариун сүмийн ажлын талаар тунгаан бодохыг хүс.



баптисмын адил бидний авралд зайлшгүй хэрэгтэй. Тэдгээр нь Их Эзэний ариун сүмд гүйцэтгэгдсэн байх ёстой.

Бид мөн Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христийн талаар илүү их сурч мэдэхийн тулд Ариун сүмд очдог. Бид амьдралынхаа зорилго болон Их Эзэн мөн Есүс Христтэй харилцах харьцааныхаа талаар илүү сайн ойлголтыг олж авдаг. Бид өмнөх амьдрал, дэлхийн амьдралын утга учир, үхлийн дараах амьдралын талаар суралцдаг.

### **Ариун Сүмийн ёслолууд гэр бүлүүдийг мөнхөд хамтад нь холбон лацаддаг**

- Лацагдан холбогдоно гэдэг юу гэсэн үг вэ?

Ариун сүмийн бүх ёслолуудыг санваарын хүчээр гүйцэтгэдэг. Энэ хүчээр дамжуулан энэ дэлхий дээр гүйцэтгэсэн ёслолууд нь тэнгэрт лацагддаг буюу холбогддог. Аврагч Өөрийн Төлөөлөгч нартаа, “Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно” хэмээн заасан (Матай 16:19; мөн С ба Г 132:7).

Зөвхөн ариун сүмд гэр бүлүүд мөнхөд холбогдож чадна. Хэрэв тэд гэрээндээ үнэнч байх аваас эхнэр нөхөр болсон эрэгтэй эмэгтэй хоёрыг ариун сүмийн гэрлэлт мөнхөд холбодог. Баптисм ба бусад бүх ёслолууд бидэнд энэ нандин үйл явдалд бэлтгэдэг.

Эрэгтэй эмэгтэй хоёр ариун сүмд гэрлэснээс хойш мэндлэх хүүхдүүд нь мөн тэдний мөнхийн гэр бүлийн нэгэн хэсэг нь болдог. Иргэний журмаар гэрлэлтээ батлуулсан хосууд ариун сүмд явж холболтыг хийлгэж адислалуудыг хүлээн авч болно. Хуулийн дагуу хүүхэд өргөж авсан эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ лацдуулан холбуулж болно.

- Гэрлэлтээ холбуулахын тулд хосууд юу хийх хэрэгтэй вэ?

### **Өвөг дээдэст маань бидний тусламж хэрэгтэй**

- Санваарын ёслолуудыг хүлээн авалгүй нас барсан өвөг дээдсийнхээ төлөө бид ямар хариуцлага хүлээдэг вэ?

1882 онд Марио Каннамела Мариа Витта нар гэрлэжээ. Тэд Италийн Трипанид амьдардаг байсан ба олон жилийн турш хамт

---

амьдарч, сайн сайхан үр хүүхдийг өсгөн хүмүүжүүлжээ. Марио, Мариа хоёр амьдралынхаа турш Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаар сонсоогүй аж. Тэд баптисм хүртээгүй байв. Тэд ариун сүмд очих боломж тохиогоогүй учраас мөнхийн холболтыг хийлгэх боломж байсангүй. Нас барсны дараа тэдний гэрлэлт цуцлагджээ.

Зуу гаруй жилийн дараа агуу нэгдэл болсон юм. Марио, Мариа нарын үе удам тэдний гуч хүү эхнэрийнхээ хамт Лос Анжелесын Ариун Сүмд очиж, тахилын ширээний өмнө өвдөглөн сууж, Марио, Мариа нарын холболтыг хийлгэжээ. Марио, Мариа нарын баяр баясгаланг хуваалцан, баярын нулимс тэдний нүдэнд дүүрсэн байв.

Сайн мэдээний талаар дэлхий дээр сонсож амжилгүй нас барсан бидний өвөг дээдэс олон байдаг. Тэд одоо сүнсий дэлхийд амьдарч байгаа (энэ номны 41-р бүлгийг үз). Тэнд тэдэнд Есүс Христийн сайн мэдээг заасан. Тэд Сайн мэдээг хүлээн авсан ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэхийг хүлээж байгаа. Бид эдгээр ёслолуудыг ариун сүмд тэдний төлөө гүйцэтгэснээр бид тэдний баяр баяслыг хуваалцаж чадна.

- Авралын сургаал нас барагсдын төлөөх Бурханы шударга ёс, нигүүлсэл, өршөөлийг хэрхэн харуулж байна вэ?
- Өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмийн ажлыг хийхэд та нарт ямар байсан бэ?

### **Гэр бүлийн Түүх—Бид хэрхэн өвөг дээдэстээ тусалж эхлэх вэ**

- Гэр бүлийн түүхийг юунаас эхлэх вэ?

Хожмын үеийн Гэгээнтнүүд гэр бүлийн түүхийн үйл ажиллагаануудад оролцдог. Эдгээр үйл ажиллагаануудаар дамжуулан бид өвөг дээдсийнхээ талаар суралцаж, тэдний төлөө ёслолуудыг гүйцэтгэдэг. Гэр бүлийн түүх нь үндсэн гурван үе шаттай:

1. Өвөг дээдсээ таньж тогтоох.
2. Аль өвөг дээдэстээ ариун сүмийн ажил гүйцэтгэх хэрэгтэйг олж мэдэх.

### 3. Ёслолууд гүйцэтгэсэн эхэд анхаар

Ихэнх тойрог ба салбарууд асуултанд чинь хариулж, хэрэгтэй мэдээлэл уруу чиглүүлэх гэр бүлийн түүхийн зөвлөхүүдтэй. Хэрэв тойрог эсвэл салбарт гэр бүлийн түүхийн зөвлөх байхгүй бол бишоп эсвэл салбарын ерөнхийлөгч зааврыг өгнө.

#### *Өвөг дээдсээ таньж тогтоох*

Өвөг дээдсийнхээ ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэхийн тул бид тэдний нэрийг мэдэх хэрэгтэй. Өнөө үед өвөг дээдсийнхээ нэрсийг тогтооход туслах олон янзын гайхамшигтай нөөц эх үүсвэрүүд байна.

Өвөг дээдсийнхээ талаар мэдээлэл цуглуулах ажлаа эхлүүлэх нэг сайн арга бол гэрт маань юу байгааг судлах. Бидэнд төрсөний гэрчилгээ, гэрлэлтийн баталгаа эсвэл нас барсаны гэрчилгээ баримт байж магад. Бидэнд мөн гэр бүлийн Дурсамжийн ном (гэр бүлийнхний төрсөн, нас барсан зэрэг онцгой тохиолдлуудыг эсвэл түүх бичигдсэн) эмгэнэл, гэр бүлийн түүх эсвэл тэмдэглэлийн дэвтэр, гар бичмэл байж болох юм. Дээр нь бид ахан дүүсээсээ мэдээлэл авч болно. Гэртээ болон хамаатан садангаасаа мэдээлэл цуглуулсны дараа бид бусад эх үүсвэрүүдээс FamilySearch.org сайтаас мэдээлэл хайж болно. Мөн орон нутгийнхаа Сүмийн гэр бүлийн төвүүд дээр очиж болно.

Бид хир зэрэг зүйл мэдэх нь ямар мэдээлэл бидэнд боломжтой байхаас хамаарна. Бидэнд зөвхөн өөрсдийн эцэг эх, эмээ өвөөгөөс хэтрэхгүй гэр бүлийн багахан мэдээлэл байж болох юм. Хэрэв бидэнд бэлэн гэр бүлийн түүхийн удмын бичээс байгаа бол бид бүр хэдэн үеийн өмнөх өвөг дээдсээ тогтоож болно.

Бид гэр бүлийн бичээс ба удмын бичиг дээр үргэлжлүүлж болно.

#### *Аль өвөг дээдэст маань ариун сүмийн ёслолууд хэрэгтэйг олж мэд*

Сүмийн эртний өдрүүдээс эхлэн нас барагсдын төлөөх ариун сүмийн ёслолууд хийгдэж эхэлсэн. Тийм учраас бидний элэнц хуланцын төлөөх зарим ёслолууд хийгдсэн байж болно. Аль өвөг дээдэст маань ариун сүмийн ёслол хэрэгтэй байгааг олж мэдэхийн тулд бид хоёр газарт хайж болно. Гэр бүлийн бичээс

---

дээр чинь энэ тухай мэдээлэл байж болно. Хэрэв байхгүй бол ариун сүмд гүйцэтгэсэн бүх ёслолуудын талаарх мэдээлэл сүмд байдаг. Танай тойрог эсвэл салбарын гэр бүлийн түүхийн зөвлөх үүнд тусалж чадна.

### *Ёслолууд гүйцэтгэсэн эсэхэд анхаар*

Сүнсний дэлхий дэх өвөг дээдсүүд маань ариун сүмийн ёслолуудыг тэсч ядан хүлээж байгаа. Бид өвөг дээдсийнхээ нэрсийг аль болох түргэн олж тогтоогоод тэдний төлөө хийлгэх ажилд бэлтгэх ёстой.

Гэр бүлийн түүхийн ажлын нэг гайхамшигтай хэсэг бол ариун сүмд очиж, элэнцийнхээ төлөө ёслолуудыг гүйцэтгэх юм. Бид ариун сүмийн зөвшөөрлийн бичгээ авахад бэлтгэснээр, боломж тохиоход энэ ажлыг хийж чадна. Хэрэв бидний хүүхэд 12 ба түүнээс дээш настай бол тэд өвөг дээдсийнхээ төлөө баптисм хүртэж, гишүүнээр батлагдах ёслолуудыг хийлгэж, адислалуудыг хуваалцаж чадна.

Хэрэв бид ариун сүмд очиж ёслолуудад оролцох боломжгүй бол бусад сүмийн гишүүд тэдгээр ёслолуудыг гүйцэтгэх ажлыг ариун сүм зохицуулдаг.

- Их Эзэн та нарт эсвэл танай гэр бүлийн гишүүдэд өвөг дээдсийнхээ талаарх мэдээллийг олоход хэрхэн тусалсан бэ?

### **Гэр бүлийн түүхийн нэмэлт боломжууд**

- Завгүй хүн гэр бүлийн түүхийн ажилд хэрхэн оролцох вэ?

Өөрсдийн мэддэг өвөг дээдсийнхээ төлөөх ариун сүмийн ёслолуудад бэлтгэх явцаа бид сүнсний дэлхий дэх тэдгээрт бусад олон замаар тусалж болдог. Бид юу хийх талаар залбиралтайгаар эргэцүүлэн бодохдоо Сүнсний удирдамжийг эрэлхийлэх хэрэгтэй. Бид тухайн нөхцөл байдлаасаа шалтгаалан дараах зүйлсийг хийж болно. Үүнд:

1. Аль болох олон ойр ойрхон ариун сүмд ор. Бид өөрсдийнхөө төлөө ариун сүмд орсны дараа сүнсний дэлхий дээр хүлээж буй тэдгээрийн төлөө аврагдах ёслолуудыг гүйцэтгэж чадна.

2. Олж тодруулахад илүү хүндрэлтэй өвөг дээдсийнхээ талаар сайн судал. Гэр бүлийн түүхийн зөвлөхүүд биднийг хэрэгтэй эх үүсвэрүүд уруу хөтөлж чадна.
  3. Сүмийн индексжүүлэх хөтөлбөрт тусал. Энэ хөтөлбөрөөр дамжуулан гишүүд Сүмийн гэр бүлийн түүхийн комьютерийн програмууд ашиглан үе удмын мэдээллийг бэлтгэдэг. Эдгээр програмууд бидэнд өвөг дээдсээ олж тогтооход тусалдаг.
  4. Гэр бүлийн мэдээллээ Сүмийн одоогийн гэр бүлийн түүхийн компьютер програмууд уруу оруулан мэдээллийн санг баяжуул. Тэдгээр програмууд дэлхий даяарх хүмүүсийн оруулсан үе удмын мэдээллийг багтаасан байдаг. Эдгээр нь хүмүүст гэр бүлийн мэдээллээ бусадтай хуваалцах боломжийг олгодог. Гэр бүлийн түүхийн зөвлөхүүд Сүмийн компьютер програмуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч чадна.
  5. Гэр бүлийн байгуулагуудад оролц. Бид бусад гэр бүлийн гишүүдтэйгээ хамтдаа ажиллах аваас илүү их мэдээллийг олж чадна.
- Ариун сүм ба гэр бүлийн түүхийн ажилд оролцох оролцоогоо ихэсгэхийн тулд юу хийж чадах талаараа бод.

### **Нэмэлт судрууд**

- 1 Петр 4:6 (сайн мэдээ нас барагсдад номлогдсон байсан)
- Малахи 4:5–6; С ба Г 2:2; 3 Нифай 25:5–6 (Елиагийн номлол)
- 1 Коринт 15:29; С ба Г 128:15–18 (нас барагсдын төлөөх ажил)
- С ба Г 138 (үхэгсдийн гэтэлгэл)

# Зуурдын амьдралын дараах Сүнсний дэлхий

Бүлэг 41

---

## Үхлийн дараах амьдрал

- Бид нас барсны дараа юу болдог вэ?

Тэнгэрлэг Эцэг бидэнд авралын төлөвлөгөөг бэлтгэсэн. Энэ төлөвлөгөөний нэг хэсэг нь Тэр биднийг энэ дэлхийд амьдруулж, яс махнаас бүрдэх мөнх бус биеийг хүлээн авахуулахаар Өөрийн оршихуйгаас нааш илгээсэн. Эцэстээ бидний мөнх бус бие үхэх болно. Харин бидний сүнс маань сүнсний дэлхийд очих болно. Сүнсний дэлхий нь хүлээх, ажиллах, суралцах харин зөв шударга хүмүүсийн хувьд зовнил ба харамслаасаа холдох тайвшрах газар юм. Бидний сүнс бид дахин амилахад бэлэн болтол амьдрах болно. Дараа нь бидний мөнх бус бие бидний сүнстэй нэгдэн нийлж, бидэнд бэлтгэсэн алдар суугийн зэргийг хүлээн авах болно (энэ номны 46-р бүлгийг үз).

Олон хүн сүнсний дэлхий ямар байдаг бол хэмээн гайхан боддог. Судрууд болон хожмын үеийн бошиглогчид бидэнд сүнсний дэлхийн тухай мэдээллийг өгсөн.

- Үхлийн дараа амьдрал байдаг гэсэн мэдлэг та нарыг хэрхэн тайвшруулдаг вэ? Бусдыг тайтгаруулахын тулд сүнсний дэлхийн талаарх мэдээгээ бид хэрхэн ашиглаж болох вэ?

## Зуурдын амьдралын дараах Сүнсний дэлхий хаана байдаг вэ?

Хожмын үеийн бошиглогчид нас барагсдын сүнс биднээс холгүй оршдог хэмээн хэлдэг. Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон: “Заримдаа энэ амьдрал ба дараах амьдралын хоорондох хөшиг маш нимгэхэн мэт болдог. Нас барсан бидний хайрт хүмүүс

---



биднээс холгүй байдаг” (Conference Report , 1971 оны 4-р сар, 18; эсвэл *Ensign*, 1971 оны 6-р сар, 33) гэжээ. Ерөнхийлөгч Бригам Янг сүнсний дэлхий энэ дэлхий дээр бидний эргэн тойронд байдаг гэж заасан (*Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997], 279).

### **Бидний сүнс ямар шинж чанартай вэ?**

Сүнсэн биетүүд мөнх бус биеийн адил хэлбэр дүрстэй. Харин сүнсэн бие төгс хэлбэрт байдаг (Ифер 3:16). Сүнснүүд дэлхийгээс өөрсдийн сүсэг бишрэлтэй байх төрх байдал эсвэл зөв шударгын эсрэг байх дайсагналаа хамт авч явдаг (Алма 34:34). Тэд дэлхий дээр амьдарч байсан шиг адил хүсэл эрмэлзэл, тэмүүлэлтэй байдаг. Бүх сүнс насанд хүрсэн хэлбэрт байдаг. Тэд мөнх бус амьдралынхаа өмнө насанд хүрсэн байсан. Тэд нярай эсвэл бага хүүхэд байхдаа нас барсан ч үхлийн дараа насанд хүрсэн хэлбэрт байдаг (*Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* [1998], 131–32).

- Сүнсний дэлхийд бидний сүнс одоо байгаатай адил хүсэл эрмэлзэлтэй байна гэдгийг мэдэх яагаад чухал вэ?

### **Зуурдын амьдралын дараах Сүнсний дэлхийд нөхцөл байдал ямар байх вэ?**

Мормоны Номын бошиглогч Алма сүнсний дэлхий дэх хоёр зааг буюу нөхцдийн талаар заасан. Энэ нь:

“Зөв шударга тэдний сүнс тэд өөрийн бүх бэрхшээлүүд мөн санаа зоволт хийгээд харамслаасаа амрах диваажин гэж нэрлэгдсэн аз жаргалын байдал, амар амгалангийн байдал, энхийн байдалд хүлээн авагдах болно.

“Мөн тэгээд улиран тохиох дор, ёс бусыг үйлдэгчдийн, тийм ээ, хүлэнцэт тэдний сүнснүүдэд, учир нь болгоогтун, Их Эзэний Сүнсний ямар ч хэсэг эсвээс хувь тэдэнд үгүй билээ; учир нь болгоогтун, тэд сайнаас илүүтэйгээр хилэнцэт үйлийг сонгосон бөлгөө; тиймийн тул чөтгөрийн сүнс тэдэнд орж, мөн тэдний гэрийг эзэмшилдээ авсан юм, мөн эдгээр нь гадаад харанхуйд хаягдах болно; уйлаан, мөн гаслан, мөн шүдээ хавирах нь байх



болно, мөн энэ нь чөтгөрийн тааллаар боолчлогдсон учир өөрсдийнх нь алдас болой.

“Эдүгээ энэ бол ёс бусыг үйлдэгчдийн сүнсний байдал болой, тийм ээ, харанхуйд, мөн тэдний дээр ирэх Бурханы уур болох галт хилэнг айн харуулахын аймшигт байдалд буюу; тийн тэд энэ байдалд, түүнчлэн зөв шударгыг үйлдэгчид диваажинд, өөрсдийн амилуулалтын цагийг хүртэл үлдэнэ” (Алма 40:12–14).

Сүнснүүд дэлхий дээрх амьдралынхаа цэвэр байдал, Их Эзэний таалалд дуулгавартай байдлынхаа дагуу ангилагдана. Зөв шударга ба ёс бусчууд хоорондоо зааглагдана (1 Нифай 15:28–30). Гэхдээ сүнснүүд сайн мэдээний зарчмуудыг суралцаж, тэдгээрийн дагуу амьдарснаар өсч хөгжиж болно. Диваажин дахь сүнснүүд шоронд буй сүнснүүдэд зааж болно (С ба Г 138).

### *Диваажин*

Бошиглогч Алмагийн хэлсний дагуу зөв шударгын сүнснүүд дэлхийн зовнил, харамслаасаа амрах болно. Тэгсэн ч тэд Их Эзэний ажлыг хийж завгүй байх болно. Есүс Христ цовдлогсоныхоо дараа удалгүй зөв шударга сүнсний дэлхийд очсоныг Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит үзэгдэлд харсан. Тэр элч нарыг томилж, тэдэнд хүч чадал хийгээд эрх мэдлийг өгч, тэдэнд “мөн урагш одон харанхуйд байсан тэдэнд, бүр хүмүүний бүх сүнснүүдэд сайн мэдээний гэрлийг хүргэ” хэмээх итгэмжлэлийг олгов (С ба Г 138:30).

Сүм сүнсний дэлхийд зохион байгуулагдаж, санваарыг атгагчид тэнд өөрсдийн үүрэг хариуцлагыг үргэлжлүүлэв (С ба Г 138:30). Ерөнхийлөгч Вилфорд Вүүдраф заахдаа: “Хөшигний нөгөө талд санваарын ижил хүч байдаг. Төлөөлөгч бүр, Далын гишүүн бүр, Ахлагч бүр гэх мэт итгэлд нас барсан тэдгээр нь хөшигний нөгөө талд очингуутаа санваартны ажилдаа ордор” (*Deseret News*, 1882 оны 1-р сарын 25, 818).

---

**Багш нарт зориулж:** Ангийн эсвэл гэр бүлийн гишүүд диваажин ба сүнсний шоронгийн хоорондох ялгааг ойлгоход нь туслахын тул самбарын юм уу том цаасны голд босоо шугам татаж хоёр багана болго. Нэг баганын дээд талд нь *Зөв шударгын нөхцөл байдал гэж бич*. Нөгөө баганын дээд талд нь *Ёс бусын нөхцөл байдал гэж бич*. Энэ хэсгээс уншиж мэдсэн зүйлээсээ сүнсний дэлхийн нөхцөл бүрийг тодорхойлон хэлэхийг хүс. Зохих багана дээр тэдний хэлсэн зүйлсийг нэгтгэн бич.

Гэр бүлийн харилцаа холбоо мөн чухал Бригам Янгын зөвлөх, Ерөнхийлөгч Жедедиах М.Грант сүнсний дэлхийг харсан. Тэгээд Хебер С.Кимбалд тэнд байдаг зохион байгуулалтын талаар тайлбарлан хэлэхдээ: “Тэнд харсан хүмүүс гэр бүлүүд болон зохион байгуулагдсан байв. Тэр хэлэхдээ: ‘Гэр бүлүүдийг харахад заримд нь дутмаг зүйл буйг би харав. Учир нь тэдгээр гэр бүлүүд энэ дэлхийд байхдаа өөрсдийн дуудлагад үнэнч байгаагүй тул тэдгээр гэр бүлүүдэд хамтдаа амьдрахыг зөвшөөрөөгүй болохыг би харсан’” гэжээ (*Deseret News*, 1856 оны 12-р сарын 10, 316–17).

### *Сүнсний шорон*

Төлөөлөгч Паул зарим нэгний хувьд сүнсний дэлхий шорон мэт байна гэжээ (1 Петр 3:18–20). Сүнсний шоронд Есүс Христийн сайн мэдээг хараахан хүлээж аваагүй сүнснүүд байна. Тэдгээр сүнснүүдэд сайн ба муугийн аль нэгнийх нь нөлөөнд орох сонгох эрх байгаа. Хэрэв тэд сайн мэдээ болон тэдний төлөө ариун сүмүүдэд гүйцэтгэгдсэн ёслолуудыг хүлээн зөвшөөрвөл сүнсний шоронгоос суллагдаж, диваажинд амьдрах болно.

Мөн энэ дэлхий дээр байна уу сүнсний шоронд байна уу хамаагүй, тэдэнд заагдсаны дараа сайн мэдээг эсэргүүцэх сүнснүүд сүнсний шоронд байдаг. Эдгээр сүнснүүд там хэмээх нөхцөл байдалд зовон шаналдаг. Тэд өөрсдийгөө “Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ; гэвч хэрэв тэд үл наманчлах аваас, бүр миний адилаар тэд зовох ёстой; бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн тэрхүү зовлон” хэмээн хэлсэн Есүс Христийн нигүүлслээс холдуулсан (С ба Г 19:16–18). Нүглүүдийнхээ улмаас зовон шаналсаны дараа тэд Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан алдар суугийн доод зэрэг болох телестиаал хаант улсыг эзэмших болно.

- Сүнсний дэлхий дэх нөхцөл энэ дэлхийн нөхцөл байдалтай хэрхэн адил байна вэ?

### **Нэмэлт судрууд**

- 1 Петр 4:6 (сайн мэдээ нас барагсдад номлогддог)
- Мосе 7:37–39 (сүнсний шорон ёс бусчуудад бэлтгэгдсэн)
- С ба Г 76 (алдар суугийн гурван хаант улсын тухай илчлэлт)
- Лук 16:19–31 (сүнсний дэлхий дэх гуйлгачин ба баян хүний хувь заяа)

# Израилын овгийг нэгтгэх нь

Бүлэг 42

---

## **Израилын овог нь Бурханы гэрээт хүмүүс**

- Дэлхийн үндэстэнгүүдийн төлөө Бурханы гэрээт хүмүүс ямар үүрэг хариуцлагыг хүлээдэг вэ?

Иаков Христийг ирэхээс олон зуун жилийн өмнө амьдарч байсан бошиглогч юм. Иаков итгэлтэй байсан тул Их Эзэн түүнд “Бурхантай хамт ялсан нэгэн” эсвэл “Бурханыг ялуулсан” гэсэн утгатай Израил хэмээх онцгой нэрийг өгсөн (Судруудын удирдамж, “Израил,” 98). Иаков арван хоёр хүүтэй байв. Тэдгээр хөвгүүд болон тэдний гэр бүлүүд Израилын арван хоёр овог буюу Израилчууд хэмээгдэх болсон (Эхлэл 49:28).

Иаков Абрахамын ач хүү байсан. Их Эзэн Абрахамтай хийсэн мөнхийн гэрээгээ Исаак, Иаков ба түүний хөвгүүдтэй шинэчлэн хийсэн (энэ номны 15-р бүлэг; мөн энэ бүлэг Иаков өөрийн хөвгүүдийг адислаж буйг дүрсэлсэн зургийг үз. Түүний зарлигуудад дуулгавартай байх аваас Түүний гэрээт хүмүүс байхыг Израилчуудад Бурхан амласан (Дэд хууль 28:9–10). Тэд сайн мэдээ хийгээд санваарыг дэлхийн бүх үндэстнүүдэд аваачих адислал байх болно (Абрахам 2:9–11). Тиймийн тул тэд Их Эзэнтэй хийсэн гэрээгээ сахиж, Тэр ч тэдэнтэй хийсэн гэрээгээ сахих болно.

## **Израилын овог тарагдсан**

Их Эзэний бошиглогчид Израилын овгийхонд хэрэв тэд ёс бус болвоос юу тохиолдохыг олон дахин анхааруулсан. Мосе “Эзэн чамайг газар дэлхийн нэг өнцгөөс нөгөө өнцөг хүртэл бүх ард

---



түмнүүдийн дунд тараах болно” хэмээн бошигласон (Дэд хууль 28:64).

Энэ анхааруулгыг үл хайхран Израилчууд Бурханы зарлигуудыг байнга зөрчсөөр байсан. Тэд өөр хоорондоо байлдаж, хоёр хаант улс болон хуваагдсан: Израилын хаант улс хэмээн нэрлэгдэх, Хойд Хаант улс ба Еврейн хаант улс хэмээн нэрлэгдэх, Өмнөд Хаант улс Израилын арван хоёр овгийн арав нь Хойд хаант улсад амьдарч байв. Тэд дайнд ялагдаж, дайснуудаа олзлогдож, боолчлогдсон. Хожим нь тэдний зарим нь хойд нутаг уруу зугтаж, дэлхийд тархан төөрөлдсөн.

Өмнөд хаант улс, Хойд Хаант улсыг булаан эзэлснээс 100 гаруй жилийн дараа ялагдсан. Нийслэл хот Иерасулим мЭӨ 586 онд устгагдан, Израилын хоёр овгоос үлдсэн олон гишүүн боолчлогдов. Хожим нь хоёр овгийн зарим гишүүд буцан ирж, Иерасулимыг дахин байгуулсан. Иерасулимыг устгагдахаас өмнөхөн Израилын овгийн гишүүд байсан Лихай ба түүний гэр бүл хотыг орхин, Америкт суурьшсан.

Христийн үеэс хойш Иерасулим дахин устсан ба энэ удаа Ромын цэргүүд устгажээ. Иудейчүүд бараг дэлхий даяар бутран тархсан. Өнөөдөр Израилчуудыг дэлхийн улс орон бүрээс олж болно. Эдгээр хүмүүс өөрсдийгөө эртний Израилын овгийн үр удам гэдгээ мэддэггүй.

- Түүний гэрээт хүмүүс дэлхийд тархсан байх нь Бурханы хүүхдүүдэд ямар тустай байсан бэ?

### **Израилын овог цугларах ёстой**

- Их Эзэн яагаад Өөрийн хүмүүсийг цугларахыг хүссэн бэ?
- Израилын овог хэрхэн цугларах вэ?

Их Эзэн Түүний гэрээт хүмүүс нэгэн өдөр цугларсан байхыг: “Би Өөрөө хонин сүргийнхээ үлдэгсдийг өөрийн хөөн зайлуулсан нутгаас цуглуулна” гэж амласан (Иеремиа 23:3).

Бурхан хүүхдүүдээ номлолын ажлаар дамжуулан цуглуулдаг. Хүмүүс Есүс Христийн талаар мэдлэгтэй болж, авралын ёслолуудыг хүлээн авч, холбогдох гэрээнүүдийг сахиснаар тэд “гэрээт

хүүхдүүд” болдог (3 Нифай 20:26). Тэр Өөрийн хүүхдүүдийг цуглуулах чухал шалтгаан бий. Тэд сайн мэдээний сургаалуудыг суралцаж, өөрсдийгөө Аврагчийг ирэхэд бэлтгэж болохын тул Тэр тэднийг цуглуулдаг. Тэд нандин ёслолуудыг хүлээн авах боломжгүйгээр нас барсан өвөг дээдсийнхээ төлөө ёслолыг гүйцэтгэх, ариун сүмүүдийг барьж болохын тулд Тэр тэднийг цуглуулдаг. Тэд бие биеэ хүчирхэгжүүлж, сайн мэдээнд нэгдэн, дэлхийн буруу нөлөөллөөс хамгаалалтыг олж болохын тул Тэр тэднийг цуглуулдаг. Тэд бусадтай сайн мэдээг хуваалцахад өөрсдийгөө бэлтгэж болохын тулд Тэрээр мөн тэднийг цуглуулдаг.

Израилын овгийг цуглуулах ажлыг удирдах хүч ба эрх мэдэл Иосеф Смитэд 1836 онд Көртландын Ариун Сүмд үзэгдсэн бошиглогч Мосегоор өгөгдсөн (С ба Г 110:11). Тэр цагаас эхлэн бошиглогч бүр Израилын овгийг цуглуулах түлхүүрүүдийг атгаж, энэ цугларалт Сүмийн ажлын чухал нэг хэсэг болсон. Өнөө үед сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авч, Абрахам, Исаак, Иаковын Бурханд үйлчилснээр Түүний гэрээт хүмүүс цугларсаар байна (Дэд хууль 30:1–5).

Израилчууд эхлээд сүнслэг байдлаараа дараа нь бие махбодиор цугларах болно. Тэд Есүс Христийн Хожмын Үеийн гэгээнтнүүдийн Сүмд нэгдэж, нандин гэрээнүүдийг хийж, сахиснаар цугларч байгаа юм. Энэ сүнслэг цугларалт Бошиглогч Иосеф Смитийн үеэс эхэлсэн ба өнөөдөр дэлхий дахинд үргэлжилсээр байна. Сүмийн хөрвүүлэгсэд нь цусан байна уу өргөмөл байна уу хамаагүй Израилчууд билээ. Тэд Абрахам ба Иаковын гэр бүлд харъяалагддаг (Абрахам 2:9–11; Галат 3:26–29).

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлэхдээ: “Сүмд олон янзын үндэстэн ястан байдаг. Тэдний дээр Их Эзэний Сүнс буусан тул тэд цугларалтын *сүнсийг хүлээн авч*, сайн мэдээг эрэлхийлэхийн тулд бүхнийг орхидог” гэсэн (*Doctrines of Salvation*, эмхэтгэл Bruce R. McConkie, 3-р боть . [1954–56], 3:256; налуу бичилт нь эх хувь).

Израилын бие махбодийн цугларалт гэдэг нь гэрээт хүмүүс “тэд өөрсдийн өвлөж авсан нутгууд болох гэртээ цуглуулагдах болно, мөн бүх амлалтын нутгууддаа төвхнүүлэгдэх тэр цагт буюу”

(2 Нифай 9:2). Ефраим ба Манассе нарын овгууд Америкт цугларах болно. Еврейн овог Иерасулим хот болон түүний ойролцоох газруудад эргэн очих болно. Алдагдсан арван овгийнхон Ефраимын овгоос тэдний амлагдсан адислалуудыг хүлээн авах болно (С ба Г 133:26–34).

Сүм анх байгуулагдахад Гэгээнтнүүд Огайд цугларахаар зааварлагдсан. Дараа нь Миссури тэгээд Солт Лейкийн Хөндийд цугласан. Гэсэн ч өнөө үеийн бошиглогчид сүмийн гишүүд өөрсдийн нутгуудад Бурханы хаант улсыг байгуулах болно хэмээн заасан. Ахлагч Рассел М.Нелсон хэлэхдээ: “Христэд ирэх сонголт нь хаана амьдардагаас хамаарахгүй, харин энэ нь хувь хүний амлалтын асуудал юм. Хүмүүс өөрсдийн амьдарч буй орон нутгийг орхилгүй “Их Эзэн Бурханыхаа мэдлэгт тэд авчрагдах болно” [3 Нифай 20:13] Эртний сүмийн гишүүдийн хувьд хөрвүүлэгдэх нь ихэнхдээ цагаачлах шаардлага гардаг байсан. Гэвч одоо цугларалт нь үндэстэн бүрийн нутагт явагдаж байна. Бразилийн Гэгээнтнүүдийн цугларах газар нь Бразил, Нигерийн Гэгээнтнүүдийн цугларах газар Нигер, Солонгосын гэгээнтнүүдийн цугларах газар Солонгос гэх мэтчилэн. Сион нь “зүрх сэтгэлдээ цэвэр.” [С ба Г 97:21. Сион нь зөв шударга Гэгээнтнүүд байгаа газар мөн” (Ерөнхий Чуулган, 2006 оны 10-р сар, 85; эсвэл *Ensign*, 2006 оны 11-р сар, 81).

Израилын бие махбодийн бодит цугларалт нь Аврагчийн хоёр дахь ирэлт, Мянган жилд амьдрахаас нааш гүйцэлдэхгүй (Иосеф Смит—Матай 1:37). Дараа нь Их Эзэний амлалт бүрэн гүйцэлдэх болно:

“Эзэн тунхаглаж байна “Тийм учраас үзэгтүн, ‘Израилын хөвгүүдийг Египет нутгаас гаргасан Эзэний амьд буйгаар тангараглая’ гэж хэлэгдэхгүй;

“Харин ‘Израилын хөвгүүдийг хойд зүгийн нутгаас болон Өөрөө тэднийг хөөж зайлуулж аваачсан бүх орнуудаас авчирсан Эзэний амьд буйгаар тангараглая’ гэж хэлдэг өдрүүд ирж байна. Учир нь Би тэдний эцэг өвгөдөд өгсөн тэдний өөрсдийн нутагт тэднийг авчрах болно” (Иеремиа 16:14–15).



- Та бүхэн хэрхэн Их Эзэний гэрээт хүмүүс болж сүнслэгээр цугларсан бэ?
- Та хэрхэн бусдыг цуглуулах ажилд оролцсон бэ?

### **Нэмэлт судрууд**

- Эхлэл 17:1–8 (Бурханы Абрахамтай хийсэн гэрээ)
- Ром 9:4–8; Галат 3:29 (Есүс Христ ба Түүний үгсийг дагадаг тэдгээр хүмүүс гэрээний хүүхдүүд)
- 2 Нифай 30:2; Мозая 5:10–11 (намаанчилдаг, бошиглогчдыг дагадаг, Есүс Христэд итгэдэг тэдгээр хүмүүс Их Эзэний гэрээт хүмүүс болдог)
- 2 Хаадын дэд 17 (Хойд Хаант улс боолчлолд авчрагдав)
- 2 Шастирын дэд 36:11–20 (Өмнөд Хаант улс боолчлолд аваачигдав)
- Иаков 1:1 (арван хоёр овог гадаадад тараагдав)
- 1 Нифай 10:12–13 (Нифайчуудын цагаачлал нүүдэл бутралтын нэг хэсэг байсан)
- Иеремиа 3:14–18 (хотоос нэг, гэр бүлээс хоёр)
- Езекиел 20:33–36 (Израил бүх улс орноос цуглаарагдах болно)
- 3 Нифай 20:29–46 (Иудейчүүд Иерасулимд цугларах болно)
- 1 Нифай 15:13–18; 3 Нифай 21:26–29 (цугларалт Сэргээгдсэн сайн мэдээний хамт эхэлсэн)
- С ба Г 38:31–33 (Их Эзэний гэрээт хүмүүс аврагдах болно)
- Исаиа 11:11–13 (Их Эзэн Өөрийн хүмүүсийг сэргээх болно)
- Илчлэлт 18:4–8 (цугларалтын дуу хоолой тунхаглагдах болно)
- С ба Г 133:6–15 (Харийнхан Сион уруу, Еврейчүүд Иерасулим уруу)

---

**Багш нарт зориулж:** Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээнд хөрвүүлэгдсэн хүмүүс өөрсдийн түүхийг хуваалцаж байгаа нь сүнслэгээр хэрхэн цугларсан тухай түүхээ хуваалцаж байгаа хэрэг. Хэдэн хүнд урьдчилан сайн мэдээнд хэрхэн хөрвүүлэгдсэн түүхээ хуваалцахыг даалга.

# Хоёр дахь ИРЭЛТИЙН ТЭМДГҮҮД

Бүлэг 43

---

## Есүс Христ Дэлхийд эргэж ирэх болно

- Хоёр дахь ирэлтийн ямар тэмдгүүд байдаг вэ?

Аврагч Иосеф Смитэд “Би тэнгэрээс сүр хүч хийгээд алдар суугаар өөрийгөө үзүүлэх болно, мөн дэлхий дээр зөв шударга ёсонд хүмүүнтэй хамт мянган жил оршин сууна, мөн ёс бусыг үйлдэгчид тэсвэрлэх нь үгүй бөлгөө” гэж хэлсэн (С ба Г 29:11; мөн энэ номны 44 ба 45-р бүлгүүдийг үз). Түүний хоёр дахь ирэлтийн цаг ойртож буйг тодорхой тэмдэг, үйл явдлуудаар анхааруулах болно гэж Есүс бидэнд хэлсэн.

Есүс Христийн дагалдагчид мянгаад жилийн туршид амар амгалан, баяр баяслыг авчрах Хоёр дахь ирэлтийг хүлээн харсаар ирсэн. Гэвч Аврагчийг ирэхээс өмнө дэлхийн хүмүүс агуу уй гашуу, зовлонг үзэх болно. Тэнгэрлэг Эцэг эдгээр гай бэрхшээлд биднийг бэлтгэлтэй байхыг хүсдэг. Тэр мөн Алдар сууд ирэх Аврагчийг ирэхэд нь сүнслэгээр бэлтгэлтэй байхыг биднээс хүсдэг. Тэр бидэнд Аврагчийн хоёр дахь ирэлт ойртсоныг мэдэгдэх тэмдгүүд, үйл явдлуудыг өгсөн. Он жилийн туршид Бурхан эдгээр тэмдгүүдийг бошиглогч нартаа үзүүлсэн. Христийн итгэлтэй бүх дагалдагчид тэмдгүүд ямар байхыг мэдэж, тэдгээрийг эрэлхийлэн харсаар байх болно хэмээн Тэр хэлсэн (С ба Г 45:39). Хэрэв бид дуулгавартай бөгөөд итгэлтэй байх аваас судруудаас судалж, тэмдгүүдийг мэдэх болно.

---

**Багш нарт зориулж:** Ангийн эсвэл гэр бүлийн гишүүд бүрийг энэ бүлэгт гарах нэг эсвэл хоёр тэмдгийн талаар авч үзэхийг даалга (олон хүнтэй анги бол нэг тэмдгийг нэгээс дээш хүнд даалга). Хичээлийн нэг хэсэг болгон тэдэнд бие даан тэмдгүүдийн талаарх мэдээллийг судалж, өнөөдөр биелэгдсэн харсан тэмдгүүдийнхээ талаар бодох цагийг өг. Дараа нь өөр хоорондоо бодлоо хуваалцахыг хүс.



Есүс Христийн хоёр дахь ирэлтийн зарим тэмдгүүд аль хэдийнэ биелэсэн эсвэл одоо биелэгдэж байгааг урьдчилан хэлдэг. Бусад нь ирээдүйд биелэгдэх болно.

*Ёс бус явдал, Дайн ба Үймээн самуун*

Тэмдгүүдийн олонх нь аймшигтай. Бошиглогчид агуу үймээн самуун, ёс бус явдал, дайн ба зовлон уй гашуу байх болно гэдгийг сануулсан. Бошиглогч Даниел Хоёр дахь ирэлтийн өмнөх үе нь дэлхийн хувьд хэзээ ч байгаагүй хүнд цаг болно гэдгийг хэлсэн (Даниел 12:1). Их Эзэн “Мөн хүмүүний хайр хөрч, мөн алдас газар авах болно” (С ба Г 45:27). “Мөн бүх зүйл үймээнд байх болно, учир нь бүх хүмүүс дээр айдас ирэх болно” гэж хэлсэн (С ба Г 88:91). Бид газар хөдлөлт, өвчин эмгэг, өлсгөлөн, хүчтэй шуурганууд, аянга ба цахилгаан гарахыг үзэх болно (Матай 24:7; С ба Г 88:90). Хүчтэй мөндрөн шуурганууд дэлхийн ургацыг устгах болно (С ба Г 29:16).

Есүс шавь нартаа дайн, дэлхийг бүрхэх болно гэдгийг хэлсэн: “Та нар дайн болоод дайны сураг чимээг удахгүй сонсох болно. Үндэстэн үндэстнийхээ эсрэг, хаанчлал хаанчлалынхаа эсрэг босох болно” гэж хэлсэн (Матай 24:6–7). Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ: “Бид зовлонг цаг мөчүүд удахгүй ирэхийг, илд сэлэм, өлсгөлөн, тахал ойртсоныг та нарт хэлэхэд зориг бүү мох. Газрын гадарга дээр аймшигт эвдрэл үгүйрэл болно. Бүх ариун бошиглогчдын бошиглолуудаас нэг зураас нэг үсэг ч гээгдэхгүй бөгөөд үлдсэн нь удахгүй бүрэн гүйцэлдэх болно (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 252).

Эдгээр тэмдгүүдийн олон нь гүйцэлдсэн. Ёс бус явдлууд газар сайгүй байна. Үндэстнүүд тогтмол дайн дажинтай байна. Газар хөдлөлт ба бусад байгалийн гай гамшгууд тохиолдсоор л байна. Олон хүн гамшигт шуурга, ган, өлсгөлөн, өвчин эмгэгүүдэд нэрвэгдэн зовсоор байна. Их Эзэнийг ирэхээс өмнө эдгээр гай гамшгууд улам ноцтой болох магадлалтай .

Гэсэн ч Хоёр дахь ирэлтээс өмнө тохиолдох үйл явдлууд бүгдээрээ хүнд хэцүү бишээ. Ихэнх нь дэлхийд баяр баяслыг авчирдаг.

### *Сайн Мэдээний Сэргээлт*

Их Эзэн “Харанхуйд суугч тэдний дунд гэрэл гийх болно, мөн энэ нь миний сайн мэдээний бүрэн байдал байх болно” гэсэн (С ба Г 45:28). Эртний бошиглогчид сайн мэдээний Сэргээлтийг урьдчилан хэлсэн. Төлөөлөгч Иохан тэнгэрийн элчээр дамжуулан сайн мэдээ сэргээгдэнэ гэдгийг харсан (Илчлэлт 14:6–7). Бошиглолын биелэлт нь тэнгэрийн элч Моронай болон бусад тэнгэрлэг гийчдийн Иосеф Смитэд авчирсан Есүс Христийн сайн мэдээ юм.

### *Мормоны Ном ирсэн нь*

Их Эзэн нифайчуудад бусад тэмдгүүдийн талаар хэлсэн: Мормоны Ном тэдний үр удамд ирэх болно (3 Нифай 21). Хуучин Гэрээний бошиглогч Исаиа болон Езекиел нар Мормоны Ном ирэхийг урьдчилан хэлсэн (Исаиа 29:4–18; Езекиел 37:16–20). Эдгээр бошиглууд одоо биелэгдээд байна. Мормоны Номыг бүх дэлхий хүлээн авсан.

### *Сайн мэдээ бүх дэлхийд тархсан*

Хожмын өдрүүдийн бас нэгэн тэмдэг бол “хаанчлалын энэхүү сайн мэдээ бүх үндэстэнд гэрчлэл болж, дэлхий даяар тунхаглагдана” (Матай 24:14; мөн Иосеф Смит—Матай 1:31). Бүх хүмүүс сайн мэдээний бүрэн байдлыг төрөлх хэл дээрээ сонсох болно (С ба Г 90:11). Сүмийн Сэргээлтээс эхлэн номлогчид сайн мэдээг номлосоор ирсэн. Өнөөдөр номлогчдын хүчин чармайлт улам өсөн нэмэгдсээр хэдэн арван мянган номлогч дэлхийн олон оронд тухайн улсын хэлээр сайн мэдээг номлож байна. Хоёр дахь ирэлтээс өмнө мөн Мянган жилийн туршид Их Эзэн бүх үндэстнийг үнэнийг мэдэх арга замуудаар хангах болно.

### *Елиагийн ирэлт*

Аврагчийн Хоёр дахь ирэлтээс өмнө бошиглогч Елиа дэлхийд илгээгдэх болно хэмээн бошиглогч Малахи бошиглосон. Гэр бүлүүд хамтдаа холбогдож болохын тул Елиа холболтын хүчийг сэргээх болно. Тэр мөн хүмүүс өөрсдийн өвөг дээдэс болон үр удмын төлөө санаа тавихад урамшуулан дэмжих

---

болно (Малахи 4:5–6; С ба Г). Бошиглогч Елиа 1836 оны 4-р сард Иосеф Смит дээр ирсэн. Тэр цагаас хойш удмын бичиг болон гэр бүлийн түүхийг хөтлөх сонирхол нэмэгдсэн. Мөн бид мөн амьд болон нас барагсдын төлөө ариун сүмд холболтын ёслолыг гүйцэтгэх боломжтой.

*Лихайн үр удам агуу хүмүүс болох болно*

Түүний ирэлт ойртох тусам Лэмэнчүүд зөв шударга, хүндэтгэлтэй хүмүүс болох болно хэмээн Их Эзэн хэлсэн. Тэр хэлэхдээ, “Их Эзэний агуу өдөр ирэхийн өмнө лэмэнчүүд сарнай цэцэг лугаа адил дэлгэрэх болно” гэсэн (С ба Г 49:24). Лихайн үр удам олон нь өнөөдөр сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авсаар байна.

*Шинэ Иерасулимьг байгуулах нь*

Есүс Христийн ирэлт ойртох цагт итгэлтэй гэгээнтнүүд Шинэ Иерасулам хэмээн нэрлэгдэх зөв шударгын хотыг, Бурханы хотыг байгуулах болно. Есүс Христ Өөрөө удирдах болно (3 Нифай 21:23–25; Мосе 7:62–64; Итгэлийн тунхаг 1:10). Их Эзэн тус хот нь Нэгдсэн Улсын Миссури мужид байгуулагдах болно гэж хэлсэн (С ба Г 84:2–3).

Эдгээр нь Их Эзэний өгсөн тэмдгүүдийн нэгээхэн хэсэг юм. Судруудад үүнээс олныг дурьддаг.

- Эдгээр тэмдгүүд биелэгдсэн ямар баталгааг та харж байна вэ?

**Цаг үеүдийн тэмдгүүдийг мэдэх нь бидэнд тустай**

- Хэдийгээр зарим тэмдгүүд аймшигтай, айдас төрүүлэм байгаа ч бид хэрхэн амар амгалан тайван байж чадах вэ?

Их Эзэн Хоёр дахь Ирэлтийнхээ талаар “Гэвч тэрхүү цаг хийгээд өдрийг мэдэх хүмүүн үгүй, тэрчлэн элчүүд ч үгүй” гэсэн (С ба Г 49:7). Тэр үүнийг инжрийн модны сургаалт үлгэрээр заасан. Бид инжрийн модны навчис зулзагалахад бид зун ойртжээ гэдгийг мэддэг гэж Тэр хэлсэн. Үүний адил бид судрууд дээр дурьдсан тэмдгүүдийг хараад, Түүний ирэлт ойрхон байгааг мэдэж чадна (Матай 24:32–33).

Их Эзэн бидэнд туслахын тулд эдгээр тэмдгүүдийг өгсөн. Бид өөрсдийгөө болон гэр бүлүүдээ удахгүй ирэх зүйлүүдэд бэлтгэж амьдралаа цэгцэлж чадна.

Сүйрэл гамшигуудын талаар бидэнд хэлж бэлтгэлтэй байх талаар анхааруулсан. Гэвч бид мөн Аврагчийн ирэлтийг хүсэн хүлээж, түүнд талархалтай байж чадна. Их Эзэн хэлэхдээ: “Бүү тэвдэн сандар, учир нь мөн эдгээр бүх зүйл тохиоход та нарт өгөгдсөн тэрхүү амлалтууд биелэгдэх болно гэдгийг та нар мэдэж болно” гэсэн (С ба Г 45:35). Түүнийг ирэхэд зөв шударга тэдгээр нь устгагдахгүй “харин тэр өдрийг тэсэн гарах болно. Мөн дэлхий тэдэнд өв болон өгөгдөх болно; мөн тэдний үр хүүхдүүд нүгэлгүйгээр авралд өсөн өндийх болно. Учир нь Их Эзэн тэдний дунд байх болно, мөн түүний алдар суу тэдний дээр байх болно, мөн тэрбээр тэдний хаан хийгээд тэдний хууль тогтоогч байх болно” (С ба Г 45:57–59).

### **Нэмэлт судрууд**

- 1 Коринт 15:22–28 (төгсгөл ирнэ, үхэл нь холдсон)
- Матай 16:1–4 (цаг үеийн тэмдгүүдийг ялган таних)
- Матай 24; С ба Г 29:14–23; 45:17–57; 88:87–94; Иосеф Смит—Матай 1 (Хоёр дахь ирэлтийн тэмдгүүд)
- 1 Тесалоник 5:1–6 (тэмдгүүдийг хай мөн бэлтгэ)
- С ба Г 38:30 (бид айхгүйн тул бэлтгэ)
- С ба Г 68:11 (бид тэмдгүүдийг мэдэж чадна)

# Есүс Христийн хоёр дахь ирэлт

Бүлэг 44

---

## **Аврагчийн хоёр дахь ирэлтийг хүсэн хүлээх нь**

Түүний амилуулалтаас дөч хоногийн дараа Есүс ба Түүний төлөөлөгчид Оливийн ууланд цугларсан. Есүсийн дэлхийг орхих цаг нь ирэв. Тэр Өөрийн хийх ёстой бүх ажлаа тэр үед дуусгасан байв. Тэр Өөрийн хоёр дахь ирэлтийг хүртэл Тэнгэрлэг Эцэг уруугаа буцсан.

Тэр төлөөлөгчиддөө зааварлаад Есүс тэнгэр өөд одсон. Төлөөлөгчид тэнгэр өөд харахад хоёр тэнгэрийн элч тэдний хажууд зогсоод, “Галилын эрчүүд ээ, юунд та нар тэнгэр ширтэн зогсоно вэ? Та нараас өргөгдөн тэнгэрт аваачигдсан энэ Есүс нь та нарын Түүнийг тэнгэр өөд явсныг нь харсан лугаа адил тийн буцаж ирнэ” гэв (Үйлс 1:11).

Тэр цагаас өнөөг хүртэл Есүс Христийн дагалдагчид хоёр дахь ирэлтийг хүсэн хүлээх болсон.

## **Есүс дахин ирээд юу хийх вэ?**

Есүс Христ энэ дэлхийд дахин ирэхдээ дараах зүйлсийг хийх болно. Үүнд:

1. *Тэр дэлхийг цэвэрлэх болно.* Есүс дахин ирэхдээ хүч хийгээд агуу алдар суутай ирэх болно. Тэр үед ёсон бусчууд устгагдах болно. Ялзарч завхарсан бүх зүйл шатах болно, мөн дэлхий галаар цэвэршүүлэгдэх болно (С ба Г 101:24–25).

---

**Багш нарт зориулж:** Ангийн эсвэл гэр бүлийн гишүүн бүрт энэ бүлгийн таван хэсгийн нэгийг даалган өг. Хүн бүрийг бие даан ажиллаж, даалгасан хэсгийг судруудаас олж судлахыг хүс. Дараа нь хүн бүрийг суралцсан зүйлсээ хуваалцахыг урь.





2. *Тэр хүмүүсээ шүүх болно.* Есүс дахин ирэхдээ үндэстнүүдийг шүүж, зөв шударгыг ёсон бусчуудаас салгах болно (Матай 25:31–46; мөн энэ номны 46-р бүлгийг үз). Илчлэгч Иохан энэ шүүлтийн талаар бичихдээ: “Би сэнтийнүүдийг харав. Тэд дээр нь заларчээ. Тэдэнд шүүх эрх өгөгдсөн байлаа. Мөн Есүсийн гэрчлэл болон Бурханы үгээс болж цаазлуулсан хүмүүсийн сэтгэлүүдийг харав. Тэд амилаад Христтэй хамт мянган жилийн турш хаанчилжээ” Түүний харсан ёс бусчууд “мянган жилийг дуустал амилсангүй” (Илчлэлт 20:4–5; мөн С ба Г 88:95–98).
3. *Тэр Мянган жилийн зохион байгуулагч байх болно.* Мянган жил нь дэлхий дээр Есүсийн хаанчлах мянган жилийн хугацаа юм. Зөв шударга хүмүүс Есүсийн ирэлтэд Түүнийг угтахаар аваачигдах болно (С ба Г 88:96). Түүний ирэлтээр мянган жилийн хаанчлал эхэлнэ (Энэ номны 45-р бүлгийг үз).

Ерөнхийлөгч Бригам Янг хэлэхдээ:

Бурханы Хаант улс дэлхий дээр хүч, алдар суу хийгээд төгс төгөлдөр байдлаар байгуулагдан, маш удаан зонхилсон ёс бусчуудын хаанчлал зогсох Мянган жилд Бурханы Гэгээнтнүүд ариун сүмүүдээ барьж, түүндээ очиж, Бурханы ариун сүмүүд дэх багана болгож [Илчлэлт 3:12], тэд өөрсдийн нас барагсдын төлөө ёслолуудыг гүйцэтгэх болно. Дараа нь бид найз нөхдөө ирэхийг харна. Магадгүй зарим нь энд танилцсан ч байх болно. Тэгээд бид өвгөд дээдсээ бүр Эцэг Адам, Эх Евагийн хүртэлх үеийг тодоос тод харж, Бурханы ариун сүмд орж, тэдний төлөө ёслолуудыг гүйцэтгэх болно. Дараа нь Адамаас эхэлсэн Санваарын төгс холбоо эцсийн үеэс Адамын үе хүртэл төгс байдлаар хийгдэж, [хүүхдүүд] өөрсдийн [эцэг эхтэйгээ] холбогдох болно” (*Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997], 333–34).

4. *Тэр Анхны амилуулалтыг гүйцэлдүүлэх болно.* Амилуулалтыг хүртэх эрхтэй хүмүүс шүүлтийн үед булнаасаа босох болно. Тэд Аврагчийг тэнгэрээс буун ирэхэд Түүнийг угтахаар өргөгдөх болно (С ба Г 88:97–98).

Есүс Христийг үхлээс боссоны дараа нас барсан бусад зөв шударга хүмүүс мөн амилсан. Тэд Иерасулимд мөн Америк тивд үзэгдсэн (Матай 27:52–53; 3 Нифай 23:9–10). Энэ нь анхны Амилуулалтын эхлэл байсан. Түүнээс хойш зарим хүмүүс амилуулагдсан. Дахин амилсан тэдгээр хүмүүс мөн Түүний ирэлтээр дахин амилах тэдгээр нь селестиал хаант улсын алдар сууг өвлөн авна (С ба Г 76:50–70).

Селестиал алдар сууг өвлөн авах тэдгээрийн амилуулалтын дараа бусад бүлэг хүмүүс амилуулагдаж эхэлнэ: тэд террестиал алдар сууг өвлөн авах болно. Эдгээр хүмүүс бүгд дахин амиласны дараа Анхны Амилуулалт бүрэн гүйцэлдэх болно.

Их Эзэний Хоёр дахь ирэлтийн үед амьдарч байх ёс бусчууд махан биед устгагдах болно. Тэд нас барсан ёс бусчуудын хамт эцсийн амилуултыг хүртэл хүлээх болно. Үлдсэн бүх нас барагсад Бурханыг угтахаар босно. Тэд телестиал хаант улсыг өвлөн авах болно эсвэл сатаны хамт гадаад харанхуйд хаягдана (С ба Г 76:32–33, 81–112).

5. *Тэр тэнгэр ба ертөнцийн Хааны хувьд Өөрийн хууль ёсны суудлыг эзлэх болно.* Есүс дэлхийд ирээд Өөрийн засгийн газрыг дэлхий дээр байгуулах болно. Сүм тэр хаант улсын хэсэг болох болно. Тэр 1000 жилийн турш дэлхийн хүмүүсийг амар амгаланд удирдах болно.

Есүс Христ анх дэлхийд ирэхдээ алдар сууд ирээгүй. Тэр даруу байдалд малын тэвшинд төрсөн. Иудейчүүдийн хүсэн хүлээж байсны адил агуу армитай Тэр хамт ирээгүй. Харин Тэрээр, “Дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир” гэж хэлсэн (Матай 5:44). Тэр үгүйсгэгдэн, цовдлогдсон. Гэхдээ Түүнийг Хоёр дахиа ирэхэд үгүйсгэх хүн үгүй, харин “чих бүхэн үүнийг сонсож, мөн өвдөг бүхэн сөхөрч, мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөх болно” (С ба Г 88:104). Тэр “эздийн Эзэн, хаадын Хаан” хэмээн угтуулах болно (Илчлэлт 17:14). Тэр “Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон” хэмээн дуудагдах болно (Исаиа 9:6).

- Хоёр дахь ирэлтийн үйл явдлын талаар төсөөлөх үед та нарт ямар мэдрэмж бодол орж ирж байна вэ?

## **Аврагчийн Хоёр дахь ирэлт ойрхон байгааг бид хэрхэн мэдэх вэ?**

Есүс Христийг төрөхөд маш цөөхөн хүн дэлхийн Аврагч ирлээ гэдгийг мэдэж байсан. Түүнийг дахин ирэх үед Түүнийг хэн гэдэгт эргэлзэх хүн үгүй. Аврагчийн яг хэзээ ирэхийг мэдэх нэг ч хүн байхгүй. “Тэр өдөр, цагийн тухайд хэн ч мэдэхгүй. Тэнгэрийн элч ч, Хүү ч мэдэхгүй. Зөвхөн Эцэг л мэднэ” (Матай 24:36; мөн С ба Г 49:7).

Их Эзэн сургаалт үлгэрийг ашиглан Өөрийн ирэлтийн цагийн талаарх санааг бидэнд өгсөн:

“Одоо инжрийн модноос сургаалт зүйрлэлийг сурч ав. Инжрийн модны мөчир хэдийнээ зөөлөрч, навчис гаргах үед зун ойртжээ гэдгийг та нар мэддэг.

“Түүнчлэн энэ бүхэн тохиолдохыг хараад, Түүний ойрхон байгааг, үүдэн дээр чинь байгааг та нар бас мэддэг” (Марк 13:28–29).

Их Эзэн мөн Түүний ирэлт ойрхон байгаа мэдэгдэх зарим тэмдгүүдийг бидэнд өгсөн. Тэмдгүүдийг илчилсний дараа Тэрээр:

“Эзэн тань ямар өдөр ирэхийг та нар мэдэхгүй тул сонор сэргэг бай. . . .

“Тиймээс та нар бас бэлэн бай. Хүний Хүү та нарын бодоогүй цаг мөчид ирнэ” хэмээн анхааруулсан (Матай 24:42, 44).

Бид хэрхэн Есүсийн Хоёр дахь ирэлт ойрхон байгааг хэрхэн мэдэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг энэ номны 43-р бүлгээс үз.

## **Бид Аврагчийн Ирэлтэд хэрхэн бэлэн байж чадах вэ?**

Аврагчийн ирэлтэнд бэлтгэх хамгийн сайн арга бол сайн мэдээг хүлээн авч, түүнийг амьдралынхаа хэсэг болгох явдал. Бид Есүс дэлхий дээр байхдаа заасны дагуу өдөр бүр өөрсдийн чадах хамгийн сайнаар амьдрах ёстой. Бид бошиглогчийн удирдамжийг эрэлхийлж, түүний зөвлөгөөг дагаж чадна. Бид Ариун Сүнс бидний чиглүүлэгч байхаар зохистой амьдрах хэрэгтэй. Тэгээд бид Аврагчийн ирэлтийг ямар ч айдасгүй харин аз жаргалтайгаар хүсэн хүлээх болно. Их эзэн хэлэхдээ: “Бүү эмээ бяцхан

сүрэг минь, хаант улс намайг ирэх хүртэл та нарынх бөлгөө. Болгоогтун, би гэнэт ирнэ. Бүр тийм буюу. Амен” (С ба Г 35:27).

- Яагаад бид Хоёр ирэлтийн тодорхой цагийн талаар санаа зовохын оронд өөрсдийн бэлтгэлдээ илүү санаа тавих хэрэгтэй вэ?

### **Нэмэлт судрууд**

- Иохан 14:2–3; Матай 26:64 (Есүс газрыг бэлтгэж дахин ирнэ)
- Малахи 3:2–3; 4:1; С ба Г 64:23–24 (дэлхий шатах болно)
- С ба Г 133:41–51 (ёс бусчууд устгагдана)
- Матай 13:40–43 (Шүүлт тунхаглагдсан)
- 1 Коринт 15:40–42; С ба Г 76; 88:17–35 (алдар суугийн хаант улсууд)
- С ба Г 43:29–30; 29:11 (Аврагчийн ирэлтээр Мянган жил болно)
- Итгэлийн тунхаг 1:10 (Есүс хаанчилна)
- Алма 11:43–44; 40:23 (Амилуулалтын тайлбар)
- С ба Г 88:96–98 (нас барагсад босно)
- Зехариа 14:9; Илчлэлт 11:15; 1 Нифай 22:24–26 (Есүс Хаан мэт хаанчилна)

# МЯНГАН ЖИЛ

Бүлэг 45

---

## Мянган жилийн үеэр дэлхий дээр байх хүмүүс

- Мянган жилийн туршид хэн дэлхий дээр байх вэ?

Есүс Христийн Хоёр дахь ирэлтээр амар амгалан, хайр, баяр баяслаар дүүрэн мянган жил дэлхий дээр эхэлнэ. Энэ хугацааг Мянган жил гэж нэрлэдэг. Судрууд ба бошиглогчид Мянган жилд дэлхий дээр амьдрах нь ямар байхыг бидэнд ойлгоход тусалдаг.

Аврагчийн хоёр дахь ирэлтээр ёс бусчууд устгагдах учир, зөвхөн зөв шударга хүмүүс Мянган жилээс эхлэн дэлхий дээр амьдрах болно. Энэ нь ариун журамтай, үнэнч шударга амьдарсан хүмүүс болой. Тэдгээр хүмүүс террестиал эсвэл селестиал хаант улсыг өвлөн авах болно.

Мянган жилийн туршид мөнх бусчууд дэлхий дээр амьдарсаар байх болно. Тэд одоо бидэнд байгаа шиг үргэлжлүүлэн үр хүүхэд төрүүлсээр байх болно (С ба Г 45:58). Үхэшгүй мөнх байдалтай хүмүүс байн байн дэлхий дээр зочлох болно гэж Иосеф Смит хэлсэн. Тэдгээр амилуулагсад засгийн газар ба бусад ажлуудад туслах болно (*Teachings of the Prophet Joseph Smith*, Joseph Fielding Smith [1976], 268).

Хүмүүст чөлөөт сонголт үргэлжлүүлэн байсаар байх бөгөөд урт цаг хугацааны турш олон хүмүүс шашин шүтлэг, үзэл санаанаагаа чөлөөтэйгөөр үргэлжлүүлэх болно. Эцсийн эцэст хүн бүр Есүс Христ бол Аврагч гэдгийг хүлээн зөвшөөрөх болно.

Мянган жилийн туршид Есүс “дэлхий дээр өөрийн биеэр хаанчлах” болно (Итгэлийн тунхаг 1:10). Есүс “Тэгээнтнүүдийн дээр хаанчилж, доош бууж, удирдах” болно хэмээн Иосеф Смит

---

**Багш нарт зориулж:** Мянган жилийн тухай сэдэв заримдаа хүмүүсийг судар дээр эсвэл хожмын үеийн бошиглогчдын сургаалд байхгүй үзэл санааны талаар эргэцүүлэн бодоход хүргэдэг. Энэ хичээлийг удирдан чиглүүлж байгаагийн хувьд та иймэрхүү зүйлээс зайлсхий.



тайлбарласан (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 258).

### **Сүмийн ажил Мянган жилийн туршид**

- Мянган жилийн туршид хийгдэх ажлуудын хоёр агуу нь юу вэ?

Мянган жилийн турш сүмийн гишүүдийн хувьд дараах хоёр агуу том ажил байх болно: ариун сүмийн ажил, номлолын ажил. Ариун Сүмийн ажил нь өргөмжлөлд шаардлагатай ёслолуудтай холбоотой. Эдгээр нь баптисм, толгой дээр гар тавилтаар хүртэх Ариун Сүнсний бэлэг болон хувийн хишиг хүртэх ариун сүмийн ёслолууд, ариун сүмийн гэрлэлт, гэр бүлээрээ хамтдаа холбогдох зэрэг юм.

Олон хүн эдгээр ёслолуудыг хүлээн авалгүйгээр нас барсан. Дэлхий дээрх хүмүүс уг ёслолуудыг тэдний төлөө гүйцэтгэх ёстой. Энэ ажил нь Их Эзэний ариун сүмүүдэд одоо хийгдэж эхлээд байгаа. Мянган жил эхлэхээс өмнө дуусгахад ихэдсэн олон ажил байна. Тиймээс энэ нь мянган жилдээ үргэлжлүүлэн хийгдсээр гүйцэлдэх болно. Амилуулагдсан тэдгээр нь нас барсан өвөг дээдсээ олоход гаргасан алдаануудаа засахад бидэнд туслах болно. Тэд мөн өөрсдийн бичээсийг бүрэн гүйцээхэд шаардлагатай мэдээллийг олоход бидэнд туслах болно (Joseph Fielding Smith, *Авралын тухай сургаал*, эмхэтгэл. Брюс Р. МакКонки, 3 дахь боть. [1954–56], 2:167, 251–52).

Мянган жилийн туршид тохиох бас нэгэн агуу ажил бол номлолын ажил юм. Сайн мэдээ бүх хүмүүст агуу хүчээр заагдах болно. Яваандаа сайн мэдээний эхний зарчмуудыг хүмүүст заах шаардлагагүй болно. Учир нь “тэдний багаас том хүртэл нь тэд бүгд Намайг мэдэх болно гэж Их Эзэн тунхаглаж байна” (Иеремиа 31:34).

- Мянган жилийн ажилд бид одооноос хэрхэн бэлтгэх вэ?

### **Мянган жилд байх нөхцөл байдал**

- Мянган жилд байх амьдрал дэлхий дээрх одоогийн амьдралаас юугаараа ялгаатай байх вэ?



Бошиглогч Иосеф Смит Мянган жилийн туршид “дэлхий шинэчлэгдэж мөн диваажингийн алдар суугаа хүлээн авах болно” гэж заасан (Итгэлийн тунхаг 1:10).

### *Сатан тусгаарлагдсан байна*

Мянган жилийн туршид Сатан тусгаарлагдсан байх болно. Энэ нь тэр үед амьдарч байх тэдгээр хүмүүсийг тэр уруу татах ямар ч хүчгүй байх болно гэсэн үг (С ба Г 101:28). “Хүүхдүүд нүгэлгүйгээр авралд өсөн өндийх болно” (С ба Г 45:58). “Мөн түүний хүмүүсийн [Их Эзэний] зөв шударгын улмаас, Сатан хүчгүй байна; иймийн тул, тэр олон жилийн хугацаанд чөлөөлөгдөж чадахгүй; учир нь тэр хүмүүсийн зүрхийг давах хүчгүй байна; учир нь тэд зөв шударгад оршиж, мөн Израилын Ариун нэгэн хаанчлах бөлгөө” (1 Нифай 22:26).

### *Дэлхий дээрх амар амгалан*

Мянган жилийн хугацаанд дайн дажин байхгүй байна. Хүмүүс хамтдаа амар амгалан, зохицол нэгдмэл байдалд амьдрах болно. Дайнд хэрэглэгдэж байсан зүйлс хэрэгцээт зорилгын юмс болон ашиглагдах болно. “Тэд илдээ анжисны хошуу, жадаа хадуур болгон давтана. Үндэстэн үндэстнийхээ эсрэг илд далайхгүй бөгөөд дахин хэзээ ч тэд дайтахад суралцахгүй” (Исаиа 2:4; мөн Исаиа 11:6–7; С ба Г 101:26).

### *Зөв шударга засаглал*

Ерөнхийлөгч Жон Тэйлор заахдаа: “Их Эзэн бүх дэлхий дээрх хаан байж, бүх хүн төрөлхтөн нэг бүрчлэн түүний хэмжээлшгүй эрх мэдэл дор, үндэстэн бүр тэнгэрийн дор түүний эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, түүний тусгал дор бөхийх болно. Түүнд зөв шударгаар үйлчлэх хүмүүс Бурхантай болон Есүстэй холбоотой байж, тэнгэрийн элчүүдээр дэмжигдэн өнгөрсөн, одоо, ирээдүйг мэдэх болно; түүний хуулиудад бүрэн дуулгавартай байгаагүй, түүний гэрээнүүдэд бүрэн сургагдаагүй бусад хүмүүс ч түүний засаглалд бүрэн дуулгавартай байх болно. Тиймээс дэлхий дээр Бурханы хаанчлал байх болно. Хууль ёсоор түүний зөв болох хуулиудыг Тэр тулган, дэлхийн

---

үндэстнүүдийг дуулгавартай байхыг тушаах болно” (*Teachings of Presidents of the Church: John Taylor* [2001], 225).

### *Үхэл гэж үгүй*

Мянган жилийн хугацаанд бидний мэдэх үхэл гэж үгүй болно. Өндөр насалсан хүмүүс үхэхгүй мөн оршуулагдахгүй. Түүний оронд тэд өөрсдийн мөнх бус байдлаасаа мөнх байдалд “нүд ирмэхийн зуурт” шилжсэн байх болно (С ба Г 63:51; 101:29–31).

### *Бүх зүйлс илчлэгдэнэ*

Зарим үнэнүүд бидэнд хараахан илчлэгдээгүй байгаа билээ. Мянган жилийн хугацаанд бүх зүйлс илчлэгдсэн байх болно. Их Эзэн “бибээр ирэх тэр өдөр бүх зүйлийг илчлэх болно. Улиран өнгөрсөн зүйлүүд мөн хүмүүний мэддэггүй байсан нуугдмал зүйлүүд үүгээр энэ нь хийгдсэн дэлхийн зүйлүүдийг, мөн үүний зорилго хийгээд төгсгөлийг нь буюу. Хамгийн их үнэт зүйлүүд, дээр байдаг зүйлүүд, мөн дор байдаг зүйлүүд, дэлхийн дотор, мөн дэлхий дээр байдаг, мөн тэнгэрт байдаг зүйлүүдийг буюу” гэж хэлсэн (С ба Г 101:32–34).

### *Мянган жилийн бусад үйл ажиллагаанууд*

Бүх зүйлс зөвхөн зөв шударгад хийгдсэн байхаас бусдаар бол олон замаараа амьдрал одоо байгаа шиг байх болно. Хүмүүс идэж, ууж, хувцас өмсөх болно (*Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997], 333). Хүмүүс тариа тариалж, ургацаа хурааж, байшин сууц барихаа үргэлжлүүлэн хийх болно (Исаиа 65:21).

- Мянган жилийн туршид байх нөхцөл байдлыг та нар хэрхэн төсөөлж, бодож байна вэ?

### **Мянган жилийн дараах төгсгөлийн нэгэн тулаан**

- Дэлхийн төгсгөлийн хувь заяа ямар байх вэ?

Мянган жилийн төгсгөлд Сатан богино хугацаанд чөлөөлөгдөх болно. Зарим хүмүүс Тэнгэрлэг Эцэгээсээ эргэх болно. Сатан өөрийн армийг цуглуулж, Михаил (Адам) тэнгэрийн түмнийг

хамтад нь цуглуулах болно. Энэ агуу тулаанд Сатан ба түүний дагалдагчид мөнхөд хөөгдөн арилах болно. Дэлхий селестиал хаант улс болон өөрчлөгдөх болно (С ба Г 29:22–29; 88:17–20, 110–15).

### **Нэмэлт судрууд**

- Зехариа 14:4–9; 1 Нифай 22:24–25 (Есүс дэлхий дээр хаанчилна)
- Даниел 7:27 (Гэгээнтнүүдэд хаант улс өгөгдөх болно)
- С ба Г 88:87–110 (Мянган жилд байх нөхцөл)
- Илчлэлт 20:1–3; 1 Нифай 22:26 (Сатан тусгаарлагдах болно)
- С ба Г 101:22–31 (дайсагнал зогсож; үхэлгүй; Сатан уруу татах хүчгүй болно)
- Исаиа 11:1–9 (чоно ба хурга хамт зэрэгцэн орших болно)
- С ба Г 43:31; Илчлэлт 20:7–10 (Сатан хэсэг зуур суллагдана)

# ЭЦСИЙН ШҮҮЛТ

Бүлэг 46

---

## Бурханы шүүлтүүд

- Эцсийн шүүлт ирэхийн өмнө зарим өөр ямар шүүлтүүд байх вэ? Эдгээр шүүлтүүд нэг нэгэнд хэрхэн хамааралдаг вэ?

Судруудад бид Бурханы өмнө зогсож, шүүгдэх талаар байн байн хэлдэг. Бид энэ чухал үйл явдалд илүүтэйгээр бэлтгэж болохын тулд шүүлт хэрхэн явагдах талаар ойлгох шаардлагатай.

Бид бүгдээрээ өөрсдийн үйлсийн дагуу шүүгдэх болно гэж судрууд бидэнд заадаг: “Үхсэн их бага хүмүүсийг сэнтийний өмнө хэвтэж байхыг би харлаа. Номууд дэлгээстэй байв. Өөр нэгэн ном дэлгээстэй байсан бөгөөд тэр нь амьдралын ном юм. Үхэгсэд нь өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номд бичигдсэн зүйлсээр шүүгдэв” (Илчлэлт 20:12; мөн С ба Г 76:111; 1 Нифай 15:32; Абрахам 3:25–28). Бид мөн “зүрх сэтгэлийнхээ хүслийн дагуу” шүүгдэх болно (С ба Г 137:9; мөн Алма 41:3).

Энд дэлхий дээр бид Бурханы хаант улсын дотор байх боломжуудыг хүлээн авахын тулд өөрсдийн зохистой байгаа эсэхээрээ шүүгддэг. Бид баптисм хүртэхдээ энэ ёслолыг хүлээн авах зохистой эсэхээрээ шүүгддэг. Сүмд үйлчлэхээр дуудагдахдаа эсвэл санваар ахих ярилцлаганд орохдоо эсвэл ариун сүмийн зөвшөөрлийн бичиг авахдаа шүүгддэг.

Биднийг нас барахад сүнснүүд маань аз жаргалын эсвэл зовлонгийн байдалд очихоор хуваарилагдах болно гэж Алма заасан (Алма 40:11–15). Энэ бол шүүлт.

---

**Багш нарт зориулж:** Та энэ бүлгийн бүх зүйлийг заах шаардлагагүй. Заахад залбиралтайгаар бэлтгэх үедээ бүлгийн аль хэсгийг заах нь зөв бэ гэдгийг мэдэхийн тул Сүнсний удирдамжийг эрэлхийл.



## **Бидний үгс, үйлдэл ба бодол санаа нь биднийг шүүхийн тулд буюу**

- Өөрийн бүх бодол санаа, үгс, үйлдлээрээ шүүгдэж байна гээд бодоод үз дээ.

Бошиглогч Алма “Учир нь бидний үгс биднийг буруутгах болно, тийм ээ, бүх үйлс маань биднийг буруутгах болно” хэмээн тунхагласан (Алма 12:14).

Их Эзэн хэлэхдээ: “Бодлогогүй хэлсэн үг бүрийнхээ төлөө хүмүүс шүүлтийн өдөр тайлагнах болно. Учир нь чи үгсээрээ зөвтгөгдөнө, мөн чи үгсээрээ ялагдана” гэв (Матай 12:36–37).

Есүс Христэд итгэх итгэл Эцсийн Шүүлтэнд бэлтгэхэд маань тусалдаг. Түүний итгэлтэй шавь нар, өөрсдийн бүх нүглийн наманчлалаар дамжуулан бид нүглүүдийнхээ төлөө уучлагдаж, Бурхантай хамт амьдрахаар цэвэр ариун болж чадна. Бид нүглүүдээ наманчилж, цэвэр бус бодол ба үйлдэл бүрээ зогсоох аваас Ариун Сүнс бидний зүрх сэтгэлийг өөрчилж, дахин нүгэл үйлдэх хүсэлгүй болгодог (Мозая 5:2). Дараа нь бид шүүгдэхдээ Бурханы оршихуйд ороход бэлэн болсон байх болно.

- Өөрсдийн бодол, үгс, үйлдлээ хэрхэн сайжруулж болох талаар бод.

## **Бид бичиглэгдсэний дагуу шүүгдэх болно**

- Бид ямар бичээсийн дагуу шүүгдэх вэ? Хэн биднийг шүүх вэ?

Үхэгсэд дэлхий дээр бичиглэгдсэн бичээсийн дагуу шүүгдэх болно хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлсэн. Бид мөн тэнгэрт бичиглэсэн “амийн ном”-ын дагуу шүүгдэх болно (С ба Г 128:6–8).

Бүх хүмүүн Израилын Ариун Нэгэний шүүлтийн суудлын өмнө очиж, мөн тийнхүү Бурханы ариун шүүлтийн дагуу шүүгдэх ёстой (2 Нифай 9:15). Иоханы харсан үзэгдлийн дагуу Номууд дэлгээстэй байв. Өөр нэгэн ном дэлгээстэй байсан бөгөөд тэр нь амийн ном юм. Үхэгсэд нь өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номонд бичигдсэн зүйлсээр шүүгдэв (Илч. 20:12). Дэлхий дээр хадгалагдан бичигдсэн “номнууд” нь [бидний үйлсийг] харуулдаг.

Амийн ном нь тэнгэрт хадгалагдсан бичээс юм.' (С ба Г 128:7.)”  
(*Teachings of Presidents of the Church: Harold B. Lee* [2000], 226–27).

Биднийг шүүхэд ашиглах бас нэгэн бичээс бий. Бид өөрсдөө амьдралынхаа бичээс нь юм гэж Төлөөлөгч Паул заасан (Ром 2:15). Бидний бие болон бодолд бидний хийсэн юм бүхэн бүрэн түүх болон хадгалагддаг. Ерөнхийлөгч Жон Тэйлор энэ үнэнийг: “[Хувь хүн] өөрийн түүхээ ярьж, өөрийнхөө эсрэг гэрчилжээ. Тэр бичээс бодлын самбар дээр нь өөрөөр нь бичиглэгдсэн. Тэр бичээс шүүгч болон суух Бурхан ба тэнгэрийн элчүүдийн өмнө тэр өдөр дэлгэгдэн худлаа хэлж чадахгүй болно (*Deseret News*, 1865 оны 3-р сарын 8, 179).

Төлөөлөгч Иохан “Учир нь Эцэг хэнийг ч шүүхгүй, харин Тэр бүх шүүлтийг Хүүдээ даатгасан” гэж заасан (Иохан 5:22). Хүү эргүүлэн Шүүлтэд бусдыг туслуулахаар дуудах болно. Түүний тохинуулалд Түүнтэй хамт байсан Арванхоёр Израилын арван хоёр овгийг шүүх болно (Матай 19:28; Лук 22:30). Нифайн Арванхоёр шавь нар нифайчууд болон леменчүүдийг шүүх болно (1 Нифай 12:9–10; Мормон 3:18–19).

### **Алдар Суугийн хаант улсад суудал өвлөн авах нь**

- Дэлхий дээрх амьдралын туршид байсан бидний итгэлтэй байдал мөнхийн амьдралд маань хэрхэн нөлөөлөх вэ?

Эцсийн Шүүлтээр бид бэлтгэсэнийхээ дагуу алдар суугийн хаант улсад байрыг өвлөх болно. Судруудад алдар суугийн селестиал хаант улс, террестиал хаант улс, телестиал хаант улс гэсэн гурван хаант улсын талаар заадаг (С ба Г 88:20–32).

Сургаал ба Гэрээ 76 дээр бидний мөнх бус амьдралдаа хэрхэн амьдрах арга замуудын талаар Их Эзэн тайлбарласан. Бидний сонголтууд бид аль хаант улсад орохыг тодорхойлдог гэж тэр тайлбарласан. Энэ илчлэлтээс Сүмийн гишүүд бид ч өөр өөр хаант улсыг өвлөх болно гэдгийг сурч авдаг. Учир нь тэдний Христэд дуулгавартай байх итгэл, зориг тэвчээр нь адил байх болно.

Дараах зүйлс бидний сонгож болох амьдралын төрлүүд бөгөөд бидний сонголтуудын бидэнд авчрах хаант улсууд юм.

---

*Селестиал*

“Тэд бол Есүсийн тухай гэрчлэлийг хүлээн авсан, мөн түүний нэрэнд итгэсэн, баптисм хүртсэн, зарлигуудыг дагаж нүглүүдээсээ угаагдан, цэвэрлэгдэж болохын тулд мөн Ариун Сүнснийг хүлээн авсан тэдгээр хүмүүс болой.” Тэдгээр нь өөрсдийн итгэлээр дэлхийг даван ялсан тэд болой. Шударга хийгээд үнэнч тэд бүгдийн дээр Ариун сүнс адислалуудыг нь лацадсан билээ (С ба Г 76:51–53). Селестиал хаант улсын дээд зэрэглэлийг өвлөн авах, бурхад болох, тэдгээр нь ариун сүмд мөнхөд гэрлэсэн байх ёстой (С ба Г 131:1–4). Селестиал хаант улсыг өвлөн авах тэд бүгд Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христтэй үүрд хамт амьдрах болно (С ба Г 76:62).

Ариун сүмд бидний хийх ажлаар дамжуулан дэлхий дээр амьдарч байсан бүх хүн сайн мэдээний бүрэн байдлын адислалууд, авралын ёслолуудыг хүлээн авах адилхан боломжтой тиймээс тэд селестиал хаант улсын дээд зэрэглэлд байрыг өвлөн авч чадна.

*Террестиал*

Дэлхий дээр сайн мэдээг үгүйсгэсэн боловч дараа нь сүнсний дэлхийд хүлээн авсан тэд болой. Тэдгээр нь Есүс Христийн сайн мэдээнд хүмүүний башир аргаар харалган болсон дэлхийн шударга сайн хүмүүс юм. Тэдгээр нь мөн Есүсийн сайн мэдээ ба гэрчлэлийг хүлээн авсан боловч дараа нь тууштай зоримог байгаагүй юм. Тэдэн дээр Есүс Христ айлчлах боловч Тэнгэрлэг Эцэг очихгүй (С ба Г 76:73–79).

*Телестиал*

Эдгээр хүмүүс дэлхий дээр ч сүнсний дэлхийд ч Есүсийн сайн мэдээ эсвэл гэрчлэлийг хүлээн аваагүй болой. Тэд нүглүүдийнхээ улмаас Мянган жилийг дуустал буюу дахин амилах хүртлээ, тамд зовох болно. “Тэд худал хэлэгчид, мэргэ төлөгчид, садарлагчид, мөн завхайрагчид, мөн худал хуурмагт дурладаг мөн тийн үйлддэг тэд юм. Эдгээр хүмүүс далайн эрэг дэх элс мэт, тэнгэрийн огторгуй дахь одод мэт тоо томшгүй олон болой. Ариун Сүнс тэдэн дээр зочлох боловч Эцэг ба Хүү тэдэн дээр зочлон очихгүй (С ба Г 76:81–88, 103–6, 109).



### *Гадаад харанхуй*

Эдгээр нь Ариун Сүнсээр дамжуулан Есүсийн гэрчлэлтэй байсан ба Их Эзэний хүчийг мэдэж байсан ч Сатанд өөрсдийгөө удирдахыг зөвшөөрсөн болой. Тэд үнэнийг үгүйсгэж, Их Эзэний хүчийг эсэргүүцсэн. Тэд хүлээн авсаныхаа дараа Ариун Сүнсийг үгүйсгэсэн тул тэдэнд ямар ч уучлал байхгүй. Тэд алдар суугийн хаант улсыг авахгүй болно. Тэд мөнхийн харанхуй, зовлон, тарчлаанд Сатан болон түүний элчүүдтэй үүрд хамт амьдрах болно (С ба Г 76:28–35, 44–48).

- Сургаал ба Гэрээ 76:50–53, 62–70-д хэлсний дагуу Есүсийн гэрчлэлд бат зоригтой, итгэлтэй байснаар дэлхийг даван ялсан тэдгээр хүмүүс ямар зан чанартай вэ?

### **Бид одоо Шүүлтэд бэлтгэх ёстой**

- Эцсийн Шүүлтэд бэлэн байхын тулд бид юу хийх ёстой вэ?

Бодит байдалд өдөр бүр л шүүлтийн өдөр байдаг. Бид селестиал, террестиал эсвэл теллистиал хуулийн дагуу ярьж, бодож, үйлддэг. Есүс Христэд итгэх бидний итгэл өдөр тутмын үйлдлүүдээр аль хаант улсыг өвлөх вэ гэдгээ харуулдаг.

Бидэнд Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ бүрэн дүүрнээрээ байгаа. Сайн мэдээ бол селестиал хаант улсын хууль юм. Бидний өсөлтийн төлөөх санваарын бүх ёслолууд илчлэгдсэн байгаа. Бид усанд умбуулсан баптисм хүртэж, Христийн адил амьдрах гэрээг хийсэн. Хэрэв бид итгэлтэй байж хийсэн гэрээнүүдээ сахих аваас шүүлт маань ямар байхыг Их Эзэн бидэнд хэлсэн. Тэр бидэнд “Миний Эцэгээр ерөөдөгсөд өө, та нар наашир. Ертөнцийн сууриас та нарт бэлтгэсэн хаанчлалыг өвлөн авсугай” гэх болно (Матай 25:34).

### **Нэмэлт судрууд**

- Ром 2:6–9; Илчлэлт 20:12–13 (Шүүлт)
- Алма 11:41, 45; Мормон 7:6; 9:13–14 (бид дахин амилсан байдалд шүүгдэнэ)
- 2 Нифай 29:11; 3 Нифай 27:23–26 (Шүүлтэнд ашиглагдах номнууд)
- Алма 41:2–7 (бидний шүүлт нь бидний үйлс, зүрх сэтгэлийн хүсэл, наманчлал, эцсээ хүртэл тэвчих байдлыг тодорхойлдог)
- Мормон 3:22 (наманчил, шүүлтийн суудалд суухад бэлтгэ)
- Лук 12:47–48; С ба Г 82:3 (хэнд их өгөгдөнө түүнээс ихийг шаардана)
- С ба Г 88:16–33 (бид бүгд зохистой байдлынхаа дагуу хүлээн авна)



# ӨРГӨМЖЛӨЛ

Бүлэг 47

---

## **Бидний өсөлтийн төлөвлөгөө**

Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдарч байхад бидний өсөлтийн төлөвлөгөөг Тэрээр тайлбарлаж өгсөн. Бид Түүнтэй адил өргөмжлөгдсөн нэгэн болж чадна. Төлөвлөгөөний дагуу бол бид Түүнээс салж дэлхийд ирэх шаардлагатай байлаа. Энэ салаалт нь бид Түүний оршихуйд хамт биш ч Эцэгийн зарлигуудад дуулгавартай байх эсэхээ нотлоход зайлшгүй шаардлагатай байсан. Төлөвлөгөөгөөр дэлхийн амьдрал төгсөхөд бид шүүгдэж, өөрсдийн итгэл ба дуулгавартай байдлын дагуу шагнагдах болно.

Судруудаас бид тэнгэрт алдар суугийн гурван хаант улс байдаг тухай суралцдаг. Төлөөлөгч Паул “гурав дахь тэнгэрт аваачигдсан” нэгэн хүнийг мэддэг байснаа дурссан байдаг (2 Коринт 12:2). Паул тэнгэрийн хоёр хаант улсыг нэрлэсэн: селестиал ба террестиал (1 Коринт 15:40–42). Селестиал нь хамгийн дээд нь бөгөөд террестиал нь хоёр дахь нь юм. Хожмын үеийн илчлэлтүүдээр дамжуулан гурав дахь хаант улс нь теллистиал хаант улс гэдгийг бид суралцсан (С ба Г 76:81). Бид мөн гурван тэнгэр эсвэл гурван зэрэг селестиал хаант улсад бий гэдгийг бид суралцсан (С ба Г 131:1).

## **Өргөмжлөл**

- Өргөмжлөл гэж юу вэ?

Өргөмжлөл нь Бурханы амьдардаг нэгэн төрлийн амьдрал буюу мөнхийн амьдрал юм. Тэр агуу алдар сууд амьдардаг. Тэр бол төгс. Түүнд бүх мэдлэг, бүх мэргэн ухаан байгаа. Тэр бол сүнсэн хүүхдүүдийн Эцэг. Тэр бол бүтээгч. Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ адил болж чадна. Энэ нь өргөмжлөл юм.

---

Хэрэв бид Их Эзэнд итгэлээ батлах аваас бид тэнгэрийн селестиал хаант улсын дээд зэрэгт амьдрах болно. Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ мөнхийн гэр бүлд хамт амьдрахаар өргөмжлөгдөх болно. Өргөмжлөл нь хүүхдүүдээ өгч чадах Тэнгэрлэг Эцэгийн маань хамгийн агуу бэлэг юм (С ба Г 14:7).

### Өргөмжлөлийн адислалууд

- Өргөмжлөгдсөн тэдэнд ямар адислалууд ирдэг вэ?

Тэнгэрлэг Эцэг бол төгс төгөлдөр. Түүний хүүхдүүд Түүнтэй адил болж болох боломжтой гэдгийг Тэр алдаршуулдаг. Түүний ажил ба алдар суу нь “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” юм (Моисе 1:39).

Есүс Христэд итгэх итгэлээрээ дамжуулан селестиал хаант улсад өргөмжлөлийг хүлээн авсан хүмүүс онцгой адислалуудыг хүлээн авах болно. Их Эзэн “Бүх зүйлс тэднийх” хэмээн амласан (С ба Г 76:59). Өргөмжлөгдсөн хүмүүст өгөгдөх зарим адислалуудыг нэрлэвэл:

1. Тэд Тэнгэрлэг Эцэг хийгээд Есүс Христийн дэргэд үүрд мөнхөд амьдрах болно (С ба Г 76:62).
2. Тэд бурхад болох болно (С ба Г 132:20–23).
3. Тэд өөрсдийн зөв шударга гэр бүлийн гишүүдтэйгээ нэгдэж, мөнхөд өсөж хөгжсөөр байх болно.
4. Тэд бүрэн баяр баяслыг хүлээн авах болно.
5. Тэдэнд Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христэд байдаг бүх хүч, алдар суу, ноёрхол ба мэдлэгийг бүгдийг авах болно (С ба Г 132:19–20). Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит “Эцэг Түүний зарлигуудад дуулгавартай байх тэдэнд Хүүгээр дамжуулан өөрт байдаг бүгдийг өгөх болно хэмээн амласан. *Тэд төгсжин бурхад болох өдрийн бүрэн байдлыг хүртэл тэд мэдлэг, мэргэн ухаан, хүчиндээ өсч, сүр жавхландаас сүр жавхланд очих нь тэдний дээр асгарсаар байх болно*” (*Doctrines of Salvation*, comp. Bruce R. McConkie, 3 –р боть. [1954–56], 2:36; налуу бичилт нь эх хувь).

## Өргөмжлөлд тавигдах шаардлага

Өргөмжлөлийн шаарлагуудыг хангах цаг нь одоо юм (Алма 34:32–34). Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит: “Өргөмжлөлийг олж авахын тулд бид сайн мэдээ болон түүний бүх гэрээнүүдийг хүлээн авч; өөрсдийн дээр Их Эзэний өгсөн үүрэг хариуцлагуудыг авах; үнэний гэрэлд алхаж, ойлгох; Бурханы амнаас усган гарах үг бүрийг даган үргэлжлүүлэн амьдрах ёстой (*Doctrines of Salvation*, 2:43).

Өргөмжлөгдөхийн тулд бид хамгийн түрүүнд Есүс Христэд итгэж, амьдралынхаа эцсийн өдрийг дуустал итгэлдээ үнэнчээр үлдэх ёстой. Түүнд итгэснээр бид нүглүүдээ наманчилж, Түүний зарлигуудад дуулгавартай байх ёстой.

Бид тодорхой ёслолуудыг хүлээн авах ёстой гэдгийг Тэр зарлигласан:

1. Бид баптисм хүртэх ёстой.
2. Бид толгой дээрх гар тавилтаар Есүс Христийн Сүмийн гишүүнээр батлагдан, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах ёстой.
3. Ах нар Мелкизедек санваарыг хүлээн авч, санваарын дуудлагууддаа өсөн хөгжих ёстой.
4. Бид ариун сүмийн хишиг хүлээн авах ёстой.
5. Бид энэ амьдралд уу эсвэл ирэх амьдралд уу хамаагүй мөнхөд гэрлэсэн байх ёстой.

Шаардлагатай ёслолуудыг хүлээн авахаас гадна Их Эзэн бид бүгдэд дараах зүйлсийг тушаасан:

1. Бурхан ба өөрийн хөршүүдээ хайрла.
2. Зарлигуудыг сахь.
3. Буруу хийсэн зүйлүүдээ наманчил.
4. Өөрсдийн нас барсан хамаатан садан өвөг дээдсээ хайж, тэдний төлөөх сайн мэдээний авралын ёслолуудыг хүлээн ав.

5. Бид ариун ёслолоос хүртэж, баптисмаар хийсэн гэрээгээ шинэчилж болохын тул аль болох Сүмийн цуглаануудад тогтмол оролц.
6. Гэр бүлийнхнийгээ хайрла. Тэднийг Их Эзэний арга замаар хүчирхэгжүүл.
7. Өдөр бүр хувийн болон гэр бүлийн залбирлыг хий.
8. Сайн мэдээг үг ба үлгэр жишээгээрээ бусдад заа.
9. Суаруудыг судал.
10. Их Эзэний бошиглогчдын урамшуулсан үгсийг сонсож, дуулгавартай бай.

Эцэст нь, бид бүгд Ариун Сүнснийг хүлээн авч, хувийн амьдралдаа Түүний удирдамжийг дагахад суралцах хэрэгтэй.

- Ёслол ба гэрээнүүд биднийг хэрхэн өргөмжлөлд бэлтгэдэг вэ?
- Есүс Христэд итгэх итгэл биднийг зарлигуудад дуулгавартай байхад хэрхэн тусалдаг вэ?
- Өргөмжлөлд хүрэхийн тулд яагаад бид Ариун Сүнсний удирдамжийг дагахад суралцах ёстой вэ?

### **Бид итгэлтэйгээр эцсээ хүртэл тэвчсэний дараа**

- Эцсээ хүртэл Христийн итгэлт шавь нар байсны дараа юу болдог вэ?

Их Эзэн “Хэрэв чи миний зарлигуудыг сахиж мөн эцсээ хүртэл тэвчих аваас, чи Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу болох мөнх амьдралтай байх болно” гэж хэлсэн (С ба Г 14:7). Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит “Хэрэв бид Бурханд үргэлжлүүлэн байж, түүний зарлигуудыг сахин, түүнийг бишрэн шүтэж, түүний үнэнд амьдрах аваас төгсжих өдрийг хүртэл улам гэгээрэн гэгээрсээр үнэний бүрэн байдалд умбах цаг ирэх болно” гэж хэлсэн (*Doctrines of Salvation*, 2:36).

Бошиглогч Иосеф Смит “Бид шатаар өгсөхийн тулд доод талаас нь эхлэх хэрэгтэй. Тэгээд дээр хүртэл алхам алхмаар өгсдөг. Энэ нь яг сайн мэдээний зарчмуудтай адил бид хамгийн эхнийхээс нь эхлэх хэрэгтэй. Тэгээд өргөмжлөлийн бүх зарчмуудыг

---

суралцах хүртлээ явах хэрэгтэй. Гэхдээ энэ нь та нар хөшгийг нэвтрэн (үхэх) орсоны дараа тэдгээрийг суралцах хүртэл нэлээн хугацаа байна. Энэ дэлхийд бүгдийг ойлгож мэдэх нь үгүй. Булшны цаана ч гэсэн аврал ба өргөмжлөлийг суралцах нь агуу ажил байх болно” хэмээн заасан (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 268).

Иосеф Смит заахдаа: “Бурханы Шинж чанарыг эргэлзээгүйгээр мэдэх нь сайн мэдээний анхны зарчим билээ. Тэр бидэнтэй адил эгэл хүн байсан. Бурхан өөрөө, бид бүгдийн Эцэг, Есүс Христтэй адил дэлхий дээр амьдарч байсан (*Teachings of the Prophet Joseph Smith*, Joseph Fielding Smith [1976], 345–46).

Тэнгэрлэг Эцэг бидний зовлон зүдгүүр, сул дорой байдал ба нүглүүдийг мэднэ. Тэр бидэнд энэрэнгүй, нинжин сэтгэлээр ханддаг. Тэр биднийг Өөрийн адил амжилтанд хүрэхийг хүсдэг.

Хэрэв бид бүгд Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очоод дараах үгсийг хэлж чадахаар байхдаа ямар их баяр баяслыг эдлэхээ төсөөлөөд үз дээ: “Аав аа, би Таны тааллын дагуу амьдарсан” Би Таны зарлигуудыг сахиж, итгэлтэй байсан. Би дахин гэртээ ирсэндээ баяртай байна.” Дараа бид Түүний, “Сайн байна, чи цөөн юманд итгэмжтэй байсан тул чамд ихийг хариуцуулъя. Эзэнийхээ баяр баясгалад ор” гэх болно (Матай 25:23).

- Матай 25:23 дахин судал. Их Эзэн чамд эдгээр үгсийг хэлэхийг сонсоод чамд ямар байх байсан талаар бод.

### Нэмэлт судрууд

- С ба Г 132:3–4, 16–26, 37 (өргөмжлөлд хамаарах нь)
- С ба Г 131:1–4 (мөнхийн гэрлэлт нь өргөмжлөлд орох түлхүүр)
- С ба Г 76:59–70 (сестиаал алдар суугийн адислалуудыг тайлбарласан)
- С ба Г 84:20–21 (бурханлаг байдлын хүч нь санваарын ёслолуудаар дамжуулан тунхаглагддаг)

**Багш нарт зориулж:** Ангийн эсвэл гэр бүлийн гишүүдэд сайн мэдээний үнэний талаар тунгаан бодох цагийг өгөхдөө өөрсдийнх нь амьдрал эсвэл Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг хайрлах хайрынхаа тухай бод. Тэдэнд Ариун сүнс заах боломжийг өг.





# Зургийн жагсаалт

---

**Хавтас:** *Амьд ус*, Саймон Девей, © Саймон Девей.

Арын нүүр © Artbeats

**Хуудас 4:** Гэрэл зураг © NASA ба STScI

**Хуудас 8:** Гэрэл зураг © NASA ба STScI

**Хуудас 14:** *Есүс Еммосд* Карл Генрих Блох. Данийн Хиллерод дахь Үндэсний түүхийн музейгээс зөвшөөрөл авч ашиглав

**Хуудас 18:** Димитрий Вервициотисын гэрэл зураг/Digital Vision/Getty Images

**Хуудас 22:** Гэрэл зураг © Corbis

**Хуудас 26:** *Едены цэцэрлэгийг орхисон нь* Жозеф Брики.

© 1998 Жозеф Брики

**Хуудас 40:** *Иосеф Смит*, Хуулбарлахыг хориглоно зураачийн нэр тодорхойгүй, Community of Christ Archives-ийг зөвшөөрлөөр нийтлэв. *Бригам Янг*, Данквүрт Антон Вегтеланд, Сүмийн Түүхийн Музей *Жон Тэйлор*, зураачийн нэр тодорхойгүй, Сүмийн түүхийн номын сан ба Архив *Вилфорд Вуудраф*, Х. Е.Петерсоны бүтээл. *Лорензо Сноу*, Левис Рамсейн бүтээл, Сүмийн түүхийн музей *Жозеф Ф.Смит*, А.Салзбреннер, © IRI *Хебер Ж.Грант*, С. Ж.Фоксын бүтээл, © IRI. *Жорж Алберт Смит*, Лий Грийн Ричардсн бүтээл, © IRI. *Дэвид О. МкКей*, Еверетт Кларк Торпийн бүтээл, © Everett Clark Thore. *Жозеф Фиелдинг Смит*, Шауна Куук Клингерийн бүтээл, © 1983 IRI. *Харолд Б.Лий*, Грант Ромней Клаусоны бүтээл, © IRI. *Езра Тафт Бенсоны гэрэл зураг* © Busath Photography. *Томас С.Монсоны гэрэл зураг* © Busath Photography

**Хуудас 50:** *Есүс Жейрусын охиныг амилуулсан нь*,

Грег К.Олсены бүтээл. © 1990 IRI

---

- Хуудас 60:** *Миний хүсэл биш Таны хүсэл биелэх болтугай*, Харри Андерсоны бүтээл. © Seventh-day Adventist Church. Иосефийг Хуулбарлахыг хориглоно
- Хуудас 82:** *Абрахам Мамрегийн талд*, Харри Андерсоны бүтээлээс. © IRI
- Хуудас 88:** *Христ Арванхоёрыг томилсон нь*, Харри Андерсоны бүтээлээс. © IRI
- Хуудас 94:** *Миний зурхний хүслэн*, Волтер Рэйний бүтээлээс. Сүмийн түүхийн музейн зөвшөөрлөөр нийтлэв
- Хуудас 102:** *Есүс Христ*, Харри Андерсоны бүтээлээс. © IRI
- Хуудас 134:** *Сүүлчийн Зоог*, Саймон Девейн бүтээл. © Simon Dewey
- Хуудас 150:** *Христ ба баян залуу удирдагч*, Генрих Хофманы бүтээлээс. С. Harrison Congro Co., Инс-ийн зөвшөөрлөөр нийтлэв.
- Хуудас 162:** *Есүс Төлөөлөгчдийнхөө хөлийг угаасан нь*, Дел Парсоны бүтээлээс. © 1983 IRI
- Хуудас 168:** Гэрэл зураг © Getty Images
- Хуудас 174:** *Сайн Самари хүн*, Жозеф Брикийн бүтээлээс. © 2001 Joseph Brickey
- Хуудас 180:** Жорж Дойлын гэрэл зураг/Stockbyte/Getty Images
- Хуудас 190:** *Явж, бүх үндэстэнд заа*, Харри Андерсоны бүтээлээс. © IRI
- Хуудас 200:** *Адам ба Ева золиослол өргөсөн нь*, Кейт Ларсоны бүтээл. © 1996 Keith Larson
- Хуудас 218:** Роберт Кэйсигийн авсан гэрэл зураг © 2004 Robert Casey
- Хуудас 224:** Роберт Кэйсигийн авсан гэрэл зураг © 2004 Robert Casey
- Хуудас 246:** *Иаков Иосефийг адисласан нь*, Харри Андерсоны бүтээлээс. © IRI
- Хуудас 252:** *Хоёр дахь ирэлт* Харри Андерсоны бүтээлээс. © IRI
-

**Хуудас 258:** *Хоёр дахь ирэлт* Харри Андерсоны  
бүтээлээс. © IRI

**Хуудас 264:** *Ямар ч уур хилэнгүйгээр*, Нэнси Глазиер-Кохлерын  
бүтээлээс. © 1984 Nancy Glazier-Koehler

**Хуудас 268:** *Эцсийн Шүүлт*, Иохан Скоттын бүтээлээс.  
© 1974 IRI

**Хуудас 276:** Дан Бакстерын ханын зургийн хэсэг

# ИНДЕКС

---

## А

---

- Ароны санваар  
албан тушаал ба үүрэг  
хариуцлагууд, 83–86  
чуулгууд, 86  
Мелкизедек Санваар;  
Санваарыг *мөн үз*
- Абрахам, Бурханы гэрээ, 91
- Аврагч. Есүс Христийг үз
- Авралын Төлөвлөгөө, 10–12, 23
- Авьяас билгүүд  
Жозеф Ф.Смитийн  
хариуцлагатай байх  
тухай мэдэгдэл, 219
- Марвин Ж.Аштоны дэвшил  
хөгжлийн тухай мэдэгдэл,  
219
- Хебер Ж.Грантын дэвшил  
хөгжлийн тухай мэдэгдэл,  
219
- дэлхийн өмнөх амьдралд  
хөгжсөн, 9–10  
хөгжиж буй, 217
- Агуу Урвалт, 100
- Агуу Үнэт Сувд, 52
- Адам ба Ева  
Ариун Сүнс ирсэн, 32–35  
гэрлэлт, 27  
дэлхийд анх ирсэн, 27  
зоригтой сүнснүүд, 27  
тусгаарлагдах, Бурханаас,  
29–31
- уналт, 27–31  
хүүхэдтэй болохоор  
зарлигдуулсан, 29
- Ажил, 171–177, 185  
Дэвид О.МакКейн мэдэгдэл, 175  
Хебер Ж.Грантын мэдэгдэл,  
172
- Алдар суу, хаант улсууд, 298–300
- Амралт, 174
- Амрах, 174, 185
- Анхны зарчмууд ба ёслолууд, 98  
Сэргээлтээр дамжуулан тэдний  
бүрэн байдалд буцаан  
авчирсан, 101
- Аравны нэг, 203–209  
Гордон Б.Хинклигийн  
мэдэгдэл, 206  
Стефен Л.Ричардсийн  
мэдэгдэл, 204  
Хебер Ж.Грантын мэдэгдэл,  
206
- Арванхоёр Төлөөлөгчид, шүүлт,  
295  
Төлөөлөгчийг *мөн үз*
- Ариун Ёслол, 145–151  
Христ танилцуусан, 145, 147  
дамжуулан гэрээнүүд  
шинэчлэгдсэн, 148  
түгээлт, 147–148  
хүртэх үеийн хандлага, 149
- Ариун Библи, 49–52  
Ариун Сүмүүд
-

- Мянган жилийн турш гүйцэт-  
гэгдэх ажил, 289, 265  
ажил гүйцэтгэгдсэн, 259  
мөнхийн гэрлэлт  
гүйцэтгэгдсэн, 259–265  
Ариун Сүнс, 32–34  
Адам, Ева руу ирсэн, 32–33  
баптисм бэлгийг хүлээн авахад  
шаардлагатай, 129  
мэдэгдэл, Жозеф Фиелдинг  
Смит, 34  
номлол, 33–34  
шинж чанарууд, 32  
Ариун Сүнсний бэлгийг *мөн үз*  
Ариун Сүнсний бэлэг, 131–135  
Ариун Сүнсний нөлөөг  
таних нь, 134  
Бурханы агуу бэлгүүдийн нэг,  
134  
тодорхойлолт, 131  
хүлээн авах нь, 133  
Ариун явдал, 249–257  
Архи согтууруулах ундаа,  
185, 187  
Ахлагч, албан тушаал ба үүргүүд,  
75–78
- Б**
- 
- Багш, алба ба үүрэг  
хариуцлагууд, 83  
Баптисм, 125–130  
арга зам, 127  
баптисм хүртэх хэрэгтэй  
тэдгээр хүмүүс, 126  
гэрээнүүд, 128  
хэрэгцээ, 125–126  
шинэ эхлэлээр дамжуулан, 129  
Баталгаа. Ариун Сүнсний  
бэлгийг үз
- Баяр баясгалангийн бүрэн  
байдал, 11  
Бичээсүүд, бид шүүгдэх болно,  
295–296  
Бишоп, албан тушаал ба үүргүүд,  
84  
Бодол санааныхаа дагуу шүүгдэх  
болно, 297–298  
Бошиглогчид, 43–49  
Бурхан цаг үеүүдэд дуудсан,  
43  
дэлхий дээрх Бурханы  
төлөөлөгчид, 43  
урьдчилан томилогдсон, 9–10  
үгс, судар, 49  
Бошиглолын бэлэг, 140  
Буруугаа хүлээх нь наманчлалын  
хэсэг, 118–120  
Бурхан. Тэнгэрлэг Эцэгийг үз  
Бурханы Шүүлт, 295  
Бусдыг уучлах, наманчлалын  
хэсэг, 120  
Бусдын гэрчлэлд итгэх нь, бэлэг,  
129  
Бүтээлт  
Бурханы хайрыг харуулдаг,  
24–25  
Есүс Христээр, 23–24  
гаргах, 23–24  
Бүтээлтийн хүч, 23
- Г**
- 
- Гадаад харанхуй, 300  
Гадас, 106  
Гайхамшиг, ажиллахын бэлэг,  
141  
Гэр бүл  
Дэвид О.МкКэй, мэдэгдэл, 229  
Харолд Б.Лий, мэдэгдэл, 232  
амжилттай, 231

мөнхийн, 231–232  
хангах, 232  
харьцаа холбоо, 231  
чухал ач холбогдол, 229, 230  
үүрэг хариуцлагууд, 232–234  
Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх  
тунхаг, 10, 207, 210, 211, 213,  
214, 215, 229, 235  
Гэр бүлийн түүх, 261–264  
Гэрлэлт  
мэдэгдэл, Спенсер В.Кимбал,  
245  
мөнхийн, 241–244  
Гэрээ  
Абрахамын, 91–92  
ариун ёслолоор дамжуулан  
шинэчлэгдсэн, 145  
баптисмын, 128–129  
тодорхойлолт, 95  
шинэ ба үүрдийн, 93  
Гэрээт хүмүүс, 89–95

## Д

---

Дал, албан тушаал ба үүрэг  
хариуцлагууд, 85  
Дарс, 185, 187  
Диваажин  
Вилфорд Вуудрофын мэдэгдэл,  
268  
Жедедиа М.Грантын мэдэгдэл,  
269  
сүнсний дэлхийд, 265  
Дикон, албан тушаал ба үүргүүд,  
83  
Дуулгаваргүй байх, үр дүн, 226  
Дуулгавартай байдал, 221–229  
Иосеф Смитийн мэдэгдэл, 127  
баптисм үзүүлдэг, 125  
Дэвид О.МкКэйгийн гэрчлэл  
ба мэдэгдэл, 138–139

Дэвшил, дэлхийн амьдрал нь  
хэрэгтэй, 10–11  
Дэлхийн амьдрал сорилт, 10–11  
Дээд прист, албан тушаал ба  
үүргүүд, 81

## Е

---

Ева. Адам ба Еваг үз  
Едены цэцэрлэг, 29  
Елиа, ирсэн нь, 280  
Есүс Христ  
Бүтээгч, 25–26  
Орсон Ф.Витнейгийн зовлон-  
гийн талаарх үзэгдэл, 61  
Сүм зохион байгуулагдсан, 61  
Цагаатгалаар дамжуулан  
адислалууд боломжтой  
болсон, 61  
Эцэгийн Цорын ганц  
Хайрт Хүү, 58  
Эцэгтээ дуулгавартай байсан,  
221  
амьдрал, 51–58  
ариун ёслол танилцуулагдсан,  
145, 147  
биднийг бусдад үйлчлэхийг  
хүсдэг, 177  
гэтэлгэл, 61–63  
дэлхийн амьдралын Аврагч  
ба удирдагч, 13  
золиослол, 63, 163, 191  
сургаалууд, 55–56  
төгс амьдрал, 58  
төрөх ба үүрэг нь урьдчилан  
хэлэгдсэн, 55–56  
хайр, 60–61  
энэрлийн үлгэр жишээ,  
191–193

- үйлчлэлийн үлгэр дууриал, 177–178
- өмнөх дэлхийд урьдчилан томилогдсон, 9
- Есүс Христийн хоёр дахь ирэлт; Есүс Христэд итгэх Итгэл; Цагаатгалыг *мөн үз*
- Есүс Христ Бурханы Хүү гэдгийг мэдэх нь бэлэг, 137–138
- Есүс Христийн Сүм
- Америк тивд, 99
- байгууллага, 97–99, 99–101
- баптисмаар гишүүн болох, 109
- илчлэлт, 95, 97
- Иосеф Смитээр дамжуулан зохион байгуулагдсан, 103–107
- дэх эрх мэдэл, 93, 97
- сэргээгдсэн, хэзээ ч устгаагдахгүй, 108
- сэргээлт, урвдчилан хэлэгдсэн, 101–, 103–105
- тогтоох онцлогууд, 87–91
- урвалт, 99–100
- өнгөрсөн цаг үеүүдэд, 95–101
- өнөөдөр, 107
- Есүс Христийн Хоёр дахь Ирэлт, 283–289
- тэмдгүүд, 286–287, 296
- Есүс Христэд итгэх итгэл, 109–115
- бид хэрхэн өсөж чадах вэ, 133
- Итгэлийн тухай лекц* үр дүнгийн мэдэгдэл, 109
- даган ирэх адислалууд, 134–135
- Спенсер В.Кимбал, ажиллах хэрэгтэй зүйлийн талаарх мэдэгдэл, 113
- сүнсний бэлэг, 131, 132
- тодорхойлолт, 131, 133
- яагаад бидэнд хэрэгтэй, 112
- Ё**
- Ёслолууд
- сэргээгдсэн, 105–106
- Үнэн Сүмийн онцлог шинж, 95–96
- Ж**
- Жимс, 170
- З**
- Залбирал, 37–38
- хэзээ залбирах вэ, 38–39
- хэрхэн залбирах вэ, 39
- хэрхэн залбирлууд хариулагддаг вэ, 39–40
- яагаад залбирдаг вэ, 37–38
- Залхуурал, 174–175
- Золиослол, 163–171
- И**
- Иаков
- Бурханы гэрээ, 271
- нэр Израил болон өөрчлөгдсөн, 271
- Израил
- Иаковын нэр өөрчлөгдсөн, 271
- овгийг тараасан нь, 271, 273
- овгийн цугларалт, 271–276
- цугларалтын талаарх
- Жозеф Фиелдинг
- Смитийн мэдэгдэл, 274
- цугларалтын талаарх Рассел М. Нелсоны мэдэгдэл, 275
- Израилчууд, 271
- Илчлэлт, үнэн Сүмийн онцлог шинж, 95, 97



Их Эзэний өдөр, 151–152  
Хүндэтгэлийн өдрийг *мөн үз*

## А

---

Лацдалт, Елиагаар сэргээгдсэн  
хүч, 280  
Люсифер. Сатаныг үз

## М

---

Мах, 185  
Мацаг барих, 157–158  
адислалууд, 160–162  
зүй ёсны, 159–160  
Мацгийн өдөр, 157–161  
Мацгийн өргөл, 160, 200  
Мелкизедек Санваар  
албан тушаалууд ба үүрэг  
хариуцлагууд, 81–82  
чуулгууд, 81–82  
Аароны санваартан;  
Санваарыг *мөн үз*  
Мормоны Ном, 50–52  
Мэдлэг нь бэлэг, 139  
Мэргэн ухаан, бэлэг, 140  
Мэргэн ухааны үг, 185–191  
Хебер Ж.Грантын мэдэгдэл,  
189  
Мэхлэх, 172–174  
Мянган жил, 289–295  
Бригам Янгын мэдэгдэл, 267  
Жон Тэйлорын мэдэгдэл, 292

## Н

---

Наманчлал  
Спенсер В.Кимбалын  
мэдэгдэл, 118, 121–, 231  
адислалууд, 117  
зарчмууд, 118–121  
одоо бол цаг нь, 122  
тодорхойлолт, 117

хэрэгтэй, 117  
Ногоонууд, 185  
Номлолын ажил, 209–217  
Езра Тафт Бенсоны мэдэгдэл,  
211  
Ням гараг, Хүндэтгэлийн өдөр,  
151–152  
Нүглийг хаях, наманчлалын хэсэг,  
119  
Нүглүүдийг танин мэдэх,  
наманчлалын хэсэг, 117  
Нүглүүдээс ангижрах, баптисм,  
125  
Нүгэл  
бүгд буруутай, 117  
тодорхойлолт, 117  
Нүгэлдээ харамсах,  
наманчлалын хэсэг, 117

## О

---

Орчуулгын бэлэг, 138

## П

---

Патриарх, албан тушаал ба  
үүрэг хариуцлагууд, 81  
Патриархын адислалууд, 10, 85,  
130  
Томас С.Монсоны мэдэгдэл, 10  
Прист, албан тушаал ба  
үүрэг хариуцлагууд, 84

## С

---

Саад тогторууд өсөн хөгжихөд  
хэрэгтэй, 11  
Сайн мэдээний үнэнүүд  
сэргээгдсэн, 106–107  
Санваар, 75–81  
Жозеф Ф.Смитийн мэдэгдэл,  
83

- байгууллага, 81–89  
 зохистой ашигласны  
   адислалууд, 87  
 тодорхойлолт, 82  
 түлхүүрүүд, 82–83  
 хэлтэс, 84–85  
 хэрхэн зохистой хэрэглэсэн, 70  
 хэрхэн эрэгтэй хүмүүс  
   хүлээн авдаг, 81–82  
 хэрэгтэй, 81, 83  
 Аароны санваар; Мелкизедек  
   санваарыг *мөн үз*
- Сатан  
 Еваг уруу татсан, 29  
 Мянган жилийн хугацаанд  
   тусгаарлагдана, 289–295  
 Мянганы жилийн эцэст хэсэг  
   зуур чөлөөлөгдөнө, 289  
 Сүнсний бэлгүүдийг дууриах,  
   143  
 биднийг ариун явдлын хууль  
   зөрчүүлэхийг хүсдэг,  
   252–253  
 биднийг уруу татдаг, 16  
 сайныг сөргүүлдэг, 16  
 сонгох эрх чөлөөг авахыг  
   эрэлхийлсэн, 13, 15  
 тэнгэрт Есүсийн эсрэг дайтсан,  
   15  
 тэнгэрээс хөөгдөх, 15–16
- Селестиал хаант улс  
 баптисм ороход шаардлагатай,  
   265  
 өргөмжлөл, 265, 265–270
- Смит, Иосеф  
 Сүмийн дамжуулан  
   сэргээгдсэн, 105–106  
 үнэн дамжуулан сэргээгдсэн,  
   107–108
- Сонгох эрх чөлөө. Сонголтыг үз  
 Судрууд, 49–55  
   дөрвөн ном, 49–55  
   суралцах, 53–54  
 Сургаал ба Гэрээ, 51  
 Сургалт  
   бэлэг, 137  
   энэ номноос, 1–3  
 Сэргээн босголт,  
   наманчлалын хэсэг, 118  
 Сүмийн Ерөнхийлөгч, 43  
 Вилфорд Вуудрофын мэдэгдэл,  
   45  
 Сүмийг удирддаг, 103  
 дуулгавартай байдлын  
   адислалууд, 46  
 дэмжин батлах нь, 45  
 өнөөгийн амьд бошиглогч,  
   43–49  
 Бошиглогчид  
 Сүмийн Сэргээлтийг *мөн үз*  
 Иосеф Смитээр дамжуулан,  
   101–102  
 урьдчилан хэлэгдсэн, 100–101,  
   103–104  
 Сүнс, бэлэг. Сүнслэг бэлгүүдийг  
   үз  
 Сүнслэг бэлгүүд, 137–145  
   Сатан дууриадаг, 143  
   ашиглахдаа анхаарах, 146–147  
   тодорхойлолт, 137–142  
   хөгжиж буй, 142  
   үнэн Сүмийн онцлог шинж,  
   103  
 Сүнсний бэлэг. Сүнслэг  
   бэлгүүдийг үз  
 Сүнсний дэлхий, 265–268  
 Брингам Янгийн  
   сургаал, 267

Езра Тафт Бенсоны мэдэгдэл,  
265  
Сүнсний шорон, 269  
Сүнснүүд, биеийн хэлбэр, 267

## Т

---

Тамхи, 185  
Телестиал алдар суу, 299  
Террестиал алдар суу, 272  
Тойргууд, 103  
Тэнгэр дэх Эцэг. Тэнгэрлэг  
Эцэгийг үз  
Тэнгэр дэх дайн, 15–16  
Тэнгэр дэх зөвлөл, 11  
Тэнгэрлэг Эцэг  
Бидний Эцэг үүргийн талаарх  
мэдэгдэл, Жозеф Смит, 5–6  
Бүх зүйлсийн удирдагч, 5  
Бүхнийг Бүтээгч, 5  
ажил ба алдар суу, 6  
бидний адил болох боломж, 9  
бидний харилцааны талаарх  
мэдэгдэл, Жозеф Ф.Смит, 9  
бие, 6  
бодит байдал, 5–6  
мэдсэнээр, 6–7  
хүмүүс Түүний дүр  
төрхөөр хийгдсэн, 6  
хүсэл, бид Түүнд байгаа чана-  
руудыг хөгжүүлдэг, 10–12  
шинж чанарууд, 6  
эцэг байх, 9  
Тэргүүн Зөвлөл, 105–106  
Төлөөлөгч, албан тушаал Арван-  
хоёр Төлөөлөгчдийг үз  
ба үүргүүд, 77, 76–78  
Төрөлт, бидний цаг ба газар,  
Тэнгэрлэг Эцэгээр сонгогдсон,  
9

## У

---

Улаан буудай, 185  
Уналт, 27–31  
үр дүн, 29–30  
Ургамал, 185  
Уруу таталт ба түүнийг даван  
дийлэх тухай мэдэгдэл,  
Гордон Б.Хинкли, 253  
Урьдчилан томилсон, 9–10  
Иосеф Смит, мэдэгдэл, 10  
Уучлал  
Спенсер В.Кимбал, мэдэгдэл,  
255  
ариун явдлын хуулийг зөрчих  
нь, 254  
дамжуулан баяр баясал, 112

## Х

---

Халуун уух зүйлс, 186  
Хатуу ундаанууд, 197, 199  
Христ. Есүс Христийг үз  
Хувь хүн, өмнөх амьдрал  
хөгжсөн, 9–10  
Худал хуурмаг, 199  
Хулгай, 197  
Хэлний бэлэг, 137, 139  
Хэлнүүдийн хөрвүүлэг, бэлэг, 138  
Хүндэтгэлийн өдөр, 151–157  
Ням гараг, 151  
ариунаар хадгалах, 151–152  
зорилго, 151–152  
сахиснаар ирэх адислалууд,  
153  
тодорхойлолт, 151  
түүх, 147–148  
Хөшиг тэнгэрлэг гэрийн  
дурсамжийг халхалдаг, 11

**Ц**

- Цагаатгал, 61–63  
 Амилуулалтын үр дүн, 63  
 Байд К.Пакерын түүх, 69–71  
 Жозеф Фиелдинг Смитийн  
 Мэдэгдэл, 109  
 авралд шаардлагатай, 59  
 зөвхөн Христ гүйцэлдүүлж  
 чадна, 61  
 Христ зовон нас барсан,  
 55–57, 61  
 нүглүүдээс аврах нь –ын  
 үр дүн, 61–64  
 Есүс Христийг *мөн үз*  
 Цагийн тэмдгүүд. Есүс Христийн  
 Хоёр дахь ирэлтийг үз  
 Цай, 185

**Ч**

Чөтгөр. Сатаныг үз

**Ш**

- Шинэ бөгөөд үүрдийн гэрээ, 93  
 Шударга ёс, 197–201  
 Бригам Янгийн мэдэгдэл, 197  
 Жосеф Ф.Смитийн мэдэгдэл,  
 201  
 Марк И.Петерсений мэдэгдэл,  
 197  
 Шүүлт  
 Есүс Христээр, 295  
 Төгсгөл, 295–302  
 бичээсүүд ашиглагдах болно,  
 280–281  
 бэлтгэх нь, 277  
 үгс, үйлс, бодол ашиглагдах  
 болно, 281–283

**Э**

- Эдгээлт, бэлэг, 141  
 Энэрэл, 191–198  
 Иосеф Смитийн мэдэгдэл, 195  
 Томас С.Монсоны мэдэгдэл,  
 193  
 Эрх мэдэл  
 сэргээгдсэн, 105  
 үнэн Сүмийн онцлог шинж,  
 107  
 Эрэгтэй  
 Бурханы бүтээлүүдийн дээр  
 захирах, 5  
 Бурханы дүр төрхөөр  
 бүтээгдсэн, 6  
 Бурханы хүүхэд, 9  
 тэнгэрлэг эцэг эх байх тухай  
 Жозеф Ф.Смитийн  
 мэдэгдэл, 9  
 Эрүүл мэнд, Бурханы хууль.  
 Мэргэн ухааны үгийг үз  
 Эхчүүд  
 Байд К.Пакерын мэдэгдэл, 238  
 үүрэг хариуцлагууд, 238–239  
 Эцгүүд, үүрэг хариуцлагууд, 237  
 Эцсээ хүртэл тэвчих, хүлээн  
 авсан адислалууд, 226  
 Эцэг эхчүүд, үүрэг хариуцлагууд,  
 171, 235–236

**З**

зарлигууд, сахих нь, наманчлалын  
 нэг хэсэг, 118–119

**К**

кофе, 186

**М**

---

мансууруулах бодис, буруу хэрэглээ, 185

**Х**

---

хүүхдүүд

Адам, Ева нарт зарлигласан, 30

үүрэг хариуцлагууд, 251

**Ч**

---

чөлөөт сонголт

Сатан холдуулахыг эрэлхийлдэг, 15

авралын төлөвлөгөөнд

шаардлагатай, 20, 19

мөнхийн зарчим, 19

сонголт шаарддаг, 19–20

хэрэглэх, өмнөх амьдралын дурсамжгүйгээр, 11

**Ү**

---

Үгсийнхээ дагуу бид шүүгдэх болно, 297–298

Үйлдлүүдийнхээ дагуу бид шүүгдэх болно, 297–298

Үйлчлэл, 177–185, 191

Спенсер В.Кимбалын мэдэгдэл, 179

Үндсэн Зөвлөл, 11

Үр тариа, 185

Үхэл, зориулсан ёслолууд, үнэн Сүмийн онцлог шинж, 259–261

**Ө**

---

Өвөг дээдэс, тусалснаар, 260–262

Өгөх нь, 137

Стефен А.Ричардс, мэдэгдэл, 186

Өргөлүүд, 203–209

Гордон Б.Хинклийн мэдэгдэл, 206

Стефен А.Ричардсын мэдэгдэл, 204

Хебер Ж.Грантын мэдэгдэл, 206

Өргөмжлөл, 303–308

Жозеф Фиелдинг Смитийн мэдэгдэл, 274

зохистой болох нь, 16

мөнхийн гэрлэлт нь чухал, 241–243

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СУМ

